



“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСЛИЙН ДУНДЫН ТАЙЛАН – 1
БОТЬ 1: ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

2019 ОН

ЗАХИАЛАГЧ: “БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ”

ГҮЙЦЭТГЭГЧ: ”БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ, СУУРЬШЛЫН
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСЛИЙН ДУНДЫН ТАЙЛАН – 1
БОТЬ 1: ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА**

ТАНИЛЦСАН:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

ЗАХИАЛАГЧ:

Гүйцэтгэлийг хүлээн авч хянасан:
БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ХБГХБХЗГ-ЫН ДАРГА

Б.ГҮНБОЛД

БАРИЛГА,ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ХБГХБХЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Д.БОЛОРМАА

ГҮЙЦЭТГЭГЧ:

Гүйцэтгэл хүлээлгэн өгсөн:

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ

Ц.АМАРСАНАА

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ

Б.ГАНБОЛД

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН
СТХХ-ИЙН ДАРГА

Г.ГАНТУУЛ

БХТ-ИЙН ХАНБНСТХ-ИЙН ДАРГА

С.ДАВААНЯМ

БХТ-ИЙН ХСДБСТХ-ИЙН ДАРГА

Д.ЧИНЗОЛБОО

2019 ОН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	6
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН	7
1.БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	8
2. ӨМНӨХ ҮГ	9
3. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, АРГАЗҮЙ	11
3.2. Судалгааны аргачлал.....	11
3.3. Судалгааны аргазүй	12
4. БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ, НӨӨЦ	14
4.1. Газар хөдлөлт	15
4.2. Цэвдэг	16
4.3. Барилгажилтад тохиромжтой байдлын мужлал.....	20
5. ХҮН АМЫН ӨСӨЛТ, СУУРЬШИЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ СУДАЛГАА	23
5.1. Хүн амын нутагшилт суурьшлын тогтолцооны болон хотжилтын өнөөгийн байдал 23	
5.2. Хүн амын өсөлт, өөрчлөлт, орон зайн тархалтаар	30
5.3. Хүн амын нас хүйсний бүтэц, дундаж наслалт	36
5.4. Хүн амын шилжилт хөдөлгөөн	39
5.4.1. Гадаад шилжилт хөдөлгөөн	39
5.4.2. Дотоод шилжилт хөдөлгөөн	42
5.5. Угсаатны бүтэц.....	47
5.6. Хүн амын хэтийн тооцоо.....	52
6. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЭЛ ЯДУУРЛЫН СУДАЛГАА	53
6.1. Хүн амын хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн байдал	53
6.2. Ажилгүйдэл	57
6.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт	60
6.4. Ядуурал	67
7. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ХУВААРИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	69
7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн өөрчлөлтүүд.....	70
7.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн харьцуулсан судалгаа.....	75
8. ХОТЫН ЗЭРЭГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТАЛААРХИ СУДАЛГАА	80
8.1. Эрхзүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага	80
8.2. Улсын зэрэглэлтэй хотод горилогч хотууд	85
8.3. Аймгийн зэрэглэлтэй хотод горилогч хотууд	87
9. ЗАМ ТЭЭВЭР	92

9.1.	Төмөр замын тээвэр	93
9.2.	Авто замын сүлжээ	97
9.3.	Авто тээвэр.....	100
9.4.	Агаарын тээвэр	101
9.5.	Усан замын тээвэр	104
9.6.	Дамжуулах хоолойн тээвэр	106
10.	ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ.....	108
10.1.	Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, байршлын өнөөгийн байдал	108
10.1.2.	Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, дамжуулалтын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээнүүд.....	126
10.2.	Мэдээлэл, харилцаа холбооны өнөөгийн байдал.....	128
10.3.	Ус хангамж, ариутгах татуурга	134
11.	НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН СУДАЛГАА	139
11.1.	Боловсролын үйлчилгээ.....	141
11.1.1.	Сургуулийн өмнөх боловсрол.....	141
11.1.2.	Ерөнхий боловсрол.....	148
11.1.3.	Дээд болон техникийн мэргэжлийн боловсрол	152
11.2.	Эрүүл мэнд	158
11.3.	Соёлын үйлчилгээ	178
12.	ХҮН АМЫН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ.....	180
12.1.	Орон сууцны хангамж улсын түвшинд.....	180
12.2.	Орон сууцны хангамж эдийн засгийн бүс, аймгийн түвшинд	180
12.3.	Хүн амын орон сууцны хангамж сумдаар.....	186
13.	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН НӨӨЦИЙН СУДАЛГАА	194
13.1.	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД.....	194
1.3	Аялал жуулчлалын салбарын эрхзүйн орчин.....	196
13.2.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаарх төсөл, арга хэмжээнүүд	197
13.3.	Аялал жуулчлалын салбарын хөгжлийн өнөөгийн байдал.....	199
13.4.	Аймгуудын аялал жуулчлалын нөөц, маршрутууд	201
	Амралт сувилал.....	209
13.5.	Аялал жуулчлалын салбарын үндсэн бүсүүд	210
13.6.	ХИЛ ОРЧМЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	213
14.	ЭДИЙН ЗАСАГ АЖ ҮЙЛДВЭР	216
14.1.	Эдийн засгийн өсөлт, бууралт	216
14.2.	Орон нутгийн төсөв	222

14.3.	Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин	226
14.4.	Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ	227
14.5.	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	228
14.6.	Аж үйлдвэр	230
14.7.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	232
15.	ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БА ХҮН АМЫН НУТАГШИЛТ СУУРЬШИЛ	237
15.1.	Уур амьсгалын өөрчлөлт.....	239
15.2.	Газрын доройтол, цөлжилт	242
15.3.	Газар ашиглалт, газрын баланс.....	245
15.4.	УСНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ.....	248
15.5.	БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ	251
16.	НЭГДСЭН ДҮГНЭЛТ	253
	Ашигласан материалууд.....	255

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БХБЯ –	Барилга, хот байгуулалтын яам
БХТ –	Барилгын хөгжлийн төв
ХАНСХЕТ –	Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл
ХАНБНСТХ –	Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа төлөвлөлтийн хэлтэс
ХСДБСТХ -	Хот суурин, дэд бүтцийн судалгаа төлөвлөлтийн хэлтэс
УИХ –	Улсын Их Хурал
ДБ –	Дэлхийн банк
АХБ –	Азийн хөгжлийн банк
ГХГЗЗГ –	Газрын харилцаа, геодези зурагзүйн газар
ЗДТГ –	Засаг даргын тамгын газар
ЗЗНДХ –	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь
ЕБС –	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ -	Эрүүл мэндийн төв

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

1. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах багийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, орон нутагт ажиллахад дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтарч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг аймаг бүрт байгуулж, тэдгээрт хамтран ажиллаж холбогдох мэдээ материал бүхий мэдээллийн сан бүрдүүлсэн.
2. Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн Н.Тогтох гуайгаар ахлуулсан зөвлөх багт 2019 оны 4-р сард төслөө танилцуулан аргазүй, удирдлага зохион байгуулалтын талаар зохих чиглэл аван ажилласан.
3. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн өнөөгийн байдлын судалгааны явц болон Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудлыг түшиглэн хөгжих дагуул хотын тухай нээлттэй хэлэлцүүлгийг 2019.11.15-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Барилга хот байгуулалтын яам, Үндэсний хөгжлийн газар, Барилгын хөгжлийн төв, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар, Нийслэлийн хот байгуулалтын газар, Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Шинжлэх ухааны академийн Газарзүй-Гео экологийн хүрээлэн, JICA, ADB төслийн баг, Монголын архитекторуудын эвлэл, Монголын хот байгуулалт хөгжил судалгааны хүрээлэн, Мэргэжлийн зөвлөл, БХБЯ-ын сайдын зөвлөх баг болон бусад холбогдох байгууллагын 90 хүн оролцсон бөгөөд холбогдох санал шүүмжлэлийн дагуу хэлэлцүүлгийн дүгнэлт боловсруулж, ажилдаа тусган ажиллаж байна.
4. Орон нутгийн судалгааг 2018 оны 11 сараас 2019 оны 6 сар хүртэл хугацаанд нийт судалгааны 8 баг Төвийн, Зүүн, Баруун бүсийн нийт 15 аймгийн 160 гаруй хот, сум, суурин газарт ажиллаж, аймгийн дэд ажлын хэсгийг хуралдуулан төслөө танилцуулж, санал аван, тоон болон чанарын судалгааны мэдээллээ цуглуулж, өнөөгийн байдлын судалгаандаа ашигласан.
5. Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах, дагуул хотуудыг хөгжүүлэх хүрээнд Төв аймгийн төв Зуунмод хот, Аэросити, Майдар хот төслийн талбайд орон нутгийн судалгааг 2019 оны 5-р сард хийж, холбогдох дүгнэлт зөвлөмжөө БХБЯ-нд хүргүүлсэн. Төвийн бүсийн өмнөд хэсгийн говийн аймгууд болох Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь аймгийн сумдууд болон Увс, Архангай, Дорнод, Орхон аймгийн сумд болон Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүс, боомтод томилолтоор ажиллаж, ХАНСХЕТ-өө танилцуулж, аймгийн ажлын хэсгийн хурлыг хийж, холбогдох мэдээ материал цуглуулж, тэдгээрт боловсруулалт хийсэн.
6. Ажил гүйцэтгэх гэрээ болон зургийн даалгаврын дагуу дундын шатны өнөөгийн байдлын судалгааны 2 боть тайланг холбогдох 11 газрын зургийн хамт боловсруулж, 2019 оны 11 сард захиалагчийн хяналт тавьж буй ГЗБГГЗГ-т хүлээлгэн өгсөн.
7. Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй төсөл арга хэмжээний байршил, хүчин чадал нь үйлчлэх хүн амын хэрэгцээндээ хэр нийцсэн талаар харьцуулсан судалгааг боловсрол, эрүүл мэндийн салбарын хүрээнд боловсруулж, дүгнэлт гарган захиалгын дагуу Аудитийн ерөнхий газарт 2019 оны 10-р сард хүргүүлсэн.

1. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил
Зөвлөхүүд			
1	Э.Дондмаа	Хот төлөвлөлтийн зөвлөх архитектор	Архитектор
2	П.Энхээ	Хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч	Нийгэм эдийн засгийн газар зүйч
3	Н.Тогтох	Бүсчилсэн хөгжлийн зөвлөх	
4	М.Баянтөр	МУИС-ийн зөвлөх профессор	Хотын газарзүйч
Удирдах болон инженер техникийн ажилтнууд			
1	Б.Ганболд	Тэргүүн дэд захирал	Архитектор
2	С.Давааням	Хэлтсийн дарга	Газарзүйч, бүс нутаг судлаач
3	Д.Чинзолбоо	Хэлтсийн дарга	Архитектор
4	Д.Отгонбат	Газарзүйч, бүс нутаг судлаач	Газарзүйч
5	Г.Балжмаа	Газарзүйч, бүс нутаг судлаач	Газарзүйч, бүс нутаг судлаач
6	С.Гүнчинсүрэн	Хот төлөвлөлтийн архитектор	Архитектор
7	Д.Мөнхжаргал	Хот төлөвлөлтийн архитектор	Барилгын инженер
8	Г.Баттуяа	Хот төлөвлөлтийн эдийн засагч	Эдийн засагч
9	Б.Батзаяа	Газар зохион байгуулагч	Газар зохион байгуулагч
10	Б.Идэрхангай	Газар зохион байгуулагч	Газрын кадастр
11	Ж.Түвшинбаяр	Инженер геологич	Геологич
12	А.Сугар	Хот төлөвлөлтийн эдийн засагч	Хот ба бүс нутгийн төлөвлөлт
13	Б.Ганпүрэв	Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	Барилгын инженер
14	Л.Долгор	Авто тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Барилгын инженер
15	Б.Цолмон	Архитектор	Архитектор дизайнер

2. ӨМНӨХ ҮГ

Олон улсын жишгээр авч үзвэл, манай улсын хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжит орчинг өөрийн хөгжиж ирсэн онцлог, газар нутгийн нөөц, баялаг, байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлтэй уялдуулан, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан тодорхойлох, энэ үндсэн дээр нийгэм, эдийн засгийн ойр ирээдүйн хөгжил, соёлын түвшинг илэрхийлэх, нийгмийн дэвшилд идэвхитэй нөлөөлөх бодит үр дагавар бүхий нутаг дэвсгэрийг зохион байгуулах, хүн амыг зохистой байдлаар нутагшуулах төслийг боловсруулж, төрийн бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсаар байна.

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 119 тоот гэрээ болон БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын зургийн даалгаврыг үндэслэл болголоо. Монгол Улсын Үндсэн хуулинд “... хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, амрах эрхтэй...” гэж заасан нь бүхэлдээ хот байгуулалтын тухайлбал, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд дараагийн үе шатны бус нутгийн төслүүд болон хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжиж байх ёстой билээ.

Үүний зэрэгцээ дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, 1940-2010 онд дэлхийн түвшинд дулаарал +0.85°C байхад Монгол оронд +2.07°C буюу дэлхийн дунджаас 2.4 дахин их байгаа бөгөөд улмаар Монгол Улс уур амьсгалын эрсдэлд эмзэг байдлаар дэлхийн 100 гаруй орноос 8 дугаарт орж байна.

Манай оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нь усны нөөц, горимд өөрчлөлт орох, олон жилийн цэвдэгт хөрс болон өндөр уулын мөстлөг хайлах, нуур цөөрөм, булаг шанд ширгэх, хөрсний усны түвшин доошлох, зуны хэт халалт, хуурайшилт болон агаарын мандлын гаралтай конвекцийн үзэгдлийн улмаас хөрс, бэлчээр доройтон ургамлын төрөл зүйлийн бүрдлийн тоо цөөрч, цөлжих үйл явц идэвхжих, зэрлэг амьтадын тархалтын бүс нутаг өөрчлөгдөх, ой хээрийн түймрийн давтагдал нэмэгдэх зэргээр илэрч байна.

Монгол орны өргөн уудам газар нутагт хүн амын нутагшилт, суурьшлын орон зайн төлөвлөлтийг өнгөрсөн 70 гаруй жилийн уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлагатай уялдуулан авч үзэх нь хот, суурин газрын тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дасан зохицох үндсэн нөхцөл болно.

Өнгөрсөн 70 гаруй жилийн хугацаанд орон зайн хувьд уур амьсгалын өөрчлөлт 20С-ээс дээш дулаарч буй бүсэд Улаанбаатар болон 9 хот, 55 сумын төв оршиж байна. Энэхүү бүсэд нийт хүн амын 60 хувь амьдарч байгаа нь Монгол Улсын хүн амын дийлэнх хэсэг нь уур амьсгалын өөрчлөлт, дулаарлаас үүдэлтэй эрсдэл өндөртэй бүсэд суурьшиж байгааг харуулж байна.

Түүнчлэн эрчимтэй хотжилт нь зүй бус газар ашиглалтыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт хотуудын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Хуурай, эрс тэс уур амьсгалтай, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол Улсын хувьд

хамгийн их хохирол дагуулдаг байгалийн гамшиг болох ган, зудын давтамж болон хохирлын хэмжээ уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэж байна. Тухайлбал, 1999-2002 онд болон 2009-2010 онд нийт нутгийн 80-90% хамарсан ган, зуд дараалан тохиолдсон жилүүдэд олон сая мал зүй бусаар хорогдож, олон мянган малчин өрх малгүй болсон бөгөөд улмаар гамшгийн дараах жилүүдэд хөдөөнөөс хот руу шилжин суурьшсан хүн амын тоо эрс нэмэгдсэн байдаг.

Хот, суурин газрын 75 орчим хувь газар хөдлөлтийн Рихтерийн 7 ба түүнээс дээш, 12 сум 9 баллаас дээш газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд, нийт хүн амын 86 хувь нь эдгээр газар нутагт амьдарч байна. 2005 оноос Улаанбаатар хотод 20 км орчим зайд газар хөдлөлтийн идэвхжилт ажиглагдан 6 орчим хагарлыг илрүүлэн судалж байна. Улаанбаатар хот орчимд 2005 онд 1000, 2009 онд 2000, 2010 онд 2500 удаагийн газар хөдлөлтийн чичирхийлэл бүртгэгдсэн. Уур амьсгалын өөрчлөлт нь нийт Монгол Улсын хүн ам, эдийн засагт эрсдэлтэй, олон сөрөг үр дагаврыг авчрах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь ус, ой, бэлчээр, газар, хөрс зэрэг нөхөн сэргээгдэх нөөцийн ашиглалтын менежмент, хүн амын нутагшилт, суурьшил, эрүүл мэндийн үйлчилгээ, технологийн стандартыг сайжруулахыг шаардаж байна.

Дундын тайланг 2 ботиор боловсруулсан бөгөөд эхний боть нийт 15 бүлэг, 257 хуудастай бөгөөд хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн өнөөгийн байдлын судалгааг тоймлон багтаасан. Дөрөвдүгээр бүлэгт хүн амын суурьшил, хот байгуулалт болон барилгажилтад нөлөөлөх Монгол орны байгалийн нөхцөл нөөцийн судалгааны хүрээнд уур амьсгалын нөлөө, газрын гадарга, газар хөдлөлт, цэвдэг, барилгажилтад тохиромжтой байдлын үнэлгээний мужлалыг тайлбартайгаар оруулсан.

Тавдугаар болон зургадугаар бүлэгт хүн амын суурьшил, дотоод, гадаад шилжилт хөдөлгөөн, хүн амзүй, хотжилтын хандлага, хүн амын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлыг орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн динамиктайгаар тэдгээрийн хамаарал, шалтгаан, зүй тогтлыг тодорхойлон гаргасан.

Долоо болон наймдугаар бүлэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн харьцуулсан судалгаа болон хотын зэрэглэлийн судалгааг багтаасан. Ес болон аравдугаар бүлэгт зам тээвэр болон инженерийн дэд бүтцийн хөгжил, төлөвлөлтийн талаар оруулсан.

Арваннэгдүгээр бүлэгт боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний чанар, хүртээмж болон тэдгээр салбарын барилгуудын хүчин чадал, байршил нь үйлчлэх хүн амын хэрэгцээтэй хэр нийцэж байгааг тодорхой судалгаа баримттайгаар харьцуулан тодорхойлсон. Арванхоёрдугаар бүлэгт хүн амын орон сууцны хангамжийг улс, бүс, аймаг, сумдын түвшинд харьцуулан тодорхойлсон. Арвангуравдугаар бүлэгт аялал жуулчлалын салбарын хөгжлийн өнөөгийн байдал, аймгуудын нөөц, маршрутууд болон аялал жуулчлалын төрөлжсөн бүсүүдийн талаар дэлгэрэнгүй оруулсан.

Арвандөрөвдүгээр бүлэгт эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн байдал, байршил, бүс нутгуудын оруулсан бол арвантавдугаар бүлэгт уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилт, усны нөөц ашиглалт, байгаль орчны бохирдлын талаархи судалгаанаас оруулсан.

3. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, АРГАЗҮЙ

3.2. Судалгааны аргачлал

Судалгааг олон нийтийн оролцоонд тулгуурлан хүн амын нутагшилт суурьшлын тогтолцооны хүрээнд аливаа юмс үзэгдлийн зүй тогтол, төлөвлөлтийг орон зай, цаг хугацааны өөрчлөлтийн дагуу харьцуулан хийнэ.

Тулгуур зарчим


- Эдийн засгийн хувьд үр ашигтай
- Нийгмийн хувьд оновчтой
- Хүрээлэн буй орчны хувьд тогтвортой
- Түүх соёлын хувьд иргэд хүлээж авахуйц
- Орон зайн хувьд оновчтой төлөвлөлттэй байх
- Үндэсний аюулгүй байдлыг хангах

Түүнчлэн өмнө хийгдсэн судалгаа болон орон нутгийн саналыг харгалзан үзэж судалгаандаа тусгана. Тухайлбал 1996 онд болон 2004 онд Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулж байсан.

Газрын зураг 1. Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн төлөвлөлт, 1996 он



Зураг 1. Судалгааны аргачлал



3.3. Судалгааны аргазүй

Судлаачид хот, суурин газрын зэрэглэл, эдийн засгийн бүсийн хөгжлийн тулгуур төвийг судлахдаа юуны өмнө “Аливаа улсын болон бүс нутгийн хэмжээний хот, суурин газрын орон зайн байршил, тархалт нь ямар нэгэн зүй тогтлыг агуулж байна уу?” гэдэг асуултад хариулт өгөхийг зорьсоор иржээ. Эрдэмтэд тодорхой нэг хот хөгжүүлэх үзэл баримтлалаас хот, суурин газрын сүлжээ байгуулах үзэл баримтлалд шилжсэн.

Хүн амын суурьшил нутагшлыг судлахад 1970-аад оноос математик загварчлалын аргуудыг өргөн хэрэглэх болжээ. Мөн газар зүйн зураглалын арга хэрэглэдэг. Тодорхой нутаг дэвсгэр дээр хүн ам хэр зэрэг жигд нутагшиж суурьшсан байгаа нь хүн амын нутагшилт суурьшлын гол илэрхийлэл юм. Үүнийг тодорхойлохын тулд зэргэлдээ оршдог суурин газруудын хоорондын зайг тооцож, тэдгээрийн дунджаар шинжилгээ хийх арга хэрэглэдэг:

$$R_n = \frac{\bar{D}}{0.5 \sqrt{\frac{S}{n}}}$$

Үүнд:

- R_n – суурин газруудын бөөгнөрлийг тодорхойлох үзүүлэлт;
- \bar{D} – зэргэлдээ орших суурин газруудын хоорондын зайны дундаж;
- S – судалж буй газар нутгийн хэмжээ;
- n – суурин газрын тоо.

Хэрвээ суурин газрууд жигд байрласан бол энэ үзүүлэлт хамгийн их утга буюу 2,15-д дөхнө. Хэрвээ хүн ам нэг сууринд амьдардаг бол үзүүлэлт 0-той тэнцүү, эмх замбараагүй суурьшсан бол 1-тэй тэнцүү байдаг.

Тодорхой нутаг дэвсгэр дээр хүн ам хэр зэрэг жигд нутагшиж суурьшсан байгааг нутаг дэвсгэрийн бөөгнөрлийн индексээр мөн илэрхийлж болно. Уг индексийг дараах томъёогоор тодорхойлдог:

$$K_{т.к.} = 1/2 |S_i - P_i| 100\%$$

Үүнд:

S_i – Тухайн улсын нийт нутаг дэвсгэрт i дугаар бүсийн газар нутгийн эзлэх хувийн жин;

P_i – Тухайн улсын нийт хүн амд i дугаар бүсийн хүн амын эзлэх хувийн жин.

Нийгэм эдийн засгийн судалгаа: Хүн амын нутагшилт бүс нутгийн судалгаанд холбогдох нийгэм эдийн засгийн бүлэгт одоогийн байдлын судалгааг улс орны, бүсийн нутгийн, аймаг, сумд, баг, хорооны түвшинд анхдагч болон хоёрдогч датаг сүүлийн 5-10 жилээр эхний ээлжинд дараах дэд ангиллаар мэдээллийн сан үүсгэхээр боловсруулалтын бэлтгэл ажил хийж байна. Үүнд:

1. Хүн амын нийгмийн үзүүлэлт
 - 1.1 Хүн амын тоо /хот, хөдөөгөөр, насны бүлэг, хүйсээр/
 - 1.2 Ажилгүйдэл
 - 1.3 Ядуурал
2. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба эдийн засгийн бүтэц
 - 2.1 ДНБ-ны жилийн цэвэр өсөлт, бууралт
 - 2.2 ДНБ-ны салбарын бүтцээр
3. Хөдөө аж ахуйн салбар
 - 3.1 Малын тоо / төрлөөр /
 - 3.2 Газар тариалан / тариалсан талбай, хураасан ургац, төрлөөр /
4. Аж үйлдвэр
 - 4.1 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлвэрлэл /бүх төрлийн үйл ажиллагааны салбараар, эзлэх хувиар/
5. Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаархи судалгаа

Нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хүснэгтийн дагуу сүүлийн 5-10 жилийн тоон мэдээлэл цуглуулахаар бэлдээд байна.

Нийгмийн дэд бүтцийн чиглэлээр: Монгол улсын хэмжээнд нийгмийн дэд бүтцийн төлөвлөлт буюу боловсрол, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, соёлын байгууллага, орон сууцны хангамжийн талаарх судалгааг хийж байна.

Судалгааг 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь тоо хэмжээг нэгтгэж, харьцуулах байдлаар хийж байгаа болно.

Боловсролын салбарын судалгаа: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их дээд сургуулиудын тоо хэмжээ болон сургалтанд хамрагсад, төгсөгчдийн тоог мөн 1990/1991 он, 2005/2006 он, 2017/2018 оны байдлаар, мөн аймаг болон бүс нутаг тус бүрээр нь судалж нэгтгэсэн.

Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын байгууллага, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургуулиудыг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн гэсэн чиглэлээр тоо хэмжээг тусд нь гаргаж байна.

Эрүүл мэндийн салбарын судалгаа: Эмнэлгийн багууллага, эмнэлгийн орны тоо, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүний тоо болон 1 эмч, 1 сувилагчид ногдох хүний тоо гэсэн чиглэлээр 2000, 2010, 2018 оны байдлаар нь судалгааг гаргасан бөгөөд мөн эмнэлгийн байгууллагын тоог улсын болон хувийн гэсэн ангиллаар харьцуулан судалж байна.

Дээрх тоо хэмжээг Улаанбаатар хот болон бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж харьцуулах судалгааг хийж байна.

Орон сууцны хангамжийн судалгаа: Монгол улсын хэмжээнд орон сууцны барилгын тоо хэмжээг бусад зориулалтын буюу орон сууцны бус барилгын тоо хэмжээтэй харьцуулах, мөн орон сууцны барилгыг талбайн хэмжээгээр нь судалгааг гаргаж байна.

Дээрх тоо хэмжээг 2000, 2010, 2018 оны байдлаар Улаанбаатар хот, бүс, аймаг, сумын хэмжээнд гаргаж, харьцуулалт хийж байгаа болно. Дээрх чиглэлээр гаргасан судалгааг үндэслэн нэгдсэн харьцуулалт хийх, дүгнэлт гаргах замаар тулгамдсан асуудлууд болон тэдгээрээс гарах арга зам, төлөвлөлтийн оновчтой шийдлийг тодорхойлох зорилготой ажиллаж байгаа болно.

Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм БНБД 30-01-04-т нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний түвшингээр 2 ангилан 1000 хүнд ноогдох хэрэгцээгээр нь тухайн орон нутгийн төлөвлөлтийг хийдэг.

Хүснэгт 1. Соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний ангилал

Үнэлэх хүчин зүйлс		Үнэлэх үзүүлэлтийн шинж чанар	Нормативт үзүүлэлт
Хангамжийн ангилал			
Соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний хангамжийн түвшин	Өдөр тутмын зориулалттай барилга	Сургууль	1000 хүнд 200 сурагч
		Цэцэрлэг	1000 хүнд 100 хүүхэд
		Өрхийн эмнэлэг	35 үзлэг/өдөр
		Нийтийн хоол	1000 хүнд 40 суудал
		Ахуйн үйлчилгээ	1000 хүнд 9 ажилчин
	Тусгай зориулалттай барилга	Нэгдсэн эмнэлэг	1000 хүнд 9 ор
		Спортын барилга	1000 хүнд 80 м ² шалны талбай
		Соёлын ордон	1000 хүнд 33 суудал
		Кинотеатр	1000 хүнд 30 суудал
		Музей	1000 хүнд 30 м ² үзмэрийн талбай

Тайлбар: Үзүүлэлтүүдийг БНБД 30-010-04-өөс түүвэрлэв.

IV. БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ, НӨӨЦ

Манай орны хот байгуулалтын байгалийн нөхцөл онцлог түүнийг судлаж мэдэхгүйгээр газар сонгож авч барилгажуулан гэвэл учир дутагдалтай болох нь судалгаанаас харагдлаа. Хот суурин газрууд хот байгуулалтанд зориулсан шинжилгээ судалгаагүйгээр суурьшсанаас болоод нүүж байрлал солих оршин суугчдын тав тухтай амьдрах орчин бүрдэж чадахгүй болдог.

4.1. Газар хөдлөлт


Манай орны ихэнх нутаг дэвсгэр нь Төв Азийн Монгол байгалийн бүсэд хамаарагддаг учир газар хөдлөлт цөөнгүй тохиолдож ирлээ. Ялангуяа Монгол орны баруун, баруун хойд, өмнөд зүгийн уулархаг нутгаар газар хөдлөлт болж, тэр нвь хот суурин, барилга байгууламжинд /эвдрэл, хагарал бий болгож/ нөлөөлж, цаашид ашиглах боломжгүй болгодог. Тиймээс хот суурин, барилга байгууламжийн байршлыг сонгож авахад газар хөдлөлтийн баллыг нэг үндсэн үзүүлэлт болгож авдаг.

Газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байршдаг манай орны хувьд ийм судалгааны ажил явуулж дүгнэлт гаргах нь барилгын зураг төслийн шийдлийг боловсронгуй болгож чанартай бүтээгдэхүүн гарахд чухал ач холбогдолтой болох нь зураг төсөл боловсруулалтын өнөөгийн шаардлагаас урган гарч байна. Иймээс манай орны хот суурин, барилга байгууламжийн дэвсгэр газарт иж бүрэн дүгнэлт өгөхөд газар хөдлөлтийн балл нь тодорхой нэг хүчин зүйл болно. Дэвсгэр газрыг газар хөдлөлтийн баллын бүсэнд байрлаж байгаа байдлаар хот байгуулалтанд /нэн тохиромжтой, тохиромжтой, тохиромжгүй/ гэсэн гурван төрлийн үнэлэлтэд хамаарагдана.

6 буюу түүнээс доош баллын бүсэнд төвлөрч байгаа хот суурины дэвсгэр газрыг хот байгуулалтын хувьд /нэн тохиромжтой/ гэсэн үнэлэлтэд хамааруулна. Ийм дэвсгэр газарт барилга байгууламж барихад техник эдийн засгийн тусгай арга хэмжээ авдаггүй. Бидний судалгаагаар манай хотуудын 28%, хөдөөгийн суурингийн 30% нь 6 буюу түүнээс доош баллтай дэвсгэр газарт төвлөрч байна. 7-9 баллын газар хөдлөлттэй дэвсгэр газарт хот байгуулалтад /тохиромжтой/ гэсэн үнэлэлт өгнө. Ийм дэвсгэр газарт барилга байгууламж барихад техник эдийн засгийн тусгай арга хэмжээ авсны дараа ашиглалтын шаардлагыг хангана гэж үздэг. Манай хотуудын 72%, хөдөөгийн суурин газрын 68% нь ийм дэвсгэр газарт төвлөрчээ.


10 буюу түүнээс дээш баллын газар хөдлөлттэй дэвсгэр газарт хот байгуулалтад “Тохиромжгүй” гэсэн үнэлэлт өгнө. Манай орны ихэнх хот суурин газрууд 1961 он хүртэл инженер геологийн судалгаагүйгээр төвлөрч байсан тул дэвсгэр газар хот байгуулалтад тэр болгон тохирохгүй талууд байна. жишээ нь Хөдөөгийн суурин газрын 1,4% нь газар хөдлөлтийн хувьд тохиромжгүй дэвсгэр газарт төвлөрч байна.

Зураг 4.1. Улаанбаатар хотын газар хөдлөлийн идэвхижлийн мужлал



Улаанбаатар хотын Яармаг, Толгойт, Нисэх орчим нь газар хөдлөлийн идэвхитэй бүсэд байрлаж байна.

Газрын зураг 4.2. Газар хөдлөлийн мужлал



4.2. Цэвдэг

Монгол оронд цэвдэг судлалын судалгаа 1958 онд ШУА-ын “Цэвдэг судлалын групп” нэртэй байгуулагдаж 1960 онд “Цэвдэг судлалын төв станц”, 1962 онд Газарзүй-цэвдэг судлалын хүрээлэнгийн “Цэвдэг судлалын лаборатор”, 2015 оноос “Цэвдэг судлалын салбар” болон үйл ажиллагаа явуулж байна. ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн “Цэвдэг судлалын салбар”-ын даргаар доктор А.Дашцэрэн ажиллаж байна.

Цэвдэг судлалын хүрээлэнд Н.Лонжид, Н.Шархүү, Д.Төмөрбаатар, Я.Жамбалжав нарын үе үеийн эрхлэгчид удирдан үйл ажиллагаа явуулж байна. Монгол оронд цэвдгийн судалгааг анх 1969-1971 онд хуучнаар Зөвлөлтийн эрдэмтэн Г.Ф.Гравис тэргүүтэй эрдэмтэдтэй хамтарч “БНМАУ-ын геокриологийн зураглал” гаргаж 1:1500000 масштабтай цэвдгийн тархалтын зургийг хийсэн.

2017 оны байдлаар Монгол оронд 200 гаруй цэвдэгийн мониторингийн цэгүүдийг бий болгосноос 100 орчим цэг дээр байнга судалгаа хийж байна. 2016 онд “Монгол орны цэвдгийн тархалт”-ын зураглалыг 1:1000000 масштабтай зургийг гаргасан. Монгол оронд хийгдсэн цэвдэг тархалтын анхны судалгаанд нийт нутаг дэвсгэрийн 63% нь цэвдэгтэй гэж гарсан бол 2016 оны судалгаанд 29.3% нь цэвдэгтэй байна. Монгол орны цэвдэг нь Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсаар ихэвчлэн тархсан. Монгол орны 21 аймаг, 330 сумаас 105 сумын нутаг цэвдэгтэй бол 31 сумын төв цэвдэгтэй байна.

Байгаль цаг уурын хүчин зүйлсээс хот байгуулалтад техник эдийн засгийн хувьд харьцангуй илүү нөлөөлдөг нь цэвдэг хөрс юм. Манай орны нутаг дэвсгэрийн баруун ба хойт хэсэг дэлхийн мөнх цэвдэгт ул хөрсний өмнөл хилийг дайран өнгөрнө. Хөвсгөл, Хэнтийн уулст мөнх цэвдэг хөрс хамгийн зузаан, тухайлбал Хөвсгөл уулсын дунд байршдаг Цагаан-Уул сум орчим 140м хүрнэ. Монгол Алтайн уулсын төвийн ба баруун хэсэг, Хангай Хэндий, Хөвсгөлийн уулсын төв хэсэгт цэвдэг хөрс үргэлжилсэн байдалтай, эдгээрийн салбар уулсад алаг цоог ба ховор алаг цоог байдалтай тархжээ. Ер нь манай орны нийт нутаг дэвсгэрийн 9,4%-д үргэлжилсэн, 1,8%-д тасалданги, 10,0%-д алаг цоог, 12,3%-д ховор алаг цоог, 29,4%-д тохиолдлын шинжтэй цэвдэг хөрс тархсан байдаг. Энэ нь нийтдээ тус орны нутаг дэвсгэрийн 63%-д нь цэвдэг хөрс тархсан гэсэн үг юм.

Цэвдэг хөрсний тохиолдлын тархалттай бүсэд судалгаанд хамрагдсан хот, суурингийн 30 гаруй хувь нь төвлөрч байгаа бөгөөд эдгээрийн байршиж буй нутаг дэвсгэр газарт цэвдэг хөрс ихэвчлэн уулсын оройгоор тархсан учраас голын сав газар нам дор газар буюу уулсын хооронд байршдаг хот, сууринд бараг нөлөөлөхгүй юм. Энэ бүхнээс үндэслэн манай орны нутаг дэвсгэрийн 33,4%-ийг эзлэн тархсан бусад төрлийн цэвдэг хөрс хот байгуулалтад нөлөөлнө гэсэн дүгнэлт хийж болно.

Цэвдэг хөрсний тархалтын байдлыг хот байгуулалтад зориулан судлах нь барилга байгууламжийн байршилтын оновчтой зөв сонгон авахад ихээхэн ач холбогдолтой. Цэвдэг хөрстэй дэвсгэр газарт барьсан барилга байгууламж эвдэрч, тэнд байгаа хот сууринг ундааны усны найдвартай эх б улаггүйгээс нүүлгэн шилжүүлэх явдал гарсаар байна. хэрэв тухайн аймаг сумын нийт нутаг дэвсгэрт цэвдэг хөрс үргэлжлэн тархсан бүсэд төвлөрч байгаа бол нүүлгэх шаардлагагүй нь мэдээж. Харин алаг цоог тархалттай бүсэд байршиж буй бол инженер хайгуулын судалгаа хийж, цэвдэггүй газрыг сонгож болох талтай. Энэ дашрамд хэлэхэд хот сууринг цэвдэг хөрстэй газарт байршуулахгүй байх талаас биш, харин тийм тохиолдолд хот сууринг оновчтой төлөвлөж хөгжүүлэх эдийн засгийн үр ашигтай хувилбар боловсруулах нь манай өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болно.


Монгол орны цэвдгийн тархалтын төлөв байдал

- Үргэлжилсэн тархалттай
- Тасалданги тархалттай
- Алаг цоог тархалттай
- Тохиолдын тархалттай
- Улирлын тархалттай


Монгол орны цэвдэгтэй сумын төвүүд (31 сумын төв)

- Архангай аймаг – 4 сум: Өндөр-Улаан, Тариат, Хангай, Цахир
- Баян-Өлгий аймаг – 1 тосгон: Цагааннуур тосгон (Ногооннуур)
- Баянхонгор аймаг – 5 сум: Баянбулаг, Галуут, Гурванбулаг, Заг, Жаргалант
- Завхан аймаг – 7 сум: Нөмрөг, Отгон, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Цэцэн-Уул, Яруу
- Төв аймаг – 1 сум: Мөнгөнморьт
- Хөвсгөл аймаг – 13 сум: Арбулаг, Баянзүрх, Жаргалант, Ренчинлхүмбэ, Түнэл, Улаан-Уул, Хатгал, Хатгал тосгон (Алаг-Эрдэнэ), Ханх, Цагааннуур, Цагаан-Уул, Цагаан-Үүр, Цэцэрлэг


Газрын зураг 4.2.1. Монгол орны цэвдгийн тархалт



Газрын зураг 4.2.2. Цэвдэгтэй аймаг, сумдууд



Газрын зураг 4.2.3. Монгол орны цэвдгийн ирээдүйн прогноз



Улсын **барилга** зургийн төв институтад хийсэн судалгаанаас үзэхэд цэвдэг хөрстэй дэвсгэр газарт барьж буй хот суурины төсөвт өртөг ердийн хөрстэй дэвсгэр газарт буй хот суурингийнхтай харьцуулахад даруй 40 % хүртэл **өндөрждөг** болохыг тогтоов. Энэ нь байгалийн бусад хүчин зүйлстэй харьцуулахад цэвдэг хөрсний нөлөөлөл төсөвт өртгийг хамгийн их нэмэгдүүлдэг болохыг харуулав.

Хүснэгт 4.1. Хот суурингийн дэвсгэр газарт цэвдэг хөрс тархсан байдал

	Судалгааны хамрагдсан нийт хот суурин		Үүнээс цэвдэгт ул хөрстэй 100%		Цэвдэг хөрс тархсандэвсгэр газрын хэмжээ					
					50%-иас их		50%-иас бага			
	тоо	Дэвсгэр газар га	Тоо	га	тоо	га	тоо	га	тоо	га
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1 Архангай	19	1925	4	268	2	146	1	102	1	20
2 Баян-Өлгий	14	1465	1	40	1	40	-	-	-	-
	21	1659	2	278	3	200	-	78	-	-
	14	1373	1	12	-	-	-	-	1	12

3	19	1469	3	132	1	47	-	-	2	85
Баянхонгор	17	1829	1	33	1	33	-	-	-	-
4 Булган	10	1450	-	-	-	-	-	-	-	-
5 Говь-Алтай	15	1195	-	-	-	-	-	-	-	-
6 Дорнод	20	2345	11	1074	8	498	3	576	-	-
7 Дорноговь	12	1294	-	-	-	-	-	-	-	-
8 Дундговь	13	2023	-	-	-	-	-	-	-	-
9 Завхан	23	2085	9	555	3	210	2	120	4	225
10	16	1602	5	383	4	348	1	35	-	-
Сүхбаатар	17	1418	2	101	1	38	1	63	-	-
11 Сэлэнгэ	15	1251	-	-	-	-	-	-	-	-
12Төв	13	1602	1	59	-	-	1	59	-	-
13 Увс	18	1851	10	489	7	443	-	-	3	46
14	15	1694	2	89	1	73	-	-	1	16
Өвөрхангай	4	11035	2	724	-	-	1	640	1	84
15 Өмнөговь	4	2070	-	-	-	-	-	-	-	-
16 Ховд	2	1283	-	-	-	-	-	-	-	-
17 Хөвсгөл	301	43918	56	4237	32	2076	11	1673	13	488
18 Хэнтий	100	100	18,6	9,6	57,1	49,0	19,6	39,5	23,2	11,5
19 Улаанбаатар										
20 Дархан										
21 Эрдэнэт										
БҮГД										
ХУВЬ										

Цэвдэг хөрс хот суурины дэвсгэр газрын 60-70%-д тархсан бол төсөвт өртгийг 12-25%, 25-30 хувьд тархсан бол 1-2%-иар ихэсгэдэг болохыг эрдэмтэд тооцоолж гаргажээ.


Судалгаанаас үзэхэд тус улсын засаг захиргааны 21 нэгжийн 14-ийнх нь нутаг дэвсгэрт хот байгуулалтад нөлөөлөхүйц шинжтэй цэвдэг хөрс тархжээ. Өөрөөр хэлбэл хот байгуулалтын нийт дэвсгэр газрын 9,6% нь цэвдэг хөрстэй. Ялангуяа Завхан, Хөвсгөлийн ихээхэн нутаг дэсвэгр үргэлжилсэн цэвдэг хөрстэй учраас энэ аймгуудын хот суурин, Увс, Төв, Баянхонгор, Архангайн олон хот суурин алаг цоог тархалттай цэвдгийн бүсэд төвлөрчээ.

4.3. Барилгажилтад тохиромжтой байдлын мужлал

Улс ардын аж ахуйн янз бүрийн салбарт инженерийн барилга байгууламж барих, суурин газруудыг өргөтгөн төвхнүүлэх, хот сууринг шинээр байгуулах нь манай орны бүтээн байгуулалт өнөө үед улам улам өсөн нэмэгдсээр байна.

Барилгажилтанд зориулсан байгалийн мужлалын зургийг манай оронд анх удаа гарч байгаа бүтээл учраас ШУА-ийн Газарзүйн цэвдэг судлалын хүрээлэнгийн ажилтан, Газарзүйн ухааны доктор Ж.нацаг, эрдэм шинжилгээний ажилтан Д.Энхтайван, зөвөөхөөр газарзүйн ухааны доктор Базаргүр нар оролцсон. Манай хот байгуулалт барилга талаас автороор Т.Хоролжав, зөвлөхөөр барилгын инженер Б.Лхагвасүрэн нар оролцож, хоёр байгууллагын хамтарсан бүтээл гарсан юм. Уг зураг нь газарзүйн цэвдэг судлалын хүрээлэнгийн 1989оны 11-р сарын 29-ний өдрийн хурлын 26 дугаар тогтоолоор батлагджээ.

Газрын зураг 4.3.1. Барилгажилтад тохиромжтой байдлын мужлал



Хүснэгт 4.3.1. Мужуудын шинж чанар

Байгалийн хүчин зүйлс		Мужууд				
		I	II	III	IV	V
Уур амьсгал	Тооцооны температур (С°)	<-30 ⁰	<-30 ⁰ -35 ⁰	<-30 ⁰ -35 ⁰	<-30 ⁰ -40 ⁰	<-35 ⁰ -40 ⁰
	Харьцангуй чийгшлийн жилийн дундаж (%)	50-60	50-60	50-70	60-65	65
	1м2-д ногдох цасны жин (кг/см2)	50	50	50	70	70
	Тохиолдож болох салхины хурд (м/сек)	35	35	19-44	19-25	18-26
Мнженер-геоморфологийн нөхцөл	Гадаргын налуу /градусаар/	0-3	3-6	6-12	12-20	20
	Хэрчигдлийн шигүү (км/км2)	<1	2-3	4	5-6	>7
	Элсний нүүлт					
	Гулгалт					
Инженер геологийн нөхцөл	Уруй					
	Газар хөдлөлт /балл/	6	7	8	9	>9
	Олон жилийн цэвдэг хөрс /бий, эсэх/					
	Овойдог хөрс /бий эсэх/					
	Хөрсний ус /бий эсэх/					

	Усан хангамжийн найдвартай эх булаг /бий эсэх/	+	+	+	- +	-
Ерөнхий үзүүлэлтүүд	Уур амьсгалын бүс	IV	IIIb	IIIa	II	I
	Хотуудын байршил /%/	16	36	28	20	
	Хөдөөгийн суурин газрын байршилт /%/	12.3	21.7	34.6	28.0	3.4

Барилгажилтад зориулсан байгалийн мужлал

Нэгдүгээр муж. Нийт гадаргад ухаа гүвээ, тэгш талын хэв шинж зонхилно. Инженерийн барилга байгууламжинд нөлөөлөх байгалийн хүчин зүйлүүд болох газар хөдлөлийн балл 6, уур амьсгалын нөхцөл хүйтэвтэр хуурай, хуурайдуу, олон жилийн цэвдэг чулуулаг байхгүй, зөвхөн улирлын хөлдөлт гэсэлттэй гүний усны түвшин доор учир барилгад нөлөөлөхгүй, гадаргын хэвгий гол төлөв 0-3 градус, гадаргын хэрчигдлийн шигүү нэн бага 1км/км², уруй болон элсний нөлдөө байхгүй зэргийг харгалзан эдгээр үзүүлэлтээрээ хамгийн бага балл ногдож байгаа учраас барилгажилтанд байгалийн нөхцлийн хувьд тохиромжтой муж юм. Энэ мужийг зурагт шар өнгөөр үзүүлэв.

Хоёрдугаар муж, гадаргын хувьд цав толгодын ба бэсрэг, нам уулын хэв шинжит хотгор гүдгэр зонхилно. Инженерийн барилга байгууламжинд нөлөөлөх байгалийн хүчин зүйлүүд: газар хөдлөлийн балл 7, уур амьсгалын нөхцөл хүйтэн хуурайдуу, олон жилийн ц эвдэг чулуулаг, ховор алаг цоог тархалттай, гүний усны түвшин голтөлөв доор, гадаргын хэвгий 3-6⁰, гадаргын хэрчигдлийн шигүү 2-3км/км² байна. энэ муж барилгад нөлөөлөх голлох хүчин зүйл тухайлбал олон жилийн цэвдэг чулуулагн, уур амьсгалын нөхцөл жигд бус учраас дотроо А,Б,В дэд мужуудад ялгагдана.

А-дэд муж нь Б,В мужаас гадаргын ерөнхий төрхөөр эрс ялгагдаж бэсрэг нам уулсын хотгор гүдгэр зонхилж үүнтэй уялдаад бичил уур амьсгалын ялгаа нэлээд тод илрэх учир энэ онцлогийг харгалзах нь чухал.

Гуравдугаар муж. Энэ мужид ухаа гүвээт тал хөндий, цав толгод, нам бэсрэг уулс, дундаж өндөр уулсын хэв шинжийн хотгор гүдгэр зонхилно. Өөрөөр хэлбэл газрын гадарга жигд биш.

Барилгажилтанд нөлөөлөх хүчин зүйлийн хувьд: гназар хөдлөлийн балл 8, олон жилийн цэвдэг чулуулаг ховох алаг цоог тархалттай, уур амьсгал хүйтэн чийглэгдүү% усны түвшин доор, гадаргын налуу 6-12, хэрчигдлийн шигүү 4 км/км² байхын зэрэгцээ уруйн шер элсний нүүлт хөдөлгөөн ч багагүй бэрхшээл учруулж болох тул тэдгээрийг харгалзан үзэх шаардлагатай болно. Энэ мужид А,Б дэд мужид хуваагдана.

А-дэд муж ихэнхдээ Алтай, Хангай, Хэнтийн уулсын зах орчмын болон тэдгээрийн хаяа уулс хамрагдах учир гадаргын хувьд гол төлөв бэсрэг ба дундаж өндөр уулсын гадарга давамгайлах тул Б дэд мужаас уур амьсгалын бичил нөхцөл гадаргын хэвгий, уруйн үйл явцыг урьдчилан тооцоолж харгалзах нь чухал юм.

Дөрөвдүгээр муж. Энэ мужид ихэнхдээ дундаж ба өндөр уулсын хэв шинжит хотгор гүдгэр зонхилох тул барилгажилтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйлсийн эрч хүч, нөлөө харьцангуй их байна. үүнд газар хөдлөлийн балл 9, олон жилийн цэвдэг чулуулаг элбэг, алаг цоог, уур амьсгал нэн хүйтэн чийглэг чийглэгдүү, гадаргын хэвгий 12-20⁰, хэрчигдлийн шигүү 5-6км/км², энэ бүхэн барилгажилтанд тохиромжгүй нөхцөлийг бий болгодог байна.

Энэ муж А,Б хоёр дэд мужид хуваагдана. А муж нь харьцангуй их талбайг эзлэх бөгөөд гол төлөв уулархаг нутаг хамрагдана. Алтай, Хангайн уулархаг нутагт хот суурин газрууд гол төлөв уулын бэл хотгох хонхор, голын хэндийд байрласан байдаг. Иймд хур бороо элбэг жил гэнэтийн үер буух тохиолдол бий. Иймэрхүү байгалийн үзэгдэл тэр бүр давтагдаад байдаггүй ч 50-100 жилд 1-2 удаа тохиолддог гэнэтийн үзэгдлийг ямагт тооцоолу байх шаардлагатай юм. Мөн Б муж нь уруйн явц, элс элбэг, газар хөдлөлийн идэвхитэй бүсэд багтах учир дээрх үзүүлэлтүүдийг барилга байгууламжинд даруй онцгойлон харгалзах хэрэгтэй. Ялангуяа энэ дэд мужид барилга байгууламжийг хуурай сайраас алс, зайдуу барих нь чухал.

Тавдугаар муж. Бусад мужтай харьцуулбал харьцангуй бага талбайтай манай орны уулархаг нутгийн өөрөөр хэлбэл Монгол Алтай, Хөвсгөл, Хангай Хэндийн хамгийн өндөр төвийн хэсгийг эзэлнэ. Байгалийн нөхцөл нь барилгад нэн тохиромжгүй, газар хөдлөлийн 9-өөс дээш, олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн, гадаргын хэвгий гол төлөв 20⁰ их хэрчигдлийн шигүү 7-8 км/км², уур амьсгал хахир хүйтэн чийглэг, хахир хүйтэн чийглэгдүү нөхцөл зонхилох бөгөөдбид мөн энэ мужид гадаргын хувьд боломжтой боловч нэлэнхүйдээ цэвдэг чулуу төрхсан улирлын нөлөө ихтэй, /овойх, суух, дулаан хөндийлж үүсэх г.м/ Дархадын хотгор ихээхэн намгархаг, Тэсийн голын адаг орчмын нутгуудыг энэ мужид багтаасан болно.

Дөрөвдүгээр, тавдугаар мужид ямар ч барилга байгууламж барих нөхцөлгүй гэж үзэж болохгүй. Ихээхэн хэмжээний хөрөнгө хүчинд тулгуурлан ялангуяа уулархаг нутагт амралт, сувилалд аялал жуулчлалын зориулалттай багахан талбай эзэлсэн цөөн барилга байгууламжийг газар хөдлөлийн онцгой аюултай бүсээс бусад газар барьж болохыг дурьдах нь зүйтэй юм.

5. ХҮН АМЫН ӨСӨЛТ, СУУРЬШИЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ СУДАЛГАА

5.1. Хүн амын нутагшилт суурьшлын тогтолцооны болон хотжилтын өнөөгийн байдал

Бэлчээрийн мал аж ахуй зонхилсон, хангай, хээр, говь, тал хосолсон өргөн удам газар нутагтай, хүн амын тоо цөөн, нягтаршил бага, аж үйлдвэр сул хөгжсөн зэрэг шалтгаанаар 1950-иад оныг хүртэл хот, суурин газрын хөгжил эрчимжиж чадаагүй. Иймд Монгол Улсын хотжилтын үйл явц харьцангуй залуу бөгөөд хот байгуулах туршлага, соёл дутмаг байдаг.


Монгол Улсад хуучин ЗХУ болон бусад социалист орны техник, эдийн засгийн туслалцаатайгаар нийслэл Улаанбаатар болон бусад томоохон хот, аймгийн төвд шинэ үйлдвэрийг барьж байгуулсны үр дүнд хотжилтын үйл явц түргэссэн. Энэ үед Улаанбаатар хэд хэдэн үе шаттайгаар хаяагаа улам тэлж, Дархан, Эрдэнэт, Налайх, Багануур зэрэг аж үйлдвэр, уул уурхайн шинэ хот баригдаж, Чойбалсан, Ховд зэрэг хотын хүн амын суурьшил нэмэгджээ.

Монгол Улсын хүн ам 1918 онд 647.5 мянга байсан бол 2018 оны байдлаар 3177 мянгад хүрч, ХХ зуунд бараг дөрөв дахин өсчээ. Томоохон өсөлт нь 1960 ба 1970-аад онд болж, тухайн үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коэффициент 3.0 хувьд дөхөж, хүн ам 25 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин өссөн ажээ. Эдгээр жилүүдэд төрөлт ихтэй байсантай холбогдон сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны залуучууд олноор нэмэгдэж байна. 1990 оноос хойш улс оронд үүссэн эдийн засгийн хямралтай

холбогдон хүн амын өсөлт буурсан нь үндсэндээ төрөлтийн огцом бууралтын үр дүн байлаа.

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын үндсэн 2 хэлбэр нь хот, хөдөө бөгөөд хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй явагдаж 2017 оны байдлаар 68,7 хувьд хүрээд байна. Тодруулбал нийт хүн амын 45 хувь нийслэлд (агломераци буюу том хот дагасан), 29 хувь нь нийт 350 хот, суурин газарт (Шугаман буюу авто замын тэнхлэг дагасан), үлдэх 26 хувь нь хөдөөд (жигд буюу засаг захиргааны нэгжүүд дагасан) амьдарч байна (Зураг 9).

Зураг 5.1.1. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны өнөөгийн байдал




Хүснэгт 5.1.1 Хүн амын нутагшилт, суурьшлын байдалд хийсэн SWOT дүн шинжилгээ

<p>Давуу тал</p>	<ul style="list-style-type: none"> • Хүн амын нутагшил, суурьшил, хөдөлгөөнд тавигддаг байсан засаг захиргаа, хууль эрх эдийн засгийн хориг саад багассан • Зам тээвэр, эрчим хүчний харьцангуй сайн үндсэн сүлжээ бүрэлдсэн • Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээний дэд бүтэц бүрэлдсэн • Хүн амын нутаг дэвсгэрээр жигд тархан суурьшсан • Хүн амзүйн цонх үе нээгдсэн • Уул уурхай, үйлдвэрлэлийн хөгжлийг дагаад суурьшлын шинэ төвүүд бий болох таатай нөхцөл бүрдсэн
<p>Сөрөг тал</p>	<p><u>Хот байгуулалтын хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын хэт төвлөрөл (1 хотод нийт хүн амын 44.0 хувь), хэт сарнил (350 гаруй хот, суурин газарт нийт хүн амын 30.0 хувь амьдардаг) - Орон нутагт хүн ам, зах зээлийн зохистой төвлөрөл бүрдээгүйгээс ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн - Хөдөөнөөс төвийг чиглэсэн их нүүдлээс шалтгаалж, нийслэлд хүн амын хэт төвлөрөл үүссэнээр авто зам, ус, цахилгааны хангамж зэргээр дэд бүтцэд сөргөөр нөлөөлөх болсон. <p><u>Нийгмийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Засаг захиргааны хэт олон жижиг нэгжид хуваагдсанаар цус ойртолт зэрэг хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг - Хэдий засаг захиргааны нэгж тус бүрт эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний дэд бүтэц байгаа ч чанар, хүртээмж муу учир өртөг зардал ихтэйгээр эдгээр үйлчилгээгээр төв рүү таталцдаг. - Гадаадад 120.0 мянга гаруй монгол иргэн харьцангуй бага цалин хөлстэйгээр ажиллаж, амьдарч буй бол монголд 20.0 мянга орчим гадаадын иргэн харьцангуй өндөр цалин хөлстэй ажиллаж байна. Өөрөөр хэлбэл хүн ам, хөдөлмөрийн нөөц болон эдийн засгийн гадагш чиглэсэн урсгал харьцангуй их байна. <p><u>Эдийн засгийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, сум жижигрэх тусам 1 хүнд ногдох эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний өртөг зардал нэмэгдэж, эсрэгээр тэдгээрийн чанар, хүртээмж тааруу байна. - Төсвийн үрлэгэн тогтолцоо - Эдийн засгийн хувьд аймаг, сумд нь улсын төсвөөс бүрэн хараат байдалтай <p><u>Хууль, эрхзүйн орчны хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Сум, орон нутгийн бие даан хөгжих, нутгийн өөрөө удирдах эрхзүйн орчин маш сул - Сум, орон нутгийн байгууллагын төсвийн эрх мэдэл бага. <p><u>Экологийн хувьд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Ажиллах хүчний дийлэнх буюу 34.0 хувийг эзлэх хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг болж, энэ салбарт ажиллагсдын тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлөх болсон. - Нийт сумын тал орчим хувьд улирлын бэлчээр дутмаг. - Усны хомсдол нэмэгдэж, усны сав газрын хэмжээнд олон сумд хамрагддаг нь тэдгээрийг усны нэгдсэн менемент хийхэд сул тал болдог.

<p>Аюул занал, эрсдэл</p>	<ul style="list-style-type: none"> - Нийт хүн амын 44.0 хувь оршин суух нийслэл Улаанбаатар хотод хүрээлэн буй орчны бохирдол, дэд бүтцийн ачаалал ихэссэнээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэхэд ноцтой аюулд хүргэж байна. - Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн томоохон ордуудыг түшиглэсэн хот байгуулалтын бодлого байхгүйгээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллах, гэр бүлийн орчноос хол амьдарч байгаагаас үүдэлтэй гэр бүл салалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна. - Үйлдвэрлэлийн хөгжил, төвлөрлийг даган сүүлийн жилүүдэд нэмэгдсээр буй гадаадын ажиллах хүчний өсөлт, дотоодын ажиллах хүчний эрэлт хэрэгцээний хомсдол - Орон нутгийн хөгжлийг уясан төсвийн хараат байдал
<p>Боломж</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн амд төрийн үйлчилгээг ойр хүргэх үүднээс аймаг, сум бүр дээрхи одоогийн төрийн үйлчилгээний (эрүүл мэнд, боловсрол зэрэг) дэд бүтцийг тогтвортой ашиглах шаардлагатай. - Уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлтийг даган их хөрөнгийг үр ашигтай шингээх чадавхи бүхий шинэ хотыг төлөвлөн хөгжүүлбэл нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж чадна.


Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо алдагдсан байна. Тухайлбал нэг хүнд ногдох газар нутгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг хэрнээ нийт хүн амын нэг хотод ногдох хувиар дэлхийд тэргүүлж байна. Дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой Улаанбаатар хотод нийт улсын хүн амын 50 шахам хувь амьдарч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтойгоор нөлөөлж байна. Иймд хотыг дахин төлөвлөж хөгжүүлэхээс өмнө Монгол Улсын болон нийслэлийн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой бодлогыг боловсруулах шаардлагатай байна. 2017-2022 онд Монгол Улсын хүн ам 3.2-с 3.5 сая болж, хотын хүн ам буюу нийслэлийн хүн ам 200-300 мянгаар нэмэгдэх төлөвтэй байна. Хэдий Оюутолгой, Тавантолгой, Сайншанд, Багануурын оюутны хотхоныг түшиглэсэн нийт 160-170 мянган хотын хүн амын төвлөрөл бий болохоор төлөвлөж буй хэдий ч тэдгээрт хүн амын суурьшлын шинэ төв бий болгох талаархи алхмууд удаашралтай байна.

Зураг 5.1.2. Монгол Улсын болон дэлхийн хотжилтын түвшин



Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017

Зураг 5.1.3. Хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувиар дэлхийн улсуудтай харьцуулалт, 2017



Эх сурвалж: UN, Population Division, World population prospects 2017

Монгол Улсад 1990 оноос хойш хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж, 68,6 хувь буюу Итали, Унгар зэрэг өндөр хөгжилтэй орнуудын түвшинд хүрсэн байна. Иймд бусад өндөр хөгжилтэй орнуудын жишгийн дагуу хотуудад, ялангуяа нийслэл хотод хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах шаардлагатай. 1990-2017 онд Монгол Улсын хүн ам 2.0 саяас 3,2 сая болж, 55 хувиар, тэр дундаа хотын хүн ам 1.0 саяас 2.3 сая болж 2.3 дахин, нийслэлийн хүн ам 0.5 саяас 1.3 сая болж, 2.6 дахин ихээр өссөн байна. Үндсэндээ дээрх хугацаанд өссөн хүн ам нь нийслэлийн хүн ам болж байна. Хүн ам ихээр шилжин ирж байгаагаас Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгэм, төрийн үйлчилгээний ачаалал даац нэмэгдэж, хотын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх боллоо. Сүүлийн 20 жилд шилжин ирэгсдийн тоог аймгуудын хүн амтай харьцуулбал нийт 8 аймгийн хүн амын тоотой дүйцэхүйц 452 мянган хүн орон нутгаас Улаанбаатар хотод шилжин иржээ. Улмаар Монгол Улсын хотжилтын түвшин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрсэн.


Шилжих хөдөлгөөний онолын өөр нэг урсгал бол “хэмжээлшгүй том хот”-ын онол юм. Газарзүйч Мак Жефферсон (1939) анх удаа хэмжээлшгүй том хотын онолыг бий болгосон. Энэхүү хот нь хүн амын тоогоор бусдаасаа ядаж 2 дахин том байдаг. эдгээр хот нь ихэнхи тохиолд тухайн улсынхаа нийслэл байдаг. Жишээлбэл Францын Парис, Их Британийн Лондон, Тайландын Бангкок хотуудыг нэрлэж болно. Гэтэл хүн ам олонтой зарим хотод хэмжээлшгүй том хот байдаггүй. Тухайлбал Энэтхэгт хамгийн том хот Мумбай 16 сая хүнтэй байхад 2 дахь том хот Калькутта 13 сая хүнтэй байдаг. Мөн Хятад, Канад, Австрали, Бразил зэрэг улс оронд хэмжээлшгүй том хот байдаггүй. Хөгжиж буй улсын хувьд хэмжээлшгүй том хот нь үйлдвэржсэн хот биш ч гэсэн хүн амын тоо, дотоод зах зээл, боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг үзүүлэлтээрээ хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг зайлшгүй татдаг. Үүний нэг тод жишээ нь Улаанбаатар хот бөгөөд primate city index буюу хамгийн том хот нь 2 дахь том хотоосоо 15 дахин их хүн амтайгаар дэлхийд 1-рт орж байна. Иймд хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулахын тулд хүн амын шилжих хөдөлгөөнийг татах болон түлхэх хүчин зүйлсийг оновчтой байршуулахад анхаарах хэрэгтэй юм.

Хүснэгт 5.1.2. Дэлхийн улсуудын том хотуудын таталцлын индекс

№	Том хот	Улс	Том хотын индекс (Primate city index)	Хүн ам, мянгаар		Жилийн дун/өсөлт 2005-2018	Нийт хүн амд хотын эзлэх % 2018	PCI + нийт хүн амд том хотын эзлэх хувь
				Хамгийн том хот	2 дахь хот			
1	Улаанбаатар	Монгол	14.7	1396	95	3.89	44.4	14.7+44.4=59.1
2	Бангкок	Тайланд	22.2	5686	256	2.49	27.3	
3	Монрови	Либериа	17.9	1021	57	0.50	36.5	
4	Ломе	Того	17.5	1859	106	2.79	33.4	
5	Монтевидео	Уругвай	12.5	1304	104	0.57	42.2	

6	Минск	Беларус	12.5	1834	147	0.76	27.0	
7	Лима	Перу	11.4	9886	869	2.03	40.4	
8	Бужумбура	Бурунди	10.6	497	47	6.00	37.6	
9	Хартум	Судан	10.4	5129	492	2.54	38.3	
10	Аддис-Абеба	Этиоп	9.8	3352	343	2.06	16.8	
11	Ереван	Армен	8.8	1060	121	-0.40	55.7	
12	Конакри	Гвиней	8.5	1660	195	3.06	42.2	
13	Буэнос Айрес	Аргентин	8.4	13473	1613	1.30	39.2	
14	Абиджан	Кот Д'Ивуар	8.2	4395	536	3.15	42.1	
15	Наушот	Мавритани	8.1	958	118	3.70	39.6	
101	Хо Ши Мин	Вьетнам	2.0	7298	3629	5.19	11.6	
	Нийт том хотууд		3.9	364555	94067	2.26	30.63	


Зураг 5.1.4. Хот, хөдөөгийн хүн амын тоо, 2018 он, аймгаар



5.2. Хүн амын өсөлт, өөрчлөлт, орон зайн тархалтаар

Хүн амын тооллогын материалаас үзэхэд хүн амын жилийн дундаж өсөлт 1960-1970 онд 2.8%, 1970-1980 онд 2.9% байсан бол энэ үзүүлэлт буурч 1990-1995 онд 1.7%, 2000 онд 1.4%, 2018 онд 1.7% болов. Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлтийн жилийн дундаж хурд буурсан нь төрөлтийн бууралт, нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй. 1960-аад онд 1000 хүнд ноогдох төрөлт 43,2 байсан бол 2018 онд 24.5 болж буурав. 1960-аад оныг өнөөгийнхтэй жишихэд нэг эмэгтэйн төрүүлсэн хүүхдийн тоо 7-оос 3 болтлоо цөөрчээ. Сүүлийн жилүүдэд төрсөн эхчүүдийн насны бүлгээр судлахад 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн төрөлт, ялангуяа ахимаг насны эмэгтэйчүүдийн төрөлт огцом буурч байна. Төрөлтийн буурах шалтгааныг олон хүүхэдтэй эхчүүдэд үзүүлэх хөнгөлөлт багассан, эхчүүд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөр болсон, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг өргөнөөр сурталчлан чөлөөтэй ашиглах нөхцөл бололцоо бүрдсэн, оборт чөлөөтэй болж хүсээгүй төрөлтийг хязгаарлах боломжтой болсон, аж амьдралын түвшингийн доройтол зэргээр тайлбарлах боломжтой юм.

Зураг 5.2.1. Монгол Улсын хүн ам, тооллого явуулсан онуудаар



УИХ Хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг 1996 онд батлан гаргасан нь хүн амзүйн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал алхам болсон. Энэ бодлогод 2010-2015 он хүртэлх хугацаанд хүн амын дундаж өсөлтийг 1,8 хувиас доошгүй түвшинд хадгалж, 1990 оны түвшингээс нялхсын эндэгдлийг 1/3-ээр, эхийн эндэгдлийн 50%-иар тус тус бууруулж, хүн амын өсөлтийг хангах тухай тодорхой заалтуудыг тусгасан. Хүн амын бодлого нь цогц шинж чанартай бөгөөд хоол хүнс, орон сууцны хангамж, боловсрол, ажил эрхлэлт, хүн амын

хөдөлгөөн гэр бүл зэрэг харилцан уялдаа бүхий цогц асуудлыг авч үзээд хүүхэд, эхчүүд өндөр настны хувьд илүү анхаарлыг хандуулсан. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд хүн амзүйн судалгаа шинжилгээний ажил түүний үнэн бодит байдлыг онцгойлон авч үзэн иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээг бүрдүүлж, үйл ажиллагааг хангах талаар тодорхойлсон нь тэргүүн зэргийн ач холбогдолтой юм.

Хүн амын цэвэр өсөлтийг 2 аргаар олж болно.

1. Хүн амын төрөгсдийн тооноос нас барагсдын тоог хасаж гаргасан тодорхойлолтыг хүн амын ердийн бодит өсөлт гэнэ.
2. 1000 хүн тутамд төрөгсдийн тооноос нас баралтын тоог хасаж гаргасан тодорхойлолтыг хүн амын цэвэр өсөлтийн коэффициентийн үзүүлэлт ба хүн амын ердийн харьцангуй өсөлт гэнэ.

Монгол улсад төрөлтөөс нас баралтын тоо бага байдаг болохоор хүн амын цэвэр өсөлт жил ирэх тусам нэмэгдэж байна. Нэг жилийн төрөгсдийн дотроос нэг хүн дунджаар амьдрах жилийн тоог хүн амын дундаж наслалт гэнэ.

2018 оны эцсийн байдлаар монгол улсын хүн амын төрөлт 78444, нас баралт 17864, хүн амын ердийн бодит өсөлт 60580 байгаа ба 1000 хүн амд ноогдох төрөлт 24.5, нас баралт 5.6, цэвэр өсөлт 18.9 байна.

Мөн 2018 оны эцсийн статистикийн мэдээнээс үзэхэд хүн амын төрөлт хамгийн өндөртэй аймгуудад Баян-Өлгий, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай, Ховд /1000 хүн амд ноогдох төрөлт өндөр аймгуудад Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Ховд, Баянхонгор, Дорнод/, хүн амын төрөлт хамгийн багатай аймгуудад Говь-Сүмбэр, Дундговь, Булган, Говь-Алтай, Дорноговь /1000 хүн амд ноогдох төрөлт бага аймгуудад Булган, Сэлэнгэ, Дорноговь, Завхан, Говь-Алтай/ аймгууд орж байна.

Хүн амын нас баралт өндөртэй аймгуудад Хөвсгөл, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгууд /1000 хүн амд ноогдох нас баралт өндөр аймгуудад Төв, Дундговь, Дорнод, Булган, Өвөрхангай, Сэлэнгэ/, нас баралт хамгийн багатайд Говь-Сүмбэр, Дундговь, Говь-Алтай, Сүхбаатар, Өмнөговь /1000 хүн амд ноогдох нас багатай аймгуудад Баян-Өлгий, Говьсүмбэр, Улаанбаатар, Ховд, Орхон, Увс/, аймгууд хамаарагдана.

Хүснэгт 5.2.1. Хүн амын ердийн хөдөлгөөн 2018 он

эрэмбэ	1000 хүн амд ногдох төрөлт		эрэмбэ	1000 хүн амд ногдох нас баралт		эрэмбэ	1000 хүн амд ногдох ердийн харьцангуй өсөлт	
1	Баян-Өлгий	29.1	1	Төв	7.	1	Баян-Өлгий	24.4
2	Говьсүмбэр	28.3	2	Дундговь	6.8	2	Говьсүмбэр	23.2
3	Өмнөговь	28.1	3	Дорнод	6.7	3	Өмнөговь	22.5
4	Ховд	27.6	4	Булган	6.5	4	Ховд	22.5
5	Баянхонгор	26.1	5	Өвөрхангай	6.4	5	Баянхонгор	20.1
6	Дорнод	26.1	6	Сэлэнгэ	6.4	6	Увс	20.
7	Дундговь	25.8	7	Архангай	6.3	7	Сүхбаатар	19.6


8	Сүхбаатар	25.5	8	Хэнтий	6.2	8	Дорнод	19.4
9	Увс	25.5	9	Хөвсгөл	6.1	9	Орхон	19.2
10	Төв	24.6	10	Баянхонгор	6.	10	Дундговь	19.
Улсын дүн		24.5	11	Дорноговь	5.9	Улсын дүн		18.9
11	Орхон	24.5	12	Сүхбаатар	5.9	11	Улаанбаатар	18.8
12	Хэнтий	24.3	13	Дархан-Уул	5.9	12	Дархан-Уул	18.2
13	Дархан-Уул	24.1	14	Говь-Алтай	5.8	13	Завхан	18.1
14	Хөвсгөл	23.9	Улсын дүн		5.6	14	Хэнтий	18.1
15	Улаанбаатар	23.9	15	Өмнөговь	5.6	15	Говь-Алтай	17.8
16	Өвөрхангай	23.8	16	Завхан	5.5	16	Хөвсгөл	17.8
17	Архангай	23.7	17	Увс	5.5	17	Төв	17.6
18	Говь-Алтай	23.6	18	Орхон	5.3	18	Архангай	17.4
19	Завхан	23.5	19	Ховд	5.1	19	Өвөрхангай	17.4
20	Дорноговь	23.2	20	Улаанбаатар	5.1	20	Дорноговь	17.3
21	Сэлэнгэ	23.1	21	Говьсүмбэр	5.1	21	Сэлэнгэ	16.7
22	Булган	22.1	22	Баян-Өлгий	4.7	22	Булган	15.6

Монгол Улсын хүн амын төрөлт 1990 оноос эхлэн огцом буурсан ба 2007 оноос тогтворжиж төрөлт нэмэгдсэн. Төрөх насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин ерөнхийдөө буурч 20-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт хамгийн өндөр байна.

Хүн амын цэвэр өсөлт хамгийн өндөртэй аймгууд гэвэл Баян-Өлгий, Хөвсгөл, Өвөрхангай, Орхон, Ховд /1000 хүн амд ноогдох ердийн харьцангуй өсөлт өндөр аймгуудад Баян-Өлгий, Говьсүмбэр, Өмнөговь, Ховд, Баянхонгор/, цэвэр өсөлт багатай аймгуудад Говьсүмбэр, Дундговь, Булган, Говь-Алтай, Дорнод /1000 хүн амд ноогдох ердийн харьцангуй өсөлт бага аймгуудад Булган, Сэлэнгэ, Дорноговь, Өвөрхангай, Архангай/ аймгууд хамаарагдана.

Манай улсын оршин суугаа хүн ам 2018 оны байдлаар 3186.3 мянга болж өмнөх оноос 1.7%-иар буюу 54597 өссөн байна. Хүн амын жилийн дундаж өсөлт харьцангуй тогтворжиж 1.7 хувьтай байна.

Зураг 5.2.2. Төрсөн хүүхдийн тоо, 1957-2018 он




Хүснэгт 5.2.2. Сумдын хүн амын тооны өөрчлөлт, хүн амын тооны бүлгээр, 2001-2018 онд

Хот, сум, суурин газар	Тоо	Хүн ам, дундаж 2018	Хүн ам, нийт мянгаар		Жилийн дундаж өсөлт 2001-2018
			2001	2018	
Жижиг сум: 982-2500 хүнтэй	121	1926	269.5	233.1	-0.8%
Дундаж сум: 2501-4500 хүнтэй	132	3344	469.2	441.4	-0.3%
Том сум: 4501-10217	53	6340	302.5	336.7	0.8%
Хотууд: 12500-45000 хүнтэй	24	30454	554.0	731.0	2.0%
Улаанбаатар	1	1444600	781.2	14444.6	5.0%
Монгол Улс	331	3186300	2386.6	3186.3	1.9%

Хүн амын тоо ихтэй том сум болон хотуудад хүн амын өсөлт их, харин жижиг сум, суурин газруудад хүн амын тоо хамгийн ихээр буурсан.

Аймгийн төв болон бусад томоохон хот суурин газарт ойр орших сумдын хүн ам илүү их буурсан нь гадагш таталцал бүхий орон зайн хамаарлыг бас харуулж байна.

Газрын зураг 5.2.1. Хүн амын жилийн дундаж өсөлт, сум суурин газруудаар,
2000-2018 онд



Дэд бүтцийн гол тэнхлэгийн дагуух хот, сум, суурин газрын хүн ам илүү хурдацтай өсч байна.

Хүснэгт 5.2.3. Хүн амын тооны өөрчлөлт, мянгаар, аймаг, нийслэлээр, улсын дүнд эзлэх байраар, 1944-2040 онд

№	1944 он	1979 он	1990 он	2000 он	2010 он	2018 он	2040 он
1	Архангай 64.9	Улаанбаатар 402.3	Улаанбаатар 586.2	Улаанбаатар 794.7	Улаанбаатар 1244.4	Улаанбаатар 1491.4	Улаанбаатар 2591.8
2	Завхан 64.0	Хөвсгөл 88.3	Хөвсгөл 107.5	Хөвсгөл 118.9	Хөвсгөл 114.9	Хөвсгөл 134.0	Хөвсгөл 165.0
3	Хөвсгөл 60.5	Өвөрхангай 82.6	Төв 103.4	Өвөрхангай 111.6	Өвөрхангай 101.4	Өвөрхангай 117.1	Баян-Өлгий 146.5
4	Төв 56.4	Төв 80.6	Өвөрхангай 101.5	Сэлэнгэ 100.1	Сэлэнгэ 97.9	Сэлэнгэ 111.4	Өвөрхангай 139.1
5	Өвөрхангай 54.2	Завхан 79.8	Баян-Өлгий 99.0	Төв 97.5	Дархан-Уул 94.9	Орхон 106.0	Ховд 126.0
6	Увс 46.9	Архангай 77.5	Сэлэнгэ 92.5	Архангай 96.9	Орхон 90.9	Дархан-Уул 105.9	Орхон 115.4
7	Баянхонгор 43.0	Увс 72.2	Завхан 92.2	Баян-Өлгий 91.6	Баян-Өлгий 88.2	Баян-Өлгий 105.1	Дархан-Уул 115.1
8	Ховд 39.0	Баян-Өлгий 71.4	Архангай 89.0	Ховд 86.4	Төв 85.4	Архангай 96.7	Баянхонгор 111.1
9	Говь-Алтай 37.3	Сэлэнгэ 65.1	Увс 88.8	Увс 86.4	Архангай 84.6	Төв 95.7	Архангай 109.8
10	Булган 36.7	Баянхонгор 63.0	Дархан-Уул 86.9	Завхан 86.2	Ховд 76.8	Баянхонгор 88.4	Сэлэнгэ 108.1
11	Баян-Өлгий 36.0	Ховд 62.6	Дорнод 83.0	Дархан-Уул 85.0	Баянхонгор 76.2	Ховд 88.3	Увс 93.0
12	Хэнтий 35.5	Дорнод 58.8	Ховд 81.4	Баянхонгор 84.5	Увс 73.2	Увс 84.3	Төв 89.5
13	Сүхбаатар 31.1	Говь-Алтай 55.8	Баянхонгор 78.1	Орхон 76.5	Дорнод 69.6	Дорнод 81.0	Хэнтий 86.7
14	Дорнод 30.9	Хэнтий 52.8	Хэнтий 76.4	Дорнод 73.8	Хэнтий 65.9	Хэнтий 77.0	Дорнод 86.5
15	Дархан-Уул 30.4	Дархан-Уул 50.7	Говь-Алтай 64.7	Хэнтий 70.9	Завхан 65.4	Завхан 72.8	Өмнөговь 77.4
16	Дундговь 27.6	Сүхбаатар 43.0	Орхон 59.7	Говь-Алтай 63.1	Өмнөговь 61.6	Дорноговь 69.3	Дорноговь 77.0
17	Өмнөговь 20.3	Дорноговь 42.4	Дорноговь 59.7	Булган 61.8	Дорноговь 58.9	Өмнөговь 66.7	Сүхбаатар 76.7
18	Дорноговь 19.9	Булган 42.4	Булган 55.2	Сүхбаатар 55.5	Булган 53.7	Сүхбаатар 62.3	Завхан 76.5
19	Улаанбаатар 15.6	Дундговь 39.1	Сүхбаатар 53.2	Дорноговь 51.0	Говь-Алтай 53.5	Булган 62.2	Булган 64.2
20	Сэлэнгэ 14.0	Өмнөговь 32.9	Дундговь 51.0	Дундговь 50.6	Сүхбаатар 51.4	Говь-Алтай 58.5	Говь-Алтай 61.3
21		Орхон 32.0	Өмнөговь 43.9	Өмнөговь 47.9	Дундговь 38.7	Дундговь 46.6	Дундговь 52.2
22	Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2019.Мэдээллийн сан		Говьсүмбэр 12.3	Говьсүмбэр 13.3	Говьсүмбэр 17.8	Говьсүмбэр 27.8	

Өнгөрсөн зууны турш хүн амын тооны динамикаас харахад хөдөөгийн хүн амын тоо тогтвортой байгаа нь хөдөөд нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх хүн ам бэлчээрийн даацаас хамаараад харьцангуй тогтвортой байж ирснийг харуулж байна (Зураг 3). Харин Монгол Улсын хүн амын өсөлт нь үндсэндээ хотын хүн амын өсөлт байх хандлагатай байна. Аймагийн төв хотуудын хувьд төмөр замын тэнхлэг дагасан Эрдэнэт, Дархан, Сайншанд, Замын-Үүд, Чойр болон автозамын гол тэнхлэгүүдийг даган байршсан, автозамын гол тэнхлэгийн дагуух Налайх, Багануур, Баянхонгор, Арвайхээр хотуудын хүн ам өссөн тэнхлэгийн дагуух хот суурин газруудад нийгэм-эдийн засгийн таталцал явагдаж байгааг харуулж байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд давуу талаасаа сул тал нь илүү ихээр давамгайлсан байгаа нь өөрчлөлтийг хийх шаардлага нэгэнт тулгараад байгааг харуулж байна. Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн харилцаанд шилжсэнээр хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд нэлээд өөрчлөлт оржээ.

Хүснэгт 5.2.4. Хүн амын тоо нь хамгийн ихээр өссөн хот, сум, суурин газрууд, 2005-2017 онд

№	Хот, сум	2005	2017	Жилийн өсөлт %	Үүрэг
1	Цогтцэций	2128	7262	20.1	Уул уурхай
2	Ханбогд	2618	6682	12.9	Уул уурхай
3	Замын-Үүд	8058	17880	10.2	Гадаад худалдаа

4	Даланзадгад хот	15810	24467	4.6	Уул уурхай
5	Баруун-Урт хот	13616	20713	4.3	Засаг захиргаа
6	Улаанбаатар хот	933971	1399094	4.2	Засаг захиргаа, эдийн засаг
7	Налайх хот	26112	36668	3.4	Дагуул хот
8	Чойр хот	8971	12531	3.3	Засаг захиргаа
9	Гурвантэс	3457	4799	3.2	Уул уурхай
12	Өндөрхаан хот	16849	22465	2.8	Засаг захиргаа
13	Сайншанд хот	18473	24415	2.7	Тээврийн зангилаа, уул уурхай
14	Арвайхээр хот	23566	31090	2.7	Засаг захиргаа, тээврийн зангилаа
16	Алтанбулаг	3913	5070	2.5	Гадаад худалдаа

Сүүлийн 12 жилийн хугацаанд хүн амын тоо хамгийн ихээр өссөн хот, суурин газруудад уул уурхай дагасан Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сум, Даланзадгад хот, гадаад худалдаа хилийн боомт дагасан Замын-Үүд сум болон засаг захиргааны төв болсон Улаанбаатар, Баруун-Урт хот орж байна.

5.3. Хүн амын нас хүйсний бүтэц, дундаж наслалт

Хүн амын нас хүйсний бүтэц нь хүн амын өсөлт, хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй. Хүн амын нас хүйсний бүтцийг ажиллах хүчний нөөц, хүүхэд багачууд, өндөр настны тоог гаргаж хүнс, хэрэглээний бараа, хүн амын тоон өөрчлөлт, ирээдүйн төлөвийг тооцоолоход хэрэглэдэг. Энэ үзүүлэлт ямагт хувьсан өөрчлөгдөж байдаг нь нийгмийн үйлдвэрлэлийн хөгжил, байршилтай холбоотой. Хүн амын хүйсийн харьцааг 1918 оноос хойш тооллого явагдсан онуудаар авч үзэхэд хүйсийн харьцаа (100 эмэгтэйд ногдох эрэгтэй) аажим, аажмаар буурч байгаа бөгөөд энэ нь юуны өмнө эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү /9.7 жилээр 2018 он/ байгааг харуулдаг. Нөгөө талаар гадаадад шилжин явагсад, тэнд ажиллагсадын дунд эрэгтэйчүүд давамгайлж байгаагаас хүйсийн харьцааны бууралтад нөлөөлдөг байна.

Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаа 50.7 эм, 49.3 эр /2018/ байгаа боловч насны бүлэг аймаг, бүс нутгаар энэ ялгаа ихэсдэг. Монгол улсын амын насны бүтцийн хувьд залуужсан бүтэцтэй. Нийт хүн амын 63.8 хувь нь 35 хүртэл насны хүүхэд залуучууд, 25.4 % нь 35-54 насныхан, харин 10.8 хувь нь 55 дээш насныхан байгаагаас насны бүтэц нь харагдаж байна.



Дундаж наслалт: Төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2018 онд 70.2 жил болж өмнөх оноос 0.3 жилээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.8, эрэгтэйчүүдийнх 66.1 жил болсон байна.

Хүн амын дундаж наслалт 2000 оноос өсөх хандлагатай болж, 2000-2018 онд 7.0 жилээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5.3.1. Хүн амын дундаж наслалт, аймгаар, 2000-2018 он

Аймаг	2000	2010	2016	2017	2018
Улсын дүн	63.2	68.1	69.6	69.9	70.2
Баян-Өлгий	66.3	69.8	73.0	73.1	73.1
Говь-Алтай	61.5	66.0	69.1	69.4	70.0
Завхан	61.8	66.4	70.0	70.1	70.5
Увс	60.9	65.5	68.5	68.8	69.3
Ховд	64.1	68.8	72.6	72.6	72.7
Архангай	63.0	67.7	70.8	70.8	71.4
Баянхонгор	59.9	66.1	69.1	69.3	70.0
Булган	65.8	69.4	73.2	73.4	73.4
Орхон	63.3	67.9	71.1	71.3	71.9
Өвөрхангай	63.2	67.9	69.6	69.9	70.5
Хөвсгөл	59.1	63.6	66.0	66.2	66.7
Говьсүмбэр	66.0	69.9	73.1	73.0	73.6
Дархан-Уул	61.2	65.7	68.7	68.7	68.7
Дорноговь	62.7	67.3	70.4	70.6	71.3
Дундговь	66.6	70.2	73.5	73.6	73.9
Өмнөговь	65.0	68.5	71.7	71.9	72.3
Сэлэнгэ	64.3	68.9	72.1	72.1	72.1
Төв	65.1	69.8	72.9	72.9	72.6
Дорнод	58.0	64.0	68.6	68.8	69.4
Сүхбаатар	64.3	68.9	72.0	72.1	72.7
Хэнтий	63.4	68.0	71.8	71.8	72.4
Улаанбаатар	64.6	68.3	71.5	71.5	71.7

Зураг 5.3.1. Хүн амын дундаж наслал, 2018 он



Зураг 5.3.2. Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 1992-2018 он

Хангайн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 70.7 жил, төвийн бүсийнх 72.1 жил байгаа нь хамгийн өндөр байна. Аймгаар авч үзэхэд дундаж наслалтаар

хамгийн өндөр Дундговь /73.9/, Говьсүмбэр /73.6/ Булган /73.4/ буюу улсын дунджаас 3.2-3.7 жилээр илүү байхад Хөвсгөл /66.7/, Дархан-Уул /68.7/, Увс /69.3/, Дорнод /69.4/, Говь-Алтай /70.0/, Баянхонгор /70.0/ зэрэг аймгийнх улсын дунджаас 0.2-3.5 жилээр бага байна.

5.4. Хүн амын шилжилт хөдөлгөөн

Байгалийн нөхцөл байдал, аж үйлдвэр, тээврийн хөгжил, ашигт малтмалыг олборлох, ашиглахтай холбоотой, хүн амын байршил нягтшилд байнга өөрчлөлт гарч байдаг. Үүнтэй уялдаатайгаар хүн амын байршилд нөлөөлөх нэг хүчин зүйл бол хүн амын шилжих хөдөлгөөн юм.

Хүн амын шилжих хөдөлгөөн улс хооронд үүсэж байвал гадаад шилжилт, улс дотроо буюу засаг захиргааны аль нэгэн нэгжээс нөгөөд шилжиж байвал дотоод шилжилт гэнэ. Шилжих хөдөлгөөний улмаас хүн амын тоо болон хүн амын бүтэц, ажил эрхлэлтийн байдалд өөрчлөлт гарна. Гадаад ба дотоод шилжилтийн чиглэл нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжил, хүн амынх нь амьдралын түвшинтэй холбоотой байдаг гүн тогтолтой. Тухайлбал, хөгжиж буй орны хүн амын хувьд ажлын байр олох, өндөр хөлстэй хөдөлмөр эрхлэхээр хөгжингүй орнууд руу шилжих хөдөлгөөн үүсдэг бол мөн ийм зорилгоор дотоод шилжих хөдөлгөөн нь хөдөөгөөс хот суурин газар луу чиглэдэг.

Хүн амын өсөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлс нь хүн амын ердийн цэвэр өсөлт гадаад шилжих хөдөлгөөн байдаг. 1990-ээд онд нэгдлийг тараан, малыг хувьчлах үед хот суурингаас хөдөө рүү чиглэсэн хөдөлгөөн түр зуур үүссэн боловч 1995 оноос эргээд хөдөө орон нутгаас хот, суурин газар луу чиглэн өөрчлөгдөж өнөө хүртэл үргэлжилсээр байна.

1996 онд нийт хүн амын 31 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрөн амьдарч байсан бол 2010 онд 43.6%, 2018 онд 45.3 хувьд хүрч нэмэгдсэн нь дотоод шилжилт хэр эрчимтэй байгааг гэрчилнэ.

Дотоод шилжилтийн зонхилох урсгал баруун аймгуудаас Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хот, Сэлэнгэ, Булган аймаг руу, зүүн аймгуудаас Багануур, Бор-Өндөр зэрэг төв суурин газар луу чиглэж байна. 2010 оноос хойш стратегийн том ордуудыг ашиглах зүүн бүсээс говь руу чиглэсэн дэд бүтцийн сүлжээ барих хүнд аж үйлдвэрийн боловсруулах төвүүдийг байгуулахтай холбогдож шилжих хөдөлгөөний чиглэл эрчим өөрчлөгдөж Улаанбаатар луу чиглэсэн хүн амын хэт төвлөрөл буурна.

5.4.1. Гадаад шилжилт хөдөлгөөн


Гадаад шилжих хөдөлгөөн нэмэгдэж 1992 оноос 60 гаруй мянган казак иргэд Казакстан улсад хөдөлмөрийн гэрээтэй ажиллахаар шилжин суурьшсаны зэрэгцээ олон мянган залуучууд гадаадад гарч хөдөлмөр эрхэлж, суралцах болсон юм. Манай хүн амын гадаад шилжилт ихсэж 1990-ээд оноос эхлэн иргэдийн гадаадад чөлөөтэй зорчих эрх нээгдсэнээр нэмэгдэж эхэлжээ. Ялангуяа, АНУ болон Европын орнуудад урт, богино хугацаагаар шилжин суурьшиж ажил хөдөлмөр эрхлэгчдийн тоо олон арван мянгад хүрчээ.

2000-2019 оны хооронд Монгол Улсын харьяатаас 28203 иргэн гарсан байна. Одоогийн байдлаар дэлхийн 76 улсад 175687 иргэн амьдарч байна.

Хүснэгт 5.4.1.1. Монгол Улсын гадаад улсуудад амьдарч буй хүн амын тоо

Үзүүлэлт	2010	2015	2016	2019
Монгол Улсын хүн амын тоо	2760968	3057778	3119935	3290662
Монгол Улсын харьяат гадаадад байгаа хүн амын тоо	107140	87423	146566	175687
Улсын тоо			67	76
Нийт хүн амд эзлэх хувь	3.9	2.9	4.7	5.3
БНСУ	29534		32817	49000
АНУ	17036		25000	30000
Чех	7274		6412	
Хятад	7273		8653	10000
Япон	5401		6590	9000
ОХУ	5008		4870	
Герман	3852		4746	
Англи	3701		4200	
Франц	2859		4600	
Турк	2645		4000	
Казахстан	2512		15000	
Унгар	1615		1322	
Швейцари	1509		2000	
Австри	1346		2500	
Канад	1259		5500	
Ирланд	1124			
Энэтхэг	1116		700	

Зураг 5.4.1.1. Гадаадад амьдарч байгаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо, нийт хүн амд эзлэх хувиар, 2010-2019 онд



Монгол Улс дахь гадаад иргэдийн суурьшил

Гадаадын иргэн харьяатын газрын албан ёсны мэдээгээр 2019 оны 10-р сарын байдлаар Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин сууж буй 131 улсын нийт 28,268 иргэн байна. Байршлаар авч үзвэл 20,111 хүн Улаанбаатар хот, Дорнодод 1,568 хүн, Өмнөговь аймагт 1,409 гадаадын иргэн ажиллаж, амьдарч байна.


Монгол Улсад амьдарч буй иргэдийн оршин сууж буй хэлбэрээр авч үзвэл:

- Монгол Улсын иргэнээс төрсөн 18 хүртэлх насны хүүхэд 2,695 /Холимог гэр бүлээс төрсөн/
- Хөдөлмөр эрхлэгч болон тэдний гэр бүлийн гишүүд 11,114
- Ерөнхий боловсролын ба их, дээд сургуульд суралцагч 2,772
- Хөрөнгө оруулагч 2,989
- Цагаач болон харьяалалгүй иргэн 1,927 байна.

30 хоногоос дээш хугацааны 144 улсын иргэдэд виз олгосон бөгөөд виз олгосон тоо нь өмнөх оноос 8 хувиар өссөн дүнтэй байна. 39 орны 2,907 иргэн Монгол Улсын их, дээд сургуулиудад суралцаж байна. Голчлон МУБИС, МУИС, АШУУИС, СУИС, ХААИС-д гадаадын олон оюутан суралцаж байгаа. БНХАУ-ын 2,156 оюутан суралцаж байгаагийн 90 гаруй хувь нь Өвөрмонгол оюутан, ОХУ-аас 340 оюутан, Өмнөд Солонгосын 100 гаруй, Японоос 89 оюутан суралцаж байгаа.

Монгол Улсад гадаадын 87 улсын 9,929 иргэн хөдөлмөр эрхэлж байна. Нийтдээ 2018 онд гадаадын 8,522 иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл өгснөөс 6,993 хятад иргэн ажиллаж байна. Чиглэлээр нь авч үзвэл дийлэнх нь газрын тос болон зам гүүр барьж байна. Түүнчлэн Австралиас 216, Вьетнамаас 111, ОХУ-аас 193 иргэн хөдөлмөр эрхэлж байгаа аж.

Газрын зураг 5.4.1.2. Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд, улсаар



5.4.2. Дотоод шилжилт хөдөлгөөн

Монгол Улсад дотоод шилжих хөдөлгөөн нь өнөөдөр ч үргэлжилсээр байгаа урт удаан түүх уламжлалтай. Сүүлийн үеийн хандлагаас харахад, хөдөөнөөс хот руу, ялангуяа, нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьшиж буй өрхүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа бөгөөд энэ нь хотжилтын түвшинг нэмэгдүүлж, хөдөөгийн уугуул нутгийн зарим хэсэгт хүн амын хэт цөөрөлтийг бий болгож байна. Шилжих хөдөлгөөнөөс шалтгаалан хот, хөдөө аль алинд хүндрэл бэрхшээлүүдийг бий болгож байгаа нь улсын бодлогын нэг гол тулгамдсан асуудал болж байна. Шилжих хөдөлгөөний судалгааг 2009 онд хийсэн бөгөөд түүнээс хойш 2018 онд Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний байгууллагаас уугуул болон шилжин суурьшсан нутгийн 1,001 өрхийн 3,715 хүн амыг хамруулан Монгол Улсын хүн амын дотоод шилжилт хөдөлгөөний судалгаа хийсэн.

Шилжилт хөдөлгөөнд оролцогсад нь ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насныхан байна. Мөн шилжигчдийн боловсролын түвшин өндөр байгаа нь хот суурин газар боловсрол эзэмших боломж өндөр, дээд боловсрол эзэмших шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцдог, мөн залуу боловсон хүчинд хөдөлмөр эрхлэх өргөн сонголт хотод, ялангуяа нийслэлд илүү байдаг гэдгийг харуулж байна.




Хүн амын дотоод шилжилт хөдөлгөөнд хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн, ялангуяа, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн давамгайлж байна.

Зураг 5.4.2.1. Хүн амын шилжилт хөдөлгөөний хүчин зүйлсийн онол




Зураг 5.4.2.2. Хүн амын цэвэр шилжилт хөдөлгөөн, бүсүүдээр, 1990-2018




Зураг 5.4.2.2-д 1990 оноос хойшхи хүн амын дотоод шилжих цэвэр хөдөлгөөн (шилжин ирсэн хүн амаас шилжин явсан хүмүүсийг хассан зөрүү)–ийг таван бүсээр (нийслэл Улаанбаатарыг оруулснаар) харуулав. Энэ хугацаанд Улаанбаатар дотоод шилжигчдийг татдаг хамгийн гол бүс нутаг гэдэг нь харагдаж байгаа бөгөөд жилд дунджаар 21,000 орчим цэвэр шилжилттэй байна. Нөгөө талаас, Баруун бүс энэхүү хугацаанд хамгийн их хүнээ алдсан байгаа ба цэвэр шилжилтийн хэмжээ жилд дунджаар 8,000 байна. Сонирхолтой нь, нийслэл руу шилжин ирэх хөдөлгөөнийг хориглосноос болж 2017 онд Улаанбаатарын хувьд шилжилтийн хандлага өөрчлөгдөж албан ёсоор бүртгүүлсэн шилжин ирэгсэд эрс буурсан ч статистик бүртгэлд бүртгүүлээгүй шилжин ирэгчдийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Зураг 5.4.2.3. Хүн амын цэвэр шилжилт хөдөлгөөн, 2000-2018 онд нийт дүнгээр, мянган хүнээр, аймгуудаар



Зураг 5.4.2.4. Хүн амын цэвэр шилжилт хөдөлгөөн, 1000 хүнд ногдохоор, 2000-2018 оны дунджаар



Хүснэгт 5.4.2.1. Хүн амын шилжилт хөдөлгөөн, нийт хүнд эзлэх хувиар, 2000-2018

Аймаг	Шилжсэн хүн, 2000-2018		Хүн ам 2018	Нийт хүнд эзлэх %	
	ирсэн	явсан		Шилжин ирсэн	Шилжин явсан
Улсын дүн	914447	909835	3,238,479	28.2	28.1
Баруун бүс	49615	185800	408,979	12.1	45.4
Баян-Өлгий	4149	23541	105,090	3.9	22.4
Говь-Алтай	7290	29239	58,471	12.5	50.0
Завхан	14635	49449	72,779	20.1	67.9
Увс	9648	47491	84,309	11.4	56.3
Ховд	13893	36080	88,330	15.7	40.8
Хангайн бүс	114888	229003	604,353	19.0	37.9
Архангай	10058	38776	96,720	10.4	40.1

Баянхонгор	11452	32105	88,356	13.0	36.3
Булган	16877	28678	62,214	27.1	46.1
Орхон	50272	53620	105,987	47.4	50.6
Өвөрхангай	12888	40172	117,112	11.0	34.3
Хөвсгөл	13341	35652	133,964	10.0	26.6
Төвийн бүс	192988	264209	513,438	37.6	51.5
Говьсүмбэр	11386	10716	17,796	64.0	60.2
Дархан-Уул	51772	59760	105,923	48.9	56.4
Дорноговь	24597	24617	69,304	35.5	35.5
Дундговь	8614	26876	46,628	18.5	57.6
Өмнөговь	18360	19577	66,722	27.5	29.3
Сэлэнгэ	41114	54421	111,403	36.9	48.9
Төв	37145	68242	95,662	38.8	71.3
Зүүн бүс	39382	84961	220,334	17.9	38.6
Дорнод	12261	30871	80,984	15.1	38.1
Сүхбаатар	7779	20245	62,322	12.5	32.5
Хэнтий	19342	33845	77,028	25.1	43.9
Улаанбаатар	517574	145862	1,491,375	34.7	9.8

Дорноговь, Сэлэнгэ аймагт дотроо шилжих хөдөлгөөн илүү давамгайлж байгаа бол Улаанбаатарт байдал өөр байна. Дотоод шилжих хөдөлгөөн хол зайд явагддаг гэж үндсэндээ ойлгодог боловч шилжин суурьшигч хүн амын томоохон хэсэг нь уугуул аймаг дотроо нүүдэл суудал хийж байна. Дорноговь аймгийн хувьд, шилжигч хүн амын бараг тал хувь нь аймаг дотроо, Сэлэнгийн шилжигчдийн дөрөвний нэг орчим нь мөн аймаг дотроо тус тус шилжсэн байна. Харин нийслэл Улаанбаатарын хувьд дотоод шилжилт харьцангуй бага байна.

5.5. Угсаатны бүтэц

Манай оронд хүн амын аж ахуй эрхлэх арга ажиллагаа, зан заншил, нутаг бүрт харилцан адилгүй байдаг явдал бол тухайн нутгуудад суугаа хүн амын угсаатан ястны өвөрмөц байдлаас тодорхой хэмжээгээр шалтгаалдаг. Ястан угсаатны байршилт, нутагшилт, аж ахуйн онцлог нь засаг захиргааны нутаг дэвсгэрийн хуваарилалтанд нилээд хэмжээгээр тусгагдсан байдаг. Монголчууд хүн амын 96.1 хувийг эзэлдэг ба казахууд хүн амын 3.9%-ийг эзэлдэг. Үүнээс үзвэл Монгол улсын хүн ам нь бараг нэг үндэстнээс бүрэлдэн тогтсон юм.

“Үндэстэн нь нутаг дэвсгэр, хэл, соёл, аж ахуй, эдийн засаг, улс төрийн нэгдмэл нэг шинж дээр тулгуурлан бүрэлдэн тогтдог бөгөөд үүний дүнд үндэсний ухамсар бий болно. Хүн ам нийтлэг нэг хэлтэй байх нь нэгдмэл нэг үндэстэн байхын чухал нөхцөл байдаг” билээ.

Монгол улсад 29 угсаатан ястан оршин суудаг. Эдгээр угсаатан ястны материалын болон оюуны соёлын өвөрмөц байдал нь тэдгээрийн бүрэлдэн тогтсон түүхийн урт удаан хөгжлийн явцад үүсэн бий болжээ. Угсаатан ястан бүр оршин суугаа нутгийн байгалийн нөхцөл, нийгэм эдийн засгийн орчин нөхцөлдөө зохицуулан аж ахуйгаа эрхлэн явуулах үйлдвэрлэлийн өвөрмөц дадлага, туршлага хуримтлуулж зарим нь өвөрмөц сууц, суурин газрыг үүсгэн бий болгодог. Эдгээр өвөрмөц онцлогууд нь орчин үеийн хүн амын байршилт, эдийн засгийн амьдралд зохих хэмжээгээр нөлөөлдөг.

Манай улсын хүн амыг хэлний хувьд монгол хэлтэн, түрэг хэлтэн гэж хоёр хуваах бөгөөд монгол хэлтэнд халх, дөрвөд, буриад, баяд, урианхай, захчин, дархад, торгууд, өөлд, мянгад, барга, хотон, хамниган, үзэмчин, харчин болон бусад ястангууд, түрэг хэлтэнд казах, мончоого-урианхай, чантуу нар багтана. Хотон ястанг түрэг угсаатанд оруулдаг боловч одоо хотонгууд цөм дөрвөд, халх аялгуугаар ярих болсон, мөн тунгус манж хэлтэн гэж үздэг байсан хамниган нар цөм буриад, халх аялгуугаар ярих болсон учир монгол хэлтэнд багтаадаг. Монгол хэлтэнд багтах ястангууд тус тусын нутгийн аялгуугаар ярих боловч эдгээр аялгуунуудын үгийн үндэс бараг цөм нэг учир өөр хоорондоо хэл ярианы хувьд үл ойлголцох явдал бараг байдаггүй юм. Түрэг хэлтний олонхи төрөлх хэлээрээ ярихын зэрэгцээ ихэнх нь монгол хэлээр ярина.

Хүснэгт 5.5.1. Монгол улсын хүн амын угсаатан үндэстний бүрэлдэхүүн

/тооллого явуулсан онуудаар/

Ястан угсаатны нэр	Бүх хүн амд харьцуулсан хувь			
	1969	1979	2000	2015*
Халх	76.7	77.5	81.5	84.7
Казах	5.3	5.3	4.3	3.9
Дөрвөд	2.9	2.8	2.8	2.4
Буриад	2.5	1.9	1.7	1.3
Баяд	2.1	2.0	2.1	1.7
Дарьганга	1.7	1.5	1.3	0.9
Урианхай	1.3	1.2	1.1	0.8
Захчин	1.3	1.2	1.3	1.0
Торгууд	0.6	0.6	0.5	0.5
Өөлд	0.6	0.5	0.5	0.4
Бусад	5.0	5.5	2.8	2.4

Халх – Монголчуудаас хамгийн олон тоотой нь халхчууд бөгөөд Монгол орны бүх аймгаар нутаглах боловч Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Төв, Дорнод, Хэнтийн ихэнх сумд, Ховд аймгийн Дарви, Цэцэг, Чандмань, Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумд, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад үнэмлэхүй олонх сууж байна. Мөн Ховд аймгийн Буянт /46.8%/, Жаргалант /40.9%/, Мөст /31.9%/, Увс аймгийн

Баруунтуруун /24.7%/, Завхан /34.8%/ сумдын нутагт оршин суудаг. Халхчууд 2.6 сая байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 84.7 хувийг эзэлж байна.

Дөрвөд – Дөрвөдүүд голдуу Увс аймагт суух ба Ховд аймгийн Дөргөн сумын хүн амын /91.1%/, Мянгад /26.5%/, Баян-Өлгий аймгийн Бугат /5.4%/, Сэлэнгэ аймгийн Ерөө, Жавхлант, Орхонтуул, Түшиг сумдын /6.2-9.3%/, Булган аймгийн Баяннуур /5.2%/, Төв аймгийн Борнуур /5.2%/, Дархан-Уул аймгийн Шарын гол /5%/, Орхон аймгийн Жаргалант сумын /6.9%/ нутагт сууж байна. Мөн Улаанбаатар хотод дөрвөдүүд сууна. Дөрвөдүүд 72 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 2.4 хувийг эзэлж байна.

Баяд – Увс аймгийн Тэс, Хяргас, Малчин, Зүүнговь, Баруунтуруун, Наранбулагт амьдардаг. Мөн Улаанбаатар хот, Дархан-уул аймгийн Хонгор /10.2%/, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Баянгол, Жавхлант, Сант, Хушаат, Цагааннуур сумдын /5.6-18.7%/, Төв аймгийн Цээл /5.8%/, Булган аймгийн Бүрэгхангай /21.8%/, Баяннуур /11.5%/ зэрэг сумдад оршин сууна. Баядууд 51 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 1.7 хувийг эзэлж байна.

Буриад – Дорнод аймгийн Дашбалбар 80.9%, Баяндун 79.2%, Баян-Уул 73.1%, Цагаан-Овоо 78.7%, Хэрлэн 9.3%, Чулуунхороот 17.1%, Сэргэлэн 8.4%, Гурванзагал 5.6%, Хэнтий аймгийн Батширээт 56.4%, Биндэр 34.2%, Дадал 34.8%, Норовлин 10.8%, Төв аймгийн Мөнгөнморьт 13.9%, Хөвсгөл аймгийн Ханх 9.1%, Цагаан-Үүр 10.1%, Булган аймгийн Тэшиг 14.1%, Сэлэнгэ аймгийн Ерөө 3%, Мандал 0.6% Сүхбаатар 0.6% зэрэг сумдаар нутагладаг. Буриадууд 39 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 1.3 хувийг эзэлж байна.

Захчин - Ховдын Алтай /93.2%/, Зэрэг /95.4%/, Манхан /96.2%/, Үенч /69.4%/, Мөст /66.9%/, Жаргалант /18%/, Булган /2.8%/, Цэцэг /3.9%/ сумын нутгаар суурьшдаг. Захчингууд 30 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 1.0 хувийг эзэлж байна.

Дарьганга – Сүхбаатар аймгийн Баруун-Урт /32.1%/, Асгат 91.2%/, Баяндэлгэр /94.5%/, Дарьганга /93%/, Наран 92.5%, Онгон /87.7%/, Халзан /89.2%/, Сүхбаатар /3.7%/, Эрдэнэцагаан /1.6%/ зэрэг сумын нутгаар суурьшдаг. Улаанбаатар хот, Дорнод аймгийн Хэрлэн, Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд цөөн тоогоор оршин сууна. Дарьгангачууд 27 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.9 хувийг эзэлж байна.

Урианхай – Урианхай гэсэн нэрийн дор Алтайн урианхай, мончог урианхай, Хөвсгөлийн урианхай, цаатан нарыг хамруулдаг. *Алтайн урианхай*: Ховд голын эхээс Булган голын эх хүртэл Монгол Алтайн нурууг дагаж Баян-Өлгий, Ховд аймагт нутаглана. Тэдний хэл яриа, эд оюуны соёлын талаар зэргэлдээ байгаа захчин, торгууд, өөлдүүдээс бараг ялгаагүй. *Мончог урианхай*: Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут, Жаргалант, Баян-Өлгий аймгийн Буянт, Алтай, Булган, Алтанцөгц суманд оршин сууна. *Хөвсгөлийн урианхай*: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх сумд оршин сууж байна. Мөн Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ, Орхон аймгийн зарим сумдад оршин сууна. *Цаатан*: Хөвсгөл аймгийн Цагааннуур /25.5% буюу 466 цаатан/ суманд оршин сууна. Нийт урианхайчууд 25 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.8 хувийг эзэлж байна.

Дархад – Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ 96.5%, Баянзүрх 92.5%, Улаан-Уул 93.2%, Ханх 62.2%, Цагааннуур 63.7%, Алаг-Эрдэнэ 33.8% Мөрөн 3.6%, Арбулаг 4.9%, Түнэл 5.2%, сумын нутгаар нутагладаг. Мөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, Дорнод аймгийн

Халхгол суманд оршин сууж байна. Дархадууд 23 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.7 хувийг эзэлж байна.

Хотогойд – Хөвсгөл, Завхан аймгийн хил залгаа нутгаар сууна. Тухайлбал: Хөвсгөлийн Бүрэнтогтох 53.2%, Тосонцэнгэл 43.6%, Төмөрбулаг 51.2%, Цагаан-Уул 87.7%, Цэцэрлэг 91.2%, Завханы Тэс 8.9% сумын нутгаар нутагладаг. Мөн Мөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад оршин сууж байна. Хотогойдууд 22 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.7 хувийг эзэлж байна.

Торгууд – Ховд аймгийн Булган голын савд Булган 54%, Үенч 5.7% Жаргалант 2% суманд сууна. Мөн Улаанбаатар хот болон Дархан, Эрдэнэт хотуудад оршин сууж байна. Торгуудууд 15 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.5 хувийг эзэлж байна.

Өөлд – Архангай аймгийн Өлзийт /83.8%/, Ховд аймгийн Эрдэнэбүрэн /81.9%/, Жаргалант /10.7%/ суманд амьдардаг. Мөн Улаанбаатар хот болон Дархан, Эрдэнэт хотуудад оршин сууж байна. Өөлдүүд 13 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.4 хувийг эзэлж байна.

Хотон -Хотонгууд Увс аймгийн Тариалан /81.4%/, Улаангом /7.7%/, Наранбулаг /6.5%/, Сэлэнгэ аймгийн Цагааннуур /15.5%/, Баруунбүрэн /27.2%/ суманд бий. Мөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, зэрэг суманд оршин сууж байна. Хотонгууд 12 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.2 хувийг эзэлж байна.

Мянгад – Ховд аймгийн Мянгад /62%/, Жаргалант /5.7%/ суманд нутагладаг. Мөн цөөн тоогоор Улаанбаатар, Эрдэнэт хотуудад оршин сууж байна. Мянгадууд 6 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.2 хувийг эзэлж байна.

Тува – Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Буянт, Өлгий, Ховд аймгийн Буянт, Жаргалант, Дархан-Уул аймгийн Дархан/140-0.2%/, Орхон /290-9.2%/, Шарынгол, Хонгор, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол, Зүүнбүрэн /450 – 16.5%/, Мандал, Хушаат /148-8%/, Орхон аймгийн Баян-Өндөр /121-0.1%/, Төв аймгийн Батсүмбэр /156-2.3%/, Заамар /307-5.6%/, Лүн сум болон Улаанбаатар хотод оршин суудаг. Тувачууд 4 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.1 хувийг эзэлж байна.

Барга – Буриадуудтай ойролцоо юм. Дорнод аймгийн Хөлөнбуйр /56.7%/, Гурванзагал /22.3%/, Хэрлэн /1.1%/ зэрэг сумдад оршин сууж байна. Мөн цөөн тоогоор Улаанбаатар хотод оршин сууж байна. Баргууд 2.6 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.1 хувийг эзэлж байна.

Сартуул – Завхан аймгийн Дөрвөлжин, Завханмандал, Сантмаргац, Сонгино, Ургамал, Цэцэн уул, Эрдэнэхайрхан, Увс аймгийн Завхан сумд, Завхан аймгийн Алдархаан, Түдэвтэй, Яруу, Увсын аймгийн Завхан, Улаанбаатар хотод оршин сууна. Сартуулууд 2.2 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.1 хувийг эзэлж байна.

Үзэмчин – Дорнод аймгийн Сэргэлэн /40.1%/, Баянтүмэн 14.4%/, Хэрлэн /1.1%/, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан /2.3%/ сумын зүүн хэсгээр нутаглана. Үзэмчингүүд 2 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.1 хувийг эзэлж байна.

Хошууд – Хошууд 800 байгаа ба Ховд аймгийн Булган суманд 700 байна. Улаанбаатар хот, Дорнод, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Архангай Завхан, Увс маш цөөн тоогоор оршин сууж байна.


Хамниган – Дорнод аймгийн Баян-Уул, Дашбалбар, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Биндэр, Дадал зэрэг сумдад оршин суух ба буриадуудаас ялгагдах зүйлгүй. Хамниганчууд 413 бай

Бусад ястан – Хошууд 821, хамниган 413, Харчин 343, элжигэн 319, чантуу 204, хорчин 73, түмэд 37, халимаг 24, сөнөд 17, Монголын харьяат бус 541, Монголын харьяат гадаад 974 байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 0.12 хувийг эзэлж байна.

Казах – Монгол улсад сууж байгаа түрэг угсаатны хамгийн олон тоотой нь юм. 1940 онд Баян-Өлгий аймгийг тусгайлан байгуулсан бөгөөд казахын дийлэнхи олонх нь энэ аймагт амьдардаг. Баян-Өлгийн Буянтаас бусад сумд, Ховд аймгийн Ховд суманд дийлэнх олонхийг бүрдүүлдэг. Ховдын Булган, Үенч, Буянт, Жаргалант зэрэг сумд, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Шарынгол, Хонгор, Дархан, Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Хэнтий аймгийн Хэрлэн, Батноров, Улаанбаатар хот, Налайх дүүрэгт багагүй казах иргэд оршин сууж байна. Казахууд 119 мянга байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 3.9 хувийг эзэлж байна.


Товч дүгнэлт: 1990 оноос хойш баруун аймгуудаас төвийн бүсийн аймгууд руу шилжин нүүх нь ихэссэн. Үүний үр дүнд Сэлэнгэ аймагт */Ерөө 400, Жавхлант 138, Орхонтуул 300, Түшиг 158, Цагааннуур 217, Сайхан 228, Мандал 186, Алтанбулаг 112, Сүхбаатар 147 дөрвөд тус тус байна./* дөрвөд 2276, баяд 2948, Булган аймагт дөрвөд 326, баяд 993, Төв аймагт дөрвөд 1007, баяд 931 сууж байна. Эндээс үзэхэд хангай газрын дундаж хүн амтай дүйцэхүйц дөрвөд 1 сум, баяд 1 сумын хүн ам энэ бүс нутагт шилжин ирсэн байна.

Газрын зураг 5.5.1. Монгол Улсын хүн амын угсаатны бүтэц, 2018 он



5.6. Хүн амын хэтийн тооцоо


Зураг 5.6.1. Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, 2015-2045 он, мянгаар



Эх сурвалж: ҮСХ, Хүн амын шинэчилсэн хэтийн тооцоо 2015-2045 он

Насны бүтцийн суваргаас үзвэл хүн амын залуужсан бүтэцтэй Монгол улс 2010-2030 аад он хүртэл аажмаар өөрчлөгдсөөр дараагийн 20 жилд хөгшрөлийн бүтэцтэй болохыг судлаачид тооцоолжээ. Энэ үед нийгмийн халамж, тэтгэвэр авагчид эрс нэмэгдэж эхлэх тул одооноос анхаарч стратегийн бодлогыг боловсруулж эхэллээ.

Зураг 5.6.2. Хүн амын нас хүйсний бүтцийн суварга, 1989-2040 он



Эх сурвалж: ҮСХ, Хүн амын тооны мэдээллийн сан, 2019

6. ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЭЛ ЯДУУРЛЫН СУДАЛГАА

6.1. Хүн амын хөдөлмөрийн нөөц, ажил эрхлэлтийн байдал

Монгол орны нутаг дахь нийгмийн баялгийг бүтээгч нь хөдөлмөрчин ард түмэн юм. Нийгмийн үйлдвэрлэлд голчлон хөдөлмөрийн чадвартай хүн ам оролцдог. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд зааснаар хөдөлмөрлөх чадвартай хөдөлмөрийн насны хүн амд 16-60 насны эрэгтэй, 16-55 насны эмэгтэйчүүд ордог. Хөдөлмөрийн нөөцийг хөдөлмөрийн насны хүн амаас тахир дутуугийн группд байгаа хүний тоог хасч, 16 нас хүрээгүй боловч ажил эрхэлж байгаа хүүхдүүд, ажил эрхэлж байгаа өндөр настанг нэмж тооцно.

Хөдөлмөр эрхэлж байгаа хүн ам, хөдөлмөрийн зах зээлд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийг эдийн засгийн идэвхтэй хүн ам ба ажиллах хүч гэнэ. Ажиллах хүчний эзэмшиж байгаа мэдлэг, чадвар, мэргэжлийн түвшний хэмжээг хүмүүн капитал гэнэ.

Хөдөлмөр эрхлэлт: 2019.01.01-ний байдлаар Монгол улсад хөдөлмөрийн насны хүн ам 2226.6 мянга, үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн ам 1358.6 мянга, ажиллагчдын тоо 1253.0 мянга, ажилгүй иргэдийн тоо 105.6 мянга, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэд 25.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 7.1% байна.


Ажил хөдөлмөр эрхэлж буй нийт ажиллагчдын 41.0 хувь нь Улаанбаатар хотод, 59.0 хувь нь орон нутагт ажиллаж байгаагаас хангайн болон төвийн бүс, Улаанбаатарт нийт ажиллагчдын 79.0 хувь ногдож байгаа нь ажиллагчдын төвлөрөл төвийн бүсэд илүү байгааг харуулж байна.

Хүснэгт 6.1.1. Ажиллагчид болон төрийн албан хаагчид

Засаг захиргааны нэгж	2010	2015	2018	Төрийн албан хаагчид	Нийт ажиллагчдад ТАХ-ын эзлэх хувь	Хүн амд ажиллагчдын эзлэх хувь
Улсын дүн	1,033,708.	1,151,223.	1,253,023.	193,557	15	39.3
Баруун бүс	169,022.	166,668.	176,523.	25,338	14	43.4
Баян-Өлгий	42,115.	43,621.	48,758.	5,973	12	47.0
Говь-Алтай	28,183.	25,057.	26,896.	4,279	16	46.1
Завхан	33,194.	29,871.	31,868.	5,192	16	43.6
Увс	32,912.	35,224.	32,712.	4,658	14	39.1
Ховд	32,618.	32,895.	36,289.	5,236	14	41.0
Хангайн бүс	236,400.	248,614.	260,673.	28,995	11	43.4
Архангай	45,955.	40,207.	43,859.	4,800	11	45.7
Баянхонгор	36,297.	38,980.	41,458.	4,577	11	46.9
Булган	26,055.	27,012.	27,304.	3,665	13	44.2
Орхон	27,950.	38,307.	34,935.	4,224	12	33.8
Өвөрхангай	51,714.	51,415.	55,882.	5,226	9	47.9
Хөвсгөл	48,429.	52,693.	57,235.	6,503	11	42.6
Төвийн бүс	195,446.	189,617.	216,377.	28,072	13	42.3
Говьсүмбэр	4,954.	5,273.	6,597.	1,271	19	37.7
Дархан-Уул	34,694.	34,567.	31,526.	4,526	14	30.2
Дорноговь	24,599.	23,333.	29,679.	4,121	14	42.7
Дундговь	21,786.	20,076.	23,328.	3,066	13	49.8
Өмнөговь	23,409.	25,613.	29,681.	3,695	12	42.9
Сэлэнгэ	46,139.	35,599.	45,881.	5,969	13	42.0
Төв	39,865.	45,156.	49,685.	5,424	11	52.3
Зүүн бүс	71,956.	86,353.	86,397.	12,571	15	38.8
Дорнод	22,990.	29,155.	30,153.	4,596	15	36.6
Сүхбаатар	26,273.	26,724.	26,798.	3,466	13	42.8
Хэнтий	22,693.	30,474.	29,446.	4,509	15	37.9

Улаанбаатар	360,884.	459,971.	513,053.	98,581	19	35.5
-------------	----------	----------	----------	--------	----	------

Газрын зураг 6.1.1. Хүн амын, хөдөлмөр эрхлэлтийн байдал, аймгуудаар, 2018 он



Нийт ажиллагчдын дийлэнх нь буюу 26.7% нь хөдөө аж ахуйд, 12.6% нь аж үйлдвэрийн салбарт, 6.1% нь барилгад, 54.6% үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Эндээс харвал хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо буурах харин үйлчилгээний салбарт ажиллагсад нэмэгдсэн хандлагатай байна. Үйлчилгээний салбарт ажиллагсдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа юм.

Хүснэгт 6.1.2. Ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

№	Салбар	2016	эзлэх хувь	2017	эзлэх хувь	2018	эзлэх хувь
0	Бүгд	1,147,843.	100.0	1,238,333.	100.0	1,253,023.	100.0
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	348,487.	30.4	356,421.	28.8	334,101.	26.7
2	Уул уурхай, олборлолт	38,203.	3.3	52,017.	4.2	57,687.	4.6
3	Боловсруулах үйлдвэрлэл	86,105.	7.5	93,063.	7.5	100,805.	8.0
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	16,162.	1.4	17,458.	1.4	16,307.	1.3
6	Барилга	71,485.	6.2	70,606.	5.7	76,596.	6.1

7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	172,668.	15.0	204,472.	16.5	211,187.	16.9
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	65,931.	5.7	72,701.	5.9	73,568.	5.9
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	32,141.	2.8	36,448.	2.9	37,484.	3.0
10	Мэдээлэл, холбоо	18,132.	1.6	14,491.	1.2	14,090.	1.1
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	21,863.	1.9	24,118.	1.9	25,689.	2.1
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12,676.	1.1	12,746.	1.0	14,609.	1.2
14	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	15,042.	1.3	20,834.	1.7	18,185.	1.5
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	74,179.	6.5	82,239.	6.6	76,197.	6.1
16	Боловсрол	94,989.	8.3	98,873.	8.0	98,738.	7.9
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	40,982.	3.6	39,974.	3.2	49,462.	3.9

Ажиллагсдыг насны бүлэглэлээр авч үзвэл нийт ажиллагсдын дотор 15-19 насныхан 8,3%, 25-34 насныхан 28.1%, 35-44 насныхан 30.7%, 45-54 насныхан 24.4%, 60 ба түүнээс дээш насныхан 2.9%-ийг эзэлж байна.

Хүснэгт 6.1.3. Ажиллагчидын насны бүлэг

Насны бүлэг	2016	%	2017	%	2018	%
Улсын дүн	1,147,843.	100.0	1,238,333.	100.0	1,253,023.	100.0
15-19	16,071.	1.4	17,336.	1.4	18,715.	1.5
20-24	77,274.	6.7	78,312.	6.3	85,600.	6.8
25-29	161,645.	14.1	162,551.	13.1	154,925.	12.4
30-34	175,585.	15.3	189,620.	15.3	196,647.	15.7
35-39	183,071.	15.9	189,900.	15.3	189,838.	15.2
40-44	174,805.	15.2	195,756.	15.8	195,179.	15.6
45-49	150,851.	13.1	166,100.	13.4	172,482.	13.8
50-54	116,546.	10.2	134,172.	10.8	132,901.	10.6
55-59	59,222.	5.2	65,394.	5.3	69,923.	5.6
60-64	19,839.	1.7	24,055.	1.9	21,606.	1.7
65-69	7,615.	0.7	8,675.	0.7	8,341.	0.7
70+	5,320.	0.5	6,460.	0.5	6,866.	0.5


Нийгэм эдийн засгийн салбаруудад ихэнх нь ажиллаж байхад үйлдвэрлэлд ажиллахгүй суралцагсад бий. Нэг хэсэг нь зөвхөн амины аж ахуй дээр ажиллаж байхад

нөгөө хэсэг нь гэр зуурын ажил эрхэлдэг. Ер нь хөдөлмөрийн нөөцийг аж ахуйн салбаруудад зөв тэнцүүлэн хуваарилах нь түүний ашиглалтад зохистой нөлөөлнө. Хөдөлмөрийн нөөцийн үлэмж хэсэг нь ардын боловсрол, эрүүлийг хамгаалах болон үйлчилгээний салбарт ажилладаг. Хөдөлмөрийн нөөцийн хуваарилалт нутаг дэвсгэрээр харилцан адилгүй байдаг. Зарим нутагт хөдөлмөрийн нөөц илүүдэлтэй байхад зарим нутагт дутагдалтай байдаг. Хөдөлмөрийн нөөцийн ашиглалт нь манай орны нийгэм эдийн засаг, соёл, улс төрийн нөхцлөөс шалтгаалдаг.

Хүснэгт 6.1.4. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн статус

№	Статус	2016	2017	2018
0	Нийт	1,147,843.	1,238,333.	1,253,023.
1	Цалин хөлстэй ажиллагч	592,163.	616,823.	639,593.
2	Ажил олгогч	17,020.	12,160.	18,449.
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	180,537.	247,721.	252,002.
5	Нөхөрлөл, хоршооны гишүүн	900.	875.	536.
6	Мал аж ахуй эрхлэгч**	323,174.	322,823.	296,567.
7	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин, хөлсгүй оролцогч	33,548.	37,647.	45,327.
8	Бусад	501.	284.	549.

Зураг 6.1.1. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн статус




6.2. Ажилгүйдэл

Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувийг ажилгүйчүүдийн түвшин гэнэ.

Ажилгүйдлийн түвшин 2010 онд улсын дундаж 9.9 хувь байсан бол 2018 онд 7.8 хувь болж 2.1 пунктээр буурсан байна. Сүүлийн 3 жилд буюу 2018 оны 2016 онтой харьцуулахад эдийн засгийн бүсүүдэд 1.5-3.5 пунктээр буурсан байна.

Зураг 6.2.1. Ажилгүйдлийн түвшин, бүсээр, хувиар, 2010-2018 он



Байршлаар авч үзэхэд 2018 онд баруун бүсэд хамгийн өндөр 8.9 хувь болж улсын дунджаас 1.1 пунктээр дээгүүр байхад Хангайн бүс хамгийн бага 7.1 хувь буюу улсын дунджаас 0.7 пунктээр доогуур байна. Харин аймгаар авч үзвэл хамгийн өндөр Дархан-Уул 19.6 хувь, Орхон 12.7 хувь, Баян-өлгий 12.6 хувь, Говьсүмбэр 11.7 хувь, Хэнтий 11.3 хувь, Увс, Сүхбаатар, Ховд 0.6-2.4 пунктээр дээгүүр байна.


Харин ажилгүйдлийн түвшин хамгийн бага Төв 2.6 хувь, Завхан 4.3 хувь, Дундговь 5.0 хувь, Архангай 5.2 хувь буюу улсын дунджаас 2.6-5.2 пунктээр доогуур байна.

Хүснэгт 6.2.1. Ажилгүйдлийн түвшин, аймгаар, хувиар, 2010-2018 он

	2010	2016	2017	2018
Улсын дүн	9.9	10.0	8.8	7.8
Баруун бүс	10.1	12.1	10.7	8.9
Баян-Өлгий	2.8	9.3	12.4	12.6
Говь-Алтай	9.0	10.1	8.6	6.0
Завхан	14.8	11.4	4.4	4.3
Увс	15.0	14.2	13.0	10.2
Ховд	9.2	15.1	13.5	8.4
Хангайн бүс	11.9	10.6	9.8	7.1
Архангай	7.0	5.0	5.4	5.2
Баянхонгор	3.6	11.2	5.6	7.3
Булган	15.2	8.2	10.7	7.4
Өвөрхангай	4.9	8.9	7.6	5.3
Хөвсгөл	17.1	8.5	8.5	6.4
Орхон	25.9	22.4	23.5	12.7

Төвийн бүс	9.3	9.2	8.3	7.6
Дорноговь	15.8	9.9	6.1	5.3
Дундговь	10.1	5.1	4.4	5.
Өмнөговь	15.4	14.3	16.4	7.3
Сэлэнгэ	2.1	8.1	6.6	5.6
Төв	6.	2.7	3.2	2.6
Дархан-Уул	11.	15.4	14.2	19.6
Говьсүмбэр	14.3	18.1	7.8	11.7
Зүүн бүс	10.5	11.4	10.4	8.7
Дорнод	12.3	11.2	10.1	6.3
Сүхбаатар	13.8	9.9	10.9	8.5
Хэнтий	4.2	12.9	10.3	11.3
Улаанбаатар	8.7	9.1	7.5	7.6

Газрын зураг 6.2.1. Ажилгүйдэл 2018 он



6.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт

Бүртгэлтэй ажилгүй иргэд


2018 оны 12 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо **24964** болж өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: өмнөх оны мөн үеэс **486** хүнээр буюу **1,9** пунктээр буурсан байна

Хүснэгт 6.3.1. Бүртгэлтэй ажилгүй иргэд бүсээр байршлаар

Аймаг	2010	2015	2016	2017	2018
Улсын дүн	38250	32788	34412	25450	24964
Баруун бүс	7158	4597	5494	4977	4279
Баян-Өлгий	1140	1058	1320	1207	1050
Говь-Алтай	817	644	674	629	709
Завхан	2651	450	991	1084	897
Увс	1230	1163	994	901	632
Ховд	1320	1282	1515	1156	991
Хангайн бүс	12400	7743	8423	5435	5635
Архангай	2132	447	1017	910	913
Баянхонгор	2291	1531	1436	1259	1144
Булган	1616	467	1082	703	1081
Орхон	1748	1957	1286	960	666
Өвөрхангай	2230	1844	2524	969	899
Хөвсгөл	2383	1497	1078	634	932
Төвийн бүс	6868	5411	5711	5299	4345
Говьсүмбэр	128	166	197	320	157
Дархан-Уул	1773	1818	1925	2014	1254
Дорноговь	642	1127	1338	952	901
Дундговь	848	512	519	633	358
Өмнөговь	979	377	414	386	258
Сэлэнгэ	998	866	678	696	593
Төв	1500	545	640	298	824
Зүүн бүс	2736	2397	2796	2696	2429
Дорнод	786	1347	1375	1230	1197
Сүхбаатар	907	432	761	886	647
Хэнтий	1043	618	660	580	585
Улаанбаатар	9088	12640	11988	7043	8276
Улаанбаатар	9088	12640	11988	7043	8276

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4279 буюу 17.1 хувь нь Баруун бүсэд, 5635 буюу 22.6 хувь нь Хангайн бүсэд 4345 буюу 17.4 хувь нь Төвийн бүсэд, 2429 буюу 9.7 хувь нь Зүүн бүсэд, 8276 буюу 33.2 хувь нь Улаанбаатарт байна.


Зураг 6.3.1. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, бүсээр, хүйсээр



Бүртгэлтэй ажилгүй иргэд: насаар, хүйсээр

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 18,5 хувь буюу 4608 нь 15-24 насны, 38.2 хувь буюу 9548 нь 25-34 насны, 24,6 хувь буюу 6140 нь 35-44 насны, 14.9 хувь буюу 3717 нь 45-54 насны, 3хувь буюу 748 нь 55-59 насны, 0.8 хувь буюу 203 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.

Зураг 6.3.2. Бүртгэлтэй ажилгүй иргэн, насны бүлгээр, хүйсээр




Бүртгэлтэй ажилгүй иргэд: боловсролоор

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 277 буюу 1,1 хувь нь магистр, доктор, 7412 буюу 29,7хувь нь дипломын болон баклаврын, 1137 буюу 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 1627 буюу 6,5 хувь нь техникийн болон мэргэжлийн, 12103 буюу 48,5 хувь нь бүрэн дунд, 1572 буюу 6,3 хувь нь суурь, 539 буюу 2.2 хувь нь бага, 297 буюу 1,2 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 13222 буюу 52.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 6.3.4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролоор




Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 83.3 хувьтай байхад нийслэлд 52.7 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 66.8 хувьтай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тооцов.

Зураг 6.3.5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2016-2018 он



2018 оны 12 сард ажил олгогчдоос нийт 64478 ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 1904-өөр буюу 3 хувиар өссөн байна.

Хүснэгт 6.3.2. Ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэд

	Аймаг	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэд	Үүнээс: Эмэгтэй
	Баруун бүс	5784	5590	2593
1	Баян-Өлгий	956	996	351
2	Говь-Алтай	710	794	384
3	Завхан	1533	1281	666
4	Увс	1237	1183	550
5	Ховд	1348	1336	642
	Хангайн бүс	10258	8324	4310
6	Архангай	1143	1183	596
7	Баянхонгор	1762	1469	723
8	Булган	2491	1394	615
9	Орхон	1572	1433	863
10	Ховд	1430	1268	635
11	Хөвсгөл	1860	1577	878
	Төвийн бүс	8797	6614	3149
12	Говьсүмбэр	639	485	231
13	Дархан-Уул	1074	1011	481
14	Дорноговь	1158	1098	456
15	Дундговь	847	688	305
16	Өмнөговь	2190	998	488
17	Сэлэнгэ	1211	1213	636
18	Төв	1678	1121	552
	Зүүн бүс	4816	4198	1864
19	Дорнод	1953	1777	648
20	Сүхбаатар	1322	935	459
21	Хэнтий	1541	1486	757
	Улаанбаатар	34823	18379	9889
1	Хан-Уул	6770	2480	1402
2	Багануур	475	504	253
3	Баянзүрх	11412	3901	2137
4	Налайх	671	623	287
5	Баянгол	2719	2022	1055
6	Сүхбаатар	5121	2315	1289
7	Чингэлтэй	2832	1817	965
8	Багахангай	217	198	93

9	Сонгинохайрхан	4606	4519	2408
УЛСЫН ДҮН		64478	43105	21805


Хүснэгт 6.3.3. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар 2018 он

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо	Эзлэх хувь /%/
1	Хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуур	4711	7.3
2	Уул уурхай олборлолт	5349	8.3
3	Боловсруулах үйлдвэр	6101	9.5
4	Цахилгаан, хий, уур агааржуулалт	620	1.0
5	Усны хангамж бохир ус зайлуулах систем хог хаягдал	558	0.9
6	Барилга	6941	10.8
7	Бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ	2434	3.8
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	834	1.3
9	Зочид буудал, зоогийн газар	2017	3.1
10	Мэдээлэл холбоо	459	0.7
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1014	1.6
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	23	0.0
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	86	0.1
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1750	2.7
15	Төрийн удирдлага болон батлан хамгаалах үйл ажиллагаа	1348	2.1
16	Боловсрол	3680	5.7
17	Эрүүл мэнд, нийгмийн халамж	3605	5.6
18	Урлаг үзвэр тоглоом наадам	462	0.7
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	21946	34.0
20	Хүн хөлслөн ажиллуулдаг, өрхийн аж ахуй	485	0.8
21	Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	55	0.1
		64478	100


2018 оны 12 сарын байдлаар Ажил олгогчдоос нийт 64478 ажлын байрны захиалга ирүүлсэнээс 43105 иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт 66,8 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад

ажилд зуучлан оруулсан хүний тоо 2578 хүнээр буюу 5,6 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 6.3.6. Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар



Зураг 6.3.7. Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, насны бүлгээр




Хүснэгт 6.3.4. Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, өмчийн хэлбэрээр

Байгууллагын өмчийн хэлбэрээр	Ажилд орсон иргэдийн тоо: Бүгд	Үүнээс: Эмэгтэй	Эзлэх хувь
Төрийн өмчийн	10389	6192	24.1
Орон нутгийн өмчийн	637	289	1.5
Хувийн өмчийн	32079	15324	74.4
ДҮН	43105	21805	100

Монгол Улсад хөдөлмөр эрхлэж буй 95 улсын 4502 гадаадын иргэд байна. Үүнийг байршлаар нь авч үзвэл 55.7% хувь буюу 2507 иргэн нь хөдөө орон нутагт 44.3% хувь буюу 1995 иргэн Улаанбаатар хотод ажиллаж байна. Мөн улсаар нь авч үзэхэд БНХАУ, Австрали, ОХУ болон АНУ-аас хамгийн их ажилчид байна.


Газрын зураг 6.3.1. Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд, аймгаар



6.4. Ядуурал

Ажилгүйдлийн түвшин өндөр байна гэдэг нь нийгмийн хуримтлал багасаж, үйлдвэрлэл эдийн засгийн хөгжил хоцрогдож, ядуурал нэмэгдэж байгааг харуулдаг. Ядуурлын түвшин 2010 онд 38.8 хувь болж, 2003 онтой харьцуулахад 2.7 пунктээр нэмэгдсэн байна. Хэдийгээр ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь болж, 2010 оноос 17.2 пунктээр буурсан боловч 2018 онд 28.4 хувь болж 2014 оноос 6.8 пунктээр өсчээ.


Зураг 6.4.1. Ядуурлын хамралтын хүрээ, бүсээр, 2003-2018 он




Судалгааны дүнгээс харахад төвийн бүс ядууралд бага өртөж байхад 2010 онд хангайн болон баруун бүсэд ядуурлын түвшин өсөж, хүн амын талаас илүү хувь нь ядуу байсан.

Улаанбаатар болон төвийн бүсэд 2018 онд ядуурал хамгийн бага буюу улсын дунджаас 2.3-4.5 хувиар доогуур буюу нийт хүн амын 24.9-26.1 хувь нь ядуу байхад баруун, хангайн болон зүүн бүсэд ядуурлын түвшин хамгийн их буюу улсын дунджаас 2.4-9.0 хувиар дээгүүр буюу нийт хүн амын 30.8-37.4 хувь нь ядуу байна.


Зураг 6.4.2. Ядуурлын хамралтын хүрээ, нийт хүнд эзлэх хувиар, хот хөдөөгөөр, 1995-2018



Зураг 6.4.3. Ядуурлын хамралтын хүрээ, суурьшлын хэлбэрээр, 1995-2018



Газрын зураг 6.4.1. Ядуурлын зураг, аймгуудаар 2018 он



Аймгаар авч үзэхэд баруун бүсээс Баян-Өлгий аймаг ядуурлын түвшин бага буюу 24.3 хувь, бусад 4 аймгаас Говь-Алтай аймагт ядуурал хамгийн их буюу 45.1 хувь байна. Хангайн бүсээс Орхон аймаг ядуурлын түвшин бага буюу 25.1 хувь, Архангай аймагт ядуурал хамгийн их буюу 38.2 хувь байна. Төвийн бүсээс Өмнөговь аймаг ядуурал бага буюу 11.8 хувь, харин Говьсүмбэр аймагт ядуурал хамгийн их буюу 51.9 хувь байна. Зүүн бүсээс Сүхбаатар аймаг ядуурал бага буюу 30.2 хувь, харин Дорнод аймагт ядуурал хамгийн их буюу 42.5 хувь байна.

Улсын хэмжээнд нийт аймгуудын ядуурлын түвшинг харвал Өмнөговь, Төв, Дундговь, Дорноговь, Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Завхан аймгууд болон Улаанбаатар хотын хамралтын хүрээ нь улсын дунджаас доогуур байна.


7. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ХУВААРИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улс бүр өөрийн газар нутаг, нийгэм, соёл, эрхзүйн системд нийцүүлсэн орон нутгийн хуваарь, түүний удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг. Засаг захиргааны нэгж бол өөрийн харьяалах нутгийн дор оршин амьдарч буй иргэн, өрхийг бүртгэх, нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, хүрээлэн буй орчныг хамтран хамгаалах, төрийн ажил үйлсэд иргэдийг татан оролцуулах чиг үүрэгтэй анхдагч нэгж юм.

Монгол Улсын Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулах бөгөөд баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн гэж тус тус заасан байдаг. Монгол Улс нь 2019 оны байдлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн хувьд нийслэл, 21 аймаг, 330 сум, 9 дүүргээс бүрдэж байна.


7.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн түүхэн өөрчлөлтүүд

Газрын зураг 7.1.1. 1911-1919 оны Монгол Улсын засаг захиргааны хуваарь




Манжийн эрхшээлд байсан хугацаанд Монголын засаг захиргааны хуваарь нь босоо тэнхлэгийн дагуу дахь Засагт хан, Сайн ноён хан, Түшээт хан, Сэцэн хан гэсэн 4 аймаг, 70-80 орчим хошуудаас бүрдэж байсан бөгөөд аймаг хошуудын нэр нь ноёд, түшмэдийн нэрнээс бүрдэж байсан.

Газрын зураг 7.1.2. 1924-1929 оны Монгол Улсын засаг захиргааны хуваарь



1924-1929 онд Монгол Улсын засаг захиргааны хуваарь нь хуучин Манжийн үеийн хуваарийн зохион байгуулалтыг үндсэнд нь хадгалсан ч аймаг, сумдын нэрийг уулын нэрээр нэрлэж босоо тэнхлэгийн дагууд 5 аймаг болон Дарьганга хошуунаас бүрдэж байсан.


Газрын зураг 7.1.3. 1931-1939 оны Монгол Улсын засаг захиргааны хуваарь



Ардын хувьсгал ялсны дараагаар 1931 онд засаг захиргааны бүтцийн хувьд томоохон өөрчлөлт гарч, хүн амд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээг 1 өдрийн хугацаанд сумын иргэдэд мориор явж хүрэх бололцоогоор нийт 13 аймаг, 340 гаруй сумдаас бүрдүүлж жижиглэн хуваасан бөгөөд аймаг, сумдын нэрсийг уул, ус, газрын нэр болон газарзүйн байршлаар нэрлэсэн.


1950-1970 онд нэгдэлжих хөдөлгөөн өрнөж, газар тариалан болон мал аж ахуйн олон сангийн аж ахуйнуудыг байгуулж, тэдгээрийг түшиглэн олон сум, суурин газруудыг байгуулсан.

Газрын зураг 7.1.4. 1961-1994 оны Монгол Улсын засаг захиргааны хуваарь




1960-аад оноос аж үйлдвэржих хөдөлгөөн эрчимтэй өрнөж, зарим жижиг сум, суурин газруудыг нэгтгэж, аж үйлдвэр, уул уурхайн төв Дархан, Эрдэнэт хотууд болон төмөр замын босоо тэнхлэгийн дагууд шинээр үүссэн өртөө суурин газруудад сумдыг шинээр байгуулсан.

Газрын зураг 7.1.5. 1994-2019 оны Монгол Улсын засаг захиргааны хуваарь



Монгол Улс 1990-ээд оноос зах зээлийн харилцаанд шилжиж, шинэ Үндсэн хуулиндаа засаг захиргааны хувьд нийслэл, аймаг, сум, дүүрэг, баг, хорооноос бүрдэнэ гэж заасны дагуу хотын статусын асуудал тодорхойгүй болж, орон нутгийн хотууд нь сумдад харьяалагдах болж, 21 аймаг, 330 сумаас бүрдэх болсон.

Зураг 7.1.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн өөрчлөлтүүдийн тоо, 1911-2019 он




Өнгөрсөн 100 жилийн хугацаан дахь өөрчлөлтийг аваад үзвэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед аж үйлдвэржилт, нэгдэлжих хөдөлгөөн, газар тариалангийн үйлдвэрлэл болон дэд бүтэц, уул уурхайн үйлдвэрлэлийг дагаад хот, аймаг, сумын түвшний өөрчлөлтүүд, тухайлбал шинээр байгуулах, татан буулгах, нэгтгэх зэрэг өөрчлөлтүүд шуурхай хийгдэж ирсэн бөгөөд түүний дагуу аймгууд болон хотуудын хүн амын тоо хурдацтайгаар өөрчлөгдөж ирсэн.

Харин 1990 онд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш хүн амын нутагшилт суурьшлын тогтолцоонд томоохон өөрчлөлт гарч, шилжилт хөдөлгөөн эрчимжсэн хэдий ч засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд үндсэндээ өөрчлөлт хийгдээгүй байна. Иймд нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулж, орон нутагт хүн амын зохистой төвлөрөл, зах зээл бий болгох, орон нутгийн хотуудын хөгжлийг дэмжих үүднээс нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт болон хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөн болон зарим сум, тосгодын эдийн засгийн чиг үүрэг нь өөрчлөгдсөн зэрэгтэй уялдуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг үе шаттайгаар өөрчлөн зохион байгуулах шаардлагатай байна.


7.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн харьцуулсан судалгаа

Дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын засаг захиргааны нэгжүүдийн түвшин хооронд шалгуур үзүүлэлтүүдийн босго утганы хамаарал төдийлөн байхгүй байна. Тухайлбал аймгуудын 1 суманд ногдох дундаж хүн амын тоо нь Орхон, Завхан аймгийн хооронд 17 дахины зөрүүтэй байна.

Зураг 7.2.1. Аймгуудын 1 суманд ногдох дундаж хүн амын тоо, 2017 он




Зураг 7.2.2. Аймгуудын 1 багт ногдох дундаж хүн амын тоо, 2018 он



Аймгуудын нэг багт ногдох хүн амын тооны зөрүү мөн Орхон болон Завхан аймгийн хооронд 7 дахины зөрүүтэй байна.

Зураг 7.2.3. Улаанбаатар хотын дүүргийн хүн амын тоо, 2018 он




Нийслэлийн засаг захиргааны нэгжүүдийн хүрээнд ч хэт зөрүү байсаар байна. Тухайлбал Баянзүрх дүүргийн Багахангай дүүргийн хүн амын тооны зөрүү бараг 100 дахин зөрүүтэй байна. Ийнхүү засаг захиргааны нэгжүүдийн нэг түвшин дэх хүн ам, газар нутгийн хэт зөрүүтэй байдал нь нэг талаар иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний хэт ачааллыг нэмэгдүүлж байгаа бол нөгөө талаар ачаалал хэт бага нэгжүүдэд төсвийн үрэлгэн зардлыг нэмэгдүүлж байна.

Засаг захиргааны нэгжүүдээр хүн амын тоо ихээхэн ялгаатайгаас болж төрийн үйлчилгээний чанар, хүртээмж ихээхэн ялгаатай байна.

Тухайлбал Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн амын тоо өөр хоорондоо 82 дахин их, хороодын хүн амын тоо 35 дахин их, аймгийн хүн амын тоо 8 дахин их, багийн хүн амын тоо 50 дахин ихээр хоорондоо зөрүүтэй байна. Түүнчлэн засаг захиргааны нэгжүүд, хот суурин газруудын ангиллын тодорхой шалгуур үзүүлэлтүүд байхгүйгээс болж хүн амын тоогоор сумаас том баг, аймгаас том сум, дүүргээс том хороо, хотоос тосгон байсаар байна. Үүнээс хамаарч боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны үйлчилгээний чанар хүртээмж сул байна. Учир нь хэт цөөн хүнтэй засаг захиргааны нэгжид чадавхитай боловсон хүчин дутагдалтай байгаагаас болж үйлчилгээний чанар муу байгаа бол хүн амын тоо хэт их нэгжид төрийн үйлчилгээний хүртээмж сул байна.


Зураг 7.2.4. Улаанбаатар хотын дүүргүүдийн 1 хороонд ногдох хүн амын дундаж тоо, 2018 он



Зураг 7.2.5. Улаанбаатар хотын хамгийн олон болон цөөн хүн амтай 10 хороодын хүн амын тоо, 2017 он




Зураг 7.2.6. Сумдын хүн амын тоогоорх ангилал



Засаг захиргааны нэгжүүдийн хүн амын тооны ангиллын дагуу дахь хүн амын өсөлтийн төлөвөөс харахад хүн ам ихтэй аймаг, сумдын хүн амын илүү их өндөр өсөлттэй байгаа нь хүн амын төвлөрөл, зах зээлийн багтаамжийг дагаж, орон нутагт хүн амын төвлөрөл нэмэгдэж байгааг харуулж байна. Харин хүн амын тоо цөөнтэй аймаг, сумдын хүн ам өнгөрсөн 18 жилийн хугацаанд буурсан болон хамгийн бага өсөлттэй байгаа нь тэдгээр жижиг нэгжүүдийн хүн ам нийгэм эдийн засгийн хувьд томоохон хот, аймаг, сумдын төвүүд рүү таталцаж байгааг харуулж байна.

Зураг 7.2.7. Хот, сумдын хүн амын тоогоорх ангилал болон хүн амын өсөлт, 2000-2018 онд



8. ХОТЫН ЗЭРЭГЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТАЛААРХИ СУДАЛГАА

8.1. Эрхзүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага

“Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 3.3-д “Хотод улсын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал, аймгийн зэрэглэл тогтоох асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өргөн мэдүүлснээр Засгийн газар тус тус шийдвэрлэнэ”, мөн “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай” хуулийн 3.1.1-д “Бүсийн хөгжлийн тулгуур төв гэж тухайн бүсийг гадаад, дотоод зах зээлтэй холбоход байгаль, эдийн засгийн нөхцөлийн хувьд тохиромжтой байрласан улсын зэрэглэлтэй хотыг” гэж тус тус заасан. Гэвч дээрх хууль эрх зүйн баримт бичгүүд батлагдснаас хойш хотуудад “улсын зэрэглэл” тогтоох асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэсэнгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу бүх аймгийн төв болон 15,000-аас дээш хүн амтай газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг боловсруулах” гэж тусгасан. Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд зарим хотуудыг “улсын зэрэглэл”-тэй хот болгох боломжийг судлаж байна.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн сонгодог оршихуй бол хот юм. Хотжилт нь эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай байдаг. Дэлхий дээр хотжилт буюу хотын бөөгнөрлийг төлөвлөн хөгжүүлж буй олон жишиг бий. Тухайлбал, Хятад улс 19 бүс нутагт кластер буюу хотын бөөгнөрлийг төлөвлөн хөгжүүлж байна. Харин манай улс албан ёсоор ганцхан хоттой бөгөөд дэлхий ертөнцийн хотжилт эрчимтэй хөгжиж байгаа XXI зуунд “хот” гэсэн статусыг орхигдуулаад байна. Аливаа юм нэрнээсээ эхлээд мөн чанартайгаа дүйж байх ёстой. Хуулиар хотынхоо хэм хэмжээг доош нь хийн жижигрүүлснээр ямар дэвшил гарав гэдгийг эргэцүүлэх цаг болсон. Өнөөдөр Орхон аймгийн Баян-Өндөр сум буюу Эрдэнэт хот нь 98 мянга гаруй хүн амтай, хот байгуулалтын дэд бүтэц бүрэн хөгжсөн боловч 900 гаруй хүн амтай Завхан аймгийн Асгат сумтай статусыг хувьд ижил байгаа нь хууль, эрх зүйн тогтолцоо ямар их алдаатай болохыг харуулна. Монгол Улс доорх хууль болон УИХ-ын тогтоолуудаар хотын статус байхгүй болоод байна. Дараах эрх зүйн баримт бичгүүдээс үзвэл “хот” гэсэн ойлголт нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод л хамааралтай болсон.

Өнөөгийн түвшинд “хот”-ын статусыг дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд байхгүй болгосон. Одоогоор аймгийн төвүүд нь бүгд сум болсон бөгөөд Монгол орон засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн дагуу 21 аймаг, 330 суманд хуваагдаж байна.

- Үндсэн хуулийн 13.1-д “Монгол Улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот мөн”
- Үндсэн хуулийн 57.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд: аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”
- 1994 оны УИХ-ын 33-р тогтоолоор уламжлалт 18 аймгийн төвүүдийг, УИХ-ын 32-р тогтоолоор Дархан, Эрдэнэт, Чойр хотуудыг сум болгон өөрчилсөн.


- “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 3.1.2-д “Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн” гэж заасан.

**“Зарим хотуудад улсын зэрэглэл” тогтоохтой холбогдсон
хууль эрх зүйн баримт бичгүүд**


Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоохтой холбогдуулан эш татаж буй хууль, эрх зүйн баримт бичгүүд:

- Монгол Улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.21.1-д “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу бүх аймгийн төв болон 15,000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг боловсруулах”
- “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 3.1-д “Хот нь 15,000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн”
- Мөн хуулийн 4.1-д “Хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна”
- Мөн хуулийн 4.2-д “50,000-аас дээш /шаардлагатай гэж үзвэл 50,000 хүртэл/ оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно”
- “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай” хуулийн 3.1.1-д “Бүсийн хөгжлийн тулгуур төв гэж тухайн бүсийг гадаад, дотоод зах зээлтэй холбоход байгаль, эдийн засгийн нөхцөлийн хувьд тохиромжтой байрласан улсын зэрэглэлтэй хотыг” гэсэн заалт
- УИХ-ын 2003 оны 1 дүгээр тогтоол “Монгол Улсын эдийн засгийн үндсэн бүсүүдийн хүрээнд нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах чиг үүрэгтэй Ховд, Улиастай, Эрдэнэт, Хархорин, Дархан, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан хотуудыг бүсийн тулгуур төв хотууд байхаар шийдвэрлэсэн”

Газрын зураг 8.1.1. Хотуудын зэрэглэлийг тогтоох талаархи санал, ЖАЙКА төслийн саналыг харгалзсанаар



Газрын зураг 8.1.2. Хотуудын нийгэм-эдийн таталцал, агломерацийн хүрээ



Хүснэгт 8.1.1. Монгол Улсад хотууд байгуулагдсан он дараалал

Хугацаа	Байгуулагдсан он	Хотууд	Хотын тоо	Нийт хүн ам	Хүн амын өсөлтийн хувь	Хотжилтын түвшин
2010-2019	-	-	0	3238	+26%	69%
2000-2010	-	-		2761		69%
1992-2000	-	-		2403		57.2%
1980-1991	1991	Чойр	4	2158	+26%	53.9%
	1984	Хөтөл				
	1981	Бор-Өндөр				
	1980	Багануур				
1971-1979	1978	Шарын гол	3	1595	+25%	36%
	1975	Хатгал				
	1975	Эрдэнэт				
1961-1970	1963	Тосонцэнгэл	18	1197	+17%	25.3%
	1963	Баянхонгор, Арвайхээр				
	1962	Налайх				
	1961	Аймгийн төвүүд 11+ Зүүнхараа, Зүүнбаян				
1950-1960	1961	Дархан	3	1017	+13%	15.2%
	1960	Чойбалсан				
	1956	Зүүнхараа				
1935-1949	1956	Сүхбаатар	0	845	+12%	3.2%
	-	-				
1911-1934	1911	Нийслэл Улаанбаатар	1	647		

2018 оны Үндэсний Статистикийн Хорооноос нийт хүн амын 68% буюу 2.3 сая орчим нь хот, суурин газар амьдарч байна. Монгол оронд Улаанбаатар хотоос гадна 10,000-аас дээш хүн амтай 24 сумын төв байгаагаас Дархан, Эрдэнэт 85,000-аас дээш хүн амтай байна. Аймгийн төвийн бус Мандал, Замын-Үүд, Хархорин сумдууд 10,000 давсан хүн амтай байгаа ба Мандал сум аймгийн төв Сүхбаатар хотоос их хүн амтай байна.

Хүснэгт 8.1.2. Хотуудын хүн амын тоогоорх ангилал

№	Хотжилтын түвшин	Тоо	Хот (хүн ам 2018 оны байдлаар)
1	1,000,000-аас дээш	1	Улаанбаатар хот (1.4 сая)
2	100,000-1,000,000	-	
3	50,000-100,000	2	Эрдэнэт (98,652), Дархан (85,502)
4	20,000-50,000	14	Чойбалсан (46,031), Мөрөн (39,957), Өлгий (36,024), Арвайхээр (31,917), Баянхонгор (31,308), Улаангом (31,279), Ховд (30,068), Зүүнхараа (27,201), Даланзадгад (25,430) Сайншанд (25,023), Өндөрхаан (23,316), Сүхбаатар (23,031), Цэцэрлэг (21,879), Баруун-Урт (21,300)

5	10,000-20,000	8	Алтай (18,700), Замын-Үүд (18,586), Зуунмод (17,116), Улиастай (16,481), Мандалговь (15,635), Чойр (12,742), Булган (12,599), Хархорин (12,508)
	Нийт	25	Хотын хүн ам 2.2 сая буюу нийт хүн амын 68%


Хүснэгт 8.1.3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгээр улс, аймгийн чанартай байгаа хотууд

№	Хотууд	Эрх зүйн баримт бичиг	
Улсын зэрэглэлтэй хотууд			
1	Дархан	1962 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 152-р тогтоол	
2	Эрдэнэт	1975 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн 266-р тогтоол	
3	Чойр	1991 оны УБХ-ын 46-р тогтоол	
Аймгийн зэрэглэлтэй хотууд			
4	Чойбалсан	1994 оны ЗГ-ын 128-р тогтоол	
5	Мөрөн		
6	Өлгий		
7	Арвайхээр		
8	Ховд		
9	Улаангом		
10	Баянхонгор		
11	Даланзадгад		
12	Сайншанд		
13	Өндөрхаан		
14	Сүхбаатар		
15	Цэцэрлэг		
16	Баруун-Урт		
17	Алтай		
18	Зуунмод		
19	Улиастай		
20	Булган		
21	Мандалговь		
22	Зүүнхараа/Мандал Сэлэнгэ		–
23	Хархорин – Өвөрхангай		
24	Хөтөл/ Сайхан – Сэлэнгэ		
25	Хэрлэн/ Бор-Өндөр Хэнтий		–
26	Бэрх – Хэнтий		

Статистикийн Үндэсний Хорооны 2018 оны хүн амын судалгаанаас үзвэл нийслэл Улаанбаатар хотод 1.4 сая хүн аж төрж байгаа бол 21 аймгийн төв, 10 гаруй тосгонд 680 гаруй мянган хүн амьдарч байна. Улсын хэмжээнд хотжилт 67 орчим хувьтай байгаа ба нийт хүн амын 2.1 сая хүн Улаанбаатар хот, аймгийн төв, бусад тосгонд аж төрж байна. Үлдсэн 30 гаруй хувь нь хөдөөгийн суманд амьдарч байгаа ажээ. Улсын хэмжээнд Хотжилтын түвшин Хангайн бүс болон Төвийн бүсэд хамгийн өндөр байгаа бол Зүүн бүсэд хүн амын 5% нь хотод амьдарч байна.

8.2. Улсын зэрэглэлтэй хотод горилогч хотууд

Улсын хэмжээнд 1991 он хүртэл Дархан, Эрдэнэт, Чойр гэсэн “улсын зэрэглэлтэй” хотууд байсан бол энэ удаагийн санал асуулгаар Чойр хотыг хасч, бүсийн тулгуур төв болон хүн амын өсөлт, нийгэм-эдийн засгийн таталцал, хөгжлийн нөөц, чадавхи, стратегийн ач холбогдол зэргийг харгалзан Эрдэнэт, Дархан, Чойбалсан Ховд, Мөрөн болон Замын-Үүдийг “улсын зэрэглэлтэй” хот болгох, үлдсэн 16 аймгийн төв болон Сэлэнгэ аймгийн Мандал (Зүүнхараа), Өвөрхангай аймгийн Хархорин, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Завхан аймгийн Тосонцэнгэл, Ховд аймгийн Булган, Дархан-Уул аймгийн Шарын гол, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 6-р баг Хатгал тосгоныг “аймгийн зэрэглэлтэй” хотоор тодорхойлохоор санал болгож байна.



Хүснэгт 8.2.1. Улсын зэрэглэлтэй хотод санал болгож буй хотуудын газарзүйн байрлал, дэд бүтцийн давуу тал

№	Хотууд	Хүн ам (2018 он)	2000-2018 оны хүн амын өсөлт	Тайлбар
1	Эрдэнэт	98,652	Эрдэнэт хотын хүн ам 2001 онд 72,681 байсан бол 2018 оны байдлаар 98,652 болж 25,971 хүнээр нэмэгдсэн. Хүн амын тоо нь 35.7 хувиар өсчээ.	Эдийн засгийн Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хот нь Монгол орны төдийгүй Ази тивийн томоохон уул, уурхайн район юм. Төмөр зам болон хатуу хучилттай авто замаар Улаанбаатар хот болон Ази-Европыг холбосон босоо тэнхлэгтэй холбогддог нь тус хотын давуу тал юм. Үүнээс гадна Монгол орны баруун бүсийн Мөрөн, Улаангом чиглэлийн авто замын тэнхлэгт оршино. Эрдэнэт хот анх байгуулагдсан цагаас хойш хүн ам нь тогтмол өсөлттэй байгаа ба сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 12.6% хүрчээ.
2	Дархан	85,502	Дархан хотын хүн ам 2001 онд 67,519 байсан бол 2018 онд 85,502 болж	Хуучин Социалист 5 орны хамтарсан тусламжаар сүндэрлэн боссон Монгол орны аж үйлдвэрийн томоохон зангилаа хот бол Дархан хот юм. Хүнд, хөнгөн аж үйлдвэр мөн газар тариалан эрчимтэй хөгжиж буй Дархан хот нь Ази-Европыг холбосон авто болон төмөр замын гол зангилаа болдог нь тус

			17,983 хүнээр нэмэгдсэн. Хүн ам нь 18 жилийн хугацаанд 26.6%-иар өссөн байна.	хотын газарзүйн байрлалын давуу байдлыг бий болгож байдаг. Төвийн бүсийн тулгуур төв Дархан хот бол Улаанбаатар, Эрдэнэт хотуудын дараа орох том хот бөгөөд хүн ам нь 2003 онд 70,000, 2015 онд 80,000 давсан. 2003-2015 оны хооронд 12 жилийн хугацаанд 14.5%-иар өссөн бол 2015 оноос хойш 3 жилийн хугацаанд хүн ам нь 6.4%-иар өсөж 85,502 хүрчээ.
4	Чойбалсан	46,031	Чойбалсан хот 2001 онд 38,343 хүнтэй байсан бол 2018 онд 46,031 болж 7,688 хүнээр нэмэгдсэн. 18 жилийн хугацаанд 20%-иар өссөн.	Чойбалсан хот нь ЭЗ-н Зүүн бүсийн тулгуур төв , ЗБЭХС-ийн гол зангилаа болдог. Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто зам болон агаарын замаар холбогдоно. Чойбалсан хотын Баянтүмэн өртөөнөөс вагоноор ОХУ-ын Соловьёвсктой, агаарын тээврээр БНХАУ-ын Хайлар хоттой холбогдохоос гадна ОХУ-тай, БНХАУ-ын хилийн тус бүр 2 боомтоор холбогдоно. Чойбалсан хотын хүн ам сүүлийн 5 жил 13.1%-иар өссөн байна. Ялангуяа 2010 оноос хойш эрчимтэй өсөж байна.
5	Мөрөн	39,957	Мөрөн хот 2001 онд 27,819 хүнтэй байсан бол 2018 онд 39,957 хүнтэй болж 12,138 хүнээр нэмэгдэв. Өнгөрсөн 18 жилийн хугацаанд 43.6%-иар өсчээ.	Хангайн бүсийн томоохон хот Хөвсгөл аймгийн Мөрөн хот нь хэвтээ чиглэлийн авто замаар төвийн бүс болон баруун бүсийн аймгуудтай, агаарын замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Хөвсгөл аймаг бол манай орны аялал жуулчлалын гол цэгүүдийн нэг бөгөөд Хөвсгөл нуур болон Дархад нутгийг зорих гадаад, дотоодын жуулчид заавал Мөрөн хотоор дайрна. Мөрөн хотын хүн ам 2012, 2013 онд 30,000-аас доош орсон бол сүүлийн 5 жил хүн ам нь 9.7%-иар өсөж 40 орчим мянгад хүрээд байна.
6	Ховд	30,068	Ховд хотын хүн ам 2001 онд 25,717 байсан бол 2018 онд 30,068 болж 4,351 хүнээр нэмэгдсэн. Өнгөрсөн 18 жил хүн ам нь 16.9%-иар өссөн.	330 гаруй жилийн түүхтэй Ховд хот нь олон үндэстний төв мөн ЭЗ-ийн Баруун бүсийн тулгуур төв хот юм. Улаанбаатар хот руу агаарын болон авто замаар холбогдоно. “Булган” болон “Байтаг” авто боомтоор БНХАУ-тай шууд холбогдох боломжтой. Ховд хотын хүн Улистай хотын адилаар 2000 оноос хойш тогтворгүй байсан ба 2005-2009 оны хооронд бууралттай байсан бол 2009 оноос хойш тогтмол өсөлттэй байна. 2018 онд хүн ам нь анх удаагаа 30,000 давсан бөгөөд 14.6%-н өсөлттэй байгаа.
7	Замын-Үүд	18,586	Хүн амын өсөлт хамгийн эрчимтэй байгаа сум бол Замын-Үүд юм. 2001 онд 6,408 хүн бүртгэгдсэн бол 2018 онд	Сүүлийн жилүүдэд хил орчмын худалдааг даган эрчимтэй хөгжиж байгаа суурин бол Замын-Үүд юм. Замын-Үүд нь Ази-Европыг холбосон босоо тэнхлэгийн авто болон төмөр замын Монгол орны өмнөд хаалга болно. Хүн амын өсөлттэй уялдан инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон сууцны бүтээн байгуулалтын ажил өрнөж байна. 1960-аад онд 1,000

			18,586 болж 18 жилийн хугацаанд 12,178 хүнээр буюу 190 гаруй хувиар өсчээ.	гаруй хүн амтай хилийн суурин байсан Замын-Үүдэн хүн ам 50-иад жилийн дараа 2008 онд 10 дахин нэмэгдэж 10,000 хүрсэн. Харин 2008 оноос хойш 10 жилийн хугацаанд 71.1%-иар хүн ам нь өсөж 18.586-д хүрчээ.
--	--	--	--	---

“Улсын зэрэглэлтэй хот” байгуулснаар гарах үр дүн

- Нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын төвлөрлийг сааруулж, шилжилт хөдөлгөөнийг багасгана.
- Иргэдийн орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрлөн, төрийн үйлчилгээг хурдан шуурхай авах боломжтой болно.
- Хот өөрийгөө хөгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, хөрөнгийн сантай болж, хотын аж ахуй бүрдсэнээр оршин суугчдад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.
- Хотуудын бие даасан нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэх нөхцөл бүрдэж, хотуудын улс, бүс, аймагтаа гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэнэ.
- “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуульд заасны дагуу хотын удирдлагын үндсэн зарчим, удирдлагын тогтолцоог бүрдүүлж ажиллуулна.
- Олон улсын жишгийн дагуу хотыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хотжилтыг дагасан эдийн засгийн эерэг үр дагавар гарна.

8.3. Аймгийн зэрэглэлтэй хотод горилогч хотууд



Хүснэгт 8.3.1. “Аймгийн зэрэглэлтэй хот”-д горилогч хотуудын чиг үүрэг ба газарзүй, нийгэм-эдийн засгийн зарим үзүүлэлтүүд

Чиг үүрэг	Хүн ам	Тайлбар
-----------	--------	---------

		(2018 он)	
Засаг захиргаа, үйлчилгээ давамгайлсан			
1	Өлгий	36,024	<p>Монгол орны баруун захад орших Өлгий хот нь агаарын болон авто замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Өлгий хотоос Ховд, Алтай хотын чиглэлд хатуу хучилттай авто замаар холбогдох бол Улаангом хоттой сайжруулсан шороон замаар холбогдож байна. Үүнээс гадна Цагааннуурын чиглэлээр авто замаар ОХУ, “Даян” авто боомтоор БНХАУ-тай шууд холбогдоно.</p> <p>Монгол оронд аж төрөн суугаа Казах түмний төв Өлгий хот нь манай орны хамгийн их хүн амтай хотын төвүүдийн нэг бөгөөд Баруун бүсийн хамгийн олон хүн амтай аймаг, хамгийн олон хүн амтай хот юм. 2014 онд анх удаагаа 30,000-аас дээш хүн амтай болсон Өлгий хотын хүн ам сүүлийн 5 жил 19.4%-иар өсөөд байна.</p>
2	Арвайхээр	31,917	<p>Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хот нь Хангайн нурууны өврөөр явах авто замын хэвтээ тэнхлэгийн зангилаа хот юм. Эрчим хүчний хувьд ТЭХС-д холбогдсон.</p> <p>Арвайхээр хотын хүн ам 2000 оноос хойш тогтмол өсөлттэй байгаа ба сүүлийн 5 жилийн дундаж өсөлт нь 11.4%-тай байна.</p>
3	Баянхонгор	31,308	<p>Хонгор нутгийн төв Баянхонгор хот нь Хангайн нурууны өврөөр баруун бүстэй холбогдох авто замын гол тэнхлэг дээр оршдог. Баянхонгороос Алтай хотын хоорон дахь хатуу хучилттай авто зам ашиглалтанд орвол баруун аймаг болон Улаанбаатар хоттой шууд хатуу хучилттай авто замаар холбогдоно.</p> <p>Баянхонгор хотын хүн ам 2005-2007 онд бага зэрэг буурсныг эс тооцвол тогтмол өсөлттэй байна. Сүүлийн 5 жил 11.4%-н өсөлттэй байна. 2017 онд Баянхонгор хотын хүн ам түүхэндээ анх удаагаа 30,000-г давсан.</p>
4	Улаангом	31,279	<p>Улаанбаатар хотоос 1,500 км-н алс баруун хязгаар нутагт орших Увс аймгийн төв Улаангом хот нь хатуу хучилттай авто зам болон агаарын замаар Улаанбаатар хоттой холбогдож байна. Мөн хилийн “Боршоо” болон “Тэс”-ийн хилийн боомтоор ОХУ-тай шууд холбогдоно.</p> <p>Улаангом хотын хүн ам 2008 оноос хойш тогтвортой 2012 оноос эрчимтэй нэмэгдэж байна. Тэр дундаа сүүлийн 5 жил маш эрчимтэй өсөж 19.2%-д хүрчээ.</p>
5	Өндөрхаан	23,316	<p>ЭЗ-ийн Зүүн бүсийн тулгуур төвийн нэг Өндөрхаан хот нь зүүн бүсийн авто замын зангилаа бөгөөд Улаанбаатар хот болон Зүүн бүсийн Чойбалсан, Баруун-Урт хотуудтай хатуу хучилттай авто замаар холбогдоно. ТЭХС-д холбогдсон.</p> <p>Өндөрхаан хотын хүн ам 2008 оноос тогтмол өсөлттэй байгаа бөгөөд сүүлийн 5 жил 18.9%-ийн өсөлттэй байна.</p>
6	Цэцэрлэг	21,879	<p>Эрдэнэбулган буюу Цэцэрлэг хот нь баруун бүсийн авто замын тэнхлэгт оршдог давуу талтай бөгөөд хатуу хучилттай замаар баруун аймгууд болон Улаанбаатар хоттой холбогдоно.</p> <p>Цэцэрлэг хотын хүн ам 2000 оноос 2009 он хүртэл бага зэрэг бууралттай байсан бол 2009 оноос хойш тогтмол өсөж байна. Тэр дундаа сүүлийн 5 жил хүн амын өсөлт нь 9.4%-тай байна.</p>

7	Баруун-Урт	21,300	<p>ЭЗ-ийн Зүүн бүсэд багтах Баруун-Урт хот нь хатуу хучилттай авто замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Эрдэнэцагаан сумын нутаг дахь “Бичиг” боомтоор БНХАУ-тай холбогддог. Баруун-Урт хот ЗБЭХС-д холбогдсон.</p> <p>Баруун-Урт хотын хүн ам 2005 оноос хойш тогтмол өсөлттэй байгаа бөгөөд сүүлийн сүүлийн 5 жилийн статистикаас үзвэл 18.3%-н өсөлттэй байна.</p>
8	Алтай	18,700	<p>Монгол орны хамгийн өндөрт орших аймгийн төв Алтай хот нь авто замаар Улаанбаатар болон Ховд, Өлгий хотуудтай холбогдоно. Ойрын 1-2 жилдээ Алтай – Баянхонгор хотын чиглэлийн хатуу хучилттай авто зам ашиглалтанд орвол баруун бүс болон Улаанбаатар хоттой шууд хатуу хучилттай авто замаар холбогдох бол “Бургастай” авто боомтоор БНХАУ-тай холбогдоно.</p> <p>Алтай хот бол баруун 5 аймгийн Өлгий хотоос бусад 4 хотын адил хүн амын өсөлт нь тогтворгүй байна. 2004-2009 оны хооронд хүн ам нь 13%-иар буурсан бол 2009 оноос хойш хүн амын өсөлт тогтворжиж сүүлийн 5 жилд 2.1%-ийн өсөлттэй байгаа ч энэ нь улсын хэмжээнд хамгийн бага өсөлт юм.</p>
9	Зуунмод	17,166	<p>Зуунмод хот нь Улаанбаатар хотоос 40 гаруй км-н зайд орших бөгөөд энэ нь тус хотын нийгэм-эдийн засаг, дэд бүтцийн давуу байдлыг бий болгодог.</p> <p>Төвийн бүсийн тулгуур төв Зуунмод хотын хүн ам нь 2000 онд 14,600 байсан бол 2007 онд 13,670 болж буурсан. Түүнээс хойш тогтмол өсөлттэй байгаа ба сүүлийн 5 жил 11.3%-иар өссөн байна.</p>
10	Улиастай	16,481	<p>Хангайн нурууны баруун талд орших Баруун бүсийн тулгуур төв Улиастай хот нь Улаанбаатар хоттой агаарын тээвэр болон хэвтээ чиглэлийн хатуу хучилттай авто замаар холбогдоно. Эрчим хүчний хувьд Алтай-Улиастайн эрчим хүчний системд холбогдсон байдаг.</p> <p>Улиастай хотын хүн амын өсөлт сүүлийн 18 жил тогтворгүй байсан. Өөрөөр хэлбэл, хүн амын шилжилт хөдөлгөөн 2005 он хүртэл эрчимтэй явагдсан бөгөөд 2001 онд 16,111 байсан бол 2005 онд 14,754 болж буурсан байна. Харин 2013 оноос хойш тогтвортой өсөлттэй байгаа ба 2018 онд хүн ам нь 2003 оноос хойш хамгийн өндөр буюу 16,481 хүртгэгдсэн. Сүүлийн 5 жил 9.6%-иар өссөн дүнтэй байна.</p>
11	Мандалговь	15,635	<p>ЭЗ-ийн Төвийн бүсэд багтах Мандалговь хот нь Улаанбаатар – Даланзадгадын хатуу хучилттай авто замын зангилаа болно.</p> <p>Дундговь аймгийн төв Сайнцагаан сум буюу Мандалговь хот нь 2000 оноос 2011 он хүртэл хүн амын бууралттай байсан бол 2011-2018 оны хооронд 11,230-аас 15,635 болж нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жил 22.1%-иар өссөн нь улсын хэмжээнд Чойр хотын дараа орох өндөр үзүүлэлт болоод байна.</p>
12	Чойр	12,742	<p>Чойр хотод 1991 оны УБХ-ын 46-р тогтоолоор “Улсын зэрэглэл” тогтоосон байдаг.</p> <p>Чойр хот нь Ази-Европыг холбосон авто болон төмөр замын зангилаа хот юм. Зам харилцааг давуу талаа болгосон Чойр хотын хүн ам 2015 онд анх удаагаа 10,000 давсан ба сүүлийн 5 жил 102.4 хувийн өсөлттэй байгаа нь</p>

			улсын хэмжээнд нийт аймгийн төвүүдийн хүн амын өсөлтөөс хамгийн өндөр үзүүлэлт болоод байна.
13	Булган	12,599	Булган хот нь Улаанбаатар – Мөрөн – Улаангомын чиглэлийн хатуу хучилттай авто замын зангилаа юм. Манай улсын хамгийн цөөн хүн амтай хот Булганы хүн ам хамгийн удаашралттай өсөлттэй байна. Сүүлийн 5 жилийн дунджаар 7.6%-н өсөлттэй байгаа нь бусад аймгийн төвүүдээс хамгийн бага өсөлттэй хот болж байна.
Уул уурхай, үйлчилгээ давамгайлсан			
14	Даланзадгад	25,430	Монгол орны хамгийн том газар нутагтай Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдох бол хилийн “Шивээ хүрэн”, “Гашуун сухайт” боомтуудаар БНХАУ-тай шууд холбогдоно. Өмнөговь аймагт уул уурхай, аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа нь Даланзадгад хотын хөгжлийн ирээдүйн давуу талыг бий болгож байгаа. Даланзадгад хотын хүн ам 1980 онд 10,000 хүрсэн бол 2010 онд 20,000 хүрсэн. Хотын хүн ам нь 30 жилийн хугацаанд 10,000-аар нэмэгдсэн бол сүүлийн 8 жилийн хугацаанд 5,000 хүнээр нэмэгдээд байна. Цаашид ч энэ тоо уул уурхай, аялал жуулчлал, хил орчмын худалдааг даган өсөх болно. Сүүлийн 5 жилд 8.7%-иар хүн ам нь өссөн дүнтэй байна.
15	Сайншанд	25,023	Манай орны ирээдүйн аж үйлдвэрийн цогцолбор болон хөгжих Сайншанд хот нь Ази-Европыг холбосон төмөр зам болон авто замын тэнхлэгт оршдог нь газарзүйн давуу талыг бий болгодог. Тээврийн хөгжлөөс гадна ТЭХС-д холбогдсон байдал нь найдвартай дэд бүтцийг бий болгож байна. Хотын хүн амын тогтвортой өсөлттэй ба сүүлийн 5 жил 12.6%-н өсөлттэй байна.
16	Бор-Өндөр	8,959	Жоншны үйлдвэрлэлийн хамгийн том район Бор-Өндөр нь төмөр замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Инженерийн дэд бүтэцтэй барилга, байгууламжтай. 1970-аад оны эхэн үеэс жоншны уурхайн бүтээн байгуулалт өрнөснөөр суурин бий болсон бөгөөд хүн ам нь тогтмол өсөлттэй байна.
17	Шарын гол	8,127	Эрчим хүчний төвийн бүсийг нүүрсээр хангах гол цэг бол Шарын голын уурхай юм. Шарын голын уурхай нь инженерийн барилга байгууламж, орон сууцны хороололтой. Төмөр зам болон шороон замаар Улаанбаатар хоттой холбогдоно. Хагас зуун жилийн хугацаанд томоохон суурин болон хөгжөөд буй Шарын голын хүн ам тогтворгүй байна. 2001 онд 8,539 хүнтэй байсан бол 2006 онд 7,480 болтол буурсан. Буцаад 2012 онд 8,456 болсон ч 2015 онд буурч 8,071 болсон. 2018 оны байдлаар 8,127 хүнтэй байна.
18	Ханбогд	7,804	Сүүлийн жилүүдэд манай орны Говийн бүс нутаг уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд Оюутолгой, Таван толгойн уурхайг дагасан шинэ бүтээн байгуулалт өрнөж байгаа ба ирээдүйд Өмнөговь Ханбогд, Цогтцэцийд хүн амын суурьшил бий болж байна. Ялангуяа Таван толгойн уурхайг дагасан хот сүндэрлэх нь бодит ажил болоод байна. Агаарын тээвэр болон авто замаар Улаанбаатар хоттой,
19	Цогтцэций	7,692	

			<p>“Гашуун сухайт”, “Шивээ хүрэн” боомтоор БНХАУ-тай шууд холбогдох давуу талтай.</p> <p>Ханбогд, Цогтцэцийд хүн амын өсөлт эрчимтэй явагдаж байна. 2010 оноос хойш дээрх 2 сумын хүн ам эрчимтэй өсөж байна.</p>
Хөнгөн үйлдвэр, үйлчилгээ давамгайлсан			
20	Мандал/ Зүүнхараа	27,801	<p>Манай орны аймгийн төвийн биш сумдаас хамгийн их хүн амтай сум нь хуучин нэрээр Зүүнхараа буюу Мандал сум юм. Аймгийн төв Сүхбаатар хотоос 4,000 гаруй хүнээр их хүн амтай Зүүнхараа хот нь манай орны хөнгөн, хүнсний үйлдвэрийн томоохон төв юм. Үүнээс гадна төмөр замаар Ази-Европтой холбогдох бол авто замаар төвийн бүстэй холбогдоно.</p> <p>Зүүнхараа хотын хүн ам 2004-2009 онд бага зэрэг бууралттай байсан бол 2009 оноос хойш тогтвортой өсөж байгаа ба сүүлийн 5 жилийн хүн амын өсөлт нь 7.9% байна.</p>
Худалдаа, үйлчилгээ давамгайлсан			
21	Сүхбаатар	23,031	<p>Монгол орны умард хаалга болсон Сүхбаатар хот нь авто болон төмөр замаар Ази-Европтой шууд холбогдох боломжтойгоос гадна газар тариалангийн гол бүс нутаг юм. Улсын нийт газар тариалангийн 40 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг. Тус хотын эдийн засгийн давуу тал бол хил орчмын худалдаа болон газар тариалан юм.</p> <p>Хүн ам нь 2007-2009 оны хооронд 19,900 болтол буураад байсан Сүхбаатар хотын хүн ам сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байна. Сүүлийн 5 жилийн статистикийн дунжаар авч үзвэл 3.4%-иар өссөн.</p>
22	Булган (Ховд)	10,172	<p>Ховд аймгийн Булган сум нь аймгийн газар нутгийн Алтайн нурууны өмнө орших Булган, Үенч, Алтай сумдын төв болон хөгжих боломжтой. Үүнээс гадна хил орчмын худалдааг дагасан хүн хүн амын суурьшил бий болсон. Алтайн нурууны өмнө байрлах 3 сумын нийгмийн үйлчилгээг Булган сумаас авах боломжтой.</p> <p>2015 оноос хойш Булган сумын хүн ам 10,000-аас дээш гараад байна. Хүн амын өсөлт тогтмол нэмэх байгаа ба цаашид ч нэмэгдэх төлөвтэй байгаа.</p>
Аялал жуулчлал, үйлчилгээ давамгайлсан			
23	Хархорин	12,508	<p>Эртний Их Монгол улсаас улбаатай Хархорин хот нь Монгол орны аялал жуулчлалын гол цэг юм. Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хот нь аялал жуулчлал болон х.а.а хөгжсөн суурин бөгөөд Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдоно.</p> <p>Хархорины хүн ам 2000 оноос хойш ерөнхийдөө бууралттай байсан. 2001 онд 13,527 байсан бол 11 жилийн дараа 2012 онд 11,412 болж буурсан байдаг. Харин 2012 оноос хойш аажмаар өсөж байгаа ба сүүлийн 5 жилийн дунджаар 9.3%-иар өсөж 12,508 болжээ.</p>
24	Хатгал тосгон	3,248	<p>Монгол орны аялал жуулчлалын хамгийн том зорин очих цэг бол Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон юм. Энд дотоод, гадаадын олон мянган жуулчид тогтмол очиж байгаа ба зунаас гадна өвлийн аялал жуулчлалыг ч төрийн бодлогоор дэмжин үйл ажиллагаа зохиож байгаа нь тосгоны ирээдүйн үнэ цэнийг улам бүр нэмэгдүүлж байна. Төвийн бүстэй сайжруулсан авто замаар холбогдоно.</p>

9. ЗАМ ТЭЭВЭР

Зам, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг бүх төрлийн тээврийн харилцан уялдаатай үйл ажиллагааг хангах, тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, замын сүлжээний тээврийн хэрэгсэл өнгөрүүлэх боломжийг дээшлүүлэхтэй холбон авч үзлээ.

Монгол Улсад авто зам, автотээвэр, төмөр замын тээвэр, агаарын тээвэр болон усан замын тээвэр гэсэн үндсэн салбарууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсад 2018 онд нийт 69,8 сая тн ачаа тээвэрлэсэн бөгөөд үүнээс авто тээврээр 44,1 сая тн, төмөр замын тээврээр 25,7 сая тн, агаарын тээврээр 5,75 мянган тн ачаа тус тус тээвэрлэсэн байна. Ачаа тээвэрлэлт өмнөх онтой харьцуулахад 15,9 сая тн буюу 29,4%-иар өссөн ба үүнээс автотээвэр 4%, төмөр зам 13,2%, агаарын тээвэрлэлт 7,1% өссөн нь 1925 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Үүнээс үзэхэд ачаа тээвэрлэлтийн хэмжээ цаашид өсөх хандлагатай байна. Давхардсан тоогоор 2018 онд 200,9 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 15,19 сая хүн зорчигч буюу 7%-иар буурсан байна. Үүнээс авто тээврээр 196,9 сая хүн, төмөр замын тээврээр 2,57 сая хүн, агаарын тээврээр 1,42 сая хүн, усан замын тээврээр 25,6 мянган хүн зорчигч тус тус тээвэрлэсэн байна. Автотээврийн зорчигч тээвэрлэлт өмнөх оныхоос 7,3%-иар буурсан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлтийн үзүүлэлт буурахад ихээхэн нөлөөлж байна. Буурсан шалтгааныг авч үзвэл 2015 оноос нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ цахим төлбөрийн системд шилжсэн бөгөөд 2017 оноос төлбөрийг зөвхөн картаар хийдэг болсноор зорчигчид картаа тэр бүр цэнэглүүлэхгүй, бэлэн мөнгөөр зорчиж байгаа болон бусад зөрчлийн улмаас бүртгэгдэхгүй байгаа зэрэг шалтгаан нь салбарын нийт зорчигч тээвэрлэлт буурахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Салбарын хэмжээнд 2018 онд нийт 1 687 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс автотээврийн салбар 627,83 тэрбум төгрөг, төмөр замын салбар 616,48 тэрбум төгрөг, агаарын тээврийн салбар 422,2 тэрбум төгрөг, усан замын тээвэр 0,5 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Монгол Улсад чанартай, хүртээмжтэй авто замын сүлжээг бий болгохоор сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй явуулснаар улсын хэмжээнд авто замын сүлжээний нийт урт 2018 оны байдлаар 111,9 мянган км болсон байна. Үүнээс 14 918,7 км нь улсын чанартай, 96 125,3 км нь орон нутгийн чанартай авто замд хамаарч байна. Улсын чанартай авто замын 6 718 км нь хатуу хучилттай, 7 065,1 км нь ердийн хөрсөн, 923,56 хайрган хучилттай, 211,9 км нь сайжруулсан хөрсөн авто зам байна.

Тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн ачаа, зорчигч тээврийн гүйцэтгэлээс харахад улсын хэмжээний ачаа тээврийн 65 гаруй, зорчигч тээврийн 98,7 хувийг автотээврээр гүйцэтгэж байна. Гэвч Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил сул, бүс нутгуудын хөгжлийн ялгаа, шилжилт хөдөлгөөн, ядуурлын түвшин, орлогын тэгш бус хуваарилалт, зам тээврийн хөгжлийн орон зайн төлөвлөлтөд судалгаа, шинжилгээ үндэслэл муутай ханддаг, салбар хоорондын нэгдмэл бус бодлого, тээвэрлэлтийн үйл ажиллагааг саланги байдлаар зохион байгуулж ирсэн зэргээс шалтгаалан тээврийн дэд бүтэц, ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, хэрэглэгчийн эрэлт, шаардлагыг хангахгүй байна.

Далайд гарцгүй Монгол орны хувьд автотээврийн салбарын гадаад зах зээлийг хөгжүүлэх, өсөн нэмэгдэж буй тээврийн эрэлт хэрэгцээг хангахын тулд олон улсын болон бүс нутгийн тээвэр, логистикийн сүлжээгээр дамжуулан гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын чанартай хуурай боомтуудыг байгуулах, олон улсын гэрээ конвенцид нэгдэн орох замаар автотээврийн салбарыг нээлттэй хөгжүүлэх хэрэгцээ бий болж байна.

Уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан экспортын бүтээгдэхүүн жил бүр нэмэгдэж байгаа нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой байна. Энэ нь тээврийн салбарын Улсын эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөж байгаа билээ.

Орон нутгийн хөгжил, хүн амын суурьшилтай уялдуулан агаарын тээврийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ, нисэх буудлын хүчин чадлыг тодорхойлж хөгжүүлэх шаардлагатай. Дотоодын агаарын тээврийн үйлчилгээг алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүргэхэд чиглүүлж, нийгэм-эдийн үр ашгийг дээшлүүлж, газарзүйн байршил, хүн ам, зах зээл аялал жуулчлалын төв болох зэрэг нөхцлүүдийг харгалзан Ховд, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад хотуудын нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-тай уялдуулан бүсийн зангилаа (Hub) буудлуудыг байгуулах хэрэгтэй. Мөн Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулахтай холбогдуулан Сайншандад нисэх буудал байгуулна.


9.1. Төмөр замын тээвэр

Төмөр замыг барьж байгуулахад анхны хөрөнгө оруулалт их шаарддаг боловч байгаль, цаг уурын нөлөөлөлд бага автдаг. Зорчигчид ая тухтай зорчих боломжтой, механикжилтын түвшин өндөртэй, автоматжуулалт, цахилгаанжуулалт нэвтрүүлж байгальд ээлтэй экологийн орчин бүрдүүлж үйл ажиллагаа явуулж их хэмжээний ачаа, зорчигсодыг алсад тээвэрлэхэд нэн тохиромжтой учир хуурай замын тээвэр зонхилдог манай улсад төмөр замын тээврийг хөгжүүлэхэд их анхаардаг юм.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 1 920 км урт төмөр зам байна. Төмөр замын гол тэнхлэг нь Сүхбаатар хотоос, Замын үүд хүртэл явдаг. Үүнээс салбарласан төмөр замууд бий. Үүнд: Дулаанхаан-Ерөө, Дархан-Эрдэнэт, Дархан-Шарын гол, Багахангай-Багануур, Айраг- Бор-Өндөр, Сайншанд-Зүүнбаян хүртэл мөн Чойбалсан-Эрээн цав хүртэл төмөр замаар ачаа тээвэр, хүн тээврүүд явагдаж байна. Нэг мянган км хавтгай дөрвөлжин (кв.км) нутаг дэвсгэрт ногдох төмөр зам 1,22 км байна. Монгол Улсад бүртгэлтэй 7 130 ачааны вагон, 187 зүтгүүр төмөр замын хөдөлгөөнд оролцож байна.

2018 онд Төмөр замын тээврээр 2572,5 мян.хүн зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 57,8 мян.хүн буюу 2,2%-иар буурчээ. Нийт зорчигчдын 2454,3 мян.хүн буюу 95,4% нь орон нутагт, 118,2 мян.хүн буюу 4,6% нь олон улсад зорчсон байна. Олон улсын зорчигчийн тоо өмнөх оныхоос 0,6%-иар өсч, орон нутгийн зорчигчийн тоо 0,6%-иар буурсан байна.


Зураг 9.1.1 Төмөр замын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мян.хүн



Эх сурвалж: ҮСХ-2019


Төмөр замын тээврээр 25 763,3 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 2 998,3 мян.тн буюу 13,2%-иар өссөн байна. Төмөр замын тээврээр тээвэрлэсэн олон улсын ачаа 59,9%, орон нутгийн ачаа 40,1%-ийг тус тус эзэлж байна. /Зураг-2/

Зураг 9.1.2 Төмөр замын тээврээр тээсэн ачаа мян.тн




Эх сурвалж: ҮСХ-2019

Зураг 9.1.3. Төмөр замын тээврээр тээвэр олон улсын ачааны бүтэц



Төмөр замын тээврээр тээвэрлэсэн олон улсын нийт ачааны 9 272,4 мян.тн буюу 60,1%-ийг экспорт, 2 798,4 мян.тн буюу 18,1%-ийг импорт, 3 365,7 мян.тн буюу 21,8%-ийг дамжин өнгөрөх тээвэрлэлт эзэлж байна. /Зураг-3/


Зураг 9.1.4. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, ачааны нэр төрөл



Эх сурвалж: “УБТЗ” ХНН-2019

Төмөр замын тээврийн ачаа эргэлт 15 315,3 сая тн.км болж, өмнөх оныхоос 1 822 сая тн.км буюу 13,5%-иар өссөн байна. Үүнээс 2 866,3 сая тн.км буюу 18,7% нь орон нутаг, 7 307,3 сая тн.км буюу 47,7% нь экспорт, 1405,8 сая тн.км буюу 9,2% нь импорт, 3 736 сая тн.км буюу 24,4% нь дамжин өнгөрөх тээврийн ачаа эргэлт эзэлж байна. /Зураг-5/


Зураг 9.1.5. Төмөр замын тээврийн ачаа эргэлт, сая тн.км



Эх сурвалж: ҮСХ, 2019, Тээврийн салбарын үйл ажиллагааны жилийн тайлан

Төмөр замын тээврийн орлого 2018 онд 616,025 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 86,009 тэрбум төгрөг буюу 16,2%-иар өссөн байна. /Зураг-6/

Зураг 9.1.6. Төмөр замын тээврийн орлогын хэмжээ, сая төгрөг



Эх сурвалж: ҮСХ-2019

9.2. Авто замын сүлжээ

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 4.1.22, 14.1т заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ.

Улсын чанартай авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэлийг хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах ажлыг хийж дуусгасан бөгөөд энэхүү ажлын хүрээнд Монгол Улсын үндэсний авто замын сүлжээний мэдээлэл шинэчлэгдэн нэмэгдсэн. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2018 оны байдлаар 112414,2 км, байна. Үүнээс улсын чанартай 15231.3 км, олон улсын чанартай 4333км, орон нутгийн чанартай 95398 , тусгай зориулалтын авто зам 1057.6км, нийслэлийн авто зам 727,7км ашиглагдаж байна.

Сүүлийн жилүүдэд баригдсан болон барихаар төлөвлөж буй авто замууд

Ашиглалтад орсон авто улсын чанартай авто зам

1. Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 276 км хатуу хучилттай авто зам

2. Мандалговь- Даланзадгад чиглэлийн 296 км хатуу хучилттай авто зам

3. Нарийнсухайтын уурхайгаас Шивээхүрэн боомт чиглэлийн 55.2 км хатуу хучилттай авто зам

4. Оюутолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт чиглэлийн 105.3 км хатуу хучилттай авто зам

Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто зам

5. Ухаа худагийн уурхайгаас Гашуунсухайт боомт хүртэлх 239 км хүнд даацын хатуу хучилттай авто зам

6. Баруун нарангийн нүүрсний уурхайгаас Таван толгой –Гашуун сухайт чиглэлийн авто замтай нийлэх 32 км хүнд даацын асфальтбетон хучилттай авто зам

7. Цант уулын нүүрсний уурхайгаас Таван толгой – Гашуун сухайт чиглэлийн замтай нийлэх 36.8 км хүнд даацын авто зам

8. Нарийн сухайт –Шивээхүрэн чиглэлийн 43.2 км хүнд даацын бетон хучилттай зам Баригдаж байгаа зам

9. Баруун Ноён уулын нүүрсний уурхайгаас Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто зам хүртэлх 98.4 км авто зам

10. Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хучилттай авто зам Барихаар төлөвлөж байгаа зам

11. Цогт-Овоо сумаас-Цогтцэций сум хүртэлх 80 км хатуу хучилттай авто зам

12. Даланзадгад-Тавантолгой-Оюу-Толгой чиглэлийн 251 км хатуу хучилттай зам

13. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын авто зам

14. Тавантолгой-Цагаандэл уул чиглэлийн 270 км хүнд даацын авто зам

15. Оюутолгой-Хатанбулаг-Ханги чиглэлийн 303 км авто зам

Дундговь, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй улсын чанартай авто зам: Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээгүүр Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 98.2 км, Мандалговь-Даланзадгад чиглэлийн 154 км авто зам, нийт 252,2 км авто зам дайран өнгөрч байна. Эдгээр авто зам нь 100 % хатуу хучилттай зам юм. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээгүүр Мандалговь-Даланзадгад чиглэлийн 148 км, Даланзадгад-Цогтцэций-Гашуунсухайт чиглэлийн 329.9 км, нийт 477.9 км дайран өнгөрч байна. Үүнээс 233.77 км хатуу хучилттай, 12.54 км хайрган, 231.59 км байгалийн хөрсөн зам байна.

Дорноговь аймагт баригдсан болон барихаар төлөвлөж буй авто зам

Ашиглалтад орсон зам


1. Улаанбаатар-Сайншанд чиглэлийн 447 км хатуу хучилттай авто зам
2. Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 219 км хатуу хучилттай авто зам
3. Гол замаас Эрдэнэ сум хүрэлх 15.5 км хатуу хучилттай авто зам
4. Сайншанд-Хамрын хийд чиглэлийн 42 км хатуу хучилттай авто зам

Барихаар төлөвлөж байгаа зам

6. Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн 990 км хурдны зам
 7. Оюутолгой-Хатанбулаг-Ханги чиглэлийн 303 км авто зам
 8. Сайншанд-Зүүнбаян-Ханги чиглэлийн хатуу хучилттай авто зам
 9. Дэлгэрэх-Сайншанд чиглэлийн 130 км хатуу хучилттай авто зам
 10. Гол замаас Бүрдэнэ булаг чиглэлийн 18 км хатуу хучилттай авто зам
- Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй улсын чанартай авто зам

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр Чойр-Сайншанд чиглэлийн 189 км, Сайншанд-Замын-Үүд-Улсын хил чиглэлийн 219 км, нийт 408 км дайран өнгөрч байна. Эдгээр авто зам нь 100 % хатуу хучилттай зам юм. Монгол Улсын 1000 км хавтгай дөрвөлжин, (км.кв) нутаг дэвсгэрт 2018 оны жилийн эцсийн байдлаар 6.9 км сайжруулсан зам ногдож байгаа нь өмнөх оныхоос 4,6%-иар өссөн байна. Нийт сайжруулсан замын 9 023 км буюу 83.3%-ийг хатуу хучилттай, 1 207.9 км буюу 11.1%-ийг хайрган хучилттай, 604.9 км буюу 5.6%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. / Зураг 9.2.1/

Зураг 9.2.1. Монгол улсын үндэсний авто замын сүлжээ




Эх сурвалж: ҮСХ-2019

Монгол Улсын авто замын нийт сүлжээнд олон улсын болон улсын чанартай зам 14 918,7 км буюу 13,3%, орон нутгийн чанартай зам 96 125,3 км буюу 85,9%, уул уурхайн буюу тусгай зориулалттай зам 872,7 км буюу 0,8%-ийг эзэлж байна /Хүснэгт 9.2.1/. Хатуу хучилттай зам 2018 онд нийт 9 023 км болж өмнөх оныхоос 591,6 км буюу 7%-иар өсч, харин хайрган хучилттай зам 101 км буюу 7,7%-иар, сайжруулсан хөрсөн зам 10 км буюу 1,6%-иар багасчээ.

Хатуу хучилттай замын 6 718,1 км буюу 74% нь улсын, 1 431,9 км буюу 16% нь орон нутгийн, 872,7 км буюу 10% нь уул уурхайн (тусгай) зориулалттай зам байна. /Зураг 9.2.2/

Зураг 9.2.2. Хатуу хучилттай авто замын бүтэц



Эх сурвалж: ҮСХ-2019


Хүснэгт 9.2.1. Үндэсний авто замын сүлжээ

Авто замын төрөл	Хэмжих нэгж	Бүгд	Үүнээс		
			Улсын чанартай	Орон нутгийн чанартай	Уул уурхайн зориулалттай зам
Авто замын сүлжээний нийт урт	км	111916.7	14918.7	96125.3	872.7
Үүнээс:					
1. Хатуу хучилттай	км	9023	6718	1431.93	872.7
а. Цемент бетон	км	111.16	36.5	31.46	43.2
б. Асфальт бетон	км	8706.4	6476.4	1400.47	829.5
в. Хөнгөвчилсөн	км	205.2	205.2		
2. Хайрган хучилттай	км	1207.89	923.56	284.33	
3. Сайжруулсан хөрсөн	км	604.9	211.9	393	
4. Ердийн хөрсөн зам	км	101081.18	7065.1	94016.04	

9.3. Авто тээвэр


Автотээврийн салбар 2018 онд давхардсан тоогоор 196,9 сая хүн зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 2 125,7 сая хүн.км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 15,3 сая хүн буюу 7,3%-иар буурч, зорчигч эргэлт 84,8 сая хүн.км буюу 4,2%-иар өссөн байна. / Зураг 9.3.1/

Зураг 9.3.1. Автотээвэрээр зорчсон зорчигч, сая хүн



Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яамны статистик мэдээлэл-2019

Зураг 9.3.2. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, мян.тн



Автотээвэрээр 2018 онд 44 138,9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 12 926 мян.тн буюу 46 %-иар өсжээ.

Эх сурвалж: Зам тээврийн хөгжлийн яамны статистик мэдээлэл-2019

Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл: Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо 501 925 буюу нийт автомашины 57,6%-ийг эзэлж байна. 2018 онд Улаанбаатар хотод


бүртгэлтэй автомашины тоо өмнөх оныхоос 1,4%-иар буурсан үзүүлэлттэй байна. Бүх аймгийн тээврийн хэрэгслийн тоог харьцуулж үзэхэд Өмнөговь аймагт 38 971 буюу 4% ногдож буй нь хамгийн их, Говьсүмбэр аймагт 4 026 буюу 0,4% ногдож байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

9.4. Агаарын тээвэр

Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар агаарын тээврийн 62 зам бүртгэгдсэнээс бүсийн навигацийн маршрут 10, дээд агаарын зам 37, доод агаарын зам 45 тус тус байна. Дээд, доод агаарын зам нь давхцдаг ба уламжлалт маршрут нь 52 байгаа юм. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн тоо 34 байгаагаас 2018 онд нислэгт тэнцэх чадварын хүчин төгөлдөр гэрчилгээтэй агаарын хөлгийн тоо 15 байна.

Агаарын тээврийн салбар 2018 онд нийт 1422,49 мян.хүн зорчигч тээвэрлэж өмнөх оныхоос 170,7 мян.хүн буюу 13,6%-иар өссөн байна. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо орон нутагт 401,6 мян.хүн болж өмнөх оныхоос 76,57 мян.хүн зорчигч буюу 23,5%, олон улсад 1020,89 мян.хүн болж өмнөх оныхоос 94,15 мян.хүн буюу 10,16%-иар өссөн байна. /Зураг 9.4.1/


Зураг 9.4.1. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо, мянгаар, 2014-2018 он



Эх сурвалж: ҮСХ-2019

Агаарын тээврээр 2018 онд нийт ачаа 5 752 тн тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 383 тн буюу 7,1%-иар өссөн байна. Нийт тээвэрлэсэн ачаанаас олон улсад 5 644 тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оныхоос 428 тн буюу 8,2%-иар өсч, орон нутагт 108 тн ачаа тээвэрлэсэн нь 45 тн буюу 29,4%-иар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 9.4.2/


Зураг 9.4.2. Агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа, тонн



Эх сурвалж: ҮСХ-2019


2018 онд орон нутагт зорчигчдын тоо 401,6 мян.хүн болж, үүнээс зөвхөн уул уурхайн захиалгат нислэг Оюутолгой, Оюутолгой-Даланзадгад, Овоот чиглэлд зорчигчийн тоо 293,43 мян.хүн буюу 73%, орон нутгийн хуваарьт нислэгээр 106,15 мян.хүн буюу 26%, захиалгат нислэгээр 202,9 мян.хүн буюу орон нутгийн нислэгийн 1%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 9.4.3/

Зураг 9.4.3. Орон нутгийн зорчигч тээвэрлэлт



Эх сурвалж: ИНЕГ-2019

Газрын зураг 9.4.1. Агаарын тээврээр дотоодын зорчигчдын урсгал, 2018 он




Хүснэгт 9.4.1. Агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо, чиглэлээр
2017-2018 он

Агаарын тээвэрлэгч	Чиглэл	2017 он	2018 он
МИАТ ХК	Бээжин	101 663	108 723
	Сөүл	153 159	172 768
	Хонг конг	60 236	69 937
	Токио	61 854	69 795
	Москва	14 609	19 097
	Берлин	15 902	14 910
	Москва-Берлин	10 212	8 367
	Бусан	9 310	18 371
	Бангкок	3 145	13 019
	Франкфурт	9 335	9 929
	Захиалгат	10 751	9 693
Нийт		450 176	514 609
Хүннү Эйр ХХК	Манжуур	14 499	13 629
	Улаан-Үүд	1 867	4 661
	Эрээн	20 779	18 938

	Бугат	7 646	3 848
	Хайлаар	1 226	2 969
Нийт		46 017	44 045
Аэромонголиа ХХК	Хөх хот	11 309	11 609
	Эрхүү	12 028	12 718
	Улаан-Үүд		311
Нийт		23 337	24 638
Эйр Чайна	Бээжин	99 516	101 777
Кореан Эйр	Сөүл	182 979	188 571
Аэрофлот	Москва	52 809	55 119
Туркиш Эйрлайнс	Бишкек- Истанбул	39 083	42 058
Эйр Бусан	Бусан	28 029	36 589
Ангара Эйрлайнс	Эрхүү	-	3 142
Захиалгат	Захиалгат	4 792	10 343
НИИТ		926 738	1 020 891

Агаарын тээврээр олон улсад нийт 1 020,89 мян.хүн зорчсон бөгөөд үүнээс дотоодын 3 агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК 514,6 мян.хүн, “Хүннү Эйр” ХХК 44 мян.хүн, “Аэромонголиа” ХХК 24,6 мян.хүн зорчигч тус тус тээвэрлэсэн. Гадаадын 6 агаарын тээвэрлэгч “Кореан Эйр” 188,6 мян.хүн, “Эйр Чайна” 101,8 мян.хүн, “Аэрофлот” 55,1 мян.хүн, “Туркиш Эйрлайнс” 42 мян.хүн, “Эйр Бусан” 36,6 мян.хүн, “Ангара Эйрлайнс” 3,1 мян.хүн, захиалгат нислэгээр 10,3 мян.хүн зорчигчийг нийт 18 чиглэлд тус тус тээвэрлэсэн байна

Зураг 9.4.4. Нислэгийн тоо



9.5. Усан замын тээвэр

Монгол Улсын усан замын тээвэр 1950-аад оноос 1980 оны сүүл хүртэл эрчимтэй хөгжиж, 1 чирэгч, 3 чиргүүл онгоцоор ОХУ-аас импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал болон бусад ачааг Ханх, Хатгал боомтын хооронд тээвэрлэж

баруун аймгуудыг хангаж байсан төдийгүй Сэлэнгэ мөрнөөр гол төлөв мод бэлтгэл, үр тарианы тээвэрлэлт хийгддэг байсан.


Монгол Улс “Далайн эрх зүйн байдлын тухай” НҮБ-ын конвенцид 1996 онд нэгдэн орсны дараа Монгол Улсын Засгийн газраас “Их далайг ашиглах талаар авах зарим арга хэмжээний тухай” 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 316 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор хөлөг онгоцны бүртгэл хийх эхлэлийг тавьж, Улаанбаатар хотыг бүртгэлийн боомт хот болгон зарласан бөгөөд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодлогын баримт бичиг боловсруулахыг холбогдох яамдуудад даалгасан байдаг.

2018 онд усан замын тээврээр 25 638 хүн зорчиж, зорчигч эргэлт 0,4 сая хүн км болж, өмнөх оныхоос зорчигчийн тоо 5 082 хүн буюу 24.7%-иар өссөн байна.

Усан замын тээврээр 1990 онд 71,6 мян.тн ачаа тээвэрлэж байсан бол 2006-2018 онд ачаа тээвэрлээгүй байна.


Усан замын тээврийн орлого 2018 онд 566,3 сая төг болж, өмнөх оныхоос 86,7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Далайн захиргаанаас 2019 онд хийсэн усан замын тээврийн хэрэгслийн техникийн үзлэгт 145 тээврийн хэрэгсэл хамрагдсаны 71,03 хувь буюу 103 тээврийн хэрэгсэл нь Хөвсгөл аймагт, Архангай аймагт 17, Улаанбаатар хотод 7, Дархан-Уул аймагт 1, Орхон аймагт 2, Баян-Өлгий аймагт 2, Булган аймагт 4, Сэлэнгэ аймагт 2, Дорнод аймагт 2, Увс аймагт 4, Хэнтий аймагт 1 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. /Зураг 9.5.1/

Зураг 9.5.1. Усан замын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд



Эх сурвалж: Монгол улсын далайн захиргаа
статистикийн мэдээ-2019

Зураг 9.5.2. Усан замын тээврийн хэрэгслийн ангиллаар



Эх сурвалж: Монгол улсын далайн захиргаа
статистикийн мэдээ-2019

9.6. Дамжуулах хоолойн тээвэр

Орчин үеийн тээврийн нэгэн төрөл болох дамжуулах хоолойн тээвэр нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан бусад аймгийн төвүүдэд халуун, хүйтэн ус дамжуулах, бохир усыг зайлуулахад өргөн ашиглаж ирсэн. Эрдэнэтийн уулын баяжуулах комбинатыг ашиглалтанд оруулах үед үйлдвэрлэлийн хэрэгцээт усыг Сэлэнгэ мөрнөөс дамжуулах хоолойгоор тээвэрлэн авчирсан нь манай улсын анхны нэр төрлийн томоохон байгууламж болсон.

Дамжуулах хоолойн Хэрлэн-Говь шинэ төслийн зорилго нь шар усны болон борооны үерийн ус хуримтлуулах сан байгуулж, тэндээсээ далд яндан хоолойгоор дамжуулах замаар хуримтлагдсан усны багахан хэсгийг Зүүн-өмнөд Говийн бүсэд хүргэхэд оршино. Хэрлэн голын нийт урсацын 56-76%-ийг бүрдүүлэх атлаа хэдхэн хоног урсаад өнгөрөх борооны болон шар усны үерийн усны нөөцийг хуримтлуулж ашигласнаар Шивээ-Овоогийн ДЦС, Цагаан Суврагын уул уурхайн үйлдвэр, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, говийн бүсийн хот суурин, хөдөөгийн хүн амыг цэнгэг усаар найдвартай хангаж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, Хэрлэн голын болон говийн бүс нутагт экологийн чадамжийг дээшлүүлэх зэрэг бүснүтгийн эдийн засаг, нийгэм, экологийн тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэнэ. уримтлуулсан усны дийлэнх хэсгийг ган гачигтай хуурай улиралд Хэрлэн голын ус эрс багасах, тасрахаас хамгаалж сэлбэхэд ашиглах юм. Ингэснээр голын ай сав газрын экологи сайжирч, байнга тэнцвэртэй байх боломж бүрдэнэ.

Орхон-Говь төсөл нь Орхон гол дээр 70 м өндөр 300 м урт бетон боомт барьж, хаврын шар усны болон үерийн усыг хуримтлуулан далд яндан хоолойгоор дамжуулж, Булган, Төв, Дундговь аймгуудаар дамжуулан, Говийн бүсийг усаар хангах зорилготой юм. Энэ зорилгын үүднээс Булган хотоос баруун урд зүгт 35 км-т буюу, Улаанбаатар хотоос 300 км-т 800 сая м³ багтаамжтай усан сан байгуулах юм. Мөн хуримтлагдсан үерийн усыг өмнө зүгт дамжуулан шахах шугам хоолой, насос станц, туслах барилга байгууламжууд байгуулагдана. Энэхүү төсөл нь Таван Толгой, Оюу Толгойн нүүрсний уурхай, Мандалговь, Даланзадгад зэрэг хотууд болон 8 сумын төв зэрэг шугам хоолойн дагуу байрлах бүс нутагт ус түгээх юм.

Монгол Улсын Засгийн газрын захиалга Австри Улсын Засгийн газрын санхүүжилтээр “Тайшир-Алтай ус хангамж” төслийг хэрэгжүүлж байна. Цэвэр усны нийт урт нь 54 км шугам хоолой юм.

Алтай хотын ус хэрэглээний хэрэгцээ шаардлага 2000 м³/хоног буюу 23 л/с байна. Гэвч өнөөдөр 10-12 л/с усыг цагийн хатуу хязгаарлалттайгаар өгч байна. Алтай хотод 1 литр усыг албан газарт 1 төг, ус түгээх цэгт 1.5 төг, машинаар ус түгээхэд 3 төгрөгөөр борлуулж байгаа нь Улаанбаатар хотынхоос даруй 5 дахин өндөр байгаа юм. Өөрөөр хэлбэл чанар муутай усыг өндөр үнээр авч ашиглаж байгаа гэсэн үг юм. Алтай хотын ус хангамжийн системийг сайжруулах шинэчлэлтийн зураг төслөөр 2020 оны түвшинд хоногийн ус хэрэглээ нь 2376 м³/хоног буюу 27,5 л/сек байхаар тооцсон байна. Алтай хотын хөгжлийн ойрын ирээдүйн чиг хандлага, үйлдвэрлэл



үйлчилгээг хөгжүүлэх боломж, ус хангамжийн шугам сүлжээний ашиглагдах хугацаа зэргийг гол үндэс болгон 2040 оны түвшинд хоногийн ус хэрэглээ нь 4492,8 м³/хоног буюу 52 л/сек болохоор байна. Төсөл хэрэгжиснээр ундны цэвэр усны асуудал хурцаар тулгамдаж буй Алтай хотын ус хангамжийг сайжруулснаар хүн амын эрүүл мэндийн асуудлыг бүрэн шийдвэрлэхээс гадна хөнгөн, хүнсний үйлдвэрүүд, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хөгжилд мэдэгдэхүйц дэвшил гарна. Алтай хот болон яндан хоолойн дагуух уст цэгийн нийт ус хэрэглээ 60 л/сек болох ба энэхүү 60 л/сек нь Завхан голын олон жилийн дундаж урсац нь 12 м³/сек байгаатай харьцуулахад 0.5%, Улаан боомын усан сангийн ашигтай эзэлхүүний 0,47%, нийт эзэлхүүний 0,34% болж байгаа нь усан сангийн усны нөөцийн хэмжээнд тодорхой нөлөө үзүүлэхээргүй байна.

Манай улс 1996 оноос газрын тос олборлож, газрын тосны олборлох салбар шинээр хөгжиж ирсэн. Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын 32 талбай ялгаснаас одоогоор 25 талбайд 21 гэрээлэгч ажиллаж байна. Одоогоор олборлолтын үйл ажиллагааг “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос Монгол” ХХК-ууд эрхэлж байна.

Монгол улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэн, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг даган газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсээр байна.

Монгол улсын хэмжээнд олборлолт явуулж буй ордуудын ойролцоох Буйр XVIII болон Өмнөговь аймгийн нутагт орших Галба XI талбайнуудаас өнөөгийн байдлаар тос илрээд байгаа бөгөөд нэмэлт судалгааны ажлууд хийгдсэнээр шинээр газрын тосны орд бий болж, нөөц нэмэгдэх магадлалтай байна.

Манай төр засгаас дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах нөхцөл бүрдсэн гэж үзсэн учраас энэхүү томоохон хэмжээний бүтээн байгуулалтын ажлыг БНЭУ-

аас авах 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тогтлоо. Уг төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийг Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 92 дугаар тогтоолоор байгуулсан.

Газрын тосны олборлолтын байршил, дамжуулах хоолой татах газарзүйн байдал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх ложистик, улс орны хөгжлийн бодлого зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан үзсэний үр дүнд боловсруулах үйлдвэрийг Дорноговь аймгийн Алтанширээ суманд бүтээн байгуулалтыг эхлүүлээд байна.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд жил бүр 1-1.1 сая тонн шатахуун импортолж, үүнд 1 тэрбум гаруй ам.долларыг зарцуулж байна. Сүүлийн 4 жилийн дунджаас харахад газрын тосны бүтээгдэхүүний импорт 8-10 хувийн өсөлттэй байна. Газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ 2020 онд 1.3-1.5 сая тонн, 2025 онд 1.5-1.8 сая тонн болж өсөх төлөвтэй байна.

10. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ

10.1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, байршлын өнөөгийн байдал

Монгол Улс 2015 онд УИХ-ын 63-р тогтоолоор “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Улмаар эрчим хүчний салбарыг 2015-2030 он хүртэл хөгжүүлэх энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, хийхээр төлөвлөсөн ажлуудыг эрчимжүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”-ийг баталж гаргасан.

Дэлхийн улс орнууд нь эрчим хүчний салбараа эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгуур, үндэсний аюулгүй байдлыг хангах суурь салбар гэж үздэг. 2018 онд улсын хэмжээнд 6.6 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч, 9.4 сая Гкал дулаан үйлдвэрлэж, импортоор 1.7 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч худалдан авсан бөгөөд үүний 1.3 тэрбум кВт.ц цахилгааныг БНХАУ-аас “Оюутолгой” ХХК, үлдсэнийг нь ОХУ-аас Төвийн болон Баруун бүсийн эрчим хүчний систем авсан. 2017 онтой харьцуулахад 2018 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээ 9.4 хувь, дулааны эрчим хүчний хэрэглээ 4.8 хувиар нэмэгдлээ.

Монгол Улс жилдээ 7.5 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэж байгаагийн 80 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 20 орчим хувийг гаднаас импортоор авч байгаа. Импортын цахилгааны гол хэрэглэгч нь Оюутолгой ХХК. Тус компани жилдээ 1.1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг Хятадаас авч байна. Мөн Төвийн бүс болон Баруун бүсийн эрчим хүчний систем ОХУ-аас жилдээ 300 сая орчим кВт.ц цахилгаан авч байна. Дунд хугацааны хөтөлбөр хэрэгжсэнээр цахилгаан импортлох асуудлыг зогсоож, эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангаж нөөц чадлын эх үүсвэр бий болгоно гэдэг зорилт тавьсан байгаа. Үүний тулд өнөөдөр ажиллаж байгаа цахилгаан станцуудаа өргөтгөх, мөн шинэ эх үүсвэрүүд барьж байгуулах гэсэн хоёр чиглэлээр ажлаа төлөвлөж хөтөлбөрт тусгаж өгсөн. Монгол Улсын эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 1300 орчим МВт байгаа. Өнгөрсөн оны оргил ачааллын үед 1081 МВт-ын чадал хэрэглэсэн байдаг. Энэ өвөл оргил ачааллын үед 1147 МВт-ын чадал хэрэглэнэ гэсэн урьдчилсан тооцоог Диспетчерийн Үндэсний төвөөс гаргасан. Өөрөөр хэлбэл энэ өвөл Монголын цахилгаан эрчим хүчний бүх тоноглол 100 хувь ажиллаж байж хэрэгцээгээ хангахаар байгаа. Эрчим хүчний хэрэглээ

жилд 5-10 хувиар тогтмол нэмэгдэж байна. Тиймээс эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай.


Импортын цахилгааны гол хэрэглэгч нь Оюутолгой ХХК бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар болон "Оюу толгой" ХХК-ийн хооронд Тавантолгойн цахилгаан станцыг барьж байгуулахаар тохиролцож "Эрчим хүчний эх үүсвэрийн зохицуулалтын тухай гэрээ"-г 2018 онд байгуулсны дагуу 300 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станцыг Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барьж, 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

2018 онд Засгийн газраас "Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. Өөрөөр хэлбэл 2018-2023 он хүртэл эрчим хүчний салбарт хийж, хэрэгжүүлэх ажлыг маш ойлгомжтой, цэгцтэй болгож, төлөвлөж өгсөн. Дунд хугацааны хөтөлбөр хэрэгжсэнээр 2023 оноос цахилгаан импортлох асуудлыг зогсоож, эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангаж, нөөц чадлын эх үүсвэр бий болгоно гэдэг зорилт тавиад ажиллаж байна. Энэ хүрээнд өнөөдөр ажиллаж байгаа цахилгаан станцуудаа өргөтгөх, мөн шинэ эх үүсвэрүүд барьж байгуулах гэсэн хоёр чиглэлээр ажиллах шаардлага гарч байна.


Манай эрчим хүчний системийн өглөө оройн их ачаалал, шөнийн бага ачааллын хооронд 300 орчим МВт -ын зөрүү бий. 300 МВт-аас доошгүй хүчин чадалтай Эгийн голын усан цахилгаан станц төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдож байж, Монголын эрчим хүчний систем бие даасан хараат бус тогтвортой систем болж чадна.

Монгол Улс эрчим хүчний нэгдсэн сүлжээтэй болох зорилтын зүүнээсээ баруун хүртэл цахилгаан дамжуулах гол шугам сүлжээг байгуулах ажил хэрэгжиж эхэлсэн. Монгол Улсын эрчим хүчний систем Төв, Баруун, Зүүн гэсэн гурван бүсэд хуваагддаг бөгөөд энэ гурван бүсийн систем 2030 он гэхэд хоорондоо холбогдож, нэг систем болно. Энэ хүрээнд бүс нутгийн эрчим хүчний системийг өндөр чадлын цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах юм.


Зураг 10.1.1. Цахилгаан эрчим хүчний хүчин чадал, үйлдвэрлэл, хэрэглээ, гадаад худалдаа, 1989-2018 он, сая квт.цагаар



Зураг 10.1.2. Нэг хүн амд ногдох үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч, кВт.ц



Зураг 10.1.3. Эрчим хүчний хэрэглээний салбаруудын эзлэх хувь, 1989-2018 он



1. Манай улсын эдийн засгийн үйлдвэрлэлд эрчим хүчний үр ашиггүй зарцуулалт өндөр байна.
2. Харин эдийн засгийн үйлдвэрлэлийн хэмжээ өссөн нь эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд гол үүргийг гүйцэтгэж байна.

Өнөөгийн эрчим хүчний хэрэглээний өсөлт нь эдийн засгийн өргөжилт, хүн ам, өрхийн өсөлтийг даган өсжээ. Ялангуяа уулуурхай, олборлолтын салбар, үйлчилгээний салбарын эдийн засагт үзүүлэх хувь нэмэр өссөн зэргээс ихээхэн нөлөөлсөн байна.

Өнөө үед дэлхийн нийтийн өмнө эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх, байгалийн хязгаарлагдмал нөөцийг ариг гамтай зарцуулах, уур амьсгалын өөрчлөлт гэдэг зүйл тулгамдсан асуудал болж байна. Монгол улс эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Газрын зураг 10.1.1. Монгол Улсын эрчим хүчний системийн бүтцийн тойм зураг



Манай улсын эрчим хүчний систем нь Баруун бүсийн эрчим хүчний систем /ББЭХС/, Алтай-Улиастайн эрчим хүчний систем /АУЭХС/, Төвийн эрчим хүчний систем /ТЭХС/, Дорнод бүсийн эрчим хүчний систем /ЗБЭХС/, Өмнөд бүсийн эрчим хүчний систем /ӨБЭХС/ гэсэн таван эрчим хүчний системд хуваагддаг бөгөөд нийт 330 гаруй сум, сууринг бүхэлд нь найдвартай эрчим хүчээр ханган ажиллаж байна. Үүнд 9 дулааны цахилгаан станц, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц, Алтай, Улиастайн дизель станцууд болон Салхит, Цогтцэцийн салхин цахилгаан станц, Дархан-Уул аймгийн Хонгор, УБ-н СХД-н Моннарын нарны цахилгаан станцаас цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн 220\110 кВ-ын дэд станц, дамжуулах сүлжээ, 35\10\6\0,4 кВ-ын түгээх сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд цахилгаан түгээн үйлчилж байна.


Нийт хэрэглэгчдийн 7.2 хувь буюу 46.4 мянга нь аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгч, 92.8 хувь буюу 602.9 мянга нь ахуйн хэрэглэгчид байна.

Дулааны эрчим хүчний нийт хэрэглэгчдийн 88.7 хувийг ахуйн хэрэглэгчид, 11.3 хувийг аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчид эзэлж байна.

Газрын зураг 10.1.2. Эрчим хүчний бүс нутгийн хэрэглээ


БҮС НУТГИЙН ХЭРЭГЛЭЭ

Цахилгаан эрчим хүчний суурилагдсан чадал 1141 МВт
Цахилгаан эрчим хүний хэрэглээ 7215 сая кВт цаг,
Импортын эрчим хүч 1413 сая кВт цаг
Дулааны эрчим хүчний хэрэглээ 7296,1 мян. ГКал




Эрчим хүчний хэрэглээ:

Зураг 10.1.4. Эрчим хүчний хуваарилалт, хэрэглээ салбараар.сая.Квт.цаг




Зураг 10.1.5. Нэг хүн амд ногдох үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч, кВт.ц, 1990-2016 он



Хүснэгт 10.1.1. Эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн хэмжээ. 2016 он


№	Эрчим хүч дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж	Хэмжих нэгж		Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ.2016 он
		цах	м.квтц	
1	"ДЦС-2" ХК	дул	Гкал	12,570.32
		цах	м.квтц	35,291.00
2	"ДЦС-3" ХК	дул	Гкал	85,772.11
		цах	м.квтц	347,699.00
3	"ДЦС-4" ХК	дул	Гкал	336,062.78
		цах	м.квтц	448,481.00
4	"АМГАЛАН" ДС	дул	Гкал	101,717.00
5	"ДДЦС" ХК	дул	Гкал	25,757.09
		цах	м.квтц	75,605.00
6	"ЭДЦС" ХК	дул	Гкал	15,368.43
		цах	м.квтц	78,798.00
ДҮН		дул	Гкал	475,530.73
		цах	м.квтц	1,087,591.00
	"ДБЭХС" ХК	дул	Гкал	24,946.40
		цах	м.квтц	40,077.00
	"ДЗДЦС" ХК	дул	Гкал	394.20
		цах	м.квтц	4,429.30
	"Дөргөн УЦС"	цах	м.квтц	5,692.49
	"Тайшир УЦС"	цах	м.квтц	4,208.04
	"Богдын голын УЦС"	цах	м.квтц	
	"Тосонцэнгэл УЦС"	цах	м.квтц	82.38
	"Гуулин УЦС"	цах	м.квтц	
	"Хүнгүйн УЦС"	цах	м.квтц	
	"Галуутайн УЦС"	цах	м.квтц	
	"Салхит СЦС" ХХК	цах	м.квтц	10,738.93
ДҮН		цах	м.квтц	46,062.44
	"Говь-Алтай" /Есөнбулаг/	цах	м.квтц	318.20
	"Улиастай" дизель	цах	м.квтц	241.55
	"Тосонцэнгэл" дизель	цах	м.квтц	
Дизель станцуудын дүн		цах	м.квтц	559.75
	"БНДС" ХК	дул	Гкал	25,624.50
	"НДС" ХК	дул	Гкал	21,139.30
	"Дулаан шарын гол" ХК	дул	Гкал	7,164.80
Эрчим хүчний салбарын нийт дүн		дул	Гкал	522,152.91
		цах	м.квтц	1,186,025.90

Зураг 10.1.6. Нийт өрхийн цахилгаан эрчим хүчээр хангагдсан байдал, 2018 он



Дээрх зургаас өрхүүдийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг харахад сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь Ногоон хөгжлийн бодлогын зорилтоос даруй 10 дахин бага байна.

Зураг 10.1.7. Өрхийн эрчим хүчээр хангагдсан байдал, бүсүүдээр



Монгол Улсын эдийн засаг сэргэж түлш, эрчим хүчний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг түлхүү оруулж, бүтээн байгуулалт, шинэчлэлтийн ажлууд хийгдэж “Дулааны 4 дүгээр цахилгаан станцын шинэчлэлтийн төсөл”, “Түгээх сүлжээний алдагдал бууруулах төсөл”, “Эрчим хүчний хөтөлбөр-1 төсөл”, “Эрчим хүчний сургалтын төсөл”, “Төвийн бүсийн

цахилгаан дамжуулах сүлжээг шинэчлэн засварлах төсөл”, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц барих төсөл, “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг ашиглах” зэрэг төслүүд хэрэгжсэн байна.

Хэтийн төлөв: Монгол Улсын эрчим хүчний салбар 2030 он гэхэд эх үүсвэрийн суурилагдсан чадлыг одоо байгаагаас 2 дахин нэмэгдүүлж, нийт суурилагдсан чадлын 30 хүртэлх хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр /Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 он/, үүн дотроо нийт чадлын 10-аас доошгүй хувийг усны эх үүсвэрээр бүрдүүлж, эрчим хүчний аюулгүйн нөөц чадлыг 20 хувьд хүргэн, эрчим хүчний бодит үнэ тарифын тогтолцоог бий болгож / Ногоон хөгжлийн бодлого/, эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлж, эрчим хүчний систем хооронд өндөр хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугамаар холбож, мэдээллийн хяналт удирдлагын цогц систем бүхий эрчим хүчний нэгдсэн ухаалаг систем бий болгоно. Мөн түгээх, хангах сүлжээг бүрэн хувьчилж, эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөний зарчмаар ажиллуулж, хөрш орнуудтай их чадлын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамаар холбогдож цахилгаан эрчим хүч экспортлогч орон болно.

Сүүлийн жилүүдэд хэрэгжиж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн барилга угсралтын ажил

- Дорноговь аймгийн Цагаан суварга-Мандахын 22 кВ-ын ЦДАШ, дэд станц.
- Хэнтий аймгийн Багануур-Цэнхэрмандалын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц.
- Алслагдсан хот, сум суурин газрууд эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон байх шаардлагатай. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс 2018 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён, Сэврэй, Хөвсгөл аймгийн Ханх, Ховд аймгийн Алтай, Булган, Үенч, Говь-Алтай аймгийн Алтай сумдыг холбох
- Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах

Газрын зураг 10.1.3. Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлтийн өнөөгийн байдал,
ХЭТИЙН ТӨЛӨВ




10.1.1 Сэргээгдэх эрчим хүч

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр болох нар, салхи, ус, газрын гүний дулааны арвин их нөөцтэй. Энэ боломж нөөцдөө тулгуурлаж сэргээгдэх эрчим хүчний салбараа бодлого, төлөвлөлттэйгөөр бүс нутгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 болон Ногоон хөгжлийн бодлого-д тус тус эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар эрчим хүчний үр ашгийг 2030 он гэхэд 20 хувь нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж, тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар заасан. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 1,334.4 МВт. Үүний 18 хувь буюу 240.4 МВт нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд байгаа. Өнгөрсөн 2018 онд 468.8 сая.кВт.ц цахилгааныг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд үйлдвэрлэж хэрэглэгчдэд нийлүүлсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчийн үнэ тариф өсч, нэгдсэн сүлжээний горим ажиллагаанд хүндрэл учруулах нөхцөл бүрдүүлж байна.


2011 оноос эхлэн сэргээгдэх эрчим хүчний салбарт томоохон хөрөнгө оруулалт хийсний үр дүнд 50 МВт-ын “Салхитын салхин цахилгаан станц”, Дархан-Уул аймгийн 10 МВт-ын нарны цахилгаан станц, Улаанбаатар хотын ойролцоо 10 МВт-ын нарны цахилгаан станц ашиглалтанд орж Төвийн бүсийн эрчим хүчний системд цахилгаан эрчим хүчийг тогтвортойгоор нийлүүлж байна. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций суман дахь 50 МВт-ын хүчин чадалтай хоёр дахь салхин цахилгаан станцын барилгын ажил явагдаж байна. Цаашид сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэх, нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.


Газрын зураг 10.1.4. Ашиглаж буй сэргээгдэх эрчим хүчний байршлын схем, 2018 он



Нар, салхины эрчим хүчний асар их нөөц бий. Монголын говиос жилд 7 триллион кВт.цаг сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх боломжтой гэдгийг гадаадын мэргэжлийн байгууллагууд, судлаачид, эрдэмтэд тогтоогоод байна. Үүнийг ашиглаж Монгол Улстай бүс нутгийн хэмжээнд хамтран ажиллаж, эрчим хүч экспортлох боломж байгааг худалдан авах сонирхолтой бүс нутгийн орнууд илэрхийлж байна. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг 2007 онд батлахдаа үнийг их нарийн тогтоож өгсөн. “...салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1кВт.ц цахилгаан эрчим хүчийг 0.08-0.095 ам.доллар, нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний үнийг 0.15-0.18 ам.доллар...” гэх мэтээр тогтоосон заалт нь одоо үе шаардлагад нийцэхгүй байна. Хууль баталж байх 2007 оны үед ам.долларын ханш 1200 төгрөг байсан бол 2019 онд 2700 төгрөгт хүрсэн. Ханшийн зөрүүнээс болж сэргээгдэх эрчим хүчний үнэ, уламжлалт аргаар

үйлдвэрлэсэн эрчим хүчний үнэ хоёрын хооронд асар их үнийн зөрүү гарсан. Тиймээс 2015 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж нар, салхины эх үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгоно гэсэн заалтыг тусгаж өгсөн. Үүнээс үүдэн эрчим хүчний үнэ тариф нэмэгдэж байна. Нөгөө талд горим ажиллагааны найдвартай байдлын асуудал тулгарч байна. Жишээлбэл, нарны цахилгаан станцууд өглөө 07:00 цагаас орой 17:00 цаг хүртэл эрчим хүч үйлдвэрлэдэг. Салхины станцууд салхигүй өдөр ажиллахгүй. Байгаль, цаг уураас хамааралтай эрчим хүчний ийм эх үүсвэрүүд их хэмжээгээр системд холбогдох нь найдвартай горим ажиллагаанд сөрөг нөлөөтэй. Цаашид сэргээгдэх эрчим хүчийг хэрэглэгчдэд үнийн дарамтгүй, эрчим хүчний салбарынхаа тогтвортой ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр хөгжүүлэх шаардлага гарч байна.





Төвийн бүсийн эрчим хүчний систем

Тус ажлын дагуу 2019 онд Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын, 2 хэлхээтэй, 260 км урт шугам баригдсанаар Улаанбаатараас Оюутолгой руу цахилгаан дамжуулах боломж үндсэндээ бүрдэж байна. Мандалговиос Оюутолгой хүртэл 220 кВ-ын сүлжээтэй болгож, дэд станцуудыг шинэчилж байна. 2019 онд Улаанбаатараас Оюутолгой руу цахилгаан дамжуулах шугамуудыг барьж дуусгаад 2020 оны эхнээс Оюутолгойн уурхайн эрчим хүчний хэрэгцээний зарим хэсгээ Монголын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаанаар хангагдах боломж бүрдэнэ. Мөн Багануур-Чойр, Багануур-Улаанбаатар шугамыг өргөтгөж, Багануур-Өндөрхаан чиглэлээр Зүүн бүсийн системтэй холбоно.

Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн 5280 МВт-ын чадал бүхий цахилгаан станц барьж, 660 кВ-ын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамаар БНХАУ-руу экспортлох зорилгыг хэрэгжүүлэхээр хөтөлбөрт тусгасан.

Монгол Улсын төвийн бүсийн болон өмнийн говийн стратегийн орд газруудын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих тухай Засгийн газрын тогтоолыг 2013 онд баталсан. Тавантолгой цахилгаан станцыг барьж байгуулах нь өмнийн говийн уул уурхайн эрчим хүчний хэрэглээг найдвартай эрчим хүчний эх үүсгүүрээс хангах, цахилгаан станцын үйл

ажиллагааны гол зардал болох нүүрсний тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, тус бүс нутгийн эрчим хүчний системийн горимыг тогтворжуулж, найдвартай ажиллагааг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм.


Төвийн бүсийн Эрчим Хүчний Систем (ТЭХС) нь өнөөгийн байдлаар дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэх 6 станц, 2 салхин станц, 2 нарны станц, 1 дамжуулах сүлжээ, 11 цахилгаан түгээх сүлжээнээс бүрддэг. Системийн одоогийн үйлдвэрлэлийн нийт суурилагдсан хүчин чадал нь 1050 МВт байна.

Төвийн бүсийн эрчим хүчний системийн харьяанд Улаанбаатарын 2, 3, 4-р станц, Дарханы цахилгаан станц, Даланзадгад, Эрдэнэтийн цахилгаан станц гэсэн 6-н цахилгаан станц, Багануурын дулааны станц, Налайхын дулааны станц, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануурын цахилгаан түгээх сүлжээний газрууд, Улаанбаатарын, Дархан, Эрдэнэтийн дулааны сүлжээ багтдаг бөгөөд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Багануур хотууд, Төв, Дундговь, Дорноговь, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн нутгийн хот суурин газрыг хамарсан үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 10.1.2. ТЭХС-ийн бүрэлдэхүүнд орж буй ДЦС-уудын хүчин чадал

№	Цахилгаан станцын нэр	хүчин чадал, МВт
Төвийн эрчим хүчний систем		
1	2-р Цахилгаан станц	24
2	3-р Цахилгаан станц	186
3	4-р Цахилгаан станц	703
4	Дарханы Цахилгаан станц	48
5	Эрдэнэтийн Цахилгаан станц	28.8
6	Даланзадгадын цахилгаан станц	9
7	Эрдэнэтийн УБҮ-н ДЦС	53
8	Салхитын салхин цахилгаан станц	50
9	Цогтцэцийн салхин цахилгаан станц	50
10	Дархан-Ул аймгийн Хонгор сумын нарны цахилгаан станц	10
11	УБ-ын СХД-ийн Моннарын нарны ЦС	10
	Дүн	1171.8

Төлөвлөгдсөн байдал:



Баруун бүсийн эрчим хүчний систем

Баруун бүсэд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 50 орчим МВт-ын хүчин чадалтай Нар, салхины эх үүсвэрүүд баригдана. Мөн Ховд гол дээр 64 МВт-ын хүчин чадалтай Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баригдаж тус бүс нутаг эрчим хүчний дотоодын эх үүсвэрээс бүрэн хангагдах боломжтой болно. Ингэснээр баруун бүс нутаг цэвэр эрчим хүч буюу сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хэрэгцээгээ бүрэн хангасан жишиг бүс болно гэж харж байна. Мөн Тэлмэнгийн 100 МВт-ын дулааны цахилгаан станц барихаар төлөвлөж байна.


Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих, Улиастай-Дөргөн-Мянгадын 220 кВ-ын 2 хэлхээт 380 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын судалгааны ажлыг эхлүүлэх, Улаанбаатар-Улиастайн хэт өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барихаар төлөвлөсөн.

2008 онд Дөргөний УЦС-ийг тус компаний охин компани болгосноор эрчим хүчний эх үүсвэрийн хувьд ББЭХС ОХУ-ын Красноярскийн эрчим хүчний систем, 2 дахь эх үүсвэр болох Дөргөний УЦС-аас тэжээгдэж эхэлсэн бол 2009.12.29-ээс Алтайн цаадах 3 сумыг БНХАУ-ын импортын ЦЭХ-ээр, Говь-Алтай аймгийн төв болон 5 сумыг 2010.12.-р сараас

ЦЭХ –ээр хангаж эхэллээ. Тус компани жилд 100 гаруй сая кв/цаг ЦЭХ-ийг үүсгүүрүүдээс дамжуулан түгээн борлуулж байна. Өвлийн их ачааллын үед 26,8 мВт хүчин чадал ашиглана. Хоёрдогч эх үүсвэрийн хувьд Дөргөний УЦС 2009 онд ашиглалтанд орсноор 2 систем зэрэгцээ ажиллаж ОХУ-ын систем давтамж тохируулах, Дөргөний УЦС ачаалал тохируулах горимоор ажиллаж байна.

Системийн нийт суурилагдсан хүчин чадлаар 40 мвт орчмыг ашиглах бололцоотой бөгөөд одоогоор 30-40 хувийг нь ашиглаж байна. Одоо системийн 110 кв, 35 кв-ын шугам дэд станцыг ББЭХС ХК хариуцан ажиллуулдаг бөгөөд 15 кв –оос дооших хүчдэлийн шугам дэд станц бусад тоноглолыг түгээх компаниуд хариуцан ажиллуулж байна.

Төлөвлөлтийн шийдэлд:




Алтай-Улиастайн эрчим хүчний систем:

Системийн хэмжээнд Говь-Алтай болон Завхан аймаг дахь салбар 44 сум суурин, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий 4 сум харьялагддаг.

2007-2008 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Завхан Говь-Алтай аймгийн ихэнхи сумуудыг Тайширын станцтай холбох цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ажил хийгдсэн. 35-110 кв-ийн нийт 1816 км шугам, 57 дэд станцаас бүрдсэн дамжуулах, түгээх шугам сүлжээнд 40 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Үйлчлэх хүрээ:



uliastain.mn/index.php?option=com_content&view=article&id=176&Itemid=723

Зүүн бүсийн буюу Дорнод бүсийн эрчим хүчний систем

Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани болон үйл ажиллагаа нь өргөжин тэлж, эрчим хүчний хангамжийн үйлчлэх хүрээ Монгол улсын Зүүн бүс нутгийг хамарч байна.

Үндсэн үйл ажиллагааны хувьд тус компани цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, импортлох, хүрээнд Дорнод, Сүхбаатар аймгуудийн 36 сум, суурин газрын 24710 айл өрх, 3133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын баяжуулах, олборлох үйлдвэрүүдийг цахилгаан эрчим хүчээр 3455,1 км агаарын болон кабель шугам, 507 ком дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүчээр, Чойбалсан хотын 822 аж ахуйн нэгж, 6117 айл өрхийн хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тус тус хангах үйл ажиллагаа эрхэлж байна.

2019 онд Чойбалсангийн дулааны цахилгаан станцын чадлыг 50 мВт-аар өргөтгөх ажлыг эхлүүлсэн.

Хоёр аймгийн нийт хэрэглээ 215,0 мян.кВт.ц. Нийт хэрэглээний 35%-ийг дотооддоо боловсруулж, үлдсэн 65%-ийг Төвийн бүсийн НС болон ББЭХС-ээс хангаж ажиллалаа. Тайширын УЦС-ын II гидро генератор 24 цагийн турш 2.9 МВт-ын чадалтай ажиллаж, хоногт дунджаар 69.2 мян.кВт.ц ЦЭХ үйлдвэрлэж ТБНС-тэй зэрэгцээ ажиллаж байна.

Есөнбулагийн ДиЦС-д 1-5 дизель генератор ажиллаж, хоногт 3.0-5.0 мян.кВт.ц ЦЭХ үйлдвэрлэж, ТБНС болон ТУЦС-тай зэрэгцээ ажиллаж байна.

ТБНС-ээс хоногт 130,0-135,0 мян.кВт.ц, ББЭХС-ээс 7.0-8,0 мян.кВт.ц ЦЭХ худалдан авч байна.

Эх сурвалж : <http://altai-uliastain.mn/>

<http://altai->

Эх сурвалж: <http://ees.energy.mn/>

7.1.2. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл, дамжуулалтын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээнүүд

Хүснэгт 10.1.3. Түлшний хангамжийн төслүүд

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт* (тэрбум төг)	Эх үүсвэр
1.1	Багануурын уурхайн хүчин чадлын өргөтгөл	450	Хувьцаа гаргах, гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
1.2.	Шивээ-Овоогийн уурхайн хүчин чадлын өргөтгөл	287,6	Хувьцаа гаргах, гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл

*-2018 оны үнээр

Хүснэгт 10.1.4. Эх үүсвэрийн төслүүд

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт* (тэрбум төг)	Эх үүсвэр
1. Экспортын зориулалтын эх үүсвэр			
1.	Шивээ-Овоогийн уурхайн өргөтгөл, 5280 МВт-ын ДЦС	17500	Гадаадын хөрөнгө оруулалт
2. Дотоодын эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах эх үүсвэр			
2.1. Одоо байгаа эх үүсвэрүүдийн өргөтгөл, шинэчлэл			
1.	Дарханы ДЦС-ын өргөтгөл, 35 МВт	67	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
2.	ДЦС-4-ийн турбингенератор (№1-4)-ийн шинэчлэл, 89 МВт	233,4	Гадаад, дотоодын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
3.	Эрдэнэтийн ДЦС-ын өргөтгөл, 35 МВт	127	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
4.	Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөл, 50 МВт	160	Дотоодын хөнгөлөлттэй зээл
5.	ДЦС-3-ын өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, 75 МВт	230	Дотоодын хөнгөлөлттэй зээл
6.	Амгалангийн ДС-ыг дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станцаар өргөтгөх, 50 МВт	120.5	Дотоодын хөнгөлөлттэй зээл
7.	ДЦС 3-ын хүчин чадлын өргөтгөл, 250 МВт	1016	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
8.	Дулааны 2 дугаар цахилгаан станцын өргөтгөл (1 агрегат нь хийн генератор бүхий), 300 МВт	723	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
2.2. Шинээр барих уламжлалт эх үүсвэр			
1.	Тавантолгойн ДЦС	2500	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
2.	Төвийн бүсийн шинэ ДЦС, (Багануур 700 МВт, Бөөрөлжүүт 300 МВт)	2200	Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
3.	Алтай-Улиастайн Эрчим хүчний системийн ДЦС, 100 МВт	441	Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
4.	Баруун 5 аймгийн ДЦС	300	Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

5.	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн Дул/станц	367,5	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
2.3. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр			
1.	Эгийн голын 315 МВт-ын Усан цахилгаан станц	1987,7	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
2.	Эрдэнэбүрэнгийн Усан цахилгаан станц 64мвт	700	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
3.	Том чадлын цэнэг хураагуур, 100 МВт	590,4	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
4.	Сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөр, 30 МВт	159,8	Уур амьсгалын хөрөнгө оруулалтын сангийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл
5.	Нарны ЦС-ын 60 МВт-ын шинэ эх үүсвэр	120	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
6.	Салхины ЦС-ын 100 МВт-ын шинэ эх үүсвэр	482	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

*-2018 оны үнээр

Хүснэгт 10.1.5. Цахилгаан, дулааны дамжуулах шугамын төслүүд

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт* (тэрбум төг)	Эх үүсвэр
1.	Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын овортой 2 хэлхээт 260 км ЦДАШ, 220 кВ-ын дэд станц	291	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
2.	220/110/35/6 кВ-ын “Чойр” дэд станцын өргөтгөл	30.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл
3.	Чойр-Сайншанд-Замын Үүдийн 220 кВ-ын 2 хэлхээт 404 км ЦДАШ, дэд станц	250	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
4.	Багануур дэд станцаас Улаанбаатар дэд станц хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 118 км ЦДАШ барих, дэд станцын өргөтгөл	76.1	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
5.	Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын ЦДАШ, дэд станц	11.2	Улсын төсөв
6.	Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 518 км ЦДАШ барих, 220 кВ-ын дэд станц өргөтгөл,	270	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
7.	“Багануур” дэд станцаас “Чойр” хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км ЦДАШ барих, Багануур дэд станцын өргөтгөл	88	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
8.	Улиастай-Дөргөн-Мянгадын 220 кВ-ын 2 хэлхээт 380 км ЦДАШ	240	Улсын төсөв, гадаад дотоодын хөнгөлөлттэй зээл
9.	Улаанбаатар-Улиастай хэт өндөр хүчдлийн ЦДАШ-ын судалгаа	0,5	Улсын төсөв, гадаад дотоодын зээл, тусламж
10.	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн төсөл	57,1	Гадаад, дотоодын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
11.	Эрдэнэт-Булган, Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээний алдагдал бууруулах	73,5	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
12.	Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн үр ашгийг дээшлүүлэх төсөл	36,7	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл

13.	Гэр хорооллын барилгажилттай уялдуулан алслагдсан бүсүүдэд хэсэгчилсэн дулаан хангамжийн систем байгуулах төсөл	38	Гадаадын урт хугацааны хөнгөлөлттэй зээл
14.	Хот, суурин газрын дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэл	20	Улсын төсөв, ашиглагч байгууллагын хөрөнгө оруулалт,
15.	Цахилгаан, дулааны дамжуулах түгээх сүлжээний мэдээлэл, хяналтын тоон системийн хүрээг өргөжүүлэх, дэд станцуудын удирдлагыг тоон системд шилжүүлэх	20	Ашиглагч байгууллагын хөрөнгө оруулалт, гадаад, дотоодын зээл, тусламж

*-2018 оны үнээр

10.2. Мэдээлэл, харилцаа холбооны өнөөгийн байдал

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/

Монгол улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх чиглэлээр 1999-2016 онд “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал” /1999-2010/, “ Монгол улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” /2002-2006/, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр /2005-2012/, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр /2012-2016/, “Мэдээллийг аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” /2010-2015/, “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр” /2011-2015/ зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг батлан хэрэгжүүлээд байна.

Манай улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарт хувийн хэвшлийн үйл ажиллагаа давамгайлж, хувьчлал, зах зээлийн либералчлал, өрсөлдөөнийг дэмжих бодлого тууштай хэрэгжин тус салбарын үр ашиг, орлого өсч, өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 2.4 хувийг эзэлж байна. Түүнчлэн улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтэт технологи нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсон байна.


Хүснэгт 10.2.1. Орон нутагт хэрэгжсэн төслүүд

Төслийн нэр	Хэрэгжсэн газар
Алслагдсан сумдын үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ байгуулах	- Увс (Давст) - Баян-Өлгийн (Алтанцөгц, Дэлүүн)
Тоон телевизийн үйлчилгээний тасралтгүй байнгын ажиллагаа, чанар, хамрах хүрээг сайжруулах төслийн хүрээнд 100 суманд радио долгионы зурвасын шүүр нийлүүлсэн	- Архангай (Тариат, Хайрхан, Хангай, Цэцэрлэг, Өлзийт, Булган, Ихтамир) - Баянхонгор (Баянбулаг, Жаргалант, Баян-Овоо, Баянхонгор, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан) - Завхан (Улиастай, Алдархаан, Асгат, Баянтэс, Завханмандал, Идэр, Тэс, Эрдэнэхайрхан) - Өвөрхангай (Арвайхээр, Тарагт, Төгрөг, Хархорин) - Төв (Зуунмод, Цээл, Заамар, Баянчандмань, Баяндэлгэр)

Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх	<ul style="list-style-type: none"> - Архангай (Цэцэрлэг, Өгийнуур, Хотонт, Өлзийт) - Баянхонгор (Эрдэнэцогт, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянбулаг, Гурванбулаг, Шинэжинст) - Завхан (Завханмандал, Идэр, Тэс) - Өвөрхангай (Хужирт, Есөнзүйл, Бүрд) - Төв (Цээл, Сүмбэр, Жаргалант, Заамар)
Хөдөө орон нутгийн алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх	<ul style="list-style-type: none"> - Архангай (Цэцэрлэг, Ихтамир, Цэнхэр, Хангай) - Баянхонгор (Баянлиг, Баян-Өндөр, Өлзийт, Шинэжинст, Галуут) - Завхан (Идэр) - Өвөрхангай (Богд-Сансрын холбооны ВиСАТ суурилуулах) - Төв (Угтаалцайдам, Сүмбэр)
Харилцаа холбооны байр цамхаг шинэчлэх	<ul style="list-style-type: none"> - Архангай (Цахир)
Иргэдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх гарын авлага болон сурталчилгааны материал боловсруулж, хэвлэн түгээх	
Иргэдэд тоон гарын үсгийн хэрэглээг таниулах, ашиглах чадварын сайжруулах, сургалт, судалгаа, сурталчилгаа	
Харилцаа холбооны 1 цэгийн үйлчилгээний төв барих	


Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо 2018 онд 898509 мян, хүн болж, өмнөх оныхоос 869,622мян, хүн буюу 12%-иар өссөн байна.

Зураг 10.2.1. Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо улсын дүнгээр мян,хүн



Суурин утасны цэгийн тоо улсын дүнгээр 2018 онд 331430мян, ширхэг өмнөх оныхоос 313351мян, ширхэг буюу 12%-иар өссөн байна.


Зураг 10.2.2. Суурин утасны цэгийн тоо улсын улсын дүнгээр мян, ширхэг



Үүрэн Холбоо

Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо улсын дүнгээр 2018 оны байдлаар 4222мян, хэрэглэгч өмнөх оныхоос 3886.2мян хэрэглэгч буюу 17%-иар өссөн байна.



Зураг 10.2.3. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо



Хүснэгт 10.2.2. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тооны эзлэх хувь, оператороор

Нэрс	2015	2016	2017	2018
Мобиком ХХК	48.81%	39.21%	38.64%	37.80%
Скайтел ХХК	14.99%	16.00%	12.25%	16.51%
Юнител ХХК	30.87%	31.68%	35.16%	34.03%
Жи-Мобайл ХХК	12.33%	13.11%	10.95%	11.66%
Нийт	100%	100.00%	100.00%	100.00%

Зураг 10.2.4. Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч /мян.хэрэглэгч/




Хүснэгт 10.2.3. Ухаалаг гар утас хэрэглэгчийн тоо

Android	2,174,853
IOS (Apple)	646,365
Microsoft Windows Mobile	2,947
Research motion	3,421
BADA OS	338
Yunos	616
Nokia software platform	3,451
Linux	38
Бусад OS	470,023
Ухаалаг утас нийт	3,302,052


Суурин холбоо

Зураг 10.2.5. Суурин холбооны хэрэглэгчийн тоо (мян, хүн)




Интернетийн Үйлчилгээ


Зураг 10.2.6. Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ эзэмшигчид, 2018



Зураг 10.2.7. Интернет хэрэглэгчдийн тоо




Зураг 10.2.8. Гэрээт интернэт хэрэглэгчийн төрөл (мян, хүн 2017-2018)




Шуудангийн үйлчилгээний солилцооны үзүүлэлтүүд

Зураг 10.2.9. Буухиа шуудангийн солилцоо /дотоод/



Зураг 10.2.10. Буухиа шуудангийн солилцоо / гадаад/



10.3. Ус хангамж, ариутгах татуурга

Монгол улсын усны нөөц, ашиглалтын өнөөгийн байдал

Монгол орны усны нийт нөөц сүүлийн 40 жилд хийсэн судалгааны дүнгээр 608,000 сая шоо метр ба үүнд 34,600 сая шоо метр газрын доорх усны нөөцө тус тус багтана. Усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь оршин байгаа газар нутаг, байгалийн бүс, бүслүүр, агуулж байгаа чулуулгийн тогтоц, найрлагаасаа хамаарч ихээхэн өөр өөр байдаг. Гадаргын усны нөөцийн 70 хувь нь Алтай Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг эзлэх талбайд бүрэлдэн бий болдог. Бүрэлдсэн нөөц нь Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савуудад хувиарлагдах ба тэдгээрт багтах 17 томоохон гол мөрөн, тэдгээрийн цутгалуудыг тэжээж, ихэнх голууд нийлэн хөрш орнууд руу урсан гардаг онцлогтой.

Манай орны нийт ус ашиглалтын, усны хэрэглээ жилд 500 сая шоо метр байна. нийт хүн амын 30.5 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 35.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худгаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэж байна. усны хэрэглээний түвшин адилгүй бөгөөд хот, суурин газрын инженерийн хангамж бүхий орон сууцанд оршин суушчид хоногт дунджаар 230-350 л, хөдөө орон нутаг болон гэр хороололд оршин суугчид дунджаар 5-10 л ус хэрэглэдэг. Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, мал аж ахуйн болон газар тариалангийн тогтвортой байдлыг хангах, бэлчээр, газар тариалангийн талбайг усжуулах, хөнгөн, хүнс, уул уурхайн болон бусад үйлдвэрлэлийн салбар, сэргээгдэх эрчим хүчний салбаруудын хөгжлийг тодорхойлох үндсэн дэд бүтцийн нэг, хөгжлийн голлох хүчин зүйл болж байна.

Монгол орны хэмжээгээр газрын доорх усыг ашиглаж буй уст цэг 40870 байгаагаас инженерийн хийцтэй уст цэг 19460, энгийн уурхайн худаг 21410 байна. Өнөөгийн байдлаар бэлчээр усжуулалтын зориулалтаар 32263, төв суурин газрын хүн амын ундны зориулалтаар 8575 худаг ашиглагдаж байна.

Монгол улс баталгаатай цэвэр усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2015 оны байдлаар 35 хувьтай байсан. 207 оны байдлаар мал сүргийн тоо толгой 66 саяд хүрч, жилд 115 сая метр куб ус хэрэглэж байгаа боловч бэлчээр усжуулалт дөнгөж 40 орчим хувьтай байгаа бөгөөд бэлчээрийн доройтол, амлын тоо толгойн хэт өсөлт болон усан хангамжийн дутагдал зэргээс шалтгаалан сүргийн таваарлаг чанар муудаж, мал давжаарч байгааг эрдэмтэн, судлаачид анхааруулсан байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ууршиц буюу усан гадаргын ууршил монгол орны хэмжээнд 2020 онд 39-99 мм, 2050 онд 50-72 мм, 2080 онд 106-193 мм тус тус нэмэгдэх, агаарын температурын нэмэгдэх явцтай уялдан мөстлийн хайлалт нэмэгдэж, 50м зузаан мөстөл 2040 оны үед, 100м зузаан мөстөл 2050-2060 оны үед хайлж дуусч болзошгүй байна. 2007 оны бүртгэлээр гадаргын усны тоо нийт 5121 гол, горхи бүртгэгдсэнээс 887 нь, 9340 булаг, шанд бүртгэгдсэнээс 2096 нь, 3732 нуур, тойром бүртгэгдсэнээс 1166 нь ширгэсэн дүн гарсан нь ус ашиглалт ба усны хэрэглээ харьцангуй бага боловч уур амьсгалын өөрчлөлт, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр усны горим, нөөц, чанарт өөрчлөлт орж, хомсдож байгааг илэрхийлнэ.

Мөн Монгол улсын их хурлын 20008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын Монгол Улсын хөгжлийн 5 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээний стратегийн зорилт 3-т “Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх “Ус” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх-ээр заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах гол үндэслэл бол байна. хөтөлбөр нь хоёр үе шаттай хэрэгжих бөгөөд эхний буюу эрчимтэй хөгжлийн үе 2010-2015 онд, хоёр дахь буюу тогтвортой хөгжлийн үе 2016-2021 онд хэрэгжинэ.

Хүснэгт 10.3.1. Аймгийн төв хотуудын ариутгах татуургын байгууламжуудын ашиглалт

№	Аймаг, орон нутгийн нэр	Сумын нэр	Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Ашиглалта нд орсон он	Хүчин чадал м³/хон	Цэвэрлэг ээний арга	Ажиллаж байгаа эсэх	Шинэчлэл хийгдсэн эсэх
1	Архангай	Эрдэнэбулган сум	"Ар ус ундарга" ХХК	1987, 2006 онд биологи цэвэрлэгээ ний байгуулам ж барьсан.	3000	Механик-биологи	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388 " төсөл 2018-2020 онд хэрэгжинэ
2	Баян-Өлгий	Өлгий сум	"Суат" ХХК	1986, 2001, 2011	3000	Механик	Хэвийн бус	БНПУ-ын хөнгөлөлттэй зээлээр шинэчлэх төсөл хэрэгжинэ.

3	Баянхонгор	Баянхонгор сум	"Чандмань Баянхонгор" ХК	1995	4000	Механик	Хэвийн бус	2013 онд АХБ-ы зээлийн хөрөнгө оруулалтаар шинэчлэл хийгдсэн.
4	Булган	Булган сум	"Булган мээж" ХХК	1986	2000	Механик	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
		Тэшиг сум	"Тэшиг-Ус" ОНӨААТҮГ	2014	50	Механик	Ажиллаж байгаа	2014 онд АХБ-ний санхүүжилтээр хийгдсэн
5	Говь-Алтай	Алтай сум	"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ	1990, 2014	3000	Механик	Ажиллаж байгаа	2014 онд АХБ-ны зээл "МОН-2301" төсөл хэрэгжсэн
6	Говьсүмбэр	Сүмбэр сум	"Ус-Ду" ОНӨҮГ	2008	3000	Механик	Ажиллаж байгаа	БНПУ-ын хөнгөлөлттэй зээлээр
								шинэчлэх төсөл хэрэгжинэ.
		Баянтал сум	"Талын илч" ОНӨААТҮГ	2010	100	Механик	Ажиллаж байгаа	Үгүй
7	Дархан-Уул	Дархан сум	"Дархан суваг" ХК ус	1965	50000	Механик-биологи	Ажиллаж байгаа	Азийн хөгжлийн банкны МОН 3244/3245" төсөл хэрэгжиж байгаа гүйцэтгэл 60% байгаа.
		Хонгор сум	"Эмт наран" ОНӨААТҮГ	1969	200	механик	Ажиллаж байгаа	Үгүй
		Шарын гол сум	"Дулаан шарын гол" ТӨХК	1978	3000	Механик-биологи	Ажиллаж байгаа	Үгүй
8	Дорнод	Хэрлэн сум	"Дорнод НАА" ХХК	1969	10000	Механик	Хэвийн бус	БНПУ-ын хөнгөлөлттэй зээлээр шинэчлэх төсөл хэрэгжинэ.
9	Дорноговь	Сайншанд сум	"Чандмань Илч" ХХК	1987	2700	Механик	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
			"Чандмань Бадрал" ХХК	1994	3000	Механик-биологи	Ажиллаж байгаа	Үгүй
10	Дундговь	Мандалговь сум	"Дундговь ус" ОНӨААТҮГ	2001	2700	Механик	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
11	Завхан	Улиастай сум	"Амь-Ус трейд" ХХК	1973, 1985, 2001	1100	Механик, биологи	Хэвийн бус	БНПУ-ын хөнгөлөлттэй зээлээр шинэчлэх төсөл хэрэгжинэ.

		Тосоцэнгэл	"Тосон-Очирт хайрхан" ОНӨААТҮГ	2015	250	Механик, биологи	Ажиллаж байгаа	Үгүй
12	Орхон	Баян-Өндөр сум	"Эрдэнэт үйлдвэр" ХХК	1978	24000	механик-биологи-гүний-химийн	Ажиллаж байгаа	БНФУ-ын хөнгөлөлттэй зээлээр цэвэрлэх байгууламжийн өргөтгөл 2019 онд шинэчлэлийн ажил дуусна
			"Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ" ОНӨХК	1978	400	Механик	Хэвийн бус	Үгүй
13	Сэлэнгэ	Сүхбаатар сум	"Урсгал ус" ХХК	1989	7000	Механик, биологи	Ажиллаж байгаа	2012 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдсэн.
		Мандал сум	"Цант-Орхон" ХХК	1999	8000	Механик, биологи	Ажиллаж байгаа	үгүй
		Сайхан сум	"Гавшгай ус" ХХК	1985	3000	Механик	Ажиллаж байгаа	үгүй
		Салхит	"УБТЗ-ийн Барилга ашиглалт үйлчилгээний 1-р анги	1980	200	Механик	Ажиллаж байгаа	2018
		Орхонтуул сум		1980	100	Механик	Ажиллаж байгаа	2018
14	Сүхбаатар	Баруун-Урт сум	"Дөрвөлж" ХХК	1971	2700	Механик, биологи	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
15	Төв	Зуунмод сум	"Төв чандмань ДЭХГ" ОНӨҮГ	1988, 1994, 2011	2700	Механик, биологи	Ажиллаж байгаа	2011 онд цэвэрлэх байгууламжийг улсын төвлөрсөн төсвөөс өргөтгөх ажлыг хийсэн.
			"Нисэх буудлуудын удирдах газар"	2018	800	Механик, биологи	Бэлтгэлд	Ашиглалтад ороход бэлэн болсон
16	Увс	Улаангом сум	"Чандмань Увс" ХХК	2001	3800	Механик	Ажиллаж байгаа	БНПУ-ын хөнгөлөлттэй зээлээр шинэчлэх төсөл хэрэгжинэ.
17	Өвөрхангай	Арвайхээр сум	"Онги ус суваг" ОНӨҮГ	1997	3000	Механик, биологи	Ажиллаж байгаа	АХБ-ны "МОН 3388" төсөл 2018-2019 хэрэгжинэ
		Хархорин сум	"Хархорин ус суваг" ОНӨААТҮГ	2012	250	механик-	Ажиллаж байгаа	2012

18	Өмнөговь	Даланзадгад	"Гүний ус" ХХК	1971 он	2700	Механик, биологи	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
		Цогтцэций сум	"Ухаа худаг ус хангамж" ХХК	2012	1200	Механик, биологи	Ажиллаж байгаа	2012
		Гурвантэс сум	"Шугшаа уул" ОНӨААТҮГ	2016	300	Механик	Ажиллаж байгаа	2016
		Ханбогд сум	"Хандизель" ОНӨААТҮГ	2016	50	Механик	Ажиллаж байгаа	2016
19	Ховд	Жаргалант сум	"Шим-Ус" ОНӨААТҮГ	1987	2700	Механик	Хэвийн бус	2001
		Алтай сум		2013	50	Механик	Ажиллаж байгаа	2013
		Мянгад сум		2012	35	Механик	Ажиллаж байгаа	2012
		Зэрэг сум		2013	35	Механик	Ажиллаж байгаа	2013
20	Хэнтий	Өндөрхаан сум	"Хэнтий ус" ХХК	1989, 2001	2700	Механик	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
		Бор-Өндөр сум	"Бор өндөр хот тохижилт" ОНӨҮГ	1986	2100	Механик	Ажиллаж байгаа	1986 .
21	Хөвсгөл	Мөрөн сум	"Хөвсгөл ус сувар" ХХК	2001	1000	Механик	Хэвийн бус	АХБ-ны "МОН 3388" төсөл 2019-2021 хэрэгжинэ
22	Улаанбаатар хот	Сонгинохайрхан дүүрэг	Төв цэвэрлэх байгууламж	1963	170000	Механик, биологи	Хэвийн бус	1979, 1986 онуудад өргөтгөл. 1998-1999, 2001-2004, 2006-2008 онуудад тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн, 2019-2022 онд шинэ цэвэрлэх байгууламж баригдана.
				1979	1000	Механик, биологи	Ажиллаж байгаа	1996 онд өргөтгөл хийгдсэн. 2012 онд КУ байгууламжийн дээр сандвичэн барилга барьсан
		Хан-Уул дүүрэг	Нисэхийн цэвэрлэх байгууламж	1971, 2014	3000	Механик, биологи	Ажиллаж байгаа	1989 онд өргөтгөл хийгдсэн
				Морингийн давааны цэвэрлэх байгууламж	2018	20000	Механик, биологи	Бэлтгэлд
		Биогийн цэвэрлэх		1990	1000	Механик, биологи	Ажиллаж байгаа	2010 онд КУ байгууламжийн

		байгууламж					дээр сандвичэн барилга барьсан
		Урьдчилан цэвэрлэх байгууламж	1972	13000	механик, хими	Хэвийн бус	1975 2010- онд өргөтгөл хийгдсэн.
	Сүхбаатар дүүрэг	Дамбын цэвэрлэх байгууламж	2013	100	Механик, биологи	Ажиллаж байгаа	2010
	Багахангай	Багахангайн цэвэрлэх байгууламж	1989	2500	Механик, биологи	Ажиллаж байгаа	2014 оноос улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа
	Багануур	"Багануур-Ус" ОНӨААТҮГ	1983	8500	Механик, биологи	Ажиллаж байгаа	1991
	Налайх	"Чандмань Налайх" ОНӨААТҮГ	2015	1000	Механик, биологи	Ажиллаж байгаа	2015

11. НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН СУДАЛГАА

Хот байгуулалтын үйл ажиллагааны нэг томоохон бүлэг болох "нийгмийн дэд бүтэц" гэж соёл, боловсрол, худалдаа, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолбор юм. Хот байгуулалтын үйл ажиллагаа, хот төлөвлөлтийн бүх үе шатны тооцооллыг боловсруулахад тухайн орон нутгийн хүн амын өсөлт, бууралт, хөгжлийн бодлогод суурилж цаашдын чиг хандлагыг тодорхойлдог.

Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм БНБД 30-01-04-т нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний түвшингээр 2 ангилан 1000 хүнд ноогдох хэрэгцээгээр нь тухайн орон нутгийн төлөвлөлтийг хийдэг.

Хүснэгт 11.1. Соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний ангилал

Үнэлэх хүчин зүйлс		Үнэлэх үзүүлэлтийн шинж чанар	Нормативт үзүүлэлт
Хангамжийн ангилал			
Соёл, олон нийт, ахуйн үйлчилгээний хангамжийн түвшин	Өдөр тутмын зориулалттай барилга	Сургууль	1000 хүнд 200 сурагч
		Цэцэрлэг	1000 хүнд 100 хүүхэд
		Өрхийн эмнэлэг	35 үзлэг/өдөр
		Нийтийн хоол	1000 хүнд 40 суудал
		Ахуйн үйлчилгээ	1000 хүнд 9 ажилчин
	Тусгай зориулалттай барилга	Нэгдсэн эмнэлэг	1000 хүнд 9 ор
		Спортын барилга	1000 хүнд 80 м ² шалны талбай
		Соёлын ордон	1000 хүнд 33 суудал
		Кинотеатр	1000 хүнд 30 суудал
		Музей	1000 хүнд 30 м ² үзмэрийн талбай

Тайлбар: Үзүүлэлтүүдийг БНБД 30-010-04-өөс түүвэрлэв.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сум сууринд нийгмийн дэд бүтцийн одоо байгаа хүчин чадлыг төслийн хүчин чадалд харьцуулан 2017 оны эцсийн байдлаар тухайн орон нутагт оршин сууж байгаа хүн амд хүртээмжтэй буй эсэх хангамжийн түвшинийг тодорхойлох зорилготой.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

- Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулахад ашиглагдах суурь мэдээлэл болно.
- Хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдөл болгох;

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сумын нийгмийн дэд бүтцийн өдөр тутмын зориулалттай барилга байгууламж болох сургууль, цэцэрлэгийн одоогийн байдал, төслийн хүчин чадалд харьцуулсан харьцааг хүн амын өсөлттэй уялдуулан хангамжийн хувийг тодорхойлсон.

- Судалгааны ерөнхий зарчим, зохион байгуулалт, мэдээлэл цуглуулалт

Судалгаагаар Боловсрол, Шинжлэх ухаа, Соёл Урлагийн яамнаас жил бүр гаргадаг эмхэтгэл, “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” (БНБД 30-01-04-тэй уялдуулан, ЕБС, цэцэрлэгийн одоогийн хүчин чадлыг нь төслийн хүчин чадалд харьцуулан, төслийн хүчин чадлаас давсан, бага байгаа сурагч, хүүхдийн тоог тооцож гаргаж, хэрэгцээг тооцлоо.

“Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” (БНБД 30-01-04)-ийн зөвлөмжийн 13 дугаар хавсралтын заалтын дагуу ЕБС, цэцэрлэгийн норм болон төслийн хүчин чадлыг ЕБСургууль 12 жилийн бүтцэд шилжсэнтэй холбогдуулан 6-7 настай хүүхдүүдийн сургуульд хамруулах зарчмыг баримтлан тодорхойлсон болно.


- Судалгааны түүвэрлэлт

Улсын хэмжээнд 21 аймаг, 330 сум, суурины статистик мэдээнд тулгуурлан, судалгааг гаргав.


11.1. Боловсролын үйлчилгээ

11.1.1. Сургуулийн өмнөх боловсрол

Зураг 11.1.1.1. Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо, мянгаар, 2000-2045 он




Зураг 11.1.1.2. 2-5 насны хүүхдийн нийт хүн амд эзлэх хувь, 2000-2045 он




Хүн амын өсөлтийн хандлагаас үзвэл цэцэрлэгийн үйлчилгээнд хамрагдах насны хүүхдийн нийт хүн амд эзлэх хувь 2025-2030 онд буураад түүнээс цааш өсөх төлөвтэй байна.


Зураг 11.1.1.3. Цэцэрлэгийн хангамж, 1960-2018 он



Зураг 11.1.1.4. Монгол Улсын хэмжээнд СӨБ-д хамрагдалтын хувь, 2000-2018




Зураг 11.1.1.5. Цэцэрлэгт хамрагдалтын хувь, 2018-2019 онд, бүсүүдээр



Зураг 11.1.1.6. Нэг бүлэг дэх хүүхдийн тооны бүлгээрх цэцэрлэгүүдийн тоо, төрийн болон хувийн өмчийн нийт цэцэрлэгүүдээр, 2018-2019




Зураг 11.1.1.7. Төрийн өмчит цэцэрлэгүүдийн нэг бүлэг дэх хүүхдийн тоогоорх бүлэглэл, нийт дүнд эзлэх хувиар, 2018-2019




Монгол Улсын хэмжээнд төрийн өмчит нийт цэцэрлэгүүдийн 80,7 хувь нь нэг бүлэгт 40-өөс дээш хүүхэдтэй байгаа нь улсын хэмжээгээр цэцэрлэгийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгааг харуулахын сацуу цаашид ч цэцэрлэгүүдийг шинээр барих, хүчин чадлыг нь өргөтгөх эрэлт хэрэгцээ байхыг харуулж байна.

Зураг 11.1.1.7. 1 бүлэгт хамрагдсан хүүхдийн тоо, бүс, аймгаар, 2018-2019 он



Зураг 11.1.1.8. Цэцэрлэгийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо, хотуудаар, 2018-2019



Улаанбаатар хотын төвийн дүүргүүд болон Улаангом, Замын-Үүд, Арвайхээр, Тосонцэнгэл, Мөрөн, Мандалговь хотуудад СӨБ-ын үйлчилгээний ачаалал өндөр (1 бүлэгт ногдох хүүхдийн тоо) байна.

Харин аймгуудын хөдөөгийн сумдад харьцангуй бүлэг дүүргэлт хотуудтай харьцуулахад харьцангуй хэвийн түвшинд байна.

Хүснэгт 11.1.1.1. Цэцэрлэгийн барилгын хүчин чадал төлөвлөлтийн хүн амын тоотой уялдаж буй байдал

№	цэцэрлэг	Төлөвлө сөн хүчин чадал, ор 2019	нийт хүн ам	2-5 насны хүүхэд	Хамраг даж буй хүүхди йн тоо	Одоо байгаа хүчин чадал, ор	Хүчин чадал ашигла лтын зөрүү
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хэнтий, Дэлгэрхаан сум/	100	2555	230	159	90	59
2	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Хэнтий, Цэнхэрмандал сум/	120	2059	185	118	75	-2
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	150	5684	512	319	90	169
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэмандал сум/	150	5705	513	136	150	-14
5	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	150	5077	457	308	140	158
6	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Төв, Эрдэнэ сум/	150	4029	363	115	75	-35
7	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Мянгад сум/	150	3684	332	121	75	-29
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	150	4423	398	136	100	-14
9	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Их-Уул сум/	150	4163	375	200	120	50
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Тариалан сум/	150	6218	560	266	180	116
11	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Дундговь, Өндөршил сум/	200	1421	128	89	75	-111
12	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/	200	7963	717	852	665	652
13	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Норовлин сум/	200	2527	227	131	50	-69
14	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	200	5789	521	334	200	134
15	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Увс, Тариалан сум/	200	4040	364	207	105	7

Хүн амын өсөлт болон шилжилт хөдөлгөөнтэй уялдан сүүлийн жилүүдэд цэцэрлэгийн насны хүүхдийн тоо нэмэгдсэн, мөн шинэ барилга байгууламжууд хангалттай хэмжээнд баригдаагүйгээс хамаарч, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж улсын хэмжээгээр хангалтгүй байна. Байршлын хувьд авч үзвэл Улаанбаатарт хүчин чадлаас дунджаар 85 хувь, аймгийн төв хотуудад 20-30 хувь, сумдын түвшинд 0-10 хувийн хэтрэлттэй байна. Улсын хэмжээгээр 228 цэцэрлэгийн нэг бүлгийн хүүхдийн тоо 40-68,8 байгаа бөгөөд эдгээр цэцэрлэгийн 83 хувь нь нийслэлд байна. Тодруулбал нэг бүлэгтээ 50-иас дээш хүүхэдтэй 56 цэцэрлэгийн 54 нь нийслэлд байгаа нь цэцэрлэгийн хүчин чадал хэтрэлт Нийслэлд хамгийн өндөр байгааг харуулж байна.

11.1.2 Ерөнхий боловсрол

2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 803 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 81.7 хувь нь төрийн өмчийн, 18.3 хувь нь хувийн сургууль байна.

Хүснэгт 11.1.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн тоо

	Ерөнхий боловсролын сургууль							
	Бүгд	төрийн	хувийн	Бүгд	бага	дунд	ахлах	цогцолбор
2014-2015	762	628	134	762	62	136	514	50
2015-2016	768	636	132	768	62	118	538	50
2016-2017	778	645	133	778	69	117	542	50
2017-2018	798	652	146	798	74	116	562	46
2018-2019	803	656	147	803	80	115	563	45

БСШУСЯ-ны статистик мэдээ


Хүснэгт 11.1.2.2. Ерөнхий боловсролын сургууль (байршил, хэв шинжээр)

	Ерөнхий боловсролын сургууль								
	Бүгд	хот	хөдөө	Бүгд	ердийн	мэргэжлийн	гүнзгий рүүлсэн	тусгай	олон улсын хөтөлбөр
2014-2015	762	214	548	762	633	14	100	6	9
2015-2016	768	215	553	768	662	14	81	6	5
2016-2017	778	226	552	778	684	15	66	6	7
2017-2018	798	241	557	798	705	16	63	6	8
2018-2019	803	245	558	803	708	15	67	6	7

БСШУСЯ-ны статистик мэдээ

Нийт сургуулийн 69.5 хувь буюу 558 нь хөдөөд, 30.5 хувь буюу 245 нь нийслэлд сургалтын ажил эрхэлж байна. Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд 28 сургуулийн 212 бүлэгт 8,451 суралцагч 3 ээлжээр хичээллэж байна. Эдгээр 3-р ээлжийн бүлгийн 85.4 хувь нь бага ангийн, 11.8 хувь нь дунд ангийн, 2.8 хувь нь ахлах ангийн бүлэг байна. 3 ээлжээр хичээллэж байгаа 28 сургуулийн 5 нь хөдөө аймагт, 23 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс их буюу 38.0-54.4-тэй нэр бүхий нийслэлийн 35, аймгийн 3 сургууль үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 11.1.2.1. Архангай аймгийн хүн амын өсөлт 2015-2017, 2018-2020 оны байдлаар



Тайлбар: Архангай аймгийн хүн амын өсөлтийг сүүлийн 3 жилээр авч үзэхэд аймгийн төв, сумын хүн ам байнгын өссөн үзүүлэлттэй байна. Архангай аймгийн хувьд хүн амын өсөлтийн коэффициент сум тус бүрт харилцан адилгүй байгаа ч дундажаар 0,0182 байна. Хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент тухайн 2017 оны байдлаар 18.2 байгаа нь хүн амын тоо 1000 хүн тутамд ойролцоогоор 18-аар нэмэгдэж байгааг харуулж байна. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрмийн дагуу хүн амын ердийн өсөлтийг 2020 он хүртэл тооцоолж ЕБС-ийн хэрэгцээг тодорхойлов.


Хүснэгт 11.1.2.3. Архангай аймгийн шилжилт хөдөлгөөн

№	Ангилал	2013	2014	2015	2016	2017
1	Шилжиж явсан	1706	2337	1706	1226	744
2	Шилжиж ирсэн	637	570	637	667	1022
	Зөрүү	-1069	-1767	-1069	-559	278

Тайлбар: Архангай аймгийн хувьд хүн амын шилжилт хөдөлгөөн 2013-2016 онд шилжин явсан хүн их байсан нь Нийслэлийн хүн амын хязгаарлалтын бодлого хийгдээгүй, эдийн засгийн бууралт ихтэй жилүүд байв. 2017 оны байдлаар тус аймгийн Нийслэл хот шилжилт хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан шилжилт хөдөлгөөн тогтворжсон нь хүн амын хувьд ердийн өсөлт явагдана гэсэн гэж дүгнэсэн. Иймд ЕБС-ийн өсөлтийг 2020 он хүртэл хүн амын өсөлттэй уялдуулан тооцоолол хийлээ.

Судалгааны ажилд нэмэлтээр ЕБС-ийн барилгын баригдсан он, инженерийн шугам сүлжээний дулаан хангамжийн эх үүсвэрийг судаллаа.

Зураг 11.1.2.2. Сургуулийн барилгуудын баригдсан он




Тайлбар: Архангай аймгийн хувьд төрийн өмчийн сургуулиудын баригдсан оныг үзүүлэв.

Зураг 11.1.2.3. Дулаан хангамжийн эх үүсвэр



Тайлбар: Архангай аймгийн хувьд Төвлөрсөн дулаан хангамжинд Аймгийн төвийн 6 сургуулиас гадна Чулуут, Жаргалант, Өгийнуур, Хашаат, Цахир сумууд холбогдсон бусад сумдын сургуулийн барилга уурын зуухаар халдаг.

Зураг 11.1.2.4. Архангай аймгийн сургуулийн одоогийн байдал



Тайлбар: Судалгаанаас гарсан үзүүлэлтэд дүн шинжилгээ хийхэд Хүн амын өсөлт, хот төлөвлөлтийн норм ба дүрэмтэй (ЕБС-ийн 1 ээлжээр хичээллүүлэх) уялдуулан барилгын

хүчин чадлаас 30% хэтэрсэн тохиолдолд өргөтгөж, 60% давсан үед шинээр сургууль төлөвлөх шаардлагатай дүгнэлт гарч байна.

Хүснэгт 11.1.2.4. Дээрх судалгааг дүгнэвэл:

№	Аймаг, сумын нэр	Сурагчдын тоо	Дүгнэлт
1	Чулуут	250	Нэмж төлөвлөх
2	Өлзийт	264	Нэмж төлөвлөх
3	Цахир	188	Нэмж төлөвлөх
4	Аймгийн төвд	2864	Нэмж төлөвлөх

Тайлбар: Судалгаанаас үзэхэд Төрөөс боловсролын талаар баримтлах 2014-2024 хүртэлх бодлогын шалгуур үзүүлэлтээр Аймгийн төвд 2864 сурагчтай ЕБС, Чулуут, Өлзийт, Цахир сумдуудад 702 хүүхдийн ЕБС нэмж төлөвлөх шаардлагатай гэж дүгнэлээ.

Судалгааны дүгнэлт

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дээрх судалгааг дүгнэвэл төслийн хүчин чадлаас 60 хувиас дээш давсан тохиолдолд сургуулийн сургууль нэмж төлөвлөх, төслийн хүчин чадлын 30-60 хувь хэтэрсэн тохиолдолд тухайн орон нутгийн сургуулийг өргөтгөх шаардлагатай байна. Тодруулбал 21 аймаг, 330 сумын хэмжээнд 2017 оны байдлаар судалгаагаар 47648 хүүхэд барилгын хүчин чадлаас давсан барилга байгууламжид суралцаж байна.

Боловсролын үйлчилгээний таталцал хөдөө орон нутгаас Улаанбаатар, аймгийн төв болон томоохон газрууд руу илүү ихээр таталцаж байгаа нь нэг талдаа үйлчилгээний ачааллыг хэт нэмэгдүүлж байгаа ч нөгөө талдаа зарим сум орон нутагт сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж ашиглалт сул байхад хүргэж байна. Сургуулийн хувьд судалгааг дүгнэвэл хүн амын өсөлттэй уялдуулан шинээр төлөвлөх болон өргөтгөл хийхээс гадна хөдөөгийн сумдад суралцах насны бодит хүн амын тоонд нь уялдуулан сургууль, цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг оновчтой төлөвлөх шаардлагатай байна. Тухайлбал 200 хүүхэд суралцаж байгаа зарим суманд 320 хүүхдийн сургууль барьж байгаа нь нэг удаагийн барилгын өртөг зардал их гарахаас гадна жил бүр ашиглалтын урсгал үрэлгэн зардлыг нэмэгдүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжуудын хүчин чадал, байршил, эрэмбэ дараалалд дүгнэлт гаргаж өгдөг мэргэжлийн байгууллага зайлшгүй шаардлагатай байна. Ийм зүйл дутагдсанаас суралцаж буй хүүхдийн тооноос 1-2 дахин хэтэрсэн хүчин чадалтай сургууль, цэцэрлэг шинээр баригдсаар байгаа нь улсын төсвийн үрэлгэн зардлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал Дундговь аймгийн Өндөршил сумын цэцэрлэгт 89 хүүхэд суралцаж байхад 200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг шинээр барьж байна. Харин Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын цэцэрлэгт 160 хүүхэд суралцаж байхад 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 2019 онд шинээр барьж байна. Нийслэл болон аймгийн төвд хүн амын өсөлт болон нийгэм-эдийн засгийн таталцлыг нь харгалзан

аль болох хүчин чадал өндөртэй сургууль, цэцэрлэгүүдийг төлөвлөж барих шаардлагатай байна.

11.1.3. Дээд болон техникийн мэргэжлийн боловсрол

Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино” гэж заасан байдаг.

Нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр дээд боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгддэг. Улс орны эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дээд боловсролд хөрөнгө оруулалт хийх нь нэн чухал болохыг Монгол Улсын Засгийн газраас онцлоод сургалтын агуулга, чанар, хүртээмжийг сайжруулж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс их дээд сургуулийн тоог цөөлөх нэгтгэх ажлууд үе шаттайгаар хэрэгжиж байна.


Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2001/2002 оны хичээлийн жилд 178 байсан бол 2005/2006 оны хичээлийн жилээс тогтмол буурсаар 2018/2019 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 94 болж, 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад 84 (47.2%)-өөр буурсан байна.

Зураг 11.1.3.1. Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо болон суралцагчид, мянган хүн, 2001-2018 он



Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоог аймгаар авч үзвэл, 2018-2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 146.0 мянга (92.6 %) нь Улаанбаатар хотод, 3.6 мянга (2.3 %) нь Дархан-Уул аймагт, 8.0 мянга (5.1 %) нь бусад аймагт суралцаж байна.

Газрын зураг 11.1.3.1 Их, дээд сургууль, коллежид суралцагчид, аймгаар, 2018-2019 оны хичээлийн жилд




Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2001/2002 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 57.3 мянга (63.2 %) нь эмэгтэй суралцагчид байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд энэ үзүүлэлт 93.6 мянга болж, 36.3 мянга (63.2%)-аар өссөн байна.

Зураг 11.1.3.2. Нийт суралцагчид, мянган хүн, хүйсээр, 2001-2018 он



Нийт суралцагчдыг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд 31.0 мянга (19.7 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлд, 23.3 мянга (14.8 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлд, 22.4 мянга (14.2 %) нь анагаах ухааны чиглэлд, 16.8 мянга (10.6 %) нь инженерийн чиглэлд, 12.3 мянга (7.8 %) нь хууль, эрх зүйн чиглэлд, 51.9 мянга (32.9 %) нь бусад чиглэлд тус тус суралцаж байна.


Зураг 11.1.3.3. Нийт суралцагчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2001-2018 он




Суралцагчдын тоог салбараар авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 50.4 мянга (32.0%) нь, 2008/2009 оны хичээлийн жилд 59.6 мянга (37.0%) нь нийгмийн ухааны салбарын мэргэжлийг сонгон суралцсан байна.

2001/2002 оны хичээлийн жилд нэг багшид 17.1 оюутан ногдож байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 39.4 хувиар нэмэгдэж нэг багшид 23.6 оюутан ногдож байна. Нэг багшид ногдох оюутны тоог аймгаар авч үзвэл, Улаанбаатар болон Баянхонгор, Архангай аймгуудад 2018-2019 оны хичээлийн жилд нэг багшид 24.8-26.0 оюутан ногдож байгаа бол Говь-Алтай, Увс, Баян-Өлгий, Завхан, Дорноговь, Хөвсгөл аймгуудад нэг багшид 10 хүрэхгүй оюутан ногдож байна.

Зураг 11.1.3.2. Нэг багшид ногдох суралцагчид, аймгаар, 2018-2019 оны хичээлийн жилд




Зураг 11.1.3.4. Аймгуудад суралцагсдын тоо, 2010 болон 2018 оноор



2018 оны байдлаар Булган, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар гэсэн 9 аймагт дээд боловсролын үйлчилгээ эрхэлдэг байгууллага байхгүй байна.

Зураг 11.1.3.5 Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид



Монгол улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 86 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгаагаас 84 нь үйл ажиллагаа явуулж байна. Нийт мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 51 буюу 60.7 хувь нь төрийн өмчийн, 33 буюу 39.3 хувь нь төрийн бус өмчийнх байна. Байршлаар аваад үзвэл аймгуудад суралцагсдын тоо сүүлийн 10 жилд 50 шахам хувиар буурсан бол Улаанбаатар хотод суралцагчдын тоо 70 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 11.1.3.1 Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо, 2007-2018 он

	2007	2011	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	29906	48134	42797	42675	40134	35831	37039
Баруун бүс	4219	6786	5937	5157	4603	4049	3847
Баян-Өлгий	762	1218	962	820	895	720	701
Говь-Алтай	883	1564	1162	612	486	379	339
Завхан	776	990	1185	1358	1098	1050	961
Увс	1307	1515	1372	1214	1122	901	757
Ховд	491	1499	1256	1153	1002	999	1089
Хангайн бүс	6476	8023	6729	6577	5897	5746	5355
Архангай	1240	1257	1228	1032	1119	1093	1427
Баянхонгор	1636	2118	1483	1429	1301	1068	1051
Булган	845	627	584	544	449	509	460
Өвөрхангай	1097	1487	1374	1594	1383	1472	1116
Хөвсгөл	835	929	670	704	583	491	333

Орхон	823	1605	1390	1274	1062	1113	968
Төвийн бүс	7547	11308	9400	8191	7491	6821	6499
Дорноговь	921	1197	1005	664	612	597	690
Дундговь	830	862	709	657	629	546	552
Өмнөговь	972	809	995	831	749	630	537
Сэлэнгэ	1905	1464	873	957	882	773	661
Төв	1335	1710	1546	1816	1687	1716	1596
Дархан-Уул	1388	4569	3564	2469	2123	1957	1815
Говьсүмбэр	196	697	708	797	809	602	648
Зүүн бүс	2697	3297	2327	2639	2349	2347	2253
Дорнод	1026	1539	1117	1236	1256	1379	1320
Сүхбаатар	759	593	417	473	389	299	331
Хэнтий	912	1165	793	930	704	669	602
Улаанбаатар	8967	18720	18404	20111	19794	16868	19085
Аймгуудад	20939	29414	24393	22564	20340	18963	17954

Нийт суралцагчдаас 10858 буюу 28.2 хувь нь аж үйлдвэр, 7466 буюу 19.4 хувь нь барилга, 4626 буюу 12.0 хувь нь тээвэр, 2691 буюу 7.0 хувь нь уул уурхай, 2262 буюу 9.9 хувь нь үйлчилгээний салбарын мэргэжлээр суралцаж байна.

Дүгнэлт

- Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 146.0 мянга (92.6 %) нь Улаанбаатар хотод, 11.6 мянга (7.4 %) нь хөдөө, орон нутагт суралцаж байна. Сүүлийн 8 жилд аймгуудад суралцагч оюутнуудын тоо 2 дахин цөөрчээ. Тэр дундаа хоёрдогч томоохон хотууд болох Дархан, Эрдэнэтэд суралцагч оюутнуудын тоо хамгийн ихээр цөөрсөн байна. Тодруулбал 2010 онд аймгуудад 20,7 мянган оюутан сурч байсан бол 2018 онд 11,6 мянга болж огцом буурчээ.
- Хүйсийн бүтцээр аваад үзэхэд аймгуудад суралцагч оюутнуудын 33 хувийг, нийслэлд суралцагч оюутнуудын 41 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.
- Монгол Улсын хүн амын хэтийн шинэчилсэн тооцоог ашиглаж 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын өсөлтийг түүхэн дундаж утгад үндэслэн тогтмол гэж таамаглавал 2020 онд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцах суралцагчдын тоо энэ хичээлийн жилээс 4.0 хувиар буурах бол 2045 онд 64.0 хувиар өсөх магадлалтай байна.
- Сүүлийн 18 жилийн турш худалдаа, бизнесийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын тоо бусад мэргэжлийн чиглэлүүдээс өндөр хэвээр байна. Өндөр өсөлт, бууралттай чиглэлүүдийг авч үзвэл, сүүлийн 18 жилийн хугацаанд архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр суралцагчдын тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад өндөр өсөлттэй байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 294 оюутан суралцаж байсан бол 2018/2019 оны хичээлийн жилд 6.1 мянга болж, 20.7 дахин нэмэгджээ.
- Боловсролын чанараар тэргүүлэх улс, орнуудтай харьцуулахад Монгол Улсын нэг багшид ногдох суралцагчдын тоо өндөр, харин 25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй энэ насны суралцагчдын эзлэх хувь бага байна. Олон улс дахь мэргэжлийн тэргүүлэх чиглэл нь санхүү, бизнесийн удирлага байгаа нь Монгол Улсад мөн адил тэргүүлж байна.

11.2. Эрүүл мэнд


Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ. Монгол улсын хүн амд өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, клиник, амаржих газар, нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сувилал, түргэн тусламжийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

2018 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 4343 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 13, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв 12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сум дундын эмнэлэг 39, сумын эрүүл мэндийн төв 273, өрхийн эрүүл мэндийн төв 219, хувийн ортой эмнэлэг 243, үүдэн эмнэлэг 1 340 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 11.2.1. Эрүүл мэндийн байгууллагуудын тоо, зэрэглэлээр

Эрүүл мэндийн байгууллагууд	2000	2005	2010	2015	2016	2017	2018
1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага							
Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	19	17	16	13	13	13	13
Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	-	3	4	5	5	5	5
Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	30	30	35	34	34	28	28
Сум дундын эмнэлэг	13	31	37	39	39	39	39
Сумын эрүүл мэндийн төв	334	287	274	272	273	273	273
Тосгоны эрүүл мэндийн төв	-	-	17	19	19	19	19
2. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага							
Хувийн эмнэлэг	466	683	1113	1230	1310	1466	1583
Өрхийн эрүүл мэндийн төв	99	228	218	218	220	218	219
Хувийн эмийн сан	321	514	666	967	1041	1277	1460

Зураг 11.2.1. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид, 2013-2018 он



Нэг их эмчид ногдох хүний тоо 2018 онд 283 байгаань өмнөх оныхоос 10 хүнээр, нэг сувилагчид ногдох хүний тоо 256 болж, өмнөх оныхоос 3 хүнээр тус тус буурсан. Нэг их эмчид ногдох хүний тоо Хангайн бүсэд хамгийн өндөр буюу 437 хүн ногдож байгаа ба баруун бүсэд 403, зүүн бүсэд 418, төвийн бүсэд 368 хүн ногдож байна. Улаанбаатар хотод нэг их эмчид ногдох хүний тоо 208, нэг сувилагчид ногдох хүний тоо 218 байна. Нэг сувилагчид ногдох хүний тоо төвийн бүсийн аймгуудад хамгийн өндөр буюу 309 байна.

Хүснэгт 11.2.2. Нэг их эмч, сувилагчид ногдох хүний тоо, бүс, аймгаар, 2016-2018 он

Аймаг, нийслэл	Нэг их эмчид ногдох хүний тоо			Нэг сувилагчид ногдох хүний тоо		
	2016	2017	2018	2016	2017	2018
Улсын дундаж	309	293	283	269	259	256
Баруун бүс	425	409	403	279	284	279
Баян-Өлгий	539	495	482	325	318	313
Говь-Алтай	319	305	300	223	225	227
Завхан	386	395	408	251	263	258
Увс	477	485	459	289	317	293
Ховд	404	374	368	297	289	292
Хангайн бүс	447	449	437	311	314	308
Архангай	503	548	516	335	345	334
Баянхонгор	485	461	435	289	294	295
Булган	503	505	558	311	317	324
Орхон	312	313	298	242	242	235
Өвөрхангай	442	445	438	344	350	350
Хөвсгөл	539	526	513	359	355	336
Төвийн бүс	375	369	368	309	305	309
Говьсүмбэр	322	301	277	270	256	268
Дархан - Уул	357	368	380	273	281	282
Дорноговь	295	304	285	291	265	276
Дундговь	348	326	340	293	308	303
Өмнөговь	343	342	342	345	369	358
Сэлэнгэ	455	438	434	361	326	334
Төв	457	430	437	309	317	326
Зүүн бүс	427	415	418	289	296	296
Дорнод	443	430	430	281	284	290
Сүхбаатар	391	397	395	278	282	279
Хэнтий	443	416	427	309	322	319
Улаанбаатар	237	218	208	240	222	218


Эмч, сувилагчийг байршлаар авч үзэхэд хөдөө орон нутагт 10000 хүн амд ногдох их эмч 24.7, сувилагч 33.4 байхад Улаанбаатар хотод эмч 48.2, сувилагч 45.9 байгаань хот суурин газар эмчийн нягтрал ихтэй байгаа нь харагдаж байна. Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад мэс заслын эмч 2.2 дахин, гэмтэл, согог заслын эмч 2.3 дахин, дүрс оношилгоо, нүүр амны эмч 3.2-3.8 дахин тус тус бага байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад 1800-2000 хүн тутамд 1 их эмч ажиллана гэж заасан хэдий ч 2018 оны байдлаар улсын хэмжээнд 1 өрхийн эмчид 2147 хүн ногдож байна. Баян-Өлгий, Баянхонгор, Говь-сүмбэр, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд аймагт нэг их эмчид ногдох хүний тоо стандартад заасан хэмжээнд байгаа бусад аймгуудад стандартын хэмжээнээс өндөр байна.

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяанутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай

байж болно. Сум дундын эмнэлэг нь хүн амын суурьшил, нягтралаас хамааран харьяалалын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. 2013 онд батлагдсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”-аар сумын эрүүл мэндийн төвүүд нь аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймгийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран 3 зэрэглэлд ангилна. Нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ийн дотор үйлчлэх хүрээний хүн ам 3000 хүртэл, хоёрдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50-99 км-ийн дотор болон 1-2 цаг хүртэлх хугацаанд зорчих сумын эрүүл мэндийн төв, гуравдугаар зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 100 км-ээс алс, сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэг хамаарна гэж заасан. Гэвч сумын эрүүл мэндийн төв нь аймгийн төвөөс 50 км-ээс дотогш боловч үйлчлэх хүрээний хүн амын тоо 3000-аас дээш, хүн амын 70-аас дээш хувь нь сумын төвөөс алслагдсан бол хоёрдугаар зэрэглэлд, 100 км-ээс дотогш боловч хүн амын тоо 8000-аас дээш бол гуравдугаар зэрэглэлд хамааруулна гэж заасны дагуу доорх хүснэгтэд сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэлийг тогтоосон.


Зураг 11.2.2. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн тоо, 2018 он



2018 оны байдлаар эмнэлгийн нийт орны 15.9 хувь нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2015 онтой харьцуулбал 767 ороор буюу 23.8 хувиар нэмэгдсэн. Дундаж ор хоног 2015 онд 6.9 байсан бол 2018 онд 6.6 болж буурсан. Сумын

эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2015 онд 2.3 байсан бол 2018 онд 2.1 болж буурсан.

Зураг 11.2.3. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2016-2018 он



Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт жилд 115.0 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2018 онд хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 2015 онтой харьцуулахад сум дундын эмнэлэгт 8.8, сумын эмнэлэгт 6.4 хувиар тус тус нэмэгдсэн.

Хүснэгт 11.2.3. Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд, 2015, 2017-2018 он

Үзүүлэлт	2015 он			2017 он			2018 он		
	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Нийт дүн	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Нийт дүн	Сумын эмнэлэг	Сум дундын эмнэлэг	Нийт дүн
Эмнэлгийн орны тоо	2546	667	3213	3081	722	3803	3204	776	3980
Их эмчийн тоо	661	224	885	755	235	990	797	237	1034
Сувилагчийн тоо	1448	276	1722	1438	278	1716	1557	285	1842

Дундаж хоног	ор	6.9	6.7	6.9	6.9	6.6	6.8	6.7	6.5	6.6
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо		88386	19327	107713	93948	20211	114159	94003	21029	115032

Дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд нийт орны 10.2 нь хувь ногдож байгаа бөгөөд дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2015 онд 93.4 мянга байсан бол 2018 онд 125.1 мянга болж, 31.6 мянган хүнээр нэмэгдсэн байна. 2018 оны байдлаар 16 аймгийн нэгдсэн эмнэлэгт 1163 их эмч, 1783 сувилагч, 662 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 5124 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Улаанбаатар хотын дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвүүдэд 869 их эмч, 981 сувилагч, 327 эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, нийтдээ 3274 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 14.7 хувь нь ногдож байгаа бөгөөд 2018 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн орны тоо 3646 буюу 2015 онтой харьцуулахад 268 ороор нэмэгдсэн байна.

Хүснэгт 11.2.4. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлт, 2015-2018 он

Үзүүлэлт	2016 он		2017 он		2018 он		Сүүлийн 3 жилийн дундаж	
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
Эмнэлгийн орны тоо	3613	2168	3588	2386	3646	2528	3616	2361
Их эмчийн тоо	1071	813	1113	840	1163	869	1116	841
Сувилагчийн тоо	1723	889	1755	943	1783	981	1754	938
Дундаж ор хоног	7.3	6.8	7.2	6.7	7.1	6.6	7.2	6.7
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	142,658	109,579	138,161	112,314	143,144	125,096	141321	115663
Хоног болоогүй нас баралтын хувь	31.3	25.0	35.1	30.9	29.3	26.9	31.9	27.6

Сүүлийн 3 жилийн дунджаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 15.3 хувийг хөдөөнөөс буюу сум, сум дундын эмнэлгээс илгээсэн өвчтнүүд эзэлж байна. 2018 онд хөдөөнөөс аймгийн нэгдсэн эмнэлэгт ирж хэвтэн эмчлүүлэгчид өмнөх онтой харьцуулахад 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн аргачилсан зөвлөгөө өгөх,

сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм. Манай улсын эрүүл мэндийн салбарт Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгуудад 5 Бүсийн оношлогоо, эмчилгээний төв үйлчилгээ явуулдаг боловч үйлчилж байгаа хүрээг нь авч үзвэл ойр орчмын аймаг, сумдаас 1-ээс хамгийн ихдээ 5% нь үйлчлүүлж байгаа нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь харагдаж байгаа юм. Ер нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд тодорхой хэмжээний үнэлгээнүүд цөөхөн хийгддэг ба үйл ажиллагаа нь хангалтгүй, 92-95 хувь нь зөвхөн тухайн аймагтаа аймгийн эмнэлгийн хэмжээнд ажиллаж байна. Энэ нь тухайн Бүсийн оношлогоо эмчилгээний төвд хамаарах бусад аймгуудад тусламж үйлчилгээ үзүүлж чадахгүй байна гэсэн үг юм. Мөн Бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд гадаад улсын төсөл хөтөлбөрүүдээс дэмжлэг үзүүлдгээс төрийн зүгээс туслалцаа, дэмжлэг үзүүлэх тал дээр хангалтгүй байдаг тул хөрөнгө санхүү, эмч, сувилагчийн хүрэлцээ дутагдалтай байна. Эмнэлгийн эмч, сувилагч, ажилтнуудын цалинг хуулинд тусгасан байдаг боловч алслагдсан орон нутагт ажиллагсдад үзүүлэх нэмэлт цалин, урамшууллыг тодорхой заагаагүй учраас хөдөө орон нутагт ажиллах эмч, сувилагчийн тоо хангалтгүй байдаг байна. Аймаг, сумын эмнэлгийн ажиллагсдын цалин, тэтгэврийн асуудлыг хуулинд тусгасан боловч алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа эмч нарт тусгайлсан дэмжлэг байхгүй байна.


Хүснэгт 11.2.5. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2015-2018 он

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2016	2017	2018	
Эмнэлгийн орны тоо	1539	1681	1682	1634
Дундаж ор хоног	7.5	7.2	7.2	7.3
Хоног болоогүй нас баралтын хувь	30.0	30.3	30.9	30.4
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	57050	54794	56252	56032


Хүснэгт 11.2.6. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2018 он

№	Аймаг	Нийт ажиллагчид	Их эмч	Сувилагч	Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой ажилтан	Орны тоо
1	Дорнод	506	103	169	76	336
2	Орхон	502	115	194	60	434
3	Өвөрхангай	382	94	132	58	305
4	Өмнөговь	242	65	78	37	349
5	Ховд	418	104	157	48	258
Дүн		2050	481	730	279	1682

Зураг 11.2.4. Аймгуудын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо /2018 он/



Газрын зураг 11.2.1. Төрөлтийн түвшин, 1000 хүнд ногдохоор, аймгаар, 2018 он



Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хөдөө орон нутгийн харъяат 7423 эх амаржсан нь өмнөх оноос 1458 төрөлтөөр өссөн ба Улаанбаатар хотод


бүртгэгдсэн төрөлтийн 18.4 хувийг эзэлж байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Архангай /25.3/, Өвөрхангай /19.1/, Завхан /20.3/, Булган /22.9/, Увс /19.9/, Ховд /19.1/, Говь-Алтай /19.4/, Ховд /19.1/, Хөвсгөл /23.6/, Төв /26.2/ аймгуудад улсын дунджаас 2.2-9.3 тохиолдлоор өндөр байна.

Хүснэгт 11.2.7. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, аймгаар, 2018 он


№	Аймаг, хотын нэр	10 000 хүн амд				
		Зүрх-судасны тогтолцооны өвчин	Хавдар	Өвчлөл ба нас баралтны гадны шалтгаан	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
1	Архангай	20.22	13.83	7.65	3.14	2.30
2	Баян-Өлгий	20.74	9.35	4.97	2.82	4.19
3	Баянхонгор	22.55	11.96	7.18	5.35	2.73
4	Булган	23.74	15.34	5.81	1.94	1.62
5	Говь-Алтай	23.68	15.55	5.88	1.73	1.04
6	Говьсүмбэр	11.47	8.60	6.31	5.16	2.29
7	Дархан-Уул	23.58	15.14	7.47	2.91	1.07
8	Дорноговь	12.63	11.91	15.54	5.95	3.19
9	Дорнод	16.93	17.31	9.02	3.96	2.35
10	Дундговь	21.24	18.24	8.58	3.00	2.15
11	Завхан	22.04	13.09	4.96	3.03	1.65
12	Орхон	18.45	13.57	9.47	2.44	0.88
13	Өвөрхангай	26.17	10.85	7.66	4.73	2.32
14	Өмнөговь	16.77	8.16	7.42	5.94	2.67
15	Сүхбаатар	16.62	17.27	8.55	3.07	1.45
16	Сэлэнгэ	19.63	13.85	5.60	3.30	1.83
17	Төв	20.90	12.66	7.07	2.22	2.74
18	Увс	18.41	19.37	6.50	1.93	1.68
19	Ховд	20.82	10.92	5.12	2.39	1.82
20	Хөвсгөл	29.04	11.78	9.31	3.00	1.65
21	Хэнтий	16.92	11.71	5.47	3.25	4.68
22	Аймгийн дундаж	20.88	13.27	7.42	3.32	2.20
23	Улаанбаатар	16.46	14.08	11.46	4.28	2.60
24	Улсын дундаж	18.88	13.64	9.25	3.76	2.38

Өвөрхангай, Хөвсгөл зэрэг Хангайн бүсийн аймаг зүрх судасны өвчин, Увс, Дорнод, Сүхбаатар аймаг хорт хавдараар, говийн бүсийн Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгууд хоол боловсруулах эрхтний тогтолцооны өвчлөлийн хүн амд ногдох нас баралтаар тэргүүлж байна.


Газрын зураг 11.2.2. Элэгний хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2018 он




Газрын зураг 11.2.3. Ходоодны хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2018 он




Газрын зураг 11.2.4. Улаан хоолойн хорт хавдрын нас баралт, 10000 хүнд ногдохоор, аймгаар, 2018 он



Газрын зураг 11.2.5. Зүрх судасны тогтолцооны өвчний нас баралт,
10000 хүнд ногдохоор, 2018 он



Газрын зураг 11.2.6. Хоол боловсруулах тогтолцооны өвчний нас баралт, 10000 хүнд
ногдохоор, 2018 он



Хүснэгт 11.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудын төлөвлөлт, байршил, хүчин чадлын хүн амын тоотой харьцуулалт, сумдаар, 2019 оны улсын төсөвт тусгагдсанаар

Эрүүл мэндийн төвүүд	Хүн амын тоо 2018
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Архангай, Цахир сум/	2413
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сүхбаатар, Дарьганга сум/	3083
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сүхбаатар, Наран сум/	1640
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/	3051
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Хүдэр сум/	2651
Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Сонгино сум/	1498
Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өвөрхангай, Баянгол сум/	3945
Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	5684
Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/	575
Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Хөвсгөл, Тосонцэнгэл сум/	4394

Сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгын хүчин чадлын төлөвлөлтийн үйлчлэх хүрээний хүн амын тоотой харьцуулахад боловсролын байгууллагын мөн адил хамаарал багатай байна. Тухайлбал Завхан аймгийн Сонгино сум 1600 хүнтэй ч 10 ортой эмнэлэг, түүнээс 2 дахин их хүнтэй Сүхбаатар аймгийн Дарьганга суманд мөн 10 ортой эмнэлэг төлөвлөн барьж байна.

Хүснэгт 11.2.9. Эрүүл мэндийн байгууллагын хүрэлцээ хангамж / Аймаг, сумаар/

№	Аймаг, сумын нэр	Хэмжих нэгж	Төслийн хүчин чадал /2019 оны байдлаар/	Нормоор	Төслийн хүчин чадлаас /+, - /	2018 онд хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	2018 оны жилийн эцсийн хүн амын тоо
1. Завхан аймаг							
1.	Улиастай /Нэгдсэн эмнэлэг/	Ор	213	136	77	10122	16696
2.	Алдархаан /ЭМТ/	Ор	8	24	-16	205	2913
3.	Асгат /ЭМТ/	Ор	8	8	0	177	981
4.	Баянтэс /ЭМТ/	Ор	10	21	-11	382	2632
5.	Баянхайрхан /ЭМТ/	Ор	8	15	-7	182	1838
6.	Дөрвөлжин /ЭМТ/	Ор	11	18	-7	183	2236
7.	Завханмандал /ЭМТ/	Ор	15	9	6	253	1110
8.	Идэр /ЭМТ/	Ор	10	21	-11	255	2535
9.	Их-Уул /ЭМТ/	Ор	19	53	-34	684	6446
10.	Нөмрөг /ЭМТ/	Ор	7	15	-8	163	1888
11.	Отгон /ЭМТ/	Ор	10	22	-12	197	2635
12.	Сантмаргац /ЭМТ/	Ор	8	13	-5	181	1591
13.	Сонгино /ЭМТ/	Ор	9	13	-4	152	1561
14.	Тосонцэнгэл /СДЭ/	Ор	77	76	1	2013	9326

15.	Түдэвтэй /ЭМТ/	Ор	22	16	6	275	1908
16.	Тэлмэн /ЭМТ/	Ор	10	23	-13	268	2816
17.	Тэс /ЭМТ/	Ор	9	24	-15	246	2905
18.	Ургамал /ЭМТ/	Ор	6	11	-5	151	1318
19.	Цагаанхайрхан /ЭМТ/	Ор	6	11	-5	204	1305
20.	Цагаанчулуут /ЭМТ/	Ор	6	11	-5	217	1289
21.	Цэцэн-Уул /ЭМТ/	Ор	6	13	-7	206	1667
22.	Шилүүстэй /СДЭ/	Ор	11	14	-3	212	1781
23.	Эрдэнэхайрхан /ЭМТ/	Ор	6	14	-8	159	1700
24.	Яруу /ЭМТ/	Ор	6	16	-10	126	2011
	ДҮН		501	595		17213	73088

2. Баян-Өлгий аймаг

1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Ор	311	295	219	18715	36930
2	Фатиха	Ор	38				
3	Жан шарапат	Ор	31				
4	Нурлы	Ор	38				
5	Бэйс-Шипа	Ор	31				
6	Нур-Алтай	Ор	20				
7	Сансар	Ор	40				
9	Хотгор	Ор	5				
10	Алтай	Ор	17	38	-21	481	4241
11	Алтанцөгц	Ор	9	26	-17	449	2849
12	Баяннуур	Ор	22	45	-23	558	4930
13	Бугат	Ор	9	36	-27	455	3870
14	Булган	Ор	23	48	-25	870	5192
15	Буянт	Ор	10	26	-16	461	2818
16	Сагсай	Ор	22	50	-28	705	5211
17	Толбо	Ор	16	43	-27	1002	4173
18	Улаанхус	Ор	33	75	-42	638	8602
19	Дэлүүн	Ор	29	64	-35	533	7437
8	Цагааннуур	Ор	8	74	-36	1154	8044
20	Ногооннуур	Ор	30				
21	Цэнгэл	Ор	33	88	-55	1111	9468
	ДҮН		775	908		27132	103765

3. Говь-Алтай аймаг

1	Есөнбулаг	Ор	270	154	116	9649	18931
2	Алтай	Ор	10	17	-7	349	2056
3	Баян-Уул	Ор	15	25	-10	336	3026
4	Бигэр	Ор	15	18	-3	252	2243
5	Бугат	Ор	10	18	-8	310	2210
6	Дарив	Ор	10	15	-5	277	1860
7	Дэлгэр	Ор	10	26	-16	225	3146
8	Жаргалан	Ор	10	15	-5	227	1826
9	Тайшир	Ор	10	13	-3	240	1599
10	Тонхил	Ор	10	18	-8	211	2222
11	Төгрөг	Ор	15	16	-1	310	2034
12	Халиун	Ор	10	20	-10	191	2458
13	Хөхморьт	Ор	10	19	-9	212	2367
14	Цогт	Ор	10	29	-19	328	3585

15	Цээл	Ор	10	18	-8	312	2207
16	Чандмань	Ор	10	18	-8	313	2247
17	Шарга	Ор	10	16	-6	238	1936
18	Эрдэнэ	Ор	10	19	-9	282	2327
	ДҮН		455	474		14262	58280
4. Ховд аймаг							
1	Жаргалант	Ор	362	248	114		30336
2	Алтай	Ор	11	27	-16		3310
3	Булган	Ор	33	84	-51		10217
4	Буянт	Ор	10	31	-21		3733
5	Дарви	Ор	11	25	-14		3032
6	Дөргөн	Ор	13	25	-12		3060
7	Дуут	Ор	8	17	-9		2064
8	Зэрэг	Ор	13	27	-14		3318
9	Манхан	Ор	15	35	-20		4277
10	Мөнххайрхан	Ор	10	18	-8		2217
11	Мөст	Ор	13	26	-13		3144
12	Мянгад	Ор	10	30	-20		3684
13	Үенч	Ор	12	33	-21		3996
14	Ховд	Ор	11	29	-18		3604
15	Цэцэг	Ор	10	26	-16		3133
16	Чандмань	Ор	11	24	-13		2955
17	Эрдэнэбүрэн	Ор	10	19	-9		2367
	ДҮН		563	723			88447
5. Увс аймаг							
1	Улаангом	Ор	360	258	102		31613
2	Баруунтуруун	Ор	18	22	-4		2742
3	Бөхмөрөн	Ор	11	19	-8		2292
4	Давст	Ор	10	14	-4		1687
5	Завхан	Ор	10	15	-5		1875
6	Зүүнговь	Ор	10	23	-13		2805
7	Зүүнхангай	Ор	10	19	-9		2353
8	Малчин	Ор	11	21	-10		2522
9	Наранбулаг	Ор	14	35	-21		4304
10	Өлгий	Ор	10	20	-10		2428
11	Өмнөговь	Ор	18	38	-20		4681
12	Өндөрхангай	Ор	18	27	-9		3247
13	Сагил	Ор	10	20	-10		2509
14	Тариалан	Ор	12	33	-21		4040
15	Түргэн	Ор	10	17	-7		2110
16	Тэс	Ор	22	43	-21		5238
17	Ховд	Ор	11	20	-9		2485
18	Хяргас	Ор	11	21	-10		2591
19	Цагаанхайрхан	Ор	12	17	-5		2095
	ДҮН		588	682			83617
6. Орхон аймаг							
1	Баян-Өндөр	Ор	715	812	-97		99490
2	Жаргалант	Ор	10	30	-20		3727
	ДҮН		725	842			103217
7. Өвөрхангай аймаг							

1	Арвайхээр	Ор	412	265	147		32347
2	Баруунбаян-Улаан	Ор	14	23	-9		2813
3	Бат-Өлзий	Ор	25	62	-37		7597
4	Баянгол	Ор	15	32	-17		3945
5	Баян-Өндөр	Ор	15	30	-15		3724
6	Богд	Ор	24	47	-23		5654
7	Бүрд	Ор	15	24	-9		2951
8	Гучин-Ус	Ор	14	18	-4		2209
9	Есөнзүйл	Ор	24	25	-1		3034
10	Зүүнбаян-Улаан	Ор	17	33	-16		4028
11	Нарийнтээл	Ор	25	30	-5		3668
12	Өлзийт	Ор	12	20	-8		2474
13	Сант	Ор	17	29	-12		3608
14	Тарагт	Ор	14	27	-13		3338
15	Төгрөг	Ор	12	23	-11		2763
16	Уянга	Ор	45	79	-34		9615
17	Хайрхандулаан	Ор	22	29	-7		3521
18	Хархорин	Ор	75	102	-27		12499
19	Хужирт	Ор	36	56	-20		6857
	ДҮН		833	955			116645

8. Булган аймаг

1	Булган_АТ	Ор	231	102	129		12582
2	Баян-Агт	Ор	9	27	-18		3251
3	Баяннуур	Ор	6	15	-9		1827
4	Бугат	Ор	6	18	-12		2198
5	Бүрэгхангай	Ор	10	23	-13		2872
6	Гурванбулаг	Ор	10	27	-17		3289
7	Дашинчилэн	Ор	8	24	-16		3008
8	Могод	Ор	8	22	-14		2711
9	Орхон	Ор	7	28	-21		3477
10	Рашаант	Ор	8	26	-18		3253
11	Сайхан	Ор	9	29	-20		3561
12	Сэлэнгэ	Ор	8	27	-19		3343
13	Тэшиг	Ор	9	29	-20		3560
14	Хангал	Ор	5	38	-33		4660
15	Хишиг-Өндөр	Ор	19	26	-7		3152
16	Хутаг-Өндөр	Ор	23	41	-18		5050
	ДҮН		376	502			61794

9. Баянхонгор аймаг

1	Баянхонгор_АТ	Ор	387	259	128		31685
2	Жаргалант	Ор	10	30	-20		3727
3	Баацагаан	Ор	9	27	-18		3307
4	Баянбулаг	Ор	10	15	-5		1767
5	Баянговь	Ор	11	24	-13		2922
6	Баянлиг	Ор	9	31	-22		3848
7	Баян-Овоо	Ор	9	22	-13		2650
8	Баян-Өндөр	Ор	14	22	-8		2668
9	Баянцагаан	Ор	15	29	-14		3590
10	Богд	Ор	9	25	-16		3113
11	Бөмбөгөр	Ор	12	27	-15		3288

12	Галуут	Ор	13	34	-21		4103
13	Гурванбулаг	Ор	9	18	-9		2216
14	Жаргалант	Ор	14	24	-10		2961
15	Жинст	Ор	9	18	-9		2192
16	Заг	Ор	10	17	-7		2073
17	Өлзийт	Ор	9	32	-23		3870
18	Хүрээмарал	Ор	11	14	-3		1748
19	Шинэжинст	Ор	10	20	-10		2449
20	Эрдэнэцогт	Ор	11	35	-24		4239
	ДҮН		591	721			88416
10. Архангай аймаг							
1	Эрдэнэбулган	Ор	309	181	128		22138
2	Батцэнгэл	Ор	9	31	-22		3803
3	Булган	Ор	7	22	-15		2757
4	Жаргалант	Ор	12	36	-24		4465
5	Их тамир	Ор	14	46	-32		5631
6	Өгийнуур	Ор	10	26	-16		3213
7	Өлзийт	Ор	11	28	-17		3454
8	Өндөр-Улаан	Ор	13	47	-34		5811
9	Тариат	Ор	20	41	-21		4981
10	Төвшрүүлэх	Ор	9	25	-16		3042
11	Хайрхан	Ор	12	31	-19		3829
12	Хангайн бүс	Ор	10	26	-16		3206
13	Хашаат	Ор	9	27	-18		3261
14	Хотонт	Ор	12	36	-24		4380
15	Цахир	Ор	7	20	-13		2413
16	Цэнхэр	Ор	14	48	-34		5917
17	Цэцэрлэг	Ор	10	31	-21		3821
18	Чулуут	Ор	10	34	-24		4167
19	Эрдэнэмандал	Ор	20	47	-27		5705
	ДҮН		518	781			95994
11. Хөвсгөл аймаг							
1	Мөрөн	Ор	562	330	232		40510
2	Алаг-Эрдэнэ	Ор	9	54	-45		6697
3	Арбулаг	Ор	11	33	-22		4025
4	Баянзүрх	Ор	15	32	-17		3984
5	Бүрэнтогтох	Ор	9	36	-27		4423
6	Галт	Ор	22	44	-22		5483
7	Жаргалант	Ор	19	44	-25		5428
8	Их-Уул	Ор	18	34	-16		4163
9	Рашаант	Ор	14	31	-17		3828
10	Рэнчинлхүмбэ	Ор	21	40	-19		4904
11	Тариалан	Ор	23	51	-28		6218
12	Тосонцэнгэл	Ор	10	36	-26		4394
13	Төмөрбулаг	Ор	13	36	-23		4373
14	Түнэл	Ор	9	35	-26		4298
15	Улаан-Уул	Ор	18	35	-17		4233
16	Ханх	Ор	15	23	-8		2822
17	Цагааннуур	Ор	9	16	-7		1978
18	Цагаан-Уул	Ор	17	47	-30		5728

19	Цагаан-Үүр	Ор	13	22	-9	2684
20	Цэцэрлэг	Ор	20	39	-19	4738
21	Чандмань-Өндөр	Ор	14	25	-11	3126
22	Шинэ-Идэр	Ор	18	27	-9	3278
23	Эрдэнэбулган	Ор	14	25	-11	3056
	ДҮН		893	1094		134371
12. Төв аймаг						
1	Зуунмод_АТ	Ор	256	141	115	17279
2	Алтанбулаг	Ор	9	26	-17	3233
3	Аргалант	Ор	8	14	-6	1679
4	Архуст	Ор	7	11	-4	1358
5	Батсүмбэр	Ор	15	57	-42	7052
6	Баян	Ор	7	18	-11	2222
7	Баяндэлгэр	Ор	7	13	-6	1561
8	Баянжаргалан	Ор	7	14	-7	1695
9	Баян-Өнжүүл	Ор	7	19	-12	2268
10	Баянхангай	Ор	8	12	-4	1452
11	Баянцагаан	Ор	7	15	-8	1884
12	Баянцогт	Ор	7	15	-8	1826
13	Баянчандмань	Ор	14	35	-21	4288
14	Борнуур	Ор	17	42	-25	5145
15	Бүрэн	Ор	10	25	-15	3114
16	Дэлгэрхаан	Ор	7	15	-8	1812
17	Жаргалант	Ор	16	55	-39	6727
18	Заамар	Ор	19	49	-30	5963
19	Лүн	Ор	9	21	-12	2573
20	Мөнгөнморьт	Ор	7	17	-10	2091
21	Өндөрширээт	Ор	7	17	-10	2068
22	Сүмбэр	Ор	7	14	-7	1782
23	Сэргэлэн	Ор	7	17	-10	2105
24	Угтаалцайдам	Ор	9	22	-13	2697
25	Цээл	Ор	7	21	-14	2629
26	Эрдэнэ	Ор	13	33	-20	4029
27	Эрдэнэсант	Ор	13	37	-24	4513
	ДҮН		507	774		95045
13. Сэлэнгэ аймаг						
1	Сүхбаатар	Ор	387	188	199	23151
2	Алтанбулаг	Ор	13	41	-28	5008
3	Баруунбүрэн	Ор	15	26	-11	3162
4	Баянгол	Ор	15	45	-30	5579
5	Ерөө	Ор	15	56	-41	6856
6	Жавхлант	Ор	10	16	-6	1962
7	Зүүнбүрэн	Ор	15	23	-8	2865
8	Мандал	Ор	170	221	-51	27241
9	Орхон	Ор	12	19	-7	2377
10	Орхонтуул	Ор	11	31	-20	3788
11	Сайхан	Ор	60	77	-17	9418
12	Сант	Ор	12	18	-6	2143
13	Түшиг	Ор	10	15	-5	1848
14	Хүдэр	Ор	12	22	-10	2651

15	Хушаат	Ор	12	17	-5		2065
16	Цагааннуур	Ор	20	41	-21		5077
17	Шаамар	Ор	12	33	-21		4064
	ДҮН		801	889			109255
14. Говьсүмбэр аймаг							
1	Сүмбэр_АТ	Ор	100	105	-5		12773
2	Баянтал	Ор	10	10	0		1201
3	Шивээговь	Ор	14	29	-15		3515
	ДҮН		124	143			17489
15. Дорноговь аймаг							
1	Сайншанд	Ор	307	206	101		25274
2	Айраг	Ор	15	31	-16		3766
3	Алтанширээ	Ор	7	11	-4		1360
4	Даланжаргалан	Ор	7	23	-16		2895
5	Дэлгэрэх	Ор	7	15	-8		1840
6	Замын-Үүд	Ор	85	155	-70		18930
7	Иххэт	Ор	10	17	-7		2112
8	Мандах	Ор	7	13	-6		1596
9	Өргөн	Ор	7	17	-10		2076
10	Сайхандулаан	Ор	7	11	-4		1378
11	Улаанбадрах	Ор	7	12	-5		1482
12	Хатанбулаг	Ор	10	23	-13		2872
13	Хөвсгөл	Ор	7	12	-5		1540
14	Эрдэнэ	Ор	8	20	-12		2439
	ДҮН		491	566			69560
16. Дархан-Уул аймаг							
1	Дархан	Ор	691	707	-16		86749
2	Орхон	Ор	16	27	-11		3300
3	Хонгор	Ор	14	50	-36		6115
4	Шарын гол	Ор	41	66	-25		8074
	ДҮН		762	849			104238
17. Өмнөговь аймаг							
1	Даланзадгад	Ор	461	213	248		25998
2	Баяндалай	Ор	10	17	-7		2079
3	Баян-Овоо	Ор	10	15	-5		1787
4	Булган	Ор	9	17	-8		2093
5	Гурвантэс	Ор	17	41	-24		5041
6	Мандал-Овоо	Ор	9	13	-4		1629
7	Манлай	Ор	12	21	-9		2586
8	Ноён	Ор	14	12	2		1408
9	Номгон	Ор	11	21	-10		2560
10	Сэврэй	Ор	11	16	-5		2002
11	Ханбогд	Ор	35	71	-36		8632
12	Ханхонгор	Ор	9	16	-7		1992
13	Хүрмэн	Ор	9	13	-4		1547
14	Цогт-Овоо	Ор	9	15	-6		1807
15	Цогтцэций	Ор	43	65	-22		7963
	ДҮН		669	565			69124
18. Дундговь аймаг							
1	Сайнцагаан	Ор	194	129	65		15762
2	Адаацаг	Ор	10	23	-13		2888

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ,
СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСӨЛ

ДУНДЫН ТАЙЛАН-1
БОТЬ 1: ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН
СУДАЛГАА

3	Баянжаргалан	Ор	4	10	-6	1276
4	Говь-Угтаал	Ор	8	13	-5	1586
5	Гурвансайхан	Ор	6	17	-11	2093
6	Дэлгэрхангай	Ор	9	19	-10	2291
7	Дэлгэрцогт	Ор	7	14	-7	1694
8	Дэрэн	Ор	8	17	-9	2105
9	Луус	Ор	7	15	-8	1864
10	Өлзийт	Ор	10	19	-9	2363
11	Өндөршил	Ор	8	12	-4	1421
12	Сайхан-Овоо	Ор	8	18	-10	2156
13	Хулд	Ор	9	20	-11	2416
14	Цагаандэлгэр	Ор	4	9	-5	1058
15	Эрдэнэдалай	Ор	17	48	-31	5847
	ДҮН		309	382		46820
19. Дорнод аймаг						
1	Хэрлэн	Ор	438	381	57	46710
2	Баяндун	Ор	11	25	-14	3112
3	Баянтүмэн	Ор	6	20	-14	2492
4	Баян-Уул	Ор	13	38	-25	4662
5	Булган	Ор	6	16	-10	1927
6	Гурванзагал	Ор	6	12	-6	1420
7	Дашбалбар	Ор	12	28	-16	3439
8	Матад	Ор	9	27	-18	3373
9	Сэргэлэн	Ор	8	16	-8	1966
10	Халхгол	Ор	13	25	-12	3128
11	Хөлөнбуйр	Ор	9	15	-6	1869
12	Цагаан-Овоо	Ор	10	29	-19	3608
13	Чойбалсан	Ор	7	22	-15	2742
14	Чулуунхороот	Ор	9	15	-6	1847
	ДҮН		557	671		82295
20. Сүхбаатар аймаг						
1	Баруун-Урт	Ор	249	176	73	21550
2	Асгат	Ор	9	15	-6	1880
3	Баяндэлгэр	Ор	17	41	-24	5033
4	Дарьганга	Ор	15	25	-10	3083
5	Мөнххаан	Ор	17	39	-22	4828
6	Наран	Ор	9	13	-4	1640
7	Онгон	Ор	21	31	-10	3835
8	Сүхбаатар	Ор	13	28	-15	3389
9	Түвшинширээ	Ор	13	28	-15	3398
10	Түмэнцогт	Ор	10	20	-10	2496
11	Уулбаян	Ор	12	24	-12	2938
12	Халзан	Ор	10	14	-4	1741
13	Эрдэнэцагаан	Ор	21	55	-34	6800
	ДҮН		416	511		62611
21. Хэнтий						
1	Хэрлэн	Ор	320	193	127	23671
2	Батноров	Ор	8	46	-38	5591
3	Батширээт	Ор	7	19	-12	2377
4	Баян-Адарга	Ор	7	20	-13	2524
5	Баянмөнх	Ор	7	14	-7	1711

6	Баян-Овоо	Ор	8	15	-7	1888
7	Баянхутаг	Ор	7	20	-13	2444
8	Биндэр	Ор	15	33	-18	4063
9	Галшар	Ор	7	18	-11	2253
10	Дадал	Ор	8	25	-17	3089
11	Дархан	Ор	5	16	-11	1950
12	Дэлгэрхаан	Ор	7	21	-14	2555
13	Жаргалтхаан	Ор	7	18	-11	2253
14	Мөрөн	Ор	7	16	-9	1919
15	Норовлин	Ор	8	21	-13	2547
16	Өмнөдэлгэр	Ор	16	47	-31	5789
17	Цэнхэрмандал	Ор	7	17	-10	2059
18	Бор-Өндөр	Ор	38	73	-35	8981
	ДҮН		489	632		77664

11.3. Соёлын үйлчилгээ


Сүүлийн жилүүдэд хөдөө, орон нутгийн хүн амыг соёлын ахуй, спортын үйлчилгээгээр хангагдах нөхцлийг сайжруулж улсын төсвийн хөрөнгө оруулалтууд хийгдсээр байгаа ч хүчин чадал болон байршил нь үйлчлэх хүрээний хүн амын тоотой хамаарал багатайгаар төлөвлөгдөн баригдаж байна. Тухайлбал Архангай аймгийн Цэнхэр сум 5900 хүнтэй бол түүнээс 6 дахин бага хүнтэй Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд мөн ижил 240 хүний суудалтай соёлын төвийг төлөвлөн барьж байна.

Хүснэгт 11.3.1. Сумуудын соёлын төвийн барилгын төлөвлөлт, 2018 он

№	Соёлын төвийн барилга	Хүн ам
1	150 суудал /Говь-Алтай, Бугат сум/	2210
2	150 суудал /Говь-Алтай, Тонхил сум/	2222
3	150 суудал /Говь-Алтай, Цээл сум/	2207
4	200 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	2216
5	200 суудал /Завхан, Идэр сум/	2535
6	200 суудал /Завхан, Нөмрөг сум/	1753
7	200 суудал /Завхан, Түдэвтэй сум/	1908
8	240 суудал /Архангай, Хотонт сум/	4380
9	240 суудал /Архангай, Цэнхэр сум/	5917
10	240 суудал /Баянхонгор, Богд сум/	3113
11	240 суудал /Баянхонгор, Галуут сум/	4103
12	240 суудал /Баянхонгор, Жинст сум/	2192
13	240 суудал /Баянхонгор, Заг сум/	2073
14	240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	1748
15	240 суудал /Дундговь, Цагаандэлгэр сум/	1058
16	250 суудал /Дундговь, Өлзийт сум/	2363
17	250 суудал /Өвөрхангай, Гучин-Ус сум/	2209
18	250 суудал /Өвөрхангай, Тарагт сум/	3338

19	250 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	12499
20	250 суудал /Төв, Дэлгэрхаан сум/	1812
21	250 суудал /Увс, Зүүнговь сум/	2805
22	250 суудал /Увс, Цагаанхайрхан сум/	2095
23	280 суудал /Өмнөговь, Баяндалай сум/	2079
24	300 суудал /Баян-Өлгий, Бугат сум/	3870
25	300 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум/	8575
26	300 суудал /Завхан, Баянтэс сум/	2632
27	300 суудал /Ховд, Дуут сум/	2064
28	400 суудал /Сэлэнгэ, Баянгол сум/	5579

Зураг 11.3.2 Соёлын төвийн хүчин чадлын хүн амын тооноос хамаарсан хамаарал



Соёлын төвийн барилгуудын хүн чадлын хүн амын тооноос хамаарсан корреляцийн индекс = 1.0 байх ёстойгоос 0.32 буюу бараг хамааралгүй шахам байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

12. ХҮН АМЫН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ


Монгол Улсын нийт хүн амын орон сууцны хангамжийг суурьшлын дараах хэлбэрүүдээр ангилан авч үзэв. Үүнд:

- Орон сууцны хангамжийн байдал улсын түвшинд
- Орон сууцны хангамж эдийн засгийн бүс нутгийн түвшинд
- Орон сууцны хангамж аймгийн түвшинд
- Орон сууцны хангамжийн үзүүлэлт сумын түвшинд

12.1. Орон сууцны хангамж улсын түвшинд

Монгол улсын нийт хот, суурин газруудын орон сууцны хангамжийн одоогийн байдлын судалгаанд үндэслэн орон сууцны төрөл, эзлэх хувь хэмжээг нэгтгэн боловсруулав. Нийт өрхийн үзүүлэлтийг дундажаар авч үзэхэд 29 хувь нь инженерийн хангамжтай орон сууцанд, 31 хувь нь байшин сууц, 40 хувь нь үндэсний гэр сууцанд оршин сууж байгаа үр дүн гарч байна. Дараах зурагт орон сууцны эзлэх хувь хэмжээг харуулав. Жич: Орон сууцны үзүүлэлтэнд нийслэл хотын орон сууцны хангамж дундаж үзүүлэлтийг өсгөх хүчин зүйл болж байна. Тоон мэдээллийг 2018 оны байдлаар нэгтгэн гаргав.

Зураг 12.1. Орон сууцны хангамж, төрөл



- Орон сууц инженерийн хангамжтай
- Байшин сууцанд амьдардаг өрх
- Гэр сууцанд амьдардаг өрх


12.2. Орон сууцны хангамж эдийн засгийн бүс, аймгийн түвшинд

Эдийн засгийн бүсүүдийн хот, төв суурин газрын орон сууцны хангамж нь хүн амын төвлөрөл ихтэй байршлуудад эзлэх хувь хэмжээ өндөр байна. Энэ нь эдийн идэвхи болон хот бүрдүүлэгч байгууллагуудын хүрэлцээ хангамжтай шууд хамааралтай болох нь тодорхой юм. Орон сууцны хангамжийн үзүүлэлтийг хүснэгт 4.2.1 үзүүлэв.

Хүснэгт 12.1. Орон сууцны хангамжийг судалгаа, бүсүүдээр

№	Эдийн засгийн бүсүүд	Хүн амын тоо	Өрхийн тоо	Орон сууцны хангамж, төрөл		
				Орон сууцанд амьдардаг өрхийн тоо/инженерийн хангамжтай	Байшин сууцанд амьдардаг өрхийн тоо	Гэр сууцанд амьдардаг өрхийн тоо
1	Баруун бүс	134506	35613	15%	40%	45%
2	Хангайн бүс	238752	59652	28%	30%	42%
3	Төвийн бүс	206986	113115	25%	20%	55%
4	Зүүн бүс	91931	27425	33%	40%	27%
5	Улаанбаатар	1444669	387453	45%	26%	29%

Зураг 12.2. Орон сууцны хангамж, бүс нутгийн түвшинд /2015 он/



Орон сууцны хангамжийн түвшинг харьцуулалт хийхэд Улаанбаатарын бүс хамгийн өндөр инженерийн хангамжтай орон сууцны эзлэх хувь 45 хувь, хамгийн бага эзлэх хувь хэмжээтэй байгаа нь Баруун бүс нутаг буюу 15 хувьтай байна. Бүс нутгуудын орон сууцны төрөл, хангамжийг тухайн өрхийн эзлэх хувь хэмжээгээр дээрх зурагт үзүүлэв.

Орон сууцны хангамжийн түвшинг тухайн бүс нутагт хамаарах аймгийн төв хотуудын дүнг нэгтгэн дээрх хүснэгтэд үзүүлэв. Хүснэгт 2018 оны байдлаар нийслэл хот болон аймгийн төв хотуудад 623258 өрхийн 2116844 хүн ам оршин сууж байна. Орон сууцны хангамжийн хувьд нийт үзүүлэлтэд хамрагдсан байршлын орон сууцны эзлэх хувь хэмжээг үзүүлэв.


Хүснэгт 12.2. Орон сууцны хангамж аймгийн төв хотуудын түвшинд, 2018 он
/Өрхийн тооны эзлэх хувь хэмжээгээр/

№	Аймаг, хот	Аймгийн төв	Орон сууцны хангамж /Хувь хэмжээ/		
			Орон сууцанд амьдардаг өрхийн тоо/ инженерийн хангамжтай	Байшин сууцанд амьдардаг өрхийн тоо	Гэр сууцанд амьдардаг өрхийн тоо
1	Архангай	Цэцэрлэг	25%	39%	36%
2	Баян-Өлгий	Өлгий	18%	49%	33%
3	Баянхонгор	Баянхонгор	18%	25%	43%
4	Булган	Булган	35%	37%	28%
5	Говь-Алтай	Алтай	28%	30%	42%
6	Говьсүмбэр	Чойр	18%	36%	46%
7	Дархан-Уул	Дархан	38%	37%	25%
8	Дорноговь	Сайншанд	38%	29%	33%
9	Дорнод	Чойбалсан	52%	30%	18%
10	Дундговь	Мандалговь	13%	26%	61%
11	Завхан	Улиастай	15%	40%	45%
12	Орхон	Эрдэнэт	38%	37%	25%
13	Өвөрхангай	Арвайхээр	28%	30%	42%
14	Өмнөговь	Даланзадгад	28%	44%	28%
15	Сүхбаатар	Баруун-Урт	25%	35%	40%
16	Сэлэнгэ	Сүхбаатар	23%	50%	27%
17	Төв	Зуунмод	35%	35%	30%
18	Увс	Улаангом	18%	38%	44%
19	Ховд	Ховд	15%	25%	60%
20	Хөвсгөл	Мөрөн	15%	48%	37%
21	Хэнтий	Өндөрхаан	23%	55%	22%
	Улаанбаатар хот	Багануур	45%	23%	32%
		Баянгол	80%	11%	9%
		Баянзүрх	47%	26%	28%
		Налайх	25%	33%	42%
		Сонгинохайрхан	27%	37%	36%
		Сүхбаатар	50%	27%	23%
		Хан-Уул	57%	23%	20%
		Чингэлтэй	22%	50%	28%
		Багхангай	57%	9%	34%

Орон сууцны хангамжийн түвшинг аймгийн төв хотуудын дүнг нэгтгэн 2018 оны байдлаар аймгийн төвүүдийн орон сууцны хангамжийг гурван бүлэг буюу инженерийн

хангамжтай орон сууц, байшин сууц¹, гэр сууцны төрлөөр ангилан график 4.3.1-т орон сууцны эзлэх хувь хэмжээг үзүүлэв.

Зураг 12.3. Орон сууцны хангамж, төрөл, нийт өрхөд эзлэх хувиар, хотуудаар




Аймгийн төв хотуудын инженерийн хангамжтай тохиолог орон сууцны үзүүлэлтэд Дорноговь аймгийн төв Сайншанд хот, Дорнод аймгийн Чойбалсан хотууд хамгийн өндөр буюу 50-55 хувийг эзэлж байна. Орон сууцны динамик үзүүлэлийг 5 жилийн интервалд харьцуулалт хийв. 2010 оноос 2015 оны хооронд аймгийн төвүүдэд орон сууцны хангамж дундажаар 3-5 хувиар өссөн үр дүнтэй байна.

Зураг 12.4. Инженерийн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь, 2010 болон 2015 оноор

¹ Нийтийн сууц, сууцны тусдаа байшин бусад төрлийг хамруулсан



Газрын зураг 12.1. Хүн амын орон сууцны хангамж, байршлаар/аймгийн төв хотуудаар



12.3. Хүн амын орон сууцны хангамж сумдаар

Орон сууцны хангамжийг бүх сум суурин газруудын түвшинд эзлэх хувь хэмжээг тухайн байршлуудын хүн ам, өрхийн тооны орон сууцны тоон дүнд үндэслэн үр дүнг боловсруулж доорхи хүснэгтэд үзүүлэв. Саарал өнгөөр инженерийн хангамжтай тохилог орон сууц бүхий хот сууринг тэмдэглэв.

Хүснэгт 12.3. Орон сууцны хангамж сумдын үзүүлэлт

Аймаг	Сум	2010 он			2015 он		
		Орон сууцанд амьдардаг өрхийн тоо/ инженерийн хангамжтай	Байшин сууцанд амьдардаг өрхийн тоо	Гэр сууцанд амьдардаг өрхийн тоо	Орон сууцанд амьдардаг өрхийн тоо/ инженерийн хангамжтай	Байшин сууцанд амьдардаг өрхийн тоо	Гэр сууцанд амьдардаг өрхийн тоо
Баян-Өлгий	Алтай		70	30		75	27
	Цэнгэл		30	70		33	67
	Баяннуур		65	35		65	35
	Алтанцөгц		68	32		68	32
	Өлгий	16	49	35	18	49	33
	Булган		70	30		70	30
	Сагсай		68	32		68	32
	Толбо		39	61		39	61
	Буянт		75	25		75	25
	Ногооннуур		73	27		73	27
	Бугат		58	42		58	42
	Дэлүүн		55	45		55	45
Улаанхус		53	47		53	47	
Говь-Алтай	Алтай		18	82		18	82
	Цээл		5	97		5	97
	Чандмань		6	94		6	94
	Шарга		22	78		22	78
	Баян-Уул		23	77		23	77
	Бугат		7	93		7	93
	Хөхморьт		25	75		25	75
	Бигэр		8	92		8	92
	Тайшир		6	94		6	94
	Дарви	8	16	76	8	16	76
	Халиун		18	82		18	82
Цогт		18	82		18	82	

	Дэлгэр		10	90		10	90
	Тонхил		17	83		17	83
	Эрдэнэ		21	79		21	79
	Жаргалан		5	95		5	95
	Төгрөг		30	70		30	70
	Есөнбулаг	25	30	45	28	30	42
Завхан	Нөмрөг		68	32		68	32
	Яруу		11	89		11	89
	Улиастай	13	40	47	15	40	45
	Тэлмэн		46	54		46	54
	Цагаанчулуут		28			28	
	Асгат		63	37		63	37
	Цагаанхайрхан		20	80		20	80
	Сонгино		58	42		58	42
	Тосонцэнгэл		48	52		48	52
	Түдэвтэй		30	70		30	70
	Дөрвөлжин	14	39	47	14	39	47
	Их-Уул		20	80		20	80
	Ургамал		24	76		24	76
	Эрдэнэхайрхан		21	79		21	79
	Баянхайрхан		43	57		43	57
	Завханмандал		38	62		38	62
	Цэцэн-уул		32	68		32	68
	Шилүүстэй		30	70		30	70
	Идэр		12	88		12	88
	Тэс		56	44		56	44
	Алдархаан		15	85		15	85
	Баянтэс		30	70		30	70
	Отгон		43	57		43	57
Сантмаргац		37	63		37	63	
Увс	Тариалан		19	81		19	81
	Өндөрхангай		10	90		10	90
	Түргэн		11	89		11	89
	Зүүнговь		18	82		18	82
	Малчин		15	85		15	85
	Сагил		8	92		8	92
	Хяргас		18	82		18	82
	Цагаанхайрхан		10	90		10	90
	Бөхмөрөн		28	72		28	72
	Наранбулаг		12	88		12	88
	Өмнөговь		16	84		16	84
	Тэс		13	87		13	87
	Ховд		13	87		13	87

	Баруунтуруун		19	81		20	80
	Давст		11	89		11	89
	Завхан		8	92		8	92
	Зүүнхангай		11	89		11	89
	Өлгий		9	91		9	91
	Улаангом	13	38	49	18	38	44
Ховд	Мөнххайрхан		8	92		8	92
	Мянгад		9	91		9	91
	Алтай	8	35	57	17	40	43
	Дарви		8	92		8	92
	Цэцэг		5	95		5	95
	Жаргалант		10	90		10	90
	Буянт		6	94		6	94
	Дөргөн		12	88		12	88
	Булган		9	91		9	91
	Мөст		6	94		6	94
	Ховд		10	90		10	90
	Эрдэнэбүрэн		7	93		7	93
	Зэрэг		7	93		7	93
	Чандмань		9	91		9	91
	Дуут		8	92		8	92
	Манхан		6	94		6	94
Үенч		8	92		8	92	
Дорнод	Баянтүмэн		31	69		31	69
	Хөлөнбуйр		70	30		70	30
	Цагаан-овоо		60	10		60	10
	Баян-Уул		50	50		50	50
	Гурванзагал		50	50		50	50
	Дашбалбар		55	45		55	45
	Сэргэлэн		58	42		58	42
	Хал гол	20	40	40	20	40	40
	Чулуун хороот		60	40		60	40
	Матад	3	77	20	3	77	20
	Чойбалсан	50	19	31	55	20	25
	Баяндун		50	50		50	50
	Булган		50	50		50	50
Хэрлэн		30	70		30	70	
Сүхбаатар	Наран		25	75		25	75
	Түмэнцогт	20	24	56	20	24	56
	Эрдэнэцагаан		25	75		25	75
	Асгат		40	60		40	60
	Баруун-Урт						
	Түвшинширээ		38	62		38	62

	Баяндэлгэр		52	48		52	48
	Уулбаян		23	77		23	77
	Мөнххаан		55	45		55	45
	Онгон		30	70		30	70
	Халзан		20	80		20	80
	Дарьганга		50	50		50	50
	Сүхбаатар		20	80		20	80
Хэнтий	Дархан		20	80		20	80
	Баян-Адарга		15	85		15	85
	Баян-Овоо		50	50		50	50
	Дэлгэрхаан		70	30		70	30
	Мөрөн		73	27		73	27
	Хэрлэн	23	55	22	45	33	22
	Батширээт		68	32		68	32
	Баянмөнх		58	42		58	42
	Өмнөдэлгэр		85	15		85	15
	Батноров	20	40	40	20	40	40
	Галшир		78	22		78	22
	Жаргалтхаан		88	12		88	12
	Норвилон		80	20		80	20
	Цэнхэрмандал		88	12		88	12
	Баянхутаг		55	45		55	45
	Биндэр		70	30		70	30
	Дадал		90	10		90	10
Бор-Өндөр	9	50	41	9	50	41	
Говьсүмбэр	Сүмбэр						
	Шивээговь	65	25	10	68	25	7
	Баянтал	-	-	-		50	50
Дархан-Уул	Дархан	30	25	45	38	25	37
	Хонгор	14	65	21	14	65	21
	Орхон	4	38	58	4	38	58
	Шарын гол	48	34	18	48	34	18
Дорноговь	Сайншанд	48	29	36	50	29	33
	Их хэт	30	29	41	30	29	41
	Замын-Үүд	35	33	32	45	33	22
	Хатанбулаг		15	85		15	85
	Сайхандулаан		20	80		20	80
	Улаанбадрах		20	80		20	80
	Алтанширээ		23	77		23	77
	Хөвсгөл		30	70		30	70
	Мандах		26	74		26	74
	Өргөн	26	28	46	26	28	46
	Эрдэнэ		25	75		25	75
Даланжаргалан	23	65	12	23	65	12	

	Дэлгэрэх		50	50		50	50
	Айраг		38	29		38	29
Дундговь	Өндөршил		30	70		30	70
	Сайхан-Овоо		17	83		17	83
	Сайнцагаан	9	23	68	9	23	68
	Дэлгэрхангай		18	82		18	82
	Дэлгэрцогт		23	77		23	77
	Дэрэн		20	80		20	80
	Луус		22	78		22	78
	Адаацаг		19	81		19	81
	Хулд		18	82		18	82
	Эрдэнэдалай		16	84		16	84
	Баянжаргалан		17	83		17	83
	Говь-Угтаал		21	79		21	79
	Өлзийт		26	74		26	74
	Цагаандэлгэр		15	85		15	85
	Гурвансайхан		36	64		36	64
Өмнөговь	Сэврэй		8	92		8	92
	Ханбогд	8	40	52	12	40	48
	Ханхонгор		18	82		18	82
	Баян-Овоо		15	85		15	85
	Мандал-Овоо	14	19	67	14	19	67
	Цогт-Овоо		10	90		10	90
	Манлай		21	79		21	79
	Ноён	6	12	82	6	12	82
	Баяндалай		25	75		25	75
	Даланзадгад	23	44	33	28	44	28
	Булган		16	84		16	84
	Гурвантэс	6	23	71	6	23	71
	Хүрмэн		8	92		8	92
	Номгон	18	21	61	18	21	61
	Цогтцэций	25	50	25	25	50	25
Сэлэнгэ	Сант		80	20		80	20
	Мандал	20	63	17	20	63	17
	Түшиг		95	5		95	5
	Хушаат		80	20		80	20
	Баруунбүрэн	3	60	37	3	60	37
	Орхонтуул	23	50	27	23	50	27
	Сүхбаатар		50	50		53	47
	Ерөө		70	30		70	30
	Сайхан		20	80		20	80
	Алтанбулаг	6	50	44	6	50	44
	Зүүнбүрэн		75	25		75	25

	Хүдэр	20	40	40	20	40	40
	Зүүнхараа		90	10		90	10
	Орхон	3	90	7	3	90	7
	Цагааннуур		70	30		70	30
	Шаамар	5	80	15	5	80	15
	Баянгол		70	30		70	30
	Жавхлант		90	10		90	10
Төв	Архуст		50	50		50	50
	Баян-Өнжүүл		50	50		50	50
	Баянчандмань	5	60	35	5	60	35
	Жаргалант	10	50	40	10	50	40
	Эрдэнэ		50	50		50	50
	Аргалант		50	50		50	50
	Баянцогт	5	55	45	5	55	45
	Борнуур		25	75		25	75
	Дэлгэрхаан		50	50		50	50
	Өндөрширээт	3	58	39	3	58	39
	Баяндэлгэр		50	50		50	50
	Баянцагаан		50	50		50	50
	Мөнгөнморьт		50	50		50	50
	Сүмбэр		50	50		50	50
	Зуунмод	35	35	30	35	35	30
	Баян	5	55	40	5	55	40
	Лүн		50	50		50	50
	Цээл		50	50		50	50
	Эрдэнэсант	13	56	31	13	56	31
	Бүрэн		50	50		50	50
	Сэргэлэн		50	50		50	50
	Батсүмбэр	10	50	40	10	50	40
	Баянжаргалан		50	50		50	50
	Заамар	10	50	40	10	50	40
Угтаалцайдам		50	50		50	50	
Архангай	Цэнхэр		75	25		75	25
	Цэцэрлэг		6	94		6	94
	Эрдэнэмандал	25	39	36	25	39	36
	Өлзийт		50	50		50	50
	Эрдэнбулган	25	39	36	25	39	36
	Батцэнгэл		6	94		6	94
	Хангай		70	30		70	30
	Булган		80	20		80	20
	Жаргалант		90	10		90	10
	Хайрхан		80	20		80	20
	Хотонт		90	10		90	10

	Чулуут		83	17		83	17
	Ихтамир		72	28		72	28
	Түвшрүүлэх		70	30		70	30
	Хашаат		60	40		60	40
	Цахир		89	11		89	11
	Өндөр-Улаан		23	77		23	77
	Өгийнуур		3	97		3	97
	Тариат		75	25		75	25
Баянхонгор	Шинэжинст		15	75		15	75
	Баянхонгор						
	Баянлиг		25	75		25	75
	Богд		15	85		15	85
	Бөмбөгөр		10	90		10	90
	Жаргалант		24	76		24	76
	Баацагаан		24	76		24	76
	Баянбулаг		50	50		50	50
	Галуут		5	95		5	95
	Жинст		16	84		16	84
	Заг		20	80		20	80
	Баян-Өндөр		21	79		21	79
	Баянговь	3	16	81	3	16	81
	Хүрээмарал		10	90		10	90
	Баян-Овоо		30	70		30	70
	Эрдэнэцогт		8	92		8	92
	Баянцагаан					7	93
	Гурванбулаг		29	71		29	71
	Өлзийт	9	58	33	9	58	33
	Бууцагаан		24	76		24	76
Булган	Гурванбулаг		25	75		25	75
	Баян-агт		28	72		28	72
	Хишиг-Өндөр		65	35		65	35
	Тэшиг		80	20		80	20
	Булган	34	37	29	35	37	28
	Орхон		70	30		70	30
	Хангал		85	15		85	15
	Дашинчилэн		60	40		60	40
	Могод		65	35		65	35
	Баяннуур		50	50		50	50
	Бугат		36	64		36	64
	Рашаант		70	30		70	30
	Сайхан		75	25		75	25
	Бүрэгхангай		40	60		40	60
	Сэлэнгэ		73	27		73	27
Хутаг-Өндөр		52	48		52	48	

Орхон	Жаргалант		80	20		80	20
	Баян-Өндөр	28	37	35	38	37	25
Өвөрхангай	Богд		30	70		30	70
	Бурд		21	79		21	79
	Уянга		31	69		31	69
	Баянгол		58	42		58	42
	Гучин-ус		19	81		19	81
	Өлзийт		23	77		23	77
	Зүүнбаян-Улаан		11	89		11	89
	Нарийнтээл		8	92		8	92
	Хархорин	6	31	63	6	31	63
	Баруунбаян-Улаан		80	20		80	20
	Баян-Өндөр		68	32		68	32
	Төгрөг		23	77		23	77
	Бат-Өлзий		60	40		60	40
	Есөнзүйл		23	77		23	77
	Сант		20	80		20	80
	Хайрхандулаан		19	81		19	81
	Хужирт	3	40	57	3	40	57
	Арвайхээр	21	30	49	28	30	42
Тарагт		9	91		9	91	
Хөвсгөл	Шинэ-Идэр		20	80		20	80
	Бүрэнтогтох		60	40		60	40
	Ханх		95	5		95	5
	Алаг-Эрдэнэ		20	80		20	80
	Арбулаг		10	90		10	90
	Баянзүрх		50	50		50	50
	Галт		50	50		50	50
	Тариалан		90	10		90	10
	Улаан-уул		90	10		90	10
	Их-Уул		50	50		50	50
	Төмөрбулаг		85	15		85	15
	Эрдэнбулган		25	75		25	75
	Мөрөн	15	48	37	15	48	37
	Ренчинлхүмбэ		80	20		80	20
	Цагааннуур		90	10		90	10
	Чандмань-Өндөр		80	20		80	20
	Жаргалант		60	40		60	40
	Түнэл		80	20		80	20
	Цагаан-Уул		25	75		25	75
	Цагаан-Үүр		63	37		63	37
Тосонцэнгэл		15	85		15	85	
Цэцэрлэг		30	70		30	70	

	Рашаант		70	30		70	30
Улаанбаатар	Багануур	31	23	46	45	23	32
	Баянгол	68	11	21	80	11	9
	Баянзүрх	35	26	39	47	26	28
	Налайх	23	33	44	25	33	42
	Сонгинохайрхан	23	37	40	27	37	36
	Сүхбаатар	36	27	27	50	27	23
	Хан-Уул	35	35	30	57	23	20
	Чингэлтэй	18	48	34	22	50	28
	Багахангай	57	9	34	57	9	34

13. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН НӨӨЦИЙН СУДАЛГАА

Аргазүй

Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын аялал жуулчлал, амралт сувилалын өнөөгийн байдлын талаар судалгааг хийж мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийж үзлээ.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 95 тоот тушаалаар батлагдсан “Бүс нутгийн хөгжлийн төсөл боловсруулах аргачилсан зааврын 4.3-т Амралт сувилал аялал жуулчлал хөгжүүлэх нөөцөд байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газрууд, рашаан ус, эмчилгээний шавар болон бусад нөөц, амьтан, ургамал, байгалийн сонин үзэгдэл, тусгай хамгаалалттай газрууд, нуур цөөрөм, гол горхи, хүрхрээ говийн элсэн манхан, баян бүрд зэрэг өвөрмөц тогтоц бүхий газар нутаг хамаарна. Амралт сувилал аялал жуулчлалын нөөцийн үнэлгээний үр дүн нь тухайн нутаг дэвсгэрийн түвшинд үүргийн чиглэлийг нийтийн амралт, сувилал, аялал жуулчлал хөгжүүлэхэд тохиромжтой, аялал жуулчлал хөгжүүлэхэд хязгаарлагдмал тохиромжтой, уулын спорт, байгалийн аялалын, орон нутгийн амралт, аялал жуулчлалын, аялал жуулчлал амралтанд тохиромжгүй зэрэг ангиллаар зэрэглэл тогтооход оршино.” гэсэн аргачлалын баримталлаа.

13.1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

Аялал жуулчлалын тухай хуулийн 8.2. “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хүн амын эрүүл мэнд, уламжлалт зан заншилд харшлахгүй аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлнэ” гэж заасан байна. Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх салбар болгон тодорхойлсон байдаг. Мөн Их хурлаас 2008 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод аялал жуулчлалыг 2007-2021 он хүртэл хөгжүүлэх бодлогыг томъёолсон байдаг. Энэ бодлогын хүрээнд 2015 хүртэл Монголд ирэх жуулчдын тоог хүн амын тоотой тэнцэхүйц болгох зорилтыг дэвшүүлсэн.

Аялал жуулчлалын салбар нь монгол улсын хөгжлийн тэргүүлэх 4 чиглэлийн 1-д ордог бөгөөд өнөөгийн байдлаар эдийн засгийн бие даасан салбар болон хөгжих Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого, томоохон төсөл, төлөвлөгөө боловсруулах ажлууд хийгдэж улсын хэмжээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжих боломж бүрдээд байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн бөгөөд хот байгуулалтын салбартай холбоотой

- аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;

Хөтөлбөрийг 2016-2025 оны хооронд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

I үе шат - эрчимтэй хөгжлийн үе 2016-2020 он

II үе шат - тогтвортой хөгжлийн үе 2021-2025 он


Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу түр буудаллах болон боловсон ариун цэврийн байгууламж, хогийн цэгүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийт 50 байршилд байгуулах, Монгол Улсад ирэх жуулчдын тоог 2 саяд хүргэх, хил дамнасан аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, замналыг бий болгох, дотоод, гадаадын жуулчдад зориулсан нийт 6 төрлийн мэдээллийн төвүүдийг байгуулсан байхаар хүрэх үр дүнгээ тодорхойлсон.

Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого

Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ны хурлаар БОАЖЯ-аас Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлогыг боловсруулж батлуулсан. Үүнд хот байгуулалттай холбоотой зорилтууд тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газар “Түүхэн болон төрөлжсөн аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилт дэвшүүлж, 2020 он гэхэд Монголд аялах гадаадын жуулчдын тоог 1 саяд хүргэх, салбарын орлогыг 1,4 тэрбум ам.доллар буюу 2,8 их наяд төгрөгт хүргэхээр. 2020-2040 онд жил тутам 1 сая жуулчин хүлээж авахаар тооцож томоохон төслүүдийг эхлүүлсэн.


Зураг 13.1. Аялал жуулчлалын салбарын эрхзүйн орчин



13.2. Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаарх төсөл, арга хэмжээнүүд

6 АЙМГИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДЛЫГ ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ БОЛГОХ ТӨСӨЛ

Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж 4D зэрэглэл бүхий нисэх буудал нь цагт 500-аас багагүй зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай, 2 хүзүүвтэй болгон өргөтгөх, Хөвсгөл аймгийн Мөрөн, Дорнод аймгийн Чойбалсан, Ховд аймгийн Ховд, Увс аймгийн Дэглий цагаан, Өвөрхангай аймгийн нисэх буудлыг 4C зэрэглэл бүхий нисэх буудал цагт 300-аас багагүй зорчигчид үйлчлэх хүчин чадалтайгаар зорчигч үйлчилгээний цогцолборыг өргөтгөхөөр төлөвлөж байна.



Эх сурвалж: БОАЖЯ,2019, Аялал жуулчлалын төмөр замыг хөгжүүлэх санал

Хөшгийн хөндий-Чойбалсан чиглэлийн төмөр зам-626 км, Хөшгийн хөндий-Зоргол хайрхан чиглэлийн төмөр зам-110 км, Зоргол хайрхан-Даланзадгад чиглэлийн төмөр зам-460 км, Зоргол хайрхан-Найман нуур чиглэлийн төмөр зам-403 км, Найман нуур-Шаргалжуут чиглэлийн төмөр зам—60км, Найман нуур-Хорго чиглэлийн төмөр зам-261 км, Хорго-Хөвсгөл далай чиглэлийн төмөр зам-276 км, Хорго-Ховд чиглэлийн төмөр зам-640км нийт 2560 км төмөр зам тавих төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГОЛ ЧИГЛЭЛ ДАГУУ АВТО ЗАМЫН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Сайншанд-Хөвсгөл сум-Хатнбулаг сум-Ханги боомт-328 км
Айраг сум-Баянжаргалан сум-Гурвансайхан сум-Чингис хот-225 км
Өлгий (БӨ) – Улаанхус сум – Алтай сум – Сагсай сум 185 км
Улаанбаатар хот – Лүн сум – Дашинчилэн сум – Булган сум (БУ) – Хутаг-Өндөр сум – Их уул сум – Мөрөн сум – Хатгал тосгон 109 км
Чойбалсан – Баяндун сум – Угтамын хийд – Яхь нуур

Чойбалсан – Баян-Уул сум Баяндун сум – Угтамын хийд – Дашбалбар сум – Монгол Дагуур – Хөх нуур - Чойбалсан 235 км

Баруун-Урт – Дарьганга сум – Эрдэнэцагаан сум – Бичигт боомт 290 км


Даланзадгад – Цогтцэций сум – Ханбогд сум – Дэмчигийн хийд – Шар цав – Өлгий хийд 100 км

Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын чиглэл

Эрэнцав боомт – Чойбалсан – Хавирга боомт 75 км

Эрэнцав боомт – Чойбалсан – Буйр нуур – Халхгол – Сүмбэр боомт 414 км

Гашуунсухайт боомт – Цогтцэций сум – Даланзадгад – Баяндалай сум – Ноён сум – Гурвантэс сум – Шивээхүрэн боомт 306 км



Эх сурвалж: БОАЖЯ

АВТО ЗАМ ДАГУУХ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор нь А, В, С гэсэн гурван төрлийн ангилалтай байх бөгөөд А ангиллын хувьд хоногт 10 мянгаас дээш тээврийн хэрэгсэл зорчих улсын чанартай авто зам дагуу, 1000м² талбайд байрлах нийт 39 түр буудаллах цэгийг байгуулна. Эхний ээлжинд Булган аймгийн Рашаант сумын нутаг Элсэн тасархайн бүсэд байгуулахаар төлөвлөсөн байна. Тус түр буудаллах цэгт авто зогсоол, шатахуун түгээх станц, авто үйлчилгээний газар, машин угаалга, түргэн үйлчилгээний ресторан, зам дагуу зочид буудлын үйлчилгээ, ариун цэврийн байгууламж, худалдаа үйлчилгээтэй байна.

“МЯНГАНЫ СУУТ ХҮН ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН” ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР

Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэх, тэр дундаа Их эзэн Чингис хааны төрсөн нутаг Хэнтий аймагт орших Чингис хаан, 13-р зуун, “Нууц товчоо”-той холбоотой түүхэн газар нутгууд руу жуулчдыг татах зорилгоор бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг 2018 оноос эхлүүлсэн.

Үүнд, Хэнтий аймгийн Биндэр суманд “Их Монгол улс-Монголын эзэнт гүрэн”, Батноров суманд “Хүлэгбаатар Боорчи-Андлалын өргөө”, Норовлин суманд “Шихихутаг-Нууц товчоо” цогцолборуудыг улсын төсвийн 5.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар, мөн Азийн хөгжлийн банкны 19 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Хэнтий аймгийн Дадал суманд “Мянганы суут хүн-Их эзэн Чингис хаан” цогцолбор байгуулах бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эхлүүлээд байна.


МАНЗУШИР ХИЙДИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, ШАШИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР

13.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Аялал жуулчлалын хувьд жуулчдын бүртгэл судалгаа дутмаг, улсын хэмжээнд тоо баримт байгаа боловч аймаг, сумаар гадаад болон дотоодын жуулчдын тоо бүртгэл байхгүй зарим аймгуудаас тоо баримтыг гарган өгөх боломжгүй мэдээлэл байхгүй байлаа. Нийт Монгол улсын хэмжээний тоо баримтыг Байгаль орчин аялал жуулчлалын яамны мэдээлэл болон Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн боловсруулав.

Монгол Улсад ирж буй гадаад иргэдийг аяллын зорилгоор нь албан ажлаар, хувийн журмаар, жуулчлал, ажиллах, суралцах, дамжин өнгөрөх мөн байнга оршин суух гэж ангилан бүртгэдэг. Эдгээрээс байнга оршин суух, ажиллах, суралцах зорилгоос бусад зорилгоор ирсэн гадаадын иргэдийг гадаад жуулчин гэж тодорхойлдог.

Зураг 13.2. Гадаадын жуулчдын тоо, мянгаар, 1999-2018 он




Монгол Улсыг зорин ирсэн жуулчдын тоо 2018 онд 529.4 мянга болж, өмнөх оноос 60.1 мянган жуулчин буюу 12.8 хувиар, 2014 оноос 136.6 мянган жуулчин буюу 34.8 хувиар,

2015 оноос 143.2 мянган жуулчин буюу 37.1 хувиар, 2016 онд 125.2 мянган жуулчин буюу 31.0 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсад ирсэн нийт жуулчдын 65.0-68.0 хувь нь 2,3 дугаар улиралд буюу 4 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд иржээ. Өвлийн улиралд ирэх жуулчдын тоо бага байгаа нь өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй, жуулчин хүлээн авах газрууд улирлын чанартай ажилладаг, өвлийн улиралд жуулчин хүлээн авах газрууд бага, мөн манай орны хатуу ширүүн уур амьсгалтай холбоотой байх магадлалтай.

Зураг 13.4. Гадаадын жуулчдын тоо, орнуудаар, 2009-2018 онд



Жуулчдын тоог улсаар авч үзвэл 30.9 хувийг БНХАУ-ын иргэд, 24.4 хувийг ОХУ-ын иргэд, 15.9 хувийг БНСУ-ын иргэд, 28.8 хувийг бусад улсын иргэд эзэлж байна.

Мөн манай улсаас гадаад орнуудад аялал жуулчлал, болон бусад зорилгоор зорчиж байгаа хүний тоо 2460.9 мянгад хүрээд байна.

Хүснэгт 13.1. Улсын хилээр гарсан монгол иргэд.

Он	Улсын хилээр гарсан зорчигчид	Ажиллах	Суралцах	Байнга оршин суух	Гадаад зорчсон монгол жуулчид	Гадаад зорчсон монгол жуулчид				
						Албан	Хувийн	Жуулчлал	Дамжин өнгөрөх	Бусад
2014	1677.6	118.6	20.9	12.4	1525.7	68.1	1412.5	39.4	0.9	4.9
2015	1975.7	136.3	14.7	6.8	1817.9	535	1642.8	104.3	0.3	17.0

2016	2252.5	304.8	19.9	12.0	1916.0	50.6	1769.9	80.9	2.5	12.1
2017	2439.9	422.7	24.3	13.8	1979.2	70.0	1792.4	104.1	0.1	12.6
2018	2460.9	418.3	26.0	16.3	2000.3	57.1	1776.7	131.5	0.2	34.9

Хүснэгт 13.2. Гадаадын жуулчдаас олсон орлого, дотоодын жуулчдын гадаадад аялсан зардал, тэнцэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Гадаадын жуулчдаас олсон орлого	367.4	455.5	597.6	844.1	958.7
Дотоодын жуулчдын гадаадад аялсан зардал	562.0	557.7	728.4	930.9	1083.8
Тэнцэл	-194.7	-102.2	-130.8	-86.8	-125

Эх сурвалж* Монгол банк, Төлбөрийн тэнцэл

Аймгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 21 аймаг тус бүр өөрийн 7 ба 9 гайхамшиг тодруулах, аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. /Хавсралтаар оруулав/

Манай улс жуулчин хүлээж авах өнөөгийн ор/хоногийн даацыг тооцвол өдөрт 72 мянган жуулчин, энэ нь бүрэн хүчин чадлаараа ажиллавал зуны гурван сард 1,6 сая гадаадын жуулчин хүлээж авах боломжтой гэж Байгаль орчин аялал жуулчлалын яамны судалгаа байдаг. Одоогоор аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1518 аж ахуйн нэгж байгууллага байна.

13.4. Аймгуудын аялал жуулчлалын нөөц, маршрутууд

АРХАНГАЙ АЙМАГ

Архангай аймгийн есөн гайхамшигаар Чулуутын гол, Хоргын тогоо, Тэрхийн цагаан нуур, Суварга хайрхан уул, Тамирын гол, Булган уул, Тайхар чулуу, Хар балгас, Билгэ хааны цогцолборуудыг тодруулжээ.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

Түүх дурсгал: Эртний хүмүүсийн соёл иргэншлийн нэгэн гайхамшигт бүтээл болох хад, чулуун дээр улаан зосоор зурсан сүг зургууд ба хаданд сийлж зурсан ан амьтан, хүний дүрс бүхий сүг зургуудаас гадны элдэв тамга, тэмдэг, үсэг зурлага Алтайн нуруунд элбэг. Энэ зургууд нь Монгол Алтайд амьдарч байсан хүмүүсийн 2500-3000 жилийн өмнө үйлдэж үлдээсэн түүх соёлын өв сан юм. Алтайн нурууны буган хөшөө Хангайн нурууныхаас нэлээд өвөрмөц ялгаатай бөгөөд бугын оронд адуу зурсан адуун чулуун хөшөө, сэлэмт хөшөө тохиолддог. Буган хөшөөнүүд нь саарал өнгийн боржин чулууг засаж хийсэн, сийлсэн байх бөгөөд хөшөөний өвөр талын дээд өнцөгт том нар, жижиг сар, заримдаа нарыг харвасан сум сийлсэн байдаг. Буган хөшөөнүүд он цагийн хувьд МЭӨ Y-YII зуунд хамаардаг. Энд эртний Скифийн үеэс авхуулаад Хүннүгийн өмнөх дөрвөлжин булш, Хүннү, Түрэг, Уйгар, Монгол гүрний он цаг үе нь тогтоогдоогүй булш, бунхан элбэг байдаг.

Аялал жуулчлал: Монгол Алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудад байгалийн аялал хийх, бүргэдээр ан хийх, казах, тува, урианхай, дөрвөд үндэстэн, ястны зан заншил, соёлтой танилцах, загасчлах, ууланд авирах, Алтай Таванбогд уул, мөсөн

голыг үзэх, овоо тахих, тэмээн аялал хийх, морин аялал хийх, усан аялал хийх, ховордсон ан амьтан, ургамал судлах, дурсгалт газруудыг үзэх, судлах боломжтой. Орчин тойронд нь байгаль хамгаалах нөхөрлөлүүд аялал жуулчлал эрхэлдэг.

Баян-Өлгий аймагт ирдэг жуулчдын дотор АНУ 25%, Франц 18%, Англи 15%, Канад 13%, ОХУ 8%, Израйль 7%, бусад орон 14% эзэлдэг.

Аялал жуулчлалын маршрут:

- **Хойд чиглэл:** Ачит нуур - Ногоон нуурын хүн чулуу - Сүг зургууд - Сийлхэмийн нуруу - Цагаан нуур
- **Зүүн өмнөд чиглэл:** Мөнгөн дөшийн сүг зураг - Эрээн харганатын түрэг бичээс - Ховд гол - Баяннуур - Дэвэлийн арал БЦГ - Цамбагарав БЦГ.
- **Өмнөд чиглэл:** Алтайн их уулс - их гол нуур, казах ард түмний амьдрал - Толбо нуур - Хөх сэрхийн нуруу ДЦГ - Чигэртэйн рашаан
- **Баруун хойд чиглэл:** Монгол-Алтайн шинэсэн ой - Цагаан салаагийн хадны зураг - Хар ямаатын чулуу - Цагаан гол - Чулуун хөшөөнүүд - Буган чулуу хөшөө - Бага ойгорын бичээс - Цэнгэл сум - Улаанхус сум - Сагсай сум - Таван богд уул

БАЯНХОНГОР АЙМАГ

Баянхонгор аймгийн долоон гайхамшигаар Цагаан агуй, Бичигт хад, Шатар чулуун хөшөө, Түрэгийн үеийн бичээс, Бүгийн цавын хоолой, Шаргалжуутын халуун рашаан, Их богд уул тодорчээ.

БУЛГАН АЙМАГ

Булган аймаг нь Монгол орны төв хэсэгт Орхон Сэлэнгийн сав газарт орших бөгөөд Булганхангай, Бүрэгхангай, Дулаанхан, Бүтээл, Хантай зэрэг ой хөвчит уул нурууд бий. Нутгийн хойд захаар эртний төрмөлийн эриний боржин чулуу өмнө хэсгийн үлэмж талбайд дунд Дөрөвдөгч галавын үед оргилж байсан Уран тогоо, Тулга, Бүрхээр, Жалавч зэрэг унтарсан галт уул байдаг бөгөөд одоо үед дархлан хамгаалж байна. Булган аймагт чулуун нүүрс, барилгын материалын баялаг нилээд бий. Булган аймгийн долоон гайхамшигаар Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газар, Уран тогоо уул, Шивээт улааны цогцолбор, Хар бухын балгас, Чин толгойн балгас, Бийбулагийн туурь, Могойт шинэ ус зэрэг газруудыг тодруулжээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

Тус аймгийн есөн гайхамшигаар Ээж хайрхан уул, Бурхан буудай уул, Сутай хайрхан уул, Цагаан голын хадны зураг, Монгол элс, Хасагт хайрхан уул, Аж богдын нуруу, Эрээн нуур, Шаахар толгой зэрэг газрууд тодорчээ.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

Тус аймгийн 7 гайхамшигаар Чойрын богд уул, Зүүн жанжин Чойрын хийдийн туурь, Цагаан дарь эхийн хадан хөрөг, Дагвасүндэл бурханы хөрөг, Хүүхдийн овоо, Дугар мээрэнгийн хөшөө, Цоорхойн рашаан хэмээх газрууд тодорчээ.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

Дархан-Уул аймгийн 7 гайхамшигаар Тахилгат их Дархан уул, Дурлалын мод, Шарын голын зосон зураг, Буурал уулын булш, Дүрс нарс, Лам Дондовын рашаан, Хүйтний голын хадны бичээс зэрэг газрууд тодорчээ.

ДОРНОГОВЬ АЙМАГ

Дорноговь аймгийн 7 гайхамшигаар Хамрын хийд, Цагаан дарь эх, Сүйхэнтийн ой ба Өлгий хийд, Цонжийн булуу, Бүрдэнэ булаг ба Мөнхийн ам, Эргэлийн зоо, Нүдэнгийн хонхор зэрэг газрууд тодорчээ.

ДОРНОД АЙМАГ

Дорнод аймгийн 9 гайхамшигаар Чингисийн хэрмэн зам, Хэрлэн барс хотын туурь, Буйр нуур, Хайлангийн хадны хүн дүрст чулуу ба дөрвөлжин булш, Их бурхант чулуун бурханы цогцолбор, Шонх таван толгойн хүн чулуун хөшөө, Хамар даваан дээрхи ялалтын хөшөө, Халх гол, Вангийн цагаан уул зэрэг газрууд тодорчээ.

ДУНДГОВЬ АЙМАГ

Дундговь аймгийн 7 гайхамшигаар Их газрын чулуу, дэл уул, Бага газрын чулуу, Онгийн хийдийн туурь, Морин хуурын хөшөө, Өөш манхан, Дэлгэрхангай уул зэрэг газрууд тодорчээ.

ЗАВХАН АЙМАГ

Завхан аймгийн 9 гайхамшигаар Отгонтэнгэр хайрхан, Хар нуур, Загастайн давааны хүн чулуу, Бор хярын элсэн манхан ба Мухартын гол, Тэсийн гол Нисэхийн шугуй, Их хайрхан уул, Дааган дэлийн буган чулуун хөшөө, Идэр голын буган чулуун хөшөө зэрэг газрууд тодорчээ.

Маршрут-1: Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр (4021м) уул, Их Монголын элсэн манхан, тал хээрийн бүсийг багтаасан аяллын маршрут.

Аялал:

- Улиастай хотоос Богдын гол Мөнгөт хясаа, Богдын голын хүрхрээ, Цагаан нуур, Даян уулын үдлэх цэгт амарна. Туулах зам 50км.
- Даян уулаас Отгонтэнгэр уул харах, вансэмбэрүү цэцэг үзэх, Долоогийн даваа, Ширээгийн голын үдлэх цэг, Хөндлөнгийн даваа, Отгон сум, Буянт багаар дайран Отгонтэнгэр уулын өвөрт ирнэ. 160км
- Цагаан чулуут сумын Бурханы цогцолбор, Жавцаг баг Завхан голоор гаран Эрээн нуурт ирнэ. Нийт 150км.
- Эрээн нуур Завхан голын Далтын гарам, Ханийн худагийн хясаа, Ямаан усны үдэх цэг, Алдархаан сум, Улиастай хотод ирнэ. 140км.

Нийт туулах зам: 650км

Нэмэлт маршрут: Отгонтэнгэрээс Отгон сум, Шилүүстэйн дааган дэлийн буган чулуун хөшөөт цогцолборын үдлэх цэг, Шилүүстэй сумын төв. Нийт 140км.

- Шилүүстэй сум, Мандалт нуур, Нарбанчин хийдийн туурь, Гэгээн нуур, Завхан голын усан цахилгаан станц. Нийт 80км.
- Тайшир сум, Харандаа хад Хүнхэрийн амралт. Нийт 50км
- Хүнхэрийн амралт Жаргалан сум, Эрээн нуур жуулчны бааз. Нийт 80км.

Маршрут-2 Байгалийн өвөрмөц тогтоц бүхийн Хангай, Говь хосолсон тусгай сонирхлын аялалыг багтаасан маршрут.

Аялал:

- Завхан аймгийн Улиастай хотоос эхэлнэ.
- Улиастай сумаас Их Монгол жуулчны бааз, Хатавчийн амны хүн чулуун хөшөө, Загастайн даваа, Идэр сумын төв Ногоон нуур дахь Маргад ембүү жуулчны бааз. Туулах зам 95 км.
- Ногоон нуураас Идэр сумын төв, Тун, Жаргалангийн гол, Бөхөн шарын даваа Тэгшийн голын үдлэх цэг. Туулах зам 50км.
- Тэгшийн голоос Баяжихын даваа, Хангайн нурууны Марз уул, Хажуулын рашаан сувиллын газар ирнэ. Туулах зам 80км.
- Хажуулын голоо уруудан байгалийн үзэсгэлэнт газраар аялан Тосонцэнгэл сумын Skyline зочид буудалд ирнэ. Туулах зам 80 км.
- Тосонцэнгэл сумаас Мэргэний давааны үдлэх цэг дээр буун цааш Долоон товгор Элсэн манхан Ангирт нуурын хөвөөнд орших Замбага жуулчны баазад хүрнэ. Туулах зам 80км.
- Замбага жуулчны баазаас Нарийны даваа, Дахтын даваа, Тээлийн гол уруудан Хар нуур жуулчны баазад ирнэ. Мөн Улаагчны голын үдлэх цэг, Гол мод, Тээлийн гол уруудан Хар нуурт ирж болно. Туулах зам 120км.
- Хар нуураас Сэнжит цохио, Их, Бага Хатавчийн ам, Мухартын үдлэх цэгт очно. Туулах зам 50км
- Мухартаас Сээрийн дөрөлжөөр давж, Донойн хөндий, Яруугийн хүрээг үзэн Улиастайд ирнэ. Туулах зам 110км. **Нийт туулах зам: 665км**

Маршрут-3: Тал хээр, говийн бүс нутгийн өвөрмөц, тогтоцтой нутгаар аялах

Аялал:

- Улиастай хотоос Яруугийн хүрээ, Алагийн даваа, Ханын худаг, Их хайрхан үдлэх цэгт амарна. 80км
- Их хайрханаас Эрдэнэ- Хайрхан сум мухартын элсэн манхан үдлэх цэгт амарна. 100км
- Мухартаас Сэнжит хадны үдлэх цэг, Бургастайгаар даван Хар нуур жуулчны баазад ирнэ. 50км (Хар нуурын орчмын аялалын маршрутаар аялаж болно)
- Хар нуураас Тээлийн гол, Намын давааны үдлэх цэг Дэнхэн чулуугаар дайран Улиастай хотод ирнэ. 120км **Нийт туулах зам: 350 км**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Өвөрхангай аймгийн 7 гайхамшигаар Арц богд уул, Хужиртын рашаан, Монгол түмний морины их шүтээн, Хархорум хот, Эрдэнэзуу хийд, Тэвш уул, Төвхөн хийд зэрэг газрууд тодорчээ.

ӨМНӨГОВЬ АЙМАГ

Өмнөговь аймгийн 9 гайхамшигаар Говь гурван сайхан уул, Баянзаг, Нэмэгт уул ба Хэрмэн цав, Галбын говь, Ноён богд ба Толь хад, Алгуй улаан цав, Хонгорын элс, Сангийн далай, Галбын гурван хийд зэрэг газрууд тодорчээ.

СҮХБААТАР АЙМАГ

Сүхбаатар аймгийн 7 гайхамшигаар Алтан-Овоо, Шилийн богд, Монголын хүн чулууд, Таван толгойн археологийн цогцолбор, Ганга нуур ба Оргихын булаг, Хунгийн чуулган, Егүзэрийн хийд зэрэг газрууд тодорчээ.

СЭЛЭНГЭ АЙМАГ

Сэлэнгэ аймгийн 7 гайхамшигаар Амарбаясгалант хийд, Соронзон хад, Хувьсгалын өлгий Алтанбулаг, Халуун рашаан, Тужийн нарс, Дуут хад, Сайханы хөтөл зэрэг газрууд тодорчээ.

ТӨВ АЙМАГ

Төв аймгийн 7 гайхамшигаар Манзуширын хийдийн туурь, Хустайн байгалийн цогцолборт газар, Гүнжийн сүм, Зоргол хайрхан уул, Чингис хааны морьт хөшөө, Тоньюкукын гэрэлт хөшөөний бичээс, Цогт хунтайжийн дуутын хадны бичээс зэрэг газрууд тодорчээ.

Зуунмод хотоос аялж болох маршрут

- Зуунмод - Манзуширийн хийд - Байгалийн музей - Сэрүүн лаврин (7км).
- Зуунмод - Тэрэлж – Мэлхий хад (63км) - Цонжинболдог (30км) – XIII зуун цогцолбор (31км) - Гүнжийн сүм (96км) - Зуунмод (105км). Нийт 324км.
- Зуунмод – Тоньюкукийн хөшөө (42км) - Цогтчандмань уул - Жанчивлангийн рашаан (24км) - Зуунмод (66км). Нийт 132км.
- Зуунмод - Хоолтын даваа (23км) - Хэнтийн нурууны салбар - Нагалхан уулын даваа (108км) - Зуунмод (66км) Нийт 253км.
- Зуунмод - Налайх (34км) - Тэрэлж (25км) - Хагийн хар нуур (110км) - Естийн рашаан (40км) - Зуунмод (210км). Нийт 420км, 4-5өдөр
- Зуунмод - Хустайн БЦГ, Өнгөтийн бэл цогцолбор (51км), - Лүн сум, музей, Энхдаажин (107 км) – Эрдэнэсант сум Батхаан уул БНГ (86км) - Зуунмод (261км). Нийт 505км, 5-7өдөр
- Зуунмод - Баян-Өнжүүл Зорголхайрхан (131км) - Бүрэн (95км) - Дэлгэрхаан сум Кульчурын гэрэлт хөшөө, Цогтын дуут хад (54км) - Зуунмод (246км). Нийт 526км, 5-7өдөр
- Зуунмод - Баянхангай (153км) - Авдрантын замаар салж Энхийн элс (30км) - Тавангийн элс (20км) – Лүн сум (30км) - Заамар (56км) - Сүмбэр (120км) – Борнуур сум Аглаг бүтээлийн хийд, содон зүйлийн музей, Ёл хад (70км) – Батсүмбэр сум, Ноён Уулын булш (44км) – Жаргалант сум (79км) – Улаанбаатар (128км) – Зуунмод (43км). Нийт 765км, 7 өдөр
- Зуунмод - Баян (78км) – Баянжаргалан (63км) – Бөөрөлжүүтийн рашаан (42км) – Зуунмод (141км). Нийт 324км 2-3 өдөр
- Зуунмод - Хэрлэн баян улаан (161км) – Хөдөө арал (19км) – Зуунмод (180км). Нийт 360км, 3-4 өдөр
- Зуунмод - Авдархангай уул, Ээж хад (65км) – Өлзийт нуур (52км) – Зуунмод (117км). Нийт 224км 3-4 өдөр
- Улаанбаатар – Зуунмод (43км) – Манзуширын хийд (7км) – Хустайн байгалийн цогцолборт газар (138км) – Өнгөтийн дурсгал (22км) – Зорголхайрхан уул (134км) – Зуунмод (131км). Нийт 475км, 5-6 өдөр
- Зуунмод - Тоньюкукын гэрэлт хөшөө (40км) – Цонжинболдог (33км) – Тэрэлж, Мэлхий хад, Аръяабалын сүм (33км) – Гүнжийн сүм (35км) – Зуунмод (105км) Нийт 245км, 2-3 өдөр

УВС АЙМАГ

Увс аймгийн 9 гайхамшигаар Увс нуур, Хяргас нуур ба Хэцүү хад, Алтан элсний дархан цаазат газар, Ханхөхий уулс, Чандмань уулын дурсгал, Гоожуурын хүрхрээ, Мөнгөт цахир уул, Дэглий цагаан уул, Зураагийн улаан хадны зураг зэрэг газрууд тодорчээ.

ХОВД АЙМАГ

Ховд аймгийн 9 гайхамшигаар Цэнхэрийн агуй, Хар-Ус нуур, Мөнххайрхан уул, Баянзүрхийн буган хөшөө, төрийн тахилгат Алтанхөхий уул, Харуул овоо, Ямаан усны хадны сүг зураг, Цамбагарав уулын байгалийн цогцолбор газар, Ишгэн толгойн хадны зураг зэрэг газрууд тодорчээ.

ХӨВСГӨЛ АЙМАГ

Хөвсгөл аймгийн 7 гайхамшигаар Соёны бүс нутаг, Хөвсгөл нуур, Даян дээрхийн агуй, Уушигийн өврийн буган чулуу, Улаан толгойн буган хөшөө, дархадын 13 овоо, Цаатны нутаг хэмээх газрууд тодорчээ.

ХЭНТИЙ АЙМАГ

Хэнтий аймгийн 9 гайхамшигаар Бурхан Халдун уул, Балдан бэрээвэн хийд, Чингисийн гэрэлт хөшөө, Дэлүүн болдог, Хар зүрхний хөх нуур, Хэрлэнгийн хөдөө арал, Өглөгчийн хэрэм, Рашаан хад, Дуурилаг нарсны Хүннү булш зэрэг газрууд тодорчээ.

Хүснэгт 13.3. ЖУУЛЧДЫН ХҮЛЭЭН АВАХ НӨӨЦ, ДААЦ, АЙМГУУДААР

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН НУТАГШИЛТ,
СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСӨЛ**

**ДУНДЫН ТАЙЛАН-1
БОТЬ 1: ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН
СУДАЛГАА**


№	Бүс нутаг	Аймгийн нэр	Жуулчны бааз	Орны тоо	Гэр буудал	Орны тоо	Амраг газар	Орны тоо	Зочид буудал	Орны тоо	Дэн буудал	Орны тоо	Рашаан сувилал	Орны тоо	Нийт	
															Б/Х	Ор
1	Баруун бүс	УВС	6	422	4	80	3	450	6	209	2	32	2	125	23	1318
2		ГОВЬ-АЛТАЙ	3	128	-	-	2	185	7	167	40	347	3	155	55	982
3		ХОВД	3	93	2	21	2	43	8	138	10	40	2	39	27	374
4		БАЯН-ӨЛГИЙ	8	185	65	100	2	45	6	200	2	25	3	35	86	590
5		ЗАВХАН	10	247	-	-	-	-	10	218	5	-	5	38	30	503
Бүс нутгийн нийт дүн			30	1075	71	201	9	723	37	932	59	444	15	392	211	3767
6	Хангайн бүс	ХӨВСГӨЛ	74	8997	130	2564	-	-	16	283	14	100	17	564	251	12508
7		АРХАНГАЙ	26	5980	-	-	-	-	29	143	-	-	-	-	55	6123
8		ӨВӨРХАНГАЙ	30	1831	31	86	6	470	11	310	7	-	4	950	89	3647
9		БУЛГАН	17	1327	12	48	83	3958	3	77	10	109	2	96	127	5615
10		БАЯНХОНГОР	4	220	-	-	3	285	8	269	-	-	2	512	17	1286
11		ОРХОН	0	0	0	0	5	1564	26	567	16	125	1	50	48	2306
Бүс нутгийн нийт дүн			151	18355	173	2698	97	6277	93	1649	47	334	26	2172	587	31485
12	Төвийн бүс	СЭЛЭНГЭ	7	356	-	-	16	670	34	472	-	-	2	130	59	1628
13		ӨМНӨГОВЬ	25	1692	31	518	3	335	59	987	-	-	3	94	121	3626
14		ДУНДГОВЬ	10	527	3	56	0	0	5	139	9	111	1	60	28	793
15		ДОРНОГОВЬ	7	520	109	411	60	-	26	590	-	-	3	230	212	1751
16		ТӨВ	136	6800	0	-	15	1200	5	500	-	-	33	2970	189	11470
17		ДАРХАН	0	0	0	0	8	-	27	-	16	-	2	-	37	-
18		ГОВЬСҮМБЭР	0	0	0	0	0	0	2	39	-	-	-	-	2	39
Бүс нутгийн нийт дүн			185	9895	143	985	102	2205	158	2727	25	111	44	3484	648	19307
19	Зүүн бүс	ДОРНОД	-	-	1	10	11	347	8	248	19	207	-	-	39	812
20		СҮХБААТАР	5	225	-	-	2	122	12	220	1	8	0	0	20	575
21		ХЭНТИЙ	19	947	-	-	64	1245	34	422	-	-	2	24	119	2638
Бүс нутгийн нийт дүн			24	1172	1	10	77	1714	54	890	20	215	2	24	178	4025
22	УБ	Улаанбаатар хот	109	4056	-	-	-	-	154	7778	136	2130	-	-	399	13964
Нийт байршуулах хэрэгсэл/ орны тоо			499	34553	388	3894	285	10919	496	13976	287	3234	87	6072	2042	72548

Эх сурвалж: БОАЖЯ

Нийт Монгол улсын хэмжээнд 33 тусгай хамгаалалтай газрын хамгаалалтын захиргаа байдаг бөгөөд нэвтрэх тасалбар олгосон байдлаар доорхи судалгааг гаргав.


Тусгай хамгаалалтай газар нутагт нэвтэрсэн 5 жилийн үзүүлэлтээр дотоодын жуулчдын өсөлтийг доорхи графикаар харуулав.

Зураг 13.5. Улсын тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн дотоодын жуулчдын тоо



Тусгай хамгаалалтай газар нутагт нэвтэрсэн 5 жилийн үзүүлэлтээр гадаадын жуулчдын өсөлтийг тооцвол жилийн дундаж өсөлт нь 19.3 хувьтай байгаа нь дотоодын аялал жуулчлал идэвхжиж байгааг харуулж байна. Дотоодын жуулчдын аяллын гол чиглэлийг тусгай хамгаалалтай нутагт нэвтэрсэн тооноос дүгнэн үзэхэд нэгдүгээрт Горхи Тэрэлж, хоёрдугаарт Хөвсгөл, гуравдугаарт Богд хан уул, дөрөвдүгээрт Хангайн нуруу, тавдугаарт Орхоны хөндийн чиглэлд зорин очиж байна.

Зураг 13.6. Улсын тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн гадаадын жуулчдын тоо




Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтэрсэн гадаадын жуулчдын хувьд жилийн өсөлтийн хувь 10.1 хувь буюу тогтвортой түвшинд байна. Гадаадыг жуулчдын сонирхдог гол чиглэлийг тусгай хамгаалалтай нутагт нэвтэрсэн тоо баримтан дээр үндэслэн дүгнэж үзвэл Горхи-Тэрэлж, Хустайн нуруу, Говь гурван сайхан, Орхоны хөндий, Хөвсгөл, Хангайн нуруу, Хөгнө тарна, Увс нуур, Алтай таван Богд, Богд хан уулын чиглэлд зорин очиж байна.

Үүнээс гадна аялал жуулчлалын маш олон чиглэлүүд байгаа бөгөөд эдгээр чиглэлүүдэд зорчиж байгаа иргэдийн бүртгэж тоолсон албан ёсны тоо баримт хомс байна.

13.5. Амралт сувилал

Монгол оронд анагаах илааршуулах чанартай олон төрлийн найрлага, бүтэцтэй халуун хүйтэн рашаан эрдэст нуур эмчилгээний шаврын нөөц ихтэй. Үүнд азотын хийтэй халуун рашаан 46, нүүрсхүчлийн хийтэй хүйтэн рашаан 140 гаруй байна. (Монгол орны гадаргын усны горим нөөц 2015) Рашаан төстэй усны үелэл 30 шахам, эмчилгээний онцгой бүрэлдэхүүнгүй боловч эмчилгээнд тустай 10 шахам усны илрэл, 270 гаруй рашаан төстэй харз булгууд байна.

Газрын зураг 13.1. Рашаан усны орд илрэлүүд



Хүснэгт 13.4. Улсын хэмжээнд нөөц нь тогтоогдсон рашаанууд

№	Аймгийн нэр	Рашааны ордын нэр	Ашиглаж болох нөөц м3/хоногт	Нөөц тогтоосон он
1	Дорноговь	Халзан уул	91.0	1971
2	Хэнтий	Аваргын рашаан	345.6	1992
3	Улаанбаатар	Улаанбаатар	89.9	1975
4	Төв	Өвөржанчивлан	70.0	1978
		Ар Жанчивлан	25.0	
5	Булган	Сайхан Хульж	518	1974
6	Өвөрхангай	Хужирт	1036.8	1972.2018
7	Баянхонгор	Шаргалжуут	4320.0	1975
8	Архангай	Шивэрт	450.0	-
		Цэнхэр	864.0	-
9	Баян-Өлгий	Чихэртэй	397.44	1991
10	Завхан	Отгонтэнгэр	608.0	-
		Зарт	78.0	1982
11	Сэлэнгэ	Ерөө	432.0	-
			9205.14	-

Эдгээр рашааны нөөцийг түшиглэн амралт сувиллын үйл ажиллагаа эрхэлж байна. Оргил рашаан сувилалыг түшиглэн үйл ажиллагаа явуулж байсан Рашаан сувиллын удирдах газар татан буугдаж, Рашааны тухай хууль хүчингүй болсон, Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр дуусч ихэнх рашаан сувиллын газрууд хувьд шилжсэн мөн улсын амралтын газрууд хувьчлагдсан тул амралт, сувиллын газруудын судалгаа, амрагч, сувилуулагчийн албан ёсны тоо баримт дутагдаж байна. Томоохон амралтын газруудын байршлаас үзвэл төвийн бүсэд хот орчимд байгаа нь хөдөө орон нутгаас ирж амрах цаг хугацаа зардал мөнгө шаардаж байгааг харуулж байна.

Хүснэгт 13.5. Рашаан сувиллаар үйлчлүүлэгчдийн тоо

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Рашаан сувилал	67	100	71	104	105	-	-	87
Сувиллаар үйлчлүүлэгчийн тоо	55359	63240	90801	85225	98489	86315	86015	91280

Агаар орчны бохирдол, хотжилт зэргээс үүдээд олон төрлийн харшил, нийгмийн стресс бухимдал зэргээс холдож амрах сувилуулах эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна.


13.6. Аялал жуулчлалын салбарын үндсэн бүсүүд

Аялал жуулчлалын тухай хуулийн 3.1.3. "аялал жуулчлалын бүс нутаг" гэж Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутгийг хэлнэ гэж тодорхойлсон.

Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх талаар салбарын яам болон Үндэсний хөгжлийн газраас бүс нутгуудыг тодорхойлсон. Үүнд

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГОЛ БҮС НУТГУУД

"Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө" 1999 он




АМРАЛТ СУВИЛАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МУЖЛАЛ




Эх сурвалж* Хөгжлийн газарзүйн хүрээлэн

“Монгол улсад амралт сувилал, аялал, жуулчлал хөгжүүлэх ерөнхий төсөл”-ийг 26 жилийн өмнө 1993 онд Зураг төсөл судалгааны үндэсний төвд боловсруулсан. Тус төслөөр улсын хэмжээнд улсын чанартай АСАЖ-ын 10 бүс 25 орчим сувилалын бүс-сувилал, 48 орчим амралтын бүс-амралт, 23 орчим аялал жуулчлалын бүс-жуулчны бааз бий болох төлөвтэй байгааг тодорхойлсон.

1996 онд Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутгуудыг тодорхойлсон байдаг.



Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Аялал-рекреацийн нөөц бүхий үнэ цэнэтэй гол газрууддаа хөрөнгө оруулалт хийж аялал жуулчлалыг хөгжүүлэх, нөөцүүдэд тулгуурлан аялал жуулчлалыг аж үйлдвэрийн түвшинд авч үзэн аялал-рекреацийн аж ахуйнуудыг төрөлжсөн болон хосолмол хэлбэрээр хөгжүүлэхээр төлөвлөж аялал рекреацийн нөөцийн үнэлгээнд тулгуурласан бүсчлэл хийсэн.



*Эх үүсвэр УГЗБЕТ 2018 он

13.7. ХИЛ ОРЧМЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол Улсад 2018 онд нийт 27 боомт үйл ажиллагаа явуулсан бөгөөд эдгээр боомтуудаар давхардсан тоогоор 6.1 сая зорчигч нэвтэрсэн байна. Улсын хилээр 2018 онд нэвтэрсэн зорчигчдын тоо 2008 оноос 2 дахин, 2012 оноос 29.5 хувиар, өмнөх оноос 2.6 хувиар тус тус өсжээ. Улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын 80.4 хувь нь Монгол Улсын иргэд, 19.6 хувь нь гадаадын зорчигчид, мөн 62.4 хувь нь эрэгтэй, 37.6 хувь нь эмэгтэй, 5.0 хувь нь хүүхэд байна.

Манай улсад ирж буй жуулчдын дийлэнхи хувийг Хятад жуулчид эзэлдэг бөгөөд Хятад жуулчдыг 2015 оноос Замын-Үүд, Бичигтийн боомтоор хил орчмын аялал жуулчлалын үнэмлэхээр нэвтрүүлж эхэлсэн. Тухайн онд Замын-Үүд өмнөх оноос 2.5 дахин илүү буюу 13914 хятад жуулчин хүлээн авсан бгөөд 2016 оноос энэ үйл ажиллагаа зогссон. Хил орчмын сум суурин газрууд жуулчин хүлээн авах байршуулах хэрэгсэл дутмаг байна.

Хилээр нэвтэрсэн зорчигчдыг боомтуудаар нь ангилан харвал, 39.4 хувь нь Замын-Үүд боомтоор, 17.9 хувь нь Буянт-Ухаа, 11.9 хувь нь Гашуун Сухайт, 11.2 хувь нь Алтанбулаг, 6.1 хувь нь Шивээ хүрэн, 13.5 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

Хүснэгт 13.6. Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо, 2018 он

	Гарсан	Орсон	Аяллын зорилго			
			Албан ажлаар	Хувийн журмаар	Байнга оршин суух	Бусад
Бүгд	3 058 468	3 043 550	54 359	204 557	2 455 049	329 585
Алтанбулаг	336 294	344 491	4 161	24 708	291 574	24 048
Арц суурь	7 659	8 088	6	3 050	4 968	64
Байтаг	31	35	-	2	33	-
Баянхошуу	27 387	27 234	367	954	11 746	14 167
Бичигт	55 243	55 168	287	1 092	39 039	14 750
Боршоо	46 019	45 679	111	36 544	7 801	1 223
Булган	35 856	35 986	10	379	34 117	1 480
Бургастай	17 426	17 433	25	16 989	410	9
Буянт-Ухаа	553 178	541 437	31 576	48 417	295 090	166 354
Гашуунсухайт	362 419	360 671	52	5 917	350 535	4 167
Даян	118	102	-	-	98	4
Замын-Үүд	1 203 729	1 203 166	9 222	36 282	1 096 243	61 419
Сүмбэр	1 484	1 495	2	433	914	146
Сүхбаатар	42 247	32 648	7 985	1 060	7 480	16 123
Тэс	1 261	1 331	1	955	373	2
Ульхан	2 119	2186	101	345	1 630	110
Хавирга	59 226	58 964	181	1 051	54 437	3 295
Ханги	39 919	41 060	6	1 441	39 508	105
Ханх	21 796	21 947	3	93	11 152	10 699
Ховд	13	15	6	-	1	8
Цагааннуур	52 931	52 723	82	22 000	27 053	3 588
Чойбалсан	0	35	-	2	20	13
Шивээхүрэн	186 060	185 593	142	2 217	175 464	7 770
Эрэнцав	6 053	6 063	33	626	5 363	41

Эх сурвалж* Үндэсний статистикийн хороо

Аялал жуулчлалын гол чиглэл дагуу сүүлийн үед жуулчид ихээр зорин очиж байгаа газруудаас үзэхэд манай орны ястан үндэстний өв уламжлал тухайн нутгийн онцлог, ёс уламжлал, зан заншлыг илэрхийлсэн гар урлал, бэлэг дурсгал, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл бий болох хандлагатай байна. Гэвч гадаадын болон дотоодын жуулчдын сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх нь тухайн орон нутгийн тулгамдаж байгаа асуудал юм. Сүүлийн үед соёлын өв, музей, концерт, урлагийн наадам, соёл урлагийн арга хэмжээ, эвент арга хэмжээг үзэж сонирхохоор зорих жуулчдын тоо нэмэгдэж байна.

2018 онд Монгол улсад зочилсон нийт 529,370 жуулчдын 263,490 буюу 49.7% нь агаарын тээврээр ирсэн.

ОН	Нийт суудлын тоо	Нисэх буудлаар нэвтэрч байгаа жуулчдын тоо	Нийт суудалд эзэлж буй жуулчдын хувь
2018	1,020,891	263,490	25.8%

Жуулчдын монгол улсад ирсэн тээврийн хэрэгсэл/2017/

№	Тээвэр	Гадаадын жуулчны тоо
1	Авто зам	194931
2	Төмөр зам	52280
3	Агаарын тээвэр	222098

БҮС НУТАГ ДАХЬ БООМТООР НЭВТЭРСЭН ЖУУЛЧДЫН ТОО

№	Бүс нутаг	Тоо	Хувь
	Улаанбаатарын бүс		47
	Төвийн бүс		34
	Баруун бүс		14
	Зүүн бүс		3
	Хангайн бүс		2


Мөн хил орчмын нутгийн бүсчилсэн эдийн засгийн хөгжил, аялал жуулчлалыг анхаарч хөгжүүлснээр Монгол улсын 23 боомтоор орж ирэх жуулчдын тоо нэмэгдэх боломжтой.

14. ЭДИЙН ЗАСАГ АЖ ҮЙЛДВЭР

14.1. Эдийн засгийн өсөлт, бууралт

Манай улсын оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2000 оноос хойш уул уурхайн салбарын олборлолт, үйлдвэрлэлээс ихээхэн хамаарч эрчимтэй өсөж, 2010 онд хамгийн өндөр буюу 48.0 хувиар өссөн. Гэвч эдийн засгийн өсөлт 2011 оноос эхлэн буурч, 2016 онд 3.4 хувь болж, 2017 оноос дахин сэргэсэн боловч 2018 онд буурсан байна. ДНБ-ий өсөлтийг бүсээр авч үзвэл хамгийн их өсөлттэй байсан 2010 онд төвийн бүс (60.3%), Улаанбаатар (57.2%), зүүн бүс (49.0%) өссөн нь улсын түвшнээс давсан өсөлтийг харуулж байна. Харин 2018 онд Улаанбаатар (9.6%) хамгийн их, хангайн бүс (9.6%) хамгийн бага өсөлттэй байна.


Зураг 14.1.1. ДНБ-ий жилийн өсөлт, бууралт, хувиар бүсээр 2002-2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэдийгээр бүсүүдийн ДНБ өссөн ч уг өсөлт нь улсын нийт өсөлтийг хэрхэн бүрдүүлж байгааг бүсүүдийн оролцоогоор нь илэрхийлнэ. 2018 оны ДНБ-ий 16.5 хувийн өсөлтийн 10.5 пунктийг Улаанбаатар, 2.0 пунктийг хангайн бүс, 1.6 пунктийг төвийн бүс, 0.9 пунктийг зүүн бүс, 0.9 пунктийг баруун бүс бүрдүүлсэн байна.


Зураг 14.1.2. ДНБ-ий жилийн өсөлтөд бүсүүдийн оролцоо (%) 2002-2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн бүтцээр нь улс орны хөгжлийн түвшинг тодорхойлдог. Улсын хэмжээнд ДНБ-ийхээ 20 гаруй хувийг уул уурхайгаас бүрдүүлж байгаа нь уул уурхайгаас хараат улс болон хувирсанг харуулж байгаа бөгөөд эдийн засгийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон. Бүтцийн энэ гажуудал нь манай улсын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй хөгжлийн түвшин үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар тодорхойлогддог үе шатаас ухарч уламжлалт аж ахуй, уул уурхайн олборлолт гэсэн үе шатанд орж байна. Энэ нь уул уурхайн түүхий эд экспортлогч улс болсон гэсэн үг юм.

Газрын зураг 14.1.1. ДНБ аймаг, нийслэлээр 2018 он



ДНБ-ий бүтцийг бүсээр авч үзвэл эдийн засгийн харьяатын зарчмын дагуу дийлэнх хувь нь Улаанбаатарт ногдож, үйлдвэрлэл явагдаж байгаа бүс нутгийн эдийн засагт төдийлөн хувь нэмрээ оруулахгүй байгаа нь харагдаж байна.


Хүснэгт 14.1.1. ДНБ зах зээлийн үнээр 2010-2018 он

Аймаг	2010	2015	2017	2018
Говьсүмбэр	29.40	83.72	83.96	89.15
Булган	131.31	301.39	285.48	318.53
Говь-Алтай	65.98	237.12	266.13	323.39
Дундговь	69.49	237.57	258.18	328.14
Завхан	100.16	310.60	311.61	356.52
Дорноговь	105.99	261.32	296.01	369.21
Баян-Өлгий	108.30	311.01	326.83	370.89
Ховд	113.17	322.29	326.25	384.76
Увс	106.13	330.09	318.88	388.30
Баянхонгор	105.42	366.14	399.78	417.66
Хэнтий	111.49	347.79	343.36	425.16
Дархан-Уул	163.79	367.26	409.54	428.45
Архангай	120.05	417.30	418.18	431.37
Сүхбаатар	143.19	326.88	413.69	501.19
Өвөрхангай	103.76	409.52	460.30	502.11
Төв	177.21	542.58	510.45	594.30
Хөвсгөл	192.13	506.34	512.20	617.31
Өмнөговь	238.67	281.27	714.47	657.80
Сэлэнгэ	395.16	574.52	598.22	689.58
Дорнод	139.29	597.73	799.17	837.60
Орхон	882.57	1,053.22	1,718.32	1,871.49
Улаанбаатар	6,153.94	14,964.72	18,105.28	21,404.43

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт ДНБ-ий дийлэнх хувийг Улаанбаатар бүрдүүлж байна. Тухайлбал, 2001-2010 онуудын дунджаар Улаанбаатар 57.9 хувь, хангайн бүс 19.8, төвийн бүс 10.7 хувь, баруун бүс 7.0 хувь, зүүн бүс 4.5 хувийг эзэлж байна.



Зураг 14.1.3 ДНБ-д бүсүүдийн эзлэх хувь, 2002-2018 он



Нэг хүнд ногдох ДНБ-ийг бүсээр харьцуулбал улсын дунджийг ерөнхийдөө Улаанбаатар тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл, бүх бүсийнх улсын дунджаас доогуур утгатай байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтийн хурдыг авч үзвэл 2018 онд 2010 оноос улсын дундаж 2.7 дахин өссөн бол зүүн бүсийнх 3.8 дахин, баруун бүсийнх 2.3 дахин, Улаанбаатарынх 2.7 дахин, хангайн бүсийнх 2.3 дахин, төвийн бүсийнх 2.2 дахин өссөн байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр 2018 онд Орхон, Улаанбаатар, Өмнөговь, Дорнод аймаг улсын дунджаас 1.3-8.0 сая төгрөгөөр дээгүүр байна. Эдгээр аймгийн хувьд уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл өндөр байдагтай холбоотой. Харин Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл аймгууд улсын дунджаас 5.1-5.7 сая төгрөгөөр доогуур байна.

Газрын зураг 14.12. Нэг хүнд ногдох ДНБ /сая.төг/ аймаг, нийслэлээр 2018 он



Хүснэгт 14.1.2 Нэг хүнд ногдох ДНБ, аймгаар /сая,төг/


Аймаг	2010	2015	2017	2018
Улсын дүн	3.7	7.81	9.	10.23
Орхон	10.25	11.	16.88	18.27
Улаанбаатар	5.4	11.25	12.94	14.96
Дорнод	2.02	7.9	10.16	10.35
Өмнөговь	3.99	4.65	11.05	9.76
Сүхбаатар	2.79	5.63	6.82	8.09
Дундговь	1.76	5.38	5.62	7.04
Сэлэнгэ	4.16	5.47	5.55	6.33
Төв	2.12	6.03	5.45	6.27
Говь-Алтай	1.22	4.21	4.66	5.59
Хэнтий	1.7	4.85	4.59	5.53
Дорноговь	1.84	4.13	4.39	5.36
Булган	2.46	5.02	4.64	5.15
Говьсүмбэр	2.27	5.2	4.89	5.11
Завхан	1.5	4.46	4.36	4.91
Баянхонгор	1.38	4.4	4.63	4.76
Увс	1.45	4.23	3.89	4.67
Хөвсгөл	1.68	4.	3.91	4.63
Архангай	1.42	4.52	4.44	4.52
Ховд	1.47	3.92	3.78	4.38
Өвөрхангай	1.02	3.65	4.01	4.32
Дархан-Уул	1.82	3.77	4.06	4.16
Баян-Өлгий	1.25	3.26	3.25	3.61

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр Орхон аймаг улсад тэргүүлдэг болон жилийн дундаж өсөлтийн хувиар сүүлийн 8 жилийн хугацаанд Дорнод, Өмнөговь, Сүхбаатар зэрэг уул уурхайн үйлдвэрлэл хөгжсөн аймгууд тэргүүлж байна.

14.2. Орон нутгийн төсөв

Газрын зураг 14.2.1. Орон нутгийн төсвийн орлого 2018 /тэр.төг/




Хүснэгт 14.2.1. Орон нутгийн төсвийн орлого 2018 /тэр.төг/

Аймаг	2010	2015	2018
Улсын дүн	3,609.49	2,033.76	2,769.43
Говьсүмбэр	24.86	14.5	14.71
Дундговь	40.74	36.7	41.98
Сүхбаатар	76.85	45.62	50.78
Говь-Алтай	50.8	50.31	57.13
Булган	52.32	46.96	58.38
Дорнод	53.61	50.07	59.22
Дархан-Уул	75.77	50.65	61.82
Дорноговь	80.09	43.06	63.14
Хэнтий	56.17	53.65	63.24
Завхан	52.51	53.86	65.55
Ховд	58.61	56.2	69.28
Увс	52.39	58.34	70.47
Архангай	51.84	60.23	70.52
Баянхонгор	53.8	58.44	70.96
Төв	65.69	63.32	77.21

Сэлэнгэ	145.02	62.21	77.36
Баян-Өлгий	43.79	65.51	78.22
Өвөрхангай	61.66	68.66	81.21
Орхон	407.65	73.22	96.2
Хөвсгөл	67.33	80.94	96.39
Өмнөговь	408.58	94.64	197.68
Улаанбаатар	1,629.42	846.66	1,247.97

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Газрын зураг 14.2.2. Орон нутгийн төсвийн зарлага, аймгуудаар, 2010-2018 он



Хүснэгт 14.2.2 Төсвийн зарлага аймгаар 2018 он /тэр.бум төг/


Аймаг	2010	2015	2018
Улсын дүн	358.12	2,079.17	2,716.42
Говьсүмбэр	2.23	14.93	14.57
Дундговь	3.92	39.77	40.39
Сүхбаатар	7.58	45.84	51.14
Говь-Алтай	4.77	52.73	55.31
Булган	4.9	50.9	57.01
Дорнод	5.31	50.61	59.75
Дорноговь	8.31	43.37	61.62

Хэнтий	6.02	52.99	62.56
Завхан	5.21	54.4	65.38
Ховд	5.63	56.68	67.45
Архангай	5.5	60.26	69.07
Баянхонгор	5.43	57.81	69.46
Увс	5.05	57.97	69.61
Дархан-Уул	6.89	50.81	69.88
Төв	7.56	65.15	76.05
Баян-Өлгий	4.58	64.79	78.01
Сэлэнгэ	14.09	62.76	78.24
Өвөрхангай	6.31	67.86	78.86
Орхон	40.75	73.14	89.
Хөвсгөл	6.8	81.09	97.75
Өмнөговь	41.61	91.51	166.71
Улаанбаатар	159.68	883.79	1,238.59

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Харин улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэгийн дүнг харвал Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгууд 2017 онд 12 тэр.төг- 18 тэр.бум төгрөгийн хооронд санхүүгийн дэмжлэг авсан байна.

Газрын зураг 14.2.3 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 2018 он /тэрбум төг/




Хүснэгт 2 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 2018 он
/тэр.бум төг/

Аймаг	2010	2015	2018
Улсын дүн	20.14	160.49	180.7
Орхон	0.	0.	0.
Булган	0.	0.5	0.
Говьсүмбэр	0.22	0.35	0.
Дорноговь	0.	0.	0.
Дархан-Уул	0.	1.41	0.
Өмнөговь	0.	0.	0.
Дорнод	0.	5.29	4.59
Сэлэнгэ	0.	5.33	6.95
Сүхбаатар	0.	6.89	6.96
Дундговь	1.04	7.55	7.31
Төв	0.	9.36	9.93
Говь-Алтай	0.83	9.68	11.27
Хэнтий	0.	10.4	11.81
Ховд	1.8	8.89	11.94
Завхан	2.22	11.47	13.13
Хөвсгөл	3.07	18.01	14.12
Баянхонгор	2.22	12.92	14.36
Архангай	2.22	13.2	15.24
Увс	2.42	11.98	15.83
Баян-Өлгий	1.58	12.95	16.41
Өвөрхангай	2.52	14.34	20.85

Өмнөговь, Булган, Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорноговь аймгууд нь 2018 оны байдлаар төсвийн орлого нь зарлагаасаа давсан тул улсаас санхүүгийн дэмжлэг авдаггүй бол бусад 15 аймаг төсвийн алдагдалтайгаар улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байна.

14.3. Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин

Газрын зураг 14.3.1 Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин



Хүснэгт 14.3.1. Аймгуудын эдийн засгийн хөгжлийн түвшин


Аймгийн нэр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Ховд	5	5.85	5.83	5.24	3.98	3.75	3.98
Дундговь	2.8	3.33	3.96	3.32	2.93	2.75	4.15
Архангай	4.36	5.3	5	4.7	3.3	4	4.26
Дорноговь	7	5.11	5	3.56	3.2	5.84	4.28
Завхан	5.34	4.47	4.47	4.21	3.53	4.76	4.42
Говь-Алтай	6	5.17	5.23	4	3.52	3.95	4.52
Баян-Өлгий	5	4.26	6.46	5.7	4.82	5.02	4.6
Сүхбаатар	7.8	6.6	7.48	6.23	4.27	4.7	4.98
Говьсүмбэр	5.17	5.78	5.91	4.51	4.78	5.05	5.06
Хэнтий	4.8	5.64	6.55	5.89	4.23	3.67	5.08
Дархан-Уул	5.12	4.75	5.87	4.33	4.38	4.79	5.58
Хөвсгөл	5.37	4.52	6.23	4.93	3.67	4.95	5.61
Сэлэнгэ	6.29	6	6.06	4.6	3.96	4.88	5.63
Увс	5.22	4.58	5.5	5.14	3.45	3.85	5.77
Булган	5.42	3.48	4.88	5.14	3.34	3.76	5.78
Баянхонгор	5.12	4.94	6.59	5.52	4.52	4.21	5.82
Орхон	6.45	5.33	5.9	3.44	3.65	4.48	6.04
Төв	4	4.4	6.26	5.79	4.53	4.82	6.04
Өвөрхангай	6.77	5.86	5.87	5.58	4.5	4.81	6.06
Дорнод	5	4.29	6.1	4.07	3.89	4.91	6.1

Өмнөговь	8.4	5.6	5	3.94	4.8	5.65	7.02
----------	-----	-----	---	------	-----	------	------

Дээрх хүснэгтээр аймгуудын эдийн засгийн хөгжлийг 2012-2018 он хүртэл харуулсан байна. Эдгээр онуудаас хамгийн өндөр түвшингийн үзүүлэлттэй гарсан нь 2012 он бөгөөд Дорноговь аймаг 7, Өмнөговь аймаг 8,4, Сүхбаатар аймаг 7,8 хүртэл түвшинд хүрсэн байгаа нь дэд бүтэц, уул уурхайн хөгжил дагаж эдийн засгийн эргэлт их явагдаж байгааг харуулж байна. 2015 онд түвшин их бууралттай байсан бол 2017-2018 онуудад өссөн байна. 2018 оны байдлаар 4,0-5,0 түвшинтэй 9 аймаг, 5,1-6,0 түвшинтэй 9 аймаг, 6,1-7,0 түвшинтэй Дорнод, Өмнөговь гэсэн нийт 2 аймаг байгаа бол хамгийн бага нь Ховд аймаг 3,98 түвшинтэй байна.

14.4. Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ

Зураг 14.4.1 Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ



Эх сурвалж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Хүснэгт 14.4.1 Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ


Аймгийн нэр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Архангай	37.17	41.06	49	57	49	44	37
Говь-Алтай	50.11	55.02	50	56	47	38	43
Дундговь	27.65	42.65	30	39	47	46	44
Булган	59.56	57.22	53	57	53	49	45
Завхан	51.86	51.19	51	57	53	50	54
Ховд	57.62	54.21	56	62	70	57	54
Баянхонгор	43.85	44.32	46	53	51	51	55
Хөвсгөл	49.76	49.71	51	58	67	63	57
Хэнтий	58.52	54.09	52	57	62	55	71
Баян-Өлгий	61.36	58.06	55	59	71	71	75
Увс	60.76	64.24	64	65	73	69	75
Өвөрхангай	44.53	54.92	50	57	64	65	77
Төв	63.9	76.07	69	68	76	74	77

Сүхбаатар	64.39	75.34	80	78	91	76	79
Сэлэнгэ	73.91	75.95	69	67	76	72	79
Говьсүмбэр	65.02	70.77	65	66	70	71	84
Дорноговь	77.1	80.63	68	64	76	72	84
Дорнод	70	65	65	64	74	80	84
Өмнөговь	92.77	89.99	86	85	95	85	94
Дархан-Уул	83.86	82.04	86	86	94	91	96
Орхон	100	100	100	100	100	100	100

Монгол улсын 21 аймгуудын өрсөлдөх чадварыг 100 хүртэл оноор үнэлэхэд 2012-2018 онуудад эхний гуравт Орхон аймаг, Өмнөговь аймаг, Дархан-Уул аймаг орсон байна. Дээрх онуудаас хамгийн өндөр үнэлгээг 2016 онд аймгууд авсан буюу Говь-алтай, Дундговь аймгууд 47 гэсэн хамгийн бага оноог авсан байна.

14.5. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал


Газрын зураг 14.5.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, аймгаар, 2018 он



Үйлдвэрлэлийн салбарт уул уурхай, олборлох, боловсруулах, эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж болон барилгын салбарыг оруулах бөгөөд уг салбар 2018 онд 13.5 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ий 41.9 хувийг бүрдүүлжээ. Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг 2017 онд өмнөх оноос 17.2 хувиар нэмэгдсэн байна. Үйлдвэрлэлийн


салбарын нэмүү өртгийн 65.3 хувийг Улаанбаатар, 16.6 хувийг хангайн бүс, 8.7 хувийг төвийн бүс, 6.6 хувийг зүүн бүс, 2.9 хувийг баруун бүс тус тус бүрдүүлжээ.

Зураг 14.5.1. Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг /тэр.төг/



Үйлчилгээний салбар 2018 онд ДНБ-ий 47.4 хувийг бүрдүүлжээ. Салбарын нэмэгдэл өртөг 2018 онд 15.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.4 хувиар өссөн байна. Үйлчилгээний салбарын НӨ-ийг 2018 онд 81.5 хувийг Улаанбаатар, 6.7 хувийг төвийн бүс, 5.5 хувийг хангайн бүс, 4.3 хувийг баруун бүс, 2.1 хувийг зүүн бүс тус тус бүрдүүлжээ. Нийслэл Улаанбаатарт төрийн ихэнх байгууллагууд болон олон бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг компаниудын толгой компаниуд байрладаг. Иймд үйлчилгээний салбарын НӨ-ийн хэмжээ Улаанбаатарт өндөр байдаг. Үйлчилгээний салбарын НӨ 2018 онд өмнөх оноос төвийн бүсэд 7.1 хувь, хангайн бүсэд 7 хувь, баруун бүсэд 4.1 хувь, , зүүн бүсэд 9.0 хувь, Улаанбаатарт 15.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 1.5.2. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал тус бүрээр, ДНБ-нд эзэлж буй хувиар



14.6. Аж үйлдвэр

Аж үйлдвэрлэлийн хөгжлийн боломж ба сорилтууд

Боломж

- Дотоод болон гадаад хүн амын зах зээлийн өсөлт
- Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь өндөр-хүн амзүйн цонх
- Хотжилтын өсөлт
- Импортын их хэрэглээг орлуулан нөхөх боломж
- Байгалийн нөөц, баялаг


Сорилт

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүү
- Хүн амын худалдан авах чадвар суларч, орлогын тэгш бус байдал ихэссэн
- Дэд бүтэц сул хөгжсөн,
- Дотоод зах зээл бага
- Эдийн засгийн нөхцөл суларсан (инфляци, мөнгөний ханш, эдийн засгийн өсөлт)
- Эдийн засгийн хилийн зузаан хатуу (хилийн хяналт шалгалт, хязгаарлалтын нөхцөл өндөртэй, экспортын зардал өндөр)
- Хүн амын гадагш шилжилт хөдөлгөөн нэмэгдэх

Хүснэгт 14.6.1. Хүнд болон хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн харьцуулсан шинжилгээ

№	Үзүүлэлт	Хүнд аж үйлдвэр	Хүнс, хөнгөн аж үйлдвэр	Тайлбар
1	Түүхий эд нөөц	Сайн: Гол дэд бүтцийн тэнхлэгийн дагууд дийлэнхи орд нөөц газрууд бий.	Сайн: нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хүртээмжтэй жигд тархсан	Уул уурхай болон хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц, түүхий эдээр дэлхийд тэргүүлэх орны нэг.
2	Дотоодын зах зээл	Бага: бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх эрэлт бага	Дунд: Хүн амын өсөлт өндөртэй улс	Экспорт гэхээсээ эхний ээлжинд импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй.
3	Гадаад зах зээл	Муу: Хөрш ОХУ, БНХАУ хүнд аж үйлдвэрлэлийн салбараар дэлхийд тэргүүлэх улсын нэг.	Дунд: Хилийн хяналт шалгалт өндөр,	Хөрш орнуудын 1 хүнд ногдох ДНБ, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардал илүү хурдацтай нэмэгдэж байгаа нь хямд өртөгтэй бүтээгдэхүүнээр хангах
4.	Хөрөнгө оруулалт	Их: Үйлдвэрлэлийн дэд бүтэц, тоног төхөөрөмж технологи, өндөр үр чадвартай мэргэжилтэн зэрэг нь өртөг өндөр.	Дунд: Хөрөнгө оруулалтыг төрийн хөнгөлөлттэй зээл болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдэх боломжтой	
5.	Дэд бүтэц	Муу:	Дунд: Бүх аймгийн төв хатуу хучилттай автозам болон эрчим хүчний нэгдсэн байнгын эх үүсвэрт холбогдсон.	
6.	Өрсөлдөөн	Бага: Дотоодын зах зээлийн өрсөлдөөн харьцангуй бага	Их: дотоодын үйлдвэрлэл, импортын бүтээгдэхүүний өрсөлдөөн их	Зарим нэр төрлийн барилгын материалын хувьд зах зээлээс давсан өрсөлдөөн бий болсон.
7.	Боловсон хүчин	Муу: үр чадвар өндөртэй ажлын туршлагатай мэргэжлийн боловсон хүчин бага	Сайн: Үйлдвэрлэлийн бааз сүүр, мэргэжлийн, туршлагатай ажиллах хүчний нөөц сайтай.	
8.	Технологи	Муу: Өндөр технологи нэвтрүүлэхэд зардал өндөр	Дунд:	
9.	Менежмент	Муу: мега төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн менежмент, туршлага сул	Дунд:	Чөлөөт бүсүүд, УТПарк, аж үйлдвэрийн цогцолбор төслүүд удаашралтай, зогсонги
10.	Төрийн зохицуулалт	Муу: импортыг хязгаарлалт бага орчин муу	Муу: импортыг хязгаарласан орчин муу	Үйлдвэрлэлийн салбарын төрөлжилт, хэт өрсөлдөөн, татварыг зохицуулсан эрхзүйн орчин сул, авилгал хүнд суртал, засгийн газрын тогтвортой байдал, нийгэм-эдийн засгийн үр ашиг багатай олон төслүүдийг нутаг дэвсгэрээр хавтгайруулан зээл олгосон.


Зураг 14.6.2. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эзлэх хувь, бүсүүдээр, 2000-2018 онд



Аж үйлдвэрлэлийн хөгжлийн 61 хувь нь дангаараа Улаанбаатар хотод ногдож байгаа бол Төвийн бүсэд 21 хувь нь ногдож байгаа бол Зүүн болон Баруун бүс тус бүр дөнгөж 2 хувийг

эзэлж байгаа нь аж үйлдвэрлэлийн төвлөрлийн орон зайн их ялгаатай байдлыг харуулж байна.

Газрын зураг 14.6.1. Хүнд аж үйлдвэр хөгжих тохиромжтой бүс нутаг



Түүхий эдийн нөөц, ашиглагдах бүтээгдэхүүн, эрчим хүч, инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн хөгжил, бүтээгдэхүүний нийлүүлэх зах зээлд ойр байршилтай зэргээрээ хүнд аж үйлдвэр хөгжүүлэх тохиромжтой бүс нутгаар Төвийн болон Зүүн бүс тодорч байна.

14.7. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар 1999 он хүртэл дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж байсан бол 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс үүдэн хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна. ДНБ-д 2018 оны байдлаар 10.7 хувь, экспортын орлогын 3.3 хувь, импортын 11.6 хувийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импорт бүрдүүлж байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл болон арьс, ширэн эдлэл зэрэг үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй, баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болж байна.

Монгол Улсын нийт малын тоо толгой 2013-2018 оны хугацаанд харьцангуй тогтвортой өссөн үзүүлэлттэй байна. Үүний хамгийн том хүчин зүйл нь сүүлийн жилүүдэд агаарын температур тогтворжиж, байгалийн гамшигт үзэгдэл болох ган, зуд тохиох нь багассантай холбоотойгоос гадна малчдын малын тоо толгойд анхааран өсгөн үржүүлэх сонирхол нэмэгдсэн.

Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (НӨ) 2018 онд 3.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ий 10.7 хувийг бүрдүүлсэн байна. Хөдөө аж ахуйн салбар (ХАА)-ын нэмэгдэл өмнөх оноос 22.5 хувиар нэмэгджээ. ХАА салбарын НӨ-ийн 31 хувийг хангайн бүс, 27.9 хувийг төвийн бүс, 22.6 хувийг баруун бүс, 16.2 хувийг зүүн бүс, 2.3 хувийг Улаанбаатар тус тус бүрдүүлжээ.


Аймаг, нийслэлийн түвшинд, ХАА-н салбарын эзлэх хувь 0.4 хувиас (Улаанбаатар хот) 60.2 хувь (Дундговь аймаг) байна.

Хүснэгт 14.7.1 Хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
ДНБ	11.6%	10.2%	11.2%	13.4%	13.3%	13.3%	11.5%	10.1%	10.7%
Аймаг, нийслэл = 100%									
Улаанбаатар	0.5%	0.5%	0.4%	0.6%	0.7%	0.6%	0.5%	0.3%	0.4%
Орхон	1.4%	0.9%	1.0%	1.3%	1.1%	1.2%	1.0%	0.6%	0.7%
Дархан-Уул	14.5%	11.1%	10.6%	12.5%	11.7%	9.8%	9.7%	8.2%	9.2%
Дорнод	29.4%	22.8%	27.5%	20.7%	13.3%	17.1%	14.4%	13.8%	17.4%
Өмнөговь	14.6%	12.8%	17.8%	19.3%	28.5%	32.8%	22.5%	14.7%	19.8%
Говьсүмбэр	18.1%	17.9%	22.4%	24.8%	24.2%	25.8%	20.0%	20.8%	22.6%
Сэлэнгэ	23.5%	24.5%	26.9%	29.6%	25.8%	25.0%	23.9%	20.9%	25.7%
Дорноговь	36.2%	27.5%	25.9%	31.7%	31.5%	36.0%	25.6%	27.3%	31.2%
Сүхбаатар	33.4%	37.6%	40.0%	45.4%	41.7%	46.2%	37.9%	33.1%	35.7%
Баян-Өлгий	41.5%	37.3%	37.3%	40.5%	39.3%	40.7%	38.9%	35.3%	38.5%
Увс	44.7%	42.6%	45.8%	48.0%	44.3%	41.3%	36.1%	35.0%	40.9%
Хөвсгөл	55.9%	47.4%	50.2%	48.1%	45.5%	41.8%	41.5%	39.7%	41.7%
Ховд	49.0%	40.6%	43.0%	47.1%	44.7%	44.1%	42.3%	40.3%	41.8%
Өвөрхангай	38.8%	42.2%	48.1%	53.1%	51.7%	50.4%	49.3%	47.2%	43.1%
Баянхонгор	52.0%	48.8%	53.2%	55.8%	51.5%	47.3%	44.6%	43.9%	44.3%
Завхан	47.0%	42.9%	47.8%	48.9%	47.2%	46.8%	44.5%	44.2%	46.6%
Төв	64.2%	57.7%	61.1%	63.1%	57.8%	54.0%	49.4%	40.9%	47.6%
Говь-Алтай	43.5%	43.6%	52.1%	57.0%	48.4%	47.0%	44.7%	45.8%	47.7%
Булган	68.6%	61.4%	62.9%	63.7%	62.8%	59.3%	55.5%	50.3%	51.2%
Архангай	59.3%	57.4%	60.7%	63.2%	64.1%	60.6%	58.8%	56.6%	55.1%
Хэнтий	58.6%	55.0%	58.2%	59.3%	59.3%	58.6%	56.9%	57.1%	55.4%
Дундговь	56.1%	52.6%	57.9%	60.6%	61.0%	60.1%	55.1%	56.7%	60.2%



Мал тооллогын 2018 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо толгой 66.4 саяд хүрч, өмнөх оныхоос 243.2 толгойгоор буюу 0.3 хувиар өссөн бөгөөд сүргийн төрлөөр нь авч үзвэл адуу 3.9 сая буюу нийт малын 5.8%, үхэр 4.3 сая 6.4%, тэмээ 459.7 мянга 0.6%, хонь 30.5 сая 45.9%, ямаа 27.1 сая 40.8% тоологдлоо.




100 га бэлчээрт ногдох малын тоогоор Архангай, Булган аймгийн ихэнх сумд хамгийн их байгаа бөгөөд Хангай, Хэнтийн уулархаг нутгаар зуун га бэлчээрт ногдох малын тоо болон нийт малын тоо хамгийн их байна. Говийн аймгуудын хувьд бусад аймгуудыг бодоход малын тоо цөөнтэй учир зуун га бэлчээрт ногдох малын тоо харьцангуй бага байна.




Эх сурвалж: ГХГЗЗГ, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хүрээнд сүргийн бүтцэд ямаа болон хонин сүрэг хамгийн их хувийг эзэлж уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн бүсчлэлээр нутгийн ихэнх хэсгээр бог мал, нутгийн урд хэсэг буюу говийн аймгийн нутгаар тэмээн сүрэг, хангайн нурууны салбар газруудаар үхэр сүргийг түлхүү өсгөн үржүүлэхэд тохиромжтой байна.



1 малчин өрхөд ногдох малын тоо нь 100 га бэлчээрт ногдох малын тоотой мөн адил Архангай аймгийн ихэнх сумд, Хөвсгөл, Булган аймгийн зарим сумдаараар бусад аймаг сумуудтай харьцуулахад өндөр байна. Энэ нь мал өсгөн үржүүлэхэд тохиромжтой газар нутаг, байгалийн ус хангамж, эдийн засгийн бүсчлэл зэргээс хамаарч байна. 1км



Бэлчээрийн тэжээлийн нөөц ашиглалт ихтэй буюу бэлчээрийн талхагдал ихтэй бүс нутагт Төв, Өвөрхангай, Дундговь, Булган аймгийн ихэнхи нутаг хамрагдаж байгаа бол бэлчээрийн тэжээлийн нөөц хүрэлцээ сайтай бүс нутагт Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Өмнөговь, Хөвсгөл аймаг орж байгаа нь цаашдаа бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч хүн амын суурьшлыг аймаг хооронд төлөвлөн хэрэгжүүлэх хэрэгтэйг харуулж байна.

Дүгнэлт

Хэдийгээр сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг өсөж байгаа ч хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээ нийслэл Улаанбаатар хотод төвлөрч байгаагаас нийслэл болон орон нутаг дахь эдийн засгийн тэгш бус байдал нэмэгдэж, хот хөдөөгийн хөгжлийн ялгаатай байдал улам нэмэгдсээр байна. Манай улсын нийт хүн амын 46% (1 сая 463 мянга), аж үйлдвэрлэлийн 61 %, идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын 64.2 % (50467) нь нийслэл хотод төвлөрч байна. Энэхүү төвлөрөл, хөгжлийн тэгш бус байдлыг бууруулахад дунд, урт хугацаанд орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах нь нэн чухал бөгөөд бүсчлэлээр нэгдсэн тоо мэдээллийг цуглуулж, эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийх, хөгжлийн стратегийг боловсруулах шаардлагатай байна.



15. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН БА ХҮН АМЫН НУТАГШИЛТ СУУРЬШИЛ

Монгол орны өргөн уудам газар нутагт нь байгаль экологийн хувьд харилцан адилгүй уур амьсгал, экосистемийн төлөвтэй. Энэ агуулгаар Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлого, Засаг захиргаа

нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтийг хийхдээ орон зайн хувьд байгаль орчны дараахь хүчин зүйлүүдийг харгалзан, байгалийс өгөгдсөн нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөх хэрэгтэй.

- Уур амьсгалын өөрчлөлт, цаашдын хандлага
- Усны нөөц, түүний тархалт, цаашдын хандлага
- Газрын доройтол, цөлжилт, бэлчээрийн экосистемийн төлөв байдал
- Ойн нөөц, түүний тархалт
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ

Газрын зураг 15.1. Монгол орны экологийн бүс ба хүн амын нутагшилт, суурьшил



Монгол орны нийт 330 сумдыг экологийн бүсүүдээр ангилан үзвэл тайгын бүсэд 8 сум, ойт хээрийн бүсэд 105 сум, хээрийн бүсэд 127 сум, цөлөрхөг хээрийн бүсэд 68 сум, цөлийн бүсэд 23 сумын нутаг дэвсгэр оршиж байна. Нийт 21 аймгаас ойт хээр, хээр, цөлөрхөг хээр хосолсон Увс, Завхан, Өвөрхангай, Баянхонгор гэсэн 4 аймаг байдаг Сумдын нэг бүрчлэн экологийн бүсээр ангилсан болно.

15.1. Уур амьсгалын өөрчлөлт

Монгол орны агаарын жилийн дундаж температур 1940-2018 оны хооронд 2.25°C -аар дулаарсан бол нийлбэр хур тунадас 11% -иар бага зэрэг буурсан хандлагатай байна. Олон жилийн эрэмбийн графикаас харахад 2018 он 9 дахь дулаан жил байжээ. Харин хур тунадасны хувьд 8 дахь тунадас ахиу жил байсан байна. (Зураг 2)


Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, үрэлгэн хэрэглээ, байгаль орчны бохирдол, доройтол зэрэг нь экосистемийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэж, улс орнуудын тогтвортой хөгжилд томоохон сорилт болж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи, нэвтрүүлж нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх” тухай томоохон зорилт дэвшүүлсэн.

Манай орны хувьд уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас даруй 3 дахин их буюу сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд 2.2°C дулаарч, хур тунадасны хэмжээ 7 хувиар буурсан байна. Үүний улмаас байгаль, цаг агаараас ихээхэн хараат эдийн засгийн салбаруудад илүүтэй их эрсдэл учирч, гол ус хатаж ширгэх, мөнх цэвдэг, мөстөл хайлах, хөрс бэлчээр доройтон цөлжих, байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж, хамрах хүрээ нэмэгдэж байна. 2016 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь цөлжилтөд өртсөн байна.


Монгол орны жилийн дундаж агаарын температур сүүлийн 79 жилд 2.25°C -ээр дулаарсан байна. Харьцангуй эрчимтэй дулааралт 1990-ээд оноос эхэлсэн ба хамгийн дулаан жил 2007 он байсан байна. 2017 онд жилийн агаарын дундаж температур 1.6°C хүрсэн нь 1940 оноос хойш ажиглагдсан 2 дахь дулаан жил болсон. 1997-2011 оны хооронд хур тунадас олон жилийн дунджаасаа бага байсан бол 2012, 2013, 2016, 2018 онуудад харьцангуй ахиу орсон байна.

Зураг 15.1.1. Агаарын жилийн дундаж температур, 1939-2018




Эх сурвалж: БОАЖЯ, 2019, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Зураг 15.1.2. Хур тунадасны жилийн дундаж өөрчлөлт, 1939-2019




Эх сурвалж: БОАЖЯ, 2019, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Газрын зураг 15.1.1. Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын индекс, өнөө үед




Газрын зураг 15.1.2. Уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдлын индекс 2050 онд, аймгуудаар



Сүүлийн жилүүдэд агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн тоо ихсэж, 1989-2000 онд жилд дунджаар 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол 2001-2018 онд 2 дахин нэмэгджээ. Уруйн үер ба салхи шуурга 2018 онд хамгийн олон удаа болсон бөгөөд нийт аюулт болон гамшигт үзэгдлийн 53%-ийг тус тус эзэлсэн байна.

Зураг 15.1.3. Байгалийн гамшигт үзэгдлүүдийн тоо, 1989-2018 он




Эх сурвалж: БОАЖЯ, 2019, Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ

Улаанбаатар хотын агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрч, хот, хөдөөгүй хог хаягдал хуримтлагдаж, стандартын шаардлагад нийцэхгүй ариун цэврийн байгууламж нэмэгдэж байгаагийн улмаас ус, хөрс бохирдож, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боллоо. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг хөхиүлэн дэмжих, түүхий нүүрсийг хориглох, нийлэг уут ашиглахыг хязгаарлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн шалтгаан хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал нь сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал 2014 оны байдлаар 34,482.73 мян.тн CO₂экв буюу дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгарлын 0.1%-ийг эзэлж байна. Цаашид үндэсний хэмжээнд нийт хүлэмжийн хийн ялгаралт эрчимтэй нэмэгдэх хандлагатай байгаа тул уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг манай улсын хувьд хүлэмжийн хийн ялгаралтыг үндэсний түвшинд нийт салбарын оролцоотойгоор бууруулах бодлого боловсруулж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.


Зураг 15.1.4. Хүлэмжийн хийн ялгаралт, 1990-2014 онд, CO₂ экв, сая тн-оор



15.2. Газрын доройтол, цөлжилт

Сүүлийн жилүүдэд газрын доройтол, цөлжилт эрчимтэй явагдаж нийт нутаг дэвсгэрийн 76.8% цөлжилтөд өртсөн байна.

Зураг 15.2.1. Цөлжилт, газрын доройтлын хандлага, эзлэх хувиар, 2006-2016 онд




Эх сурвалж: ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, 2017, Цөлжилтийн судалгааны тайлан


Дээрхи зургаас харахад нийт нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг буюу 76.9 % нь цөлжилт, газрын доройтолд өртсөн ба үүнд өмнө болон дорно говь хэсгийн нутаг, их нуруудын хотгор, их нуруудын Бурундийн хөндий хамрагдаж, мөн Орхон-Сэлэнгэ, Хэрлэн голын сав газар, дорнод Монголын хээрийн муж, төв халхын тэгш өндөрлөгийн хэмжээнд хөрсний доройтол нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд авч үзвэл, цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийн 62.8%, Дорнод 43.5 %, Сүхбаатар 31.1%, Дундговь 27.9%, Өмнөговь 17.5% тус тус хамрагдаж байна.

Цөлжилт хүчтэй илэрсэн газар дахь хүчин зүйлийн нөлөөллийн хувьд байгалийн хүчин зүйлийн нөлөө 53%, хүний үйл ажиллагааны нөлөө 47% байдаг.

Газрын зураг 15.2.1 Хуурайшлын зураг 2015.



Газрын зураг 15.2.2 Цөлжилтийн төлөв байдлын зураг




Таних тэмдэг

- Аймгийн төв
- Сумын төв
- Сумын хил
- Аймгийн хил
- Улсын хил
- Нуур


Цөлжилт, газрын доройтлын зэрэглэл

- Цөлжилт үгүй
- Цөлжилт сул
- Цөлжилт дунд
- Цөлжилт хүчтэй
- Цөлжилт нэн хүчтэй
- Доройтол үгүй
- Газрын доройтол сул
- Газрын доройтол дунд
- Газрын доройтол хүчтэй
- Газрын доройтол нэн хүчтэй

Зураг 15.2.2. Эвдэрсэн болон нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээ, га-аар, аймгаар, 2018 он



Зураг 15.2.3. Уул уурхайн тусгай зөвшөөрлийн тоо, 2014-2018 онд



Хүснэгт 6. Алтны ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн тоо (аймгуудаар)

Д/д	Аймаг	Тусгай зөвшөөрлийн тоо	Аж ахуй нэгжийн тоо
1	Архангай	18	10
2	Баян-Өлгий	8	6
3	Баянхонгор	65	65
4	Булган	48	31
5	Говь-Алтай	9	8
6	Дархан-Уул	34	28
7	Дорноговь	3	2
8	Дорнод	27	22
9	Дундговь	5	3
10	Завхан	6	4
11	Өвөрхангай	20	14
12	Өмнөговь	18	10
13	Сүхбаатар	6	2
14	Сэлэнгэ	101	68
15	Төв	158	92
16	Увс	13	7
17	Ховд	6	5
18	Хөвсгөл	1	1
19	Хэнтий	20	15
НИЙТ		548	393
		ААН-ийн тоо давхардсан	



15.3. Газар ашиглалт, газрын баланс

Манай улсын газрын нэгдмэл санд 2018 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн газар 114,809.2 мянган га буюу 73.4%, хот, тосгон бусад суурины газар 859.7 мянган га буюу 0.5%, зам, шугам сүлжээний газар 474.3 мянган га буюу 0.3%, ойн сан бүхий газар 14,341.4 мянган га буюу 9.2%, усны сан бүхий газар 686.1 мянган га буюу 0.4%, улсын тусгай хэрэгцээний газар 25,240.9 мянган га буюу 16.1% тус тус эзэлж байна.


Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 2000 онд 21.7 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 13.8%, 2014 онд 27.2 сая га буюу 17.4%, 2018 онд 27.9 сая га буюу 17.85% болж

тус тус өссөн байна. 2019 онд 3.4 сая га талбайг хамгаалалтанд нэмж авснаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт дэсгэрийн 19.8% болж өссөн.

Газрын зураг 15.3.1. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ ДАХЬ
ОЙН САН БҮХИЙ ГАЗАР



Газрын зураг 15.3.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тоо



Орон нутгийн хамгаалалттай газар нутаг: 2018 оны байдлаар аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 21 аймгийн 63.7 сая га (нийт нутаг дэвсгэрийн 40.7%) бүхий нийт 2612 газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.

Манай орны гол мөрний нийт урсац 2017 онд 84.1%-ийн, 2018 онд 33.3%-ийн хангамшилтай байв. 2017 онд нийт нутаг дэвсгэр дээр 21.3 км³ урсац бүрдсэн нь гол мөрний олон жилийн дундаж урсацаас 38.4%-иар буюу 13.3 км³-ээр бага устай байсан бол 2018 онд 34.1 км³ урсац бүрдсэн нь 1975-2018 оны гол мөрний дунджаас ахиу байсан байна. Сүүлийн жилүүдэд булаг шанд, гол горхи, нуур, тойром хатаж ширгэх үйл явц нэмэгдэж, 2018 оны усны тоо бүртгэлийн мэдээгээр гадаргын усны 527 эх үүсвэр хатаж, ширгэж, 519 нь сэргэсэн байна. Монгол орны мөстөл, мөсөн голын талбай 1940-1990 он хүртэл 12.1%, 1990-2000 онд 4.0%, 2000-2011 онд 13.7% буюу сүүлийн 70 орчим жилд нийтдээ 29.9%-иар багассан байна. Монгол орны газрын доорхи усны нөөц тогтоох хайгуул, судалгааны ажил 2003-2018 онуудад 2-7 удаа болж буурчээ. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хүрээнд 2006-2018 онд 2678 ширхэг булаг шандны эхийг хашиж хамгаалсан байна. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 530 орчим сая.м³ ус ашигласан бол уул уурхайн салбарт 356.7 сая.м³/жил ус ашигласан ба 74.5%-ийг дахин ашигласан байна.

2017-2018 ойн сангийн үзүүлэлтийг 2015-2016 оны төлөв байдалтай харьцуулахад нийт талбай 133.6 мянган гаар, нөөц 7.1 сая.м³-р нэмэгдэж, ойрхог чанарын эзлэх хувь (7.9%) тогтвортой хадгалагдаж байна. 2017-2018 онд гарсан ой, хээрийн түймрийг 2015-2016 онтой харьцуулахад гарсан түймрийн тоо 190-ээр, түймэрт шатсан талбай 9,409.0 мянган га-р багассан байна. Улсын хэмжээнд 2017-2018 онд ойгоос нийт 1,384.9 мян.м³ мод бэлтгэсэн бол хууль бус мод бэлтгэлийн 2015-2016 оны мэдээллийг 2017-2018 оны мэдээлэлтэй харьцуулахад бүртгэгдсэн хэрэг зөрчлийн тоо 11.4%-иар өссөн ч, хууль бусаар бэлтгэгдэж хураагдсан модны хэмжээ 79.1%-иар буурсан байна.

Монгол оронд одоогоор 19 хүрээнд хамаарах 37 ангийн 116 багийн 388 овогт хамаарах 1523 төрөлд багтах 7350 зүйл, дэд зүйл ургамал бүртгэгдэв. Манай оронд өөр хоорондоо

ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 141 зүйл хөхтөн амьтан, 513 зүйл шувуу, 21 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдээд байна. 2018 онд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох хэрэг 45 нэгжээр, химийн хорт болон аюултай бодис хууль бус эргэлтэд оруулах хэрэг 12 нэгжээр, хууль бусаар мод бэлтгэх хэрэг 104 нэгжээр, ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг 7 нэгжээр тус тус өссөн байна.

Бодлого, Хууль эрх зүйн үндсэн баримт бичгүүд

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, 2016
- Ногоон хөгжлийн бодлого, 2014
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1994
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1997

Дэлхийн байгаль соёлын өвд бүртгэгдсэн газрууд

- 2003 Увсын нуурын ай сав
- 2004 Орхоны хөндий
- 2011 Алтайн нурууны хадны сүг зургийн цогцолбор
- 2015 Бурхан Халдун болон хүрээлсэн тахилтат уулс
- 2017 Дагуурын ландшафт


Дэлхийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт багтсан газрууд

- 1991 Говийн дархан цаазат газар
- 1996 Богдхан уул
- 1997 Увсын нуурын ой сав
- 2004 Хустайн нурууны БЦГ
- 2005 Дорнод Монголын ДЦГ
- 2007 Монгол Дагуур ДЦГ


15.4. УСНЫ НӨӨЦИЙН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Эрдэмтэн судлаачдын 40 гаруй жилийн судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол орны нутаг дэвсгэр дээр жилд дунджаар 608,300.0 сая.м³ усны нөөц бүрэлдэн бий болдог байсан бол сүүлийн жилүүдэд болж байгаа уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дулаарлын улмаас мөнх цас, мөсөн голын эзлэх талбай багасч, мөсний зузаан нимгэрсний улмаас усны нийт нөөцийн хэмжээ 564,800.0 сая.м³ болж багасаад байна. Тухайлбал гол мөрний усны нөөц 34,600.0 сая.м³, нуур тойрмын усны нөөц 500,000.0 сая.м³, мөнх цас, мөсөн голын нөөцийн хэмжээ 62,900.0 сая.м³ байсан бол 19,400.0 сая.м³ болж буурсан, харин газрын доорх усны нөөц 10,800.0 сая.м³ байна.


Газрын зураг 15.4.1. ГОЛ МӨРӨН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ, КМ³ (АЙМГААР)



Зураг 15.4.1. УС АШИГЛАЛТ БА ХЭРЭГЛЭЭНИЙ ГОЛ ТӨРЛҮҮДЭЭР САЯ.М³/ЖИЛ




Зураг 15.4.2. Усны нөөцөд эх үүсвэрүүдийн эзлэх хувь



Монгол орны усны нийт нөөц 564800 сая м³/жил бөгөөд үүний 88,53 хувь нуур, 6,13 хувийг гол мөрөн, 3,44 хувийг мөстөл, мөсөн гол эзэлж байна.

Газрын зураг 15.4.2. Монгол Улсын хот, сумын төв, суурин газруудын гадаргын усны нөөцийн дагуух байршил



Нийт 336 сум, хот, суурин газрын 214 буюу 65 хувь нь гол мөрний эрэг дагуу байрласан. Дулааралт их, урсац бага, ууршилт ихтэй бүс дэх Ховд, Өлгий, Баянхонгор, Улаангом, Цэцэрлэг, Булган, Зуунмод хотууд болон Ховд, Завхан, Байдраг, Түйн, Онги, Буянт Үенч, Бодонч, Бөхмөрөн, Булган зэрэг Төв Азийн гадагш урсгалгүй, Хойд мөсөн далайн ай савын урсац багатай Хануй, Хүнүй, Тамир, Чулуут, Туул, Орхон, Номхон далайн ай савын Хэрлэн, Улз голын ай сав дагуух хот, суурин газрууд дэлхийн дулаарлаас үүдэлтэй усны хангамжид эмзэг байдал илүү өндөр байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс дулааралт үүсч энэ нь голын

эрэг дагуух хот, суурин газруудад богино, дунд хугацаандаа үер усны гамшиг, дунд урт хугацаандаа усны нөөцийн хомсдолд хүргэх эрсдэлтэй юм.

2018 оны байдлаар нийт 3078 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байгаагаас 1673 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 1405 хайгуулын тусгай зөвшөөрөл байна. Үүнээс алтны 566 ашиглалтын тусгай зөвшөөрөл буюу нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 28%-ийг эзэлж байна. 2018 оны байдлаар бүх аймагт уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газрын тооллого хийхэд 24,347.5 га газар эвдэгдснээс нөхөн сэргээх шаардлагатай орхигдсон газрын байршлын тоо 1491, талбайн хэмжээ 9,381.4 га болсон байна.


15.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨВ

Сүүлийн жилүүдэд хот, суурин газрын хүн ам, автомашины тоо өсч, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэхийн хирээр агаар, хөрс, усны бохирдлын түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс давах тохиолдол байнга гарах болжээ. Орон нутгийн агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр галлагаанаас үүсэх агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж 2017, 2018 онд Баянхонгор, Даланзадгадад хамгийн их буюу агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 1.11.8 дахин их байна.

Агаарын чанар² гэдэг нь стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанар юм. Хүрээлэн байгаа агаарт шууд хаягдсан эсвэл физик, химийн урвалын дүнд шинээр бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг агаарын бохирдолтой гэж үздэг. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ)-ын зөвлөмжөөр 24 цагийн дундаж агууламж нь 0.025 мг/м³ хүлцэх буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ юм.

² Стандарт, хэмжилзүйн газар. “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт” 2016 он

Зураг 15.5.1. Аймгийн төвүүдийн агаар бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламж³ (2018 он)



Орон нутгийн аймгийн төвүүдийн агаарын чанарын үзүүлэлтээр Баянхонгор аймаг агаарын бохирдол хүлцэх хэмжээнээс давсан бол Алтай, Ховд, Эрдэнэт, Арвайхээр, Сайншанд, Даланзадгад, Баруун-Урт хотууд азотын давхар исэл стандарт хэмжээнээс давсан байна. Хөрсний болон цайрын бохирдлын түвшингээр Чойр хот хүлцэх хэмжээнээс их хэтрэлттэй орон нутгийн ганц хот болж байна.

³ “Монгол Улсын статистикийн эмхэтгэл” 2018 он

16. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Хүн амын суурьшил, шилжилт хөдөлгөөний талаар:

- 1.1. Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөний хувьд нийслэл болон том хотуудыг дагасан шилжилт хөдөлгөөний эрчим 2015 оноос саарч, хөдөөгийн сумуудаас аймгийн төвүүдийг чиглэсэн шилжилт хөдөлгөөн илүү явагдаж байна.
- 1.2. Орон зайн хувьд хотуудын хувьд хүн амын тоо нь 30 мянгаас дээш хүнтэй хотуудын хүн ам илүү ихээр нэмэгдсэн бол аймгийн төв орчмын болон алслагдсан жижиг сумдын хүн ам илүү ихээр буурсан.
- 1.3. Орон нутгийн түвшний хүн амын шилжилт хөдөлгөөнд илүү нөлөөлж байгаа хүчин зүйл нь боловсролын үйлчилгээ бөгөөд 1 гэр бүлийн эхнэр нь хүүхдүүдээ сургууль сургахаар сумын төв болон аймгийн төв хот, суурин газарт суурьшиж байгаа нь өрх дотор өрх үүсгэж, гэр бүлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.
- 1.4. Нийслэлийг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнд дээд боловсролын үйлчилгээний таталцал хамгийн ихээр нөлөөлж буй бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар нийт оюутнуудын 92 хувь нийслэлд суралцаж буй бол аймаг, орон нутагт суралцагч оюутны тоо энэ хугацаанд бараг 2 дахин буурсан байна. Иймд нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулахын тулд зарим их, дээд сургуулиудыг төрөлжүүлэн дагуул болон хоёрдогч том хотуудын шилжүүлэн байршуулах шаардлагатайг харуулж байна.

2. Хот байгуулалтын талаар:

- 2.1. Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нийгэм эдийн засгийн таталцалтай уялдуулан хөдөөгийн сумын төвүүдийн ерөнхий төлөвлөгөөг хүн амын өсөлтийг бодитоор тооцсон, цомхон, хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөлттэйгээр хийх шаардлагатай байна. Тухайлбал Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын төвийн ерөнхий төлөвлөгөөг хүн амын өсөлтийг хэт ихээр тооцсон, мөн суурьшлын бүсийг хэт томоор тооцсоноор шинэ сургуулийн барилга нь дотуур байраас нэлээд зайтай (сумын төвийн зах) баригдаж буй нь бага ангийн хүүхдийн аюулгүй орчинд амьдрахад сөргөөр нөлөөлж байна.
- 2.2. Аймгийн төв хотуудын хүн амын өсөлт харьцангуй их болж, хотын суурьшлын бүс тэлэн хөгжих шаардлага үүсч байгаа ч нийт аймгийн төв хотуудын 90 хувь нь газар нутгийн хувьд зөвхөн суурьшлын бүсээрээ хязгаарлагдсанаас болж, хот тэлэн хөгжихөд газар зохион байгуулалтын хувьд бэрхшээл дагуулж байна. Иймд аймгийн төв хотуудыг тэлж хөгжих хандлагыг нь харгалзан зэргэлдээх хөдөөгийн сумтай нэгтгэх, эсвэл газар нутгийн хэмжээг нь томруулах шаардлагатай байна.
- 2.3. Сумын төвийн шинэчлэл зэрэг инженерийн дэд бүтцийн нэгдсэн шугам сүлжээ бүхий төсөл арга хэмжээнүүдийг хүн амын хүртээмж, нийгмийн болон эдийн засгийн үр ашгийг харгалзаж, эхний ээлжинд бүлэг суурингийн төв буюу сум дундын төв болохуйц томоохон сумдад хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- 2.4. Хүн амыг эрүүл аюулгүй, ая тухтай орчинд тогтвор суурьшилтай амьдрах нөхцлийг хангах үүднээс суурин газрын зам талбай, гэрэлтүүлэг, камержуулалт, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ, хог хаягдлын менежмент, орон сууцжуулалт зэрэг төсөл арга хэмжээнүүдийг үе шаттайгаар эрэмбэ дараатайгаар хүчин чадал, байршлын хувьд оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хөгжлийн хөрөнгө оруулалтуудыг чиглүүлэх хэрэгтэй байна.
- 2.5. Хөгжлийн хөрөнгө оруулалт нь хэрэгцээ шаардлага, ач холбогдол, хүчин чадал, байршлын хувьд оновчтой төлөвлөгөөгүйгээс зарим хот, сумын төвүүдэд ихэнхи барилга байгууламж нь шинэчлэгдсэн байхад заримд ихэнхи нь хуучирч, актлагдах

түвшинд хүрсэн, ашиглах бололцоогүй нөхцөлд байна. Иймд боловсрол, эрүүл мэнд, зам, хот байгуулалт зэрэг төсвийн хөрөнгө оруулалтыг эмх цэгцтэй, эрэмбэ дараатайгаар оновчтой төлөвлөхийн тулд хот байгуулалт, төлөвлөлтийн иж бүрэн нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, хүний нөлөө орохооргүй нээлттэй платформыг бий болгож хөгжүүлэх шаардлагатай байна.

3. Нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний талаар:

- 3.1. Хэдий орон нутгийн аймаг, сумдын эмнэлгийн боловсон хүчин, барилга байгууламжийг хүчин чадлыг өргөтгөж байгаа ч сумаас аймгийн төв, аймгийн төвөөс нийслэл хот, нийслэлээс гадаад улсыг чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээний таталцал оршсоор байна. Иймд чадалтай өндөр мэргэжлийн боловсон хүчнийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг цалин хангамж болон орон сууцны нөхцлөөр дэмжих, эмнэлгийн шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах хэрэгтэй байна.
- 3.2. Сумдын түвшинд төсвийн байгууллагын залуу ажилчид тогтвор суурьшилтай ажиллаж чадахгүй байна. Дээд боловсрол эзэмшээд 2-3 жил ажиллаж туршлага хуримтлуулаад хувийн хэвшлийн болоод аймгийн төв, Улаанбаатар хот, томоохон уул уурхай бизнесийн төв хотууд руу шилжин суурьшиж ажиллах нь түгээмэл байна. Иймд залуу боловсон хүчнийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангасан санхүүгийн болоод нийгмийн хөшүүргийг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- 3.3. Хүн амын төвлөрөл багатай хөдөөгийн сум, орон нутагт эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмж муу байна. Тухайлбал зарим сум, орон нутагт мэргэжлийн эмч, багш, галч, төрийн захиргааны ажилтан нарын ажлын байранд ажиллах хүн олдохгүй байна.
- 3.4. Боловсролын үйлчилгээний хувьд орон нутгийн сумдад ихэнхи тохиолдолд сурах насны хүүхдээсээ цөөн буюу хүчин чадалдаа хүрч чадахгүй байгаа бол нийслэл, томоохон хот, том сумдад хүчин чадлаасаа хэтэрсэн хүүхдүүд суралцаж байна. Энэ нь нэг талаар орон нутгийн хэмжээнд хүн амын шилжилт хөдөлгөөнд хүргэж байгаагаас гадна нөгөө талаар хүүхдийн тоо цөөн, жижиг сумдад боловсролын үйлчилгээний чанар муу, өрсөлдөөн бага байгаатай холбоотой байна.

4. Хүрээлэн буй орчин, хог хаягдлын менежментийн талаар:

- 4.1. Аймгийн төв хотуудад хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр агаарын бохирдол ихэсч байна. Түүнээс гадна зарим аймгийн төв болон хотуудад нэгдсэн дулааны эх үүсвэр байхгүйгээс болж, уурын зуух, гэр хорооллын айлуудын галлагаанаас үүдэлтэй утаа тортог нь Дархан, Баянхонгор, Архангай, Зүүнхараа зэрэг хотууд болон уул уурхай дагасан Налайх, Цогтцэций зэрэг хот, суурин газруудад илүү ихээр ажиглагдаж байна. Иймд бүх аймгийн төв болон хотуудыг нэгдсэн дулааны эх үүсвэртэй болгож, гэр хорооллыг сайжруулсан түлшээр хангах шаардлага гарч байна.
- 4.2. Хог хаягдлын менежмент хот, суурин газруудаар харилцан адилгүй бөгөөд хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрахад гол тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Ялангуяа жижиг сум, суурин газарт айл өрх, байгууллагууд нь дураараа хогийн цэгт хог хаягдлаа хаяж байгаа нь хогийн цэгийн талбайг хяналтгүй нэмэгдүүлж, зарим сумын төв суурин газрын суурьшлын бүс рүү орж ирсэн байна. Иймд хот, сумын төв, суурин газар тус бүрт хүн амын тооноос хамаарсан хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, стандартыг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

5. Ус хангамжийн талаар:

- 5.1. Хүн амын өсөлттэй уялдуулан нийслэлийн дагуул хотууд болон гадаргын усны хангамжийн эх үүсвэргүй говь хээрийн бүсийн хот, суурин газрууд болон уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжих газруудад усны нөөцийн хайгуул, судалгааг шинээр хийх шаардлага зүй ёсоор тулгарч байна.
- 5.2. Говь хээрийн бүсэд ундны усны хатуулаг илүү их байгаа тул ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмжөөр хангах, мөн зарим сумын төв, суурин газрын иргэд 5-10 км хол газраас усаа зөөж, хэд дахин өндөр үнэтэй ус хэрэглэж байгааг харгалзаж ус дамжуулах шугам эх үүсвэрээр холбож, иргэдийг хямд, аюулгүй цэвэр усаар тогтвортой хангах хэрэгтэй болж байна.

6. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн талаар:

- 6.1. Дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын засаг захиргааны нэгжүүдийн түвшин хооронд шалгуур үзүүлэлтүүдийн босго утганы хамаарал төдийлөн байхгүй байна. Тухайлбал аймгуудын 1 суманд ногдох дундаж хүн амын тоо нь Орхон, Завхан аймгийн хооронд 17 дахины зөрүүтэй байна.
- 6.2. Засаг захиргааны нэгжүүдийн хүн амын тооны ангиллын дагуу дахь хүн амын өсөлтийн төлөвөөс харахад хүн ам ихтэй аймаг, сумдын хүн амын илүү их өндөр өсөлттэй байгаа нь хүн амын төвлөрөл, зах зээлийн багтаамжийг дагаж, орон нутагт хүн амын төвлөрөл нэмэгдэж байгааг харуулж байна.
- 6.3. 1990 онд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш хүн амын нутагшил суурьшлын тогтолцоо болон хотжилтод томоохон өөрчлөлт гарсан тул энэ хугацаанд өөрчлөлт хийгдээгүй ирснийг харгалзан орон нутгийн хотуудын хөгжлийг дэмжих, сум, орон нутагт хүн амын зохистой төвлөрөл зах зээл бий болгох үүднээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг үе шаттайгаар томсгон өөрчлөх шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

1. Ном, товхимол, судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүллүүд

- Аймгуудын Статистикийн хэлтэс. 2018. Статистикийн эмхэтгэл 21 аймаг – 2017 он
- Базаргүр Д. 2007. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм-эдийн засгийн газарзүйн тандах судалгаа.
- Баттүвшин Б. 2005. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэл ба нийгмийн удирдлагын тогтолцооны эрхзүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл.
- БСШУЯ, 2011, Боловсролын салбарын 2010-2011 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл
- ЗГХЭГ. 2006. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үүсэл хөгжил, өнөөгийн байдал, шинэчлэл хийх саналын тухай.
- ЖАЙКА. 2016. Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа
http://open_jicareport.jica.go.jp/pdf/12283339_01.pdf
- Монгол Улсын Засгийн газар. 2005. Аймгуудад хүргүүлсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарийн санал зураг, сэтгүүл.
- Монгол Улсын Засгийн газар. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг шинэчлэх саналын тухай. Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан материал.
- Сономдагва Ц. 1998. Монгол УЛСЫН засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт.
- Үндэсний Статистикийн Хороо, 2011, Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого
- Үндэсний Статистикийн Хороо, 2011. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2010.
- Үндэсний Статистикийн Хороо, 2019. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2018.
- Үндэсний Статистикийн Хороо. 2008. Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо
- Цэдэндамба Л, Х.Маам. 2000. Монгол Улсын Өрнөд бүс.
- Цэдэндамба Л. Р.Ринчинбазар, Д.Гансэлэм. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудалд. Үндэсний Хөгжлийн хүрээлэн. Бүтээлийн эмхэтгэл.
- ШУА. Газарзүйн хүрээлэн. 2005. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөх саналын хувилбар
- Алтанбагана М., С.Давааням, Хэрлэнбаяр. 2016. Монгол Улсын хот байгуулалтын тайлан, БХБЯ-ны захиалгаар
- Давааням С., Д.Бямбаа. 2011. Монгол Улсын Хүн амын суурьшил, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

Давааням С., М.Алтанбагана нар. 2011. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэлийн талаар харьцуулсан судалгаа, бодлогын оновчтой хувилбарууд, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар

“Монгол орны хот байгуулалтын байгалийн нөхцөл” Ц.Хоролжав. УБ хот 2011 он

“Монгол ороны уулархаг бүс нутгуудын цэвдгийн ялгаа, өөрчлөлт” Я.Жамбалжав, Я.Гансүх, А.Саруулзаяа УБ хот 2016 он

ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, цэвдэг судлалын салбар

Chuluun, T, Altanbagana M., Davaanyam S. & Ojima D. 2006. Vulnerability and adaptation options of the coupled human-environmental system to global change in Mongolia. Pages 148 In: A program of Earth System Science Partnership Open Science Conference on “Global Environmental Change: Regional Challenges”, Beijing, China.

Chuluun, T. 2005. A new administrative-territorial division of Mongolia as a mechanism to increase adaptive capacity to climate change. Pages 436 In: The 6th open meeting of the international human dimensions meeting of global environmental change on “Global environmental change, globalization and international security: new challenges for the 21st century” Conference book, Bonn, Germany.

Dexia, EU sub-national governments: 2008 key figures, 2009/2010 edition

Expert Group. 2010. Analytical study on optimal administrative-territorial structure for republic of Moldova.

2. Хууль эрхзүйн баримт бичгүүд

Монгол Улсын Үндсэн хууль. 1993

Засгийн газрын тухай хууль

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хууль

Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын тухай хууль

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. 2001

Баруун, Хангайн, Төвийн болон Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрүүд

Бүсчилсэн Хөгжлийн Хороо. 2005. Бүсчилсэн хөгжил гарын авлага